



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

---

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-7
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	8-123
<hr/>	
1 Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал	8-15
2. Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	15-17
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр дүгнэлт /Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	17-32
4. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал	32-123

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
3 дугаар сарын 30-ны өдөр /Даваа гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 88 гишүүн хүрэлцэн ирж, 69.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, Х.Баттулга, Ц.Мөнхтуяа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр;  
Чөлөөтэй: П.Ганзориг, Ц.Даваасүрэн, М.Нарантуяа-Нара, Г.Очирбат;  
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ж.Баясгалан;  
Тасалсан: Л.Оюун-Эрдэнэ.

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-29 минут, Н.Алтаншагай-10 минут, Д.Амарбаясгалан-29 минут, С.Амарсайхан-29 минут, М.Бадамсүрэн-29 минут, Н.Батсүмбэрэл-13 минут, Б.Батцэцэг-01 минут, Ж.Баярмаа-10 минут, Э.Болормаа-29 минут, Г.Ганбаатар-29 минут, Д.Ганбат-13 минут, Б.Жавхлан-43 минут, Б.Жаргалан-2 цаг 26 минут, Б.Заяабал-03 минут, Т.Мөнхсайхан-05 минут, Б.Найдалаа-15 минут, Н.Наранбаатар-29 минут, П.Наранбаяр-29 минут, Э.Одбаяр-02 минут, О.Саранчулуун-03 минут, Ц.Туваан-29 минут, Г.Тэмүүлэн-04 минут, А.Ундраа-06 минут, Да.Цогтбаатар-29 минут, Д.Цогтбаатар-14 минут.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Б.Пүрэвдорж, О.Номинчимэг, Д.Энхтүвшин, С.Зулпхар, А.Ариунзаяа, С.Эрдэнэболд, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын дарга Н.Учралын үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээж авах нь зүйтэй гэснийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 81  
Татгалзсан: 20

Бүгд: 101

80.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 12.3-т заасны дагуу санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх тухай” тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ “Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:29/

*Үдээс өмнөх хуралдаан 19 минут үргэлжилж, 10 цаг 30 минутад өндөрлөв.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 20 минутад эхлэв.*

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Байнгын хороодод хуваарилсныг мэдээлэв.

Үүнд:

1.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

2.Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан нарын 3 гишүүн 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

4.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

5.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

6.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

7.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

8.Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүйн байнгын хороодод;

9.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

10.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатанд санаачилсан хуулийн төслөө татан авч болно.” гэж, 32.3-т “... хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно.” гэж заасны дагуу 2026.03.12-ны өдөр Засгийн газраас “Хуулийн төслийг татан авах тухай” ЗГ-1/09, 2026.03.20-ны өдөр “Хуулийн төсөл татан авах тухай” ЗГ-1/23 дугаартай албан бичиг ирүүлснийг тус тус танилцуулав.

Засгийн газраас 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг тус тус татан авсанд тооцов./14.24/

***Хоёр.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025.03.19-ний өдөр “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болохыг танилцуулав.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64  
Татгалзсан: 48  
Бүгд: 112  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр дүгнэлт** /Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Болдбаатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Болдбаатар танилцуулав.

*Чуулганы нэгдсэн хуралдааныг Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж дуустал 14 цаг 57 минутаас 15 цаг 35 минутад түр завсарлуулав.*

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Булгантуяа, С.Эрдэнэбат, П.Наранбаяр, Д.Ганбат, Ж.Алдаржавхлан, Ц.Туваан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр дүгнэлттэй танилцлаа.

*Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Дөрөв.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга А.Үйлстөгөлдөр, мөн газрын Хуулийн газрын дарга Ж.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Б.Пүрэвдорж, О.Номинчимэг, Д.Энхтүвшин, С.Зулпхар, А.Ариунзаяа, С.Эрдэнэболд, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудлаас Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 1 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ уг асуудлаар 1 цагийн завсарлага өгөв./17:05/

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл 18 цаг 30 минутад завсарлагын хугацаа дууссан тухай мэдэгдэж үг хэлэв.

Асуулт асуухаар нэр өгсөн Улсын Их Хурлын гишүүдийн асуултаар хуралдаан үргэлжлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ө.Шижир, Х.Тэмүүжин, Д.Бум-Очир, М.Ганхүлэг, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат, О.Батнайрамдал, А.Ганбаатар, С.Одонтуяа, Ц.Баатархүү, Х.Жангабыл, Ш.Бямбасүрэн, Б.Уянга, Г.Лувсанжамц, Б.Пунсалмаа, Л.Гантөмөр, Ж.Батсуурь, Ч.Лодойсамбуу, Р.Эрдэнэбүрэн, Ж.Баярмаа, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, М.Энхцэцэг, Б.Тулга, Ч.Анар, П.Сайнзориг, М.Мандхай, Б.Мөнхсоёл, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэболд, Ө.Шижир, Х.Тэмүүжин, Ж.Золжаргал, Ш.Бямбасүрэн, М.Энхцэцэг, Д.Жаргалсайхан, Д.Ганбат, Ж.Алдаржавхлан, Ц.Туваан нар үг хэлэв.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Ерөнхий сайдаар Ням-Осорын Учралыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 88

Татгалзсан: 19

Бүгд: 107

82.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, О.Батнайрамдал, Т.Доржханд, Л.Энхнасан нарыг дэмжсэнээр тооцож, 86.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасны дагуу нэр дэвшигчийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ “Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./22:55/

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын 35 дахь Ерөнхий сайдаар томилогдсон Н.Учралд Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учралыг суудалд нь урьж суулгав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал үг хэлж, Төрийн сүлдэнд мэхийн ёслов.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 7 цаг 15 минут үргэлжилж, 126 гишүүнээс 113 гишүүн хүрэлцэн ирж, 89.7 хувийн ирцтэйгээр 23 цаг 18 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр,  
Даваа гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 11 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**Ж.Бат-Эрдэнэ:** Өнөөдрийн ирц 126 гишүүнээс 88 гишүүн ирж, 69.8 хувьтай болсон байна аа. Ингээд Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэнэ.

Үдээс өмнөх хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойш хойших хуралдаанаар Улсын Их Хурлын чуулганаар “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 3 сарын 19-ний өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байна.

3.Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 11 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх асуудлыг хянан шийдвэрлэх тухай.

4 дүгээр асуудал. Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийг холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

5 дугаар асуудал. Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ. ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянаж шийдвэрлэсэн тухай.

6.Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ ээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

## Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөх асуудлыг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалт байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир таныг индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг үндэслэн 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн болно оо.

Төрийн байгуулалт уг хүсэлтийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасныг баримтлан 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрийн байгуулалт байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх шийдвэр гарсан тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтад заасныг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын даргаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж байгаагаа танилцуулсан болно оо.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал өөрийн хүсэлтээ гаргасантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир асуулт асууж, хариулт авсан болно.

Төрийн байгуулалт байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учралын Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх өөрийнх нь хүсэлтээр ил санал хураалт хурааж саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учралын Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалт байнгын хорооны санал, дүгнэлт чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү?

Пүрэвдорж, Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Их Хурлын гишүүдийн болон Монголынхоо ард түмний энэ өдрийн мэндийг айлтгая аа. Сайхан хаваржиж байна уу? Хаврын чуулганы анхны хуралдаан дээр үг хэлж байгаадаа баяртай байна. Тэгэхээр парламент бол ахмад, дунд, залуу үеийнхний 3 цагийн хэлхээс дээр ажилладаг ийм байгууллага байгаа.

Парламент үргэлж л мэдээж ахмадуудынхаа туршлагыг үнэхээр олон жил энэ парламентад ажилласан хүмүүс энэ танхимд суусныхаа үр дүнд бас тодорхой мэдээлэл, туршлага хуримтлуулсны үр дүнд энэ парламентын үйл ажиллагаа цэгцтэй явдаг гэж би ойлгодог. Мөн түүнчлэн залуу үеийнхээ шинэ, орчин үеийн нөхцөл байдал энэ дэлхий дахины энэ хувьсан өөрчлөгдөж байгаа энэ бүх зүйлийг парламентад оруулж ирж энэ хууль тогтоох үйл ажиллагаандаа тусгасны үр дүнд Монгол Улс илүү сайн хөгжих ийм боломжийг бүрдүүлнэ л гэж би хардаг. Тэгэх дээр өнгөрсөн хугацаанд харж байхад МАН Их Хурлын даргын томилгоон дээр бол тодорхой алдаануудыг гаргасан. Амарбаясгалан гэдэг дөнгөж анх сонгогдож байгаа хүнийг оруулж ирж энд суулгасны үр дүнд нэг жил гаруйхан болоод огцорч байх жишээтэй.

Учралд дарга бас тодорхой хэмжээний туршлагатай ч гэсэн бас намын даргын хувьд энэ дээр суухаар хоёр, гуравхан жижигхэн алдаа гаргасан. Тэр нь энэ сөрөг хүчний бас хүмүүст бас тодорхой нэг ийм эвгүй сэтгэгдэл төрөөд энэнээсээ улбаалаад намын дарга Их Хурал удирдахгүй гэдэг ийм л юм руу явчихлаа. Тэгэхдээ би энэ Их Хурлын даргыг бас сайн хийсэн гэж би үздэг. Тэгэхээр ер нь энэ энэ бүх зүйлээс харахад энэ парламент бол ер нь эрэмбийн газар, туршлагын газар гэдгийг л манай парламентын гишүүд бас ойлгож энэ дээрээ бас анхаарч ажиллах ёстой. Ер нь бол энэ парламент хоорондоо асуудалтай. Дээрээс нь энд эндээс бүгдээрээ сайд нар нь томилогдож байгаа болохлоор тэнд янз янзын идсэн уусан хулгайлсан асуудал нь энд орж ирж парламентын гишүүдээрээ дамжиж гардаг энэ бүх зүйл чинь өөрөө энэ ард түмэн дотор парламентын нэр хүндийг унагах ийм нөхцөл болоод байгаа учраас та бүхэн энэ парламентынхаа энэ үйл ажиллагааг бас тодорхой хэмжээгээр, энэ туршлагатай хүмүүсээр, илүү зөв урт хугацаанд тогтвортой сайн төртэй байлгах тэр хүмүүсийг сонгоорой л гэж хэлмээр байна аа.

Учрал даргад тэгээд Ерөнхий сайдынх нь ажилд амжилт хүсье. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Олон намын төлөөлөл бүхий парламентыг төвч байр суурьтай улс төрийн намын дотоод улс төрөөс ангид бие даасан спикертэй байлгах тухай үзэл санаа 1992 оны Үндсэн хуулиас л хойш яригдсан. Тэгээд 34 жилийн дараа ер нь энэ чиглэл рүүгээ явах нь зөв юм байна гэдэг тал дээр парламентад суудал бүхий намууд парламентын гол шийдвэр гаргаж байгаа намууд энэ байр сууриар алхаж байгаад би баяртай байна аа. Үнэхээр бид парламентын ардчилалтай бол парламент дотроо намууд нь бодлогын түвшинд чөлөөтэй мэтгэлцдэг, байр сууриа ярилцдаг, улс орны нэгдсэн асуудал дээр ойлголцож чаддаг үзэл санааны зөрөө байгаа бодлогын зөрөө байгаа бол тэрэн дээрээ бас үндэслэл гаргаад хатуухан зогсоож чаддаг ийм парламент байх юм бол Монгол Улсын шийдвэр гаргалт илүү цэвэр, сонирхлын зөрчилгүй, харилцан хяналттай болох юм. Тэгээд. Монгол Улс Улсын Их Хурлыг Засгийн газрын хуулийн хэлтэс эс үгүй бол аль нэг намын дагавар хурал шиг байлгахаа больё оо гэдэг энэ зарчим руу бид нэгдэж өнөөдөр түүхэн шийдвэрээ гаргах гэж байна.

Энэ түүхэн шийдэл цаашид Монгол Улсын парламент Үндсэн хуулийн байгууллыг илүү ул суурьтай, тулхтай хэрсүү шийдвэр гаргадаг. Монгол Улсын бүрэн эрхт байдал, улс орны бүрэн эрхт байдлыг илэрхийлдэг гол хэмжүүр бол парламентын засаглал бүхий улс оронд парламент нь байдаг юм байна лээ. Хэнээс ч хамааралгүй шийдвэрээ гаргаж чаддаг энэ институц ямар нэгэн хямралгүй, төвийг сахисан улс төрийн намын улс төржилтөөс ангид байдаг тийм спикертэй болж авах

юм бол Монгол Улсын төр салхи дагаж хямардаг биш. Салхи сөрж зогсдог ноён нуруутай уул шиг л болно. Тэгээд энэ том өөрчлөлт рүү бид алхаж байна.

Дараагийн Улсын Их Хурлын дарга дээр бид Үндсэн хуулиа бас сайн нягтлаад дахиад Үндсэн хуулийнхаа арга барилаар явах ёстой. Ардын намд би нэг зүйл дээр талархаж байна. Намын цагаан байрнаасаа парламентын спикерийг тодруулах зохимжгүй гэдэг дээр та бүхэн санал нэгдсэн юм байна. Баярлалаа.

Одоо Улсын Их Хурлын чуулган дээр намын бүлэг биш олонх 68 гишүүнийхээ гарын үсэгтэй Улсын Их Хурлын дарга оруулж ирдэг бол бүүр сайн. Яагаад гэвэл Үндсэн хууль дээр Улсын Их Хурлын гишүүд дотроосоо гэж үг байгаа. Ямар нэгэн бүлэг биш, ямар нэгэн нам биш.

Харин сонгуульд олонх цөөнх болсон намын бүлэг дэд дарга дээр хүнээ тавих тухай маш тодорхой заалт байгаа. Энэ 2 яагаад ингэж ялгамжтай хуульчлагдсан бэ гэхээр парламент бол 126 гишүүний ижил эрхтэй ийм гишүүдийн хуралддаг хурал учраас энийг аль нэг нам дангаараа юм уу эс үгүй бол намын нэрээр хаяглах биш энэ 126 гишүүн өөрсдийнхөө хурлыг эмхлэн зохион байгуулж удирдах хүнээ спикер болгон сонгоно оо л гэдэг зарчим Үндсэн хуулиар бичигдсэн байгаа. Тэгээд Монгол Улсын парламентын ардчилал бүхий Үндсэн хууль дахин сэргэн тогтсон өдөр болж байгаад талархалтай байна аа.

Бүх парламент ч бүх Улсын Их Хурлын гишүүддээ энэ бол зөвхөн бидний нэр дээр хаяглагдах түүх ерөөсөө биш. Энэ бол Монгол Улсын нэр дээр хаяглагдах түүх шүү гэж хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал дарга.

**Н.Учрал:** Юуны өмнө Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэндээ төрийн эрх барих дээд байгууллага хууль тогтоох эрх мэдлийг удирдах энэ өндөр хариуцлагатай албанд бас итгэж дэмжиж ажиллуулсанд талархаж байна. Хэдий богино хугацаа ч гэсэн парламентын дархлааг бэхжүүлэх парламентын үйл ажиллагааг илүү дэвшилтэт технологи ашиглах шилжилтүүдийг хийх ажилд бас богинохон хугацаанд анхаарч бас ахиц дэвшил гаргаж ажиллалаа.

Таван улс төрийн нам эвслээс бүрдсэн парламентын дарга бол төв ч байр суурьтай олон талын оролцоог хангаж, парламентын гишүүдийнхээ эрүүл ухаалаг мэтгэлцээнийг өрнүүлэх олон ургалч үзэл бодлыг уралдуулах энэ бололцоог бүрдүүлж ажиллах нь эрхэм чухал үүрэг нь. Тийм ч учраас өнгөрсөн хугацаанд бол бас парламентын гишүүдийнхээ дуу хоолой оролцоог хангуулах чиглэлээр бас санаачилгатай ажиллахыг хичээсэн. Мэдээж сөрөг хүчний зүгээс бол энэ 5 улс төрийн нам эвслээс бүрдсэн парламентыг бол аль нэг улс төрийн нам эвслийн дарга удирдах нь зохимжгүй юм гэдэг бас шаардлагыг бол тавьсныг бас манай нам эрүүлээр хүлээж авч бас ярилцсан.

Ингээд цаашдаа парламентын үйл ажиллагааг тасралтгүй тогтвортой явуулах, парламентын дархлааг хадгалан хамгаалах улс орны аж ахуйн эрх ашгийг эн тэргүүнд бас тавих үүднээс гүйцэтгэх засаглалын тэргүүн маань бас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж бид бас улс төрийн шийдвэрээ гаргасан гэдгийг бас та бүхэндээ хэлье. Тэгээд цаашид ч гэсэн сая бас Тэмүүжин гишүүний яг хэлж байгаагийн дагуу манай олонхын бүлэг парламентын даргаа нэр дэвшүүлнэ.

Ингээд Улсын Их Хурал олонхоороо шийдвэрлээд дараагийн парламентын даргыг сонгоод явах нь бас зөв жишиг болж үлдэнэ гэж бас ойлгож байна. Хэдийгээр улс төрийн намын дарга хэдий ч парламентын даргын индрээс бол аль нэг улс төрийн нам эвслийн мөрийн хөтөлбөр, зорилго зорилтыг тунхаглахаас илүүтэйгээр та бүхний дуу хоолойг оролцуулж ажлын хэсгүүдийг ч гэсэн аль аль намын төлөөллийг оролцуулж та бүхний үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй мэтгэлцэх, энэ эрх чөлөөг хангуулахын төлөө хичээнгүйлэн ажилласан гэдгийг бас энд хэлэхийг хүсэж байна.

Тэгээд өнгөрсөн хугацаанд Парламентын даргаар ажиллах хугацаанд дэмжиж тусалж, өндөр хариуцлага оногдуулж, хамтарч ажилласан Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд талархаж байгаагаа илэрхийлье ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд үг хэлж мөн Улсын Их Хурлын дарга үг хэлж дууслаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учралын чөлөөлөх хүсэлтийг хүлээн авах нь зүйтэй гэснийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 126 гишүүнээс 101 гишүүн оролцож, 81 гишүүн дэмжиж, 80.2 хувиар санал дэмжигдлээ. Монгол Улсын Их Хурлын даргыг чөлөөлөхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Ням-Осорын Учралыг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Ням-Осорын Учралыг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх заалт, 12.3 дахь хэсэг, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралыг Монгол Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд Улсын Их Хурлын даргын албан үүргийг гүйцэтгэх гэж байхыг Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байгаа эсэхийг асууж байна. Саналтай гишүүд байна уу? Алга байна тогтоолыг баталлаа.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үдээс өмнөх нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулж байна аа.

Чуулганы хуралдаан 14 цагаас эхэлнэ.

Эдийн засгийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны хамтарсан хуралдаан шууд хуралдана 11 цагаас.

## ҮДЭЭС ХОЙШ

**Ж.Бат-Эрдэнэ:** Үдээс хойших чуулганы хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ. Чуулганы өмнө мэдээлэл хийе.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл хууль санаачлагч төслөө татан авсан талаарх чуулганы нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийгээдэхье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Санхүүгийн хоршооны тухай хууль шинэчилсэн найруулга хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Батжаргалын Заяабал нар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд,

2.Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Тогтмолын Мөнхсайхан нарын 3 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд,

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоолын төслүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2026 оны 3 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалт байнгын хороонд,

4.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал нарын 4 гишүүн 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалт байнгын хороонд,

5.“Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг БОХХАА-н байнгын хороонд.

6.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг ХЗБХ-нд,

7.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд,

8.Төрийн нөөцийн тухай хуулийн төсөл Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон ХЗБХ-нд,

9.Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд,

10.ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нар 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл болон хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 12-ны өдөр хуулийн төслийг татан авах тухай ЗГ 1/09, 3 дугаар сарын 20-ны өдөр хуулийн төсөл татан авах тухай Засгийн газрын 1/23 дугаартай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулья аа.

Монгол Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал танаа Монгол Улсын Засгийн газар хуулийн төслийг татан авах тухай

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан Улсын Их Хуралд 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2026 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны

тэмдэглэлийг хавсаргав. Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар гэсэн байна.

Дараагийнх нь Монгол Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал танаа. Монгол Улсын Засгийн газар хуулийн төсөл татан авах тухай Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав. Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар гэсэн байна аа.

Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, хохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд 2025 оны 12 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг тус тус татан авсанд тооцлоо.

Ингээд үдээс хойших хуралдааныг үргэлжлүүлье.

Улсын Их Хурлын чуулганаар “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 3 сарын 19-ний өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн.

***“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхийг шийдвэрлэнэ.***

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн хуралд бичгээр хүсэлт тавьсан Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанаар оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Ирцийн санал хураалт явуулаадахъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Төхөөрөмжөө. Санал хураалтад бэлдье. Одоо орж байна. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Дахиад танилцуулаадахъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслүүдийг төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулган яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулах гэж байна. Яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт.

Гишүүд тогтоолын төслийг товчхон шиг сонсьё гэж байх шиг байна. Энхбаяр сайд нэг товчхон танилцуулаадах даа.

**Ж.Энхбаяр:** Гишүүдийнхээ амгаланг айлтгая. Ойрх Дорнодод болж байгаа үйл явдалтай холбоотойгоор газрын тос хийн бүтээгдэхүүний үнэ огцом өссөн. 57 доллар байсан нэг баррель нефть өнөөдөр 112 хүрсэн. Энэнтэй холбоотойгоор шатахууны үнэ нэмэгдэх нь тодорхой болсон. Бид сая үнэ зохицуулах зөвлөлтэй зөвлөлдөж байж дизель түлшинд литр тутамд 300 төгрөгийн нэмэлт хийсэн. Нийтдээ 1500 орчим төгрөгийн үнийн өсөлт үүсчихсэн. Тэгээд энэ үнийн өсөлтийг аль болох зөөлөн эдийн засагтай шингээж газардуулах инфляцад нөлөөлөхгүй байх талаас нь энэ бодлогын арга хэмжээнүүд авч байгаа юм. Тэгээд тэр хүрээндээ энэ нефть бүтээгдэхүүний гаалийн 5 хувийн татварыг өнөөдөр яаралтай журмаар орж тэглүүлье гэж байгаа юм. Ингэснээр бас шатахуун дээр 200 гаруй төгрөгийн дахин хөнгөлөлт хямдрал бас үүсгэх бололцоотой буюу үнийн өсөлтийг л зөөлрүүлэх арга хэмжээ авч байна.

Ер нь Засгийн газраас энэ эдийн засаг төсвийн хүндрэл үүссэн нөхцөлд авах хариу арга хэмжээнийхээ төлөвлөгөөг боловсруулаад бэлдчихсэн, өргөн барихад бэлэн болчихсон. Ингээд шинэ Ерөнхий сайд батлагдангуут танилцуулагдаад энэ яаралтай авах арга хэмжээний төсөл Их Хуралд орж ирнэ ээ. Тэр хүрээнд бүхий л нэг эдийн засаг төсвийг хамарсан бид нар бодлогын яаралтай зохицуулалттай арга хэмжээ авах ёстой. Энэ инфляцад зайлшгүй суурь үнэ энэ нефть бүтээгдэхүүнтэй холбоотойгоор өсөх нь тодорхой болчихоод байгаа юм. Өнөөдрийн өсөлт гэхэд л нэг инфляцад 17 орчим хувийн нөлөөлөл үзүүлэх болчихоод арга хэмжээг яаралтай хурдтай авах хэрэгтэй. Хохирол багатай даван туулах хэрэгтэй. Тэгэхийн тулд Их Хурал Засгийн газрын өргөн барьсан энэ тогтоомж хууль санаачилгуудыг маш сайн дэмжээд хамтран ажиллах, хурдтай л ажиллах ийм шаардлага үүсээд байгаа юм. Тэр хүрээнд оруулж байгаа асуудал. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад бэлдье. Түрүүн уг нь бэлдсэн юм. Санал хураалтад бэлдье. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 112 гишүүнээс 64 гишүүн оролцож, 57.1 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

14.41 цаг

Дараагийн асуудал.

***Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр дүгнэлт. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай.***

Ингээд Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр дүгнэлтийг хэлэлцье.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Бямбадоржийн Болдбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Болдбаатар:** Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр дүгнэлтийг танилцуулж байна аа. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 41.2 дахь заалт, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай, ҮХЦ-ийн хуралдааны танхим, 12 цаг.

Монгол Улсын ҮХЦ-ийн дунд суудлын хуралдааныг ҮХЦ-ийн дарга Баясгалан даргалж, ҮХЦ-ийн гишүүн Мөнхсайхан, Энхтуяа, Болдбаатар, илтгэгч Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Баяржаргалыг оролцуулан ҮХЦ-ийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Баярмагнай болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир нар оролцов.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1, 70 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

ҮХЦ-ийн 2025 оны 11 дүгээр дүгнэлт нь нийт 16 нүүр түүний үндэслэх хэсэг нь 8 нүүр болсон тул та бүхэнд дүгнэлтийн үндэслэх хэсгийг товчилж тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсоё оо.

Үндэслэл.

1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, 1.1 нутгийн өөрөө удирдах ёс гэж тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээний амьдралын асуудлыг иргэд өөрсдөө шууд эсхүл төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан бие даан шийдвэрлэж, эрхлэн хөтлөх, хариуцах зарчмыг ойлгоно оо.

Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэгт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай суурь асуудлыг зохицуулж нутгийн өөрөө удирдах ёсны үндсийг тогтоосон байна аа.

Мөн иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох, саналаа нууцаар гаргах зэрэг ардчилсан сонгуулийн зарчмыг тусгасан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуульд адил үйлчлэх бөгөөд эдгээр зарчим нь сонгогчдын хүсэл зоригийн чөлөөт илэрхийллийг баталгаажуулж, ардчилсан сонгууль явуулах суурь нөхцөлийг тогтоож өгдөг.

Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хэрвээ нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болохоор заасан. Улсын Их Хурал, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн найруулж батлахдаа тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бие даасан байдлыг баталгаажуулсан байна аа.

Түүнчлэн тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх, үүний төлөө хариуцлага хүлээх, мөн зүйлийн 12.1.5 дахь заалтад нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохгүй байх зэргээр засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг тодорхойлсон байна аа. Хурлын төлөөлөгч нь тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар улс төр өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээдийн эрх ашиг сонирхлыг илэрхийлэхгүй бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлагч мөн.

Иймээс тэрээр сонгогдох эрх эдлэхээс гадна тухайн орон нутгийн иргэдийг төлөөлөх үүрэг хүлээнэ. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад заасан төрийг удирдах хэрэг гэдэг нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотой өргөн хүрээтэй ойлголт бөгөөд олон улсын, үндэсний, бүсийн болон орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох агуулгатай. Тийм ч учраас Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх хэлбэрийг зааж, энэ хүрээнд баг, хорооны ИНХ-д иргэн саналын эрхтэй оролцох зэргээр шууд ардчиллыг, түүнчлэн аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-аар уламжлан төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэхээр зохицуулсан байна.

1.2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно гээд 40.1.2 дахь заалтад өөр шатны ИТХ-ын төлөөлөгч байх гэж заасан. Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт сум, дүүргийн хурлын төлөөлөгчид, нэр дэвшигч нь аймаг нийслэлийн хурлын төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно оо гэж хуульчилжээ. Энэ нь хурлын төлөөлөгч болон нэр дэвшигчтэй холбоотой өөр өөр харилцааг зохицуулж байгаа боловч 2 шатын хурд нэгэн зэрэг нэр дэвшиж сонгосон этгээд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтад зааснаар өөр шатын хуралд төлөөлөгчөөр хавсран ажиллах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Улсын Их Хурлын 2020 оны Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 45 дугаар тогтоолд заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийг уг хуульд нийцүүлэх арга хэмжээг өнөөг хүртэл аваагүй байна аа.

Иймд эдгээр зохицуулалтын зөрүүтэй байдлыг арилгаж хууль тогтоомжийн нийцлийг хангах үүднээс хурлын төлөөлөгчийг сонгох хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

## 2. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад нийцэх талаар

Сонгох сонгогдох эрх нь иргэний улс төрийн эрхийн бүрэлдэхүүн бөгөөд сонгох эрхийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн нийтээр эдлэх. Харин сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд тухайн албан тушаалын онцлогийг харгалзан тусгайлсан болзол шалгуурыг хуулиар тогтоож болохоор байна аа. Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлаж болох ч уул хязгаарлалт нь тухайн эрхийн цөмийг үл хөндөх, эрх зүйн тодорхой байдал тохирсон байх, ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг зарчимд нийцэхийг шаардах бөгөөд аль нэг зарчимд нийцээгүй бол тухайн хязгаарлалт үндсэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл болно.

2.1. Эрхийн цөмийг үл хөндөх зарчмыг хангасан эсэх. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх чөлөөний зарчим нь үндсэн эрхийг аль болох эдлүүлэхийг шаардах бөгөөд үндсэн эрхийг зайлшгүй тохиолдолд хязгаарлаж болох ч тэрхүү хязгаарлалт нь тухайн эрхийг бүхэлд нь буюу тус эрхийн цөмийг илт үгүйсгэхийг хориглоно оо. Өөрөөр хэлбэл үндсэн эрхэд тавих хязгаарлалт нь тухайн эрхийн цөмийг үл хөндсөн байх ёстой. Үндсэн эрхийн цөмийн тухай ойлголт нь төрийн оролцооноос хувь хүнийг ямагт хамгаалж чөлөөтэй байх хүрээг баталгаажуулсан гол агуулга буюу үндсэн эрх бүрд заавал хамгаалагдах бодит цөм бий гэдгийг илтгэх бөгөөд энэ гол агуулгыг ямар ч тохиолдолд хөндөхгүй. Үндсэн эрхийн хязгаарлалт тухайн эрхийн цөмийг хөндсөн нь тогтоогдвол тухайн эрхийг зөрчсөнд тооцох бөгөөд тохирсон байх зарчимд нийцсэн эсэхийг шалгах шаардлагагүй болно оо.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтад өөр шатны хурлын төлөөлөгч

байхыг хориглосон зохицуулалт нь иргэнийг аль нэг шатны хуралд нэр дэвших боломжийг бүрмөсөн хаасан гэж үзэх үндэслэлгүй байна аа. Иргэн 2 шатны хуралд төлөөлөгчөөр сонгогдож давхар ажиллах боломжгүй байх нь уг эрхийн мөн чанарыг үгүйсгэхгүй. Өөрөөр хэлбэл иргэн аль нэг шатын хурлын сонгуульд нэр дэвших эрх хадгалагдаж байгаа нь иргэний сонгогдох эрхийн цөмийг хөндөөгүй гэж үзэх үндэслэл болно оо.

## 2.2. Эрх зүйн тодорхой байдлын зарчмыг хангасан эсэх

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт нь өөр шатын хурлын төлөөлөгчийн албан тушаалыг хавсаргахыг хориглосон агуулгыг салаа утгагүйгээр ойлгомжтой илэрхийлж байх тул үүний үр дагаврыг сонгогч нэр дэвшигч нь урьдчилан таамаглаж зан үйлдээ нийцүүлэх боломжтой байна.

## 2.3 Тохирсон байх зарчмыг хангасан эсэх

Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тусгасан хууль дээдлэх болон шударга орчны зарчмын дагуу үндсэн эрхэд тавих хязгаарлалтад тохирсон байна аа. Уг зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай зайлшгүй тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангах ёстой.

2.3.1. Хурлын төлөөлөгч өөр шатын хурлын төлөөлөгчийн албан тушаалыг хавсрахыг хориглосон зохицуулалт нь тухайн шатын хурлын үйл ажиллагааны бие даасан байдал үр нөлөөг хангах, улмаар өөр өөр шатын хурлын чиг үүргийн зөрчилдөөн, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль ёсны зорилготой байх бөгөөд энэ зорилгод хүрэхэд уялдаатай байна аа.

Учир нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 41.2 дахь заалтыг үндэслэн нэг шатын хурлын төлөөлөгчөөр сонгогдсон бол нөгөө шатын хурлын төлөөлөгчөөс чөлөөлөх зэргээр уг заалтын хэрэгжилтийг хангаж байгаа нь холбогдох баримтаар нотлогдож байна аа.

Иймд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 41.2 дахь заалт нь хууль ёс зүйн зорилгод хүрэхэд уялдсан байх шалгуурыг хангаж байна.

2.3.2. Хурлын төлөөлөгч өөр шатын хурлын төлөөлөгчийн албан тушаалыг хавсаргахыг зөвшөөрөх эсвэл хориглох гэсэн 2 загвар байх боломжтой. Маргаан бүхий зохицуулалт нь хавсрахыг хориглох загвар мөн байх боловч аль нэг шатын хурлын төлөөлөгчөөр сонгогдох ажиллах боломжийг алдагдуулаагүй байна. Иймээс энэ хязгаарлалт нь дээр дурдсан зорилгод хүрэх үр дүнтэй арга хэмжээ төдийгүй сонгогдох эрхэд хамгийн бага халдсан хязгаарлалт байх тул хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй байх шалгуурыг хангасан байна.

2.3.3. Хурлын төлөөлөгч өөр шатын хурлын төлөөлөгчийн албан тушаалыг хавсаргахыг хориглосноор өөр өөр шатын хурлын чиг үүргийн зөрчилдөөн, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхэд чиглэж байх бөгөөд аль нэг шатын хуралд төлөөлөгчөөр сонгогдон ажиллахыг үгүйсгээгүй байна аа. Энэ нь өөр өөр шатын хурлын төлөөлөгчөөр давхар ажиллахыг зөвшөөрснөөс үүсэх сөрөг үр дагавраас

илүү чухал тул хууль ёсны зорилгыг хангаснаар хүрэх үр дүн болон хөндөгдөж байгаа эрхийг хэрэгжүүлэх шаардлага хоорондын тэнцвэрийг хангасан байна.

#### 2.4. Ялгаварлан гадуурхахгүй байх шатыг хангасан эсэх

Маргаан бүхий зохицуулалт нь өөр өөр шатын хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүргийн зөрчилдөөн, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх замаар ардчилсан шийдвэр гаргах үйл явцыг баталгаажуулахыг зорьж байх тул зохих үндэстэйд тооцогдоно оо.

Түүнчлэн өөр өөр шатын ИТХ-ын төлөөлөгч байхыг бүх шатын хурлын төлөөлөгчид адилхан хориглож мөн хурлын төлөөлөгч нар адилхан эрх зүйн байдалтай байх тул ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хангасан байна аа.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 41.2 дахь заалт нь бодитой үндэслэлтэй байх бөгөөд эрхийн цөмийг үл хөндөх, эрх зүйн тодорхой байдал тохирсон байх ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тус тус алдагдуулаагүй байх тул сонгогдох эрхийг зөрчсөн гэж үзэхээргүй байна.

3. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн нэг, 70 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт нийцсэн эсэх

3.1. Маргаан бүхий зохицуулалт нь хурлын төлөөлөгч өөр өөр шатын хурлын төлөөлөгч байхыг хориглох замаар иргэдийн төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхийг баталгаажуулахад чиглэсэн байх тул Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасанд нийцсэн байна.

3.2. Дээрхээс үзэхэд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт нь Үндсэн хуулийн 70 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасанд нийцсэн байна аа. Монгол Улсын үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн нэг дэх заалт ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтад өөр шатны ИТХ-ын төлөөлөгч байх гэсэн нь Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох хэрэгтэй. Төрийн байгууллагад сонгох сонгогдох эрхтэй 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

Далдугаар зүйлийн нэг дэх хэсэгт, Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасанд тус тус нийцсэн байна аа.

2.Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Баясгалан, гишүүд Мөнхсайхан, Энхтуяа, Болдбаатар, Батрагчаа анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болдбаатар танд баярлалаа.

Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлттэй холбогдуулан тухайн асуулгад холбон томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Алдаржавхлан гишүүнээр тасаллаа Туваан гишүүнээр тасаллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дугаар хэсэгт заасны дагуу Монгол Улсын ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд оруулсан тул уг асуудлыг өнөөдөр Төрийн байгуулалтын Байнгын хороо 15 цагт хэлэлцэхээр болсон тул Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг түр завсарлуулж байна аа.

15 цагаас Төрийн байгуулалтын Байнгын хороо хуралдана.

## ЗАВСАРЛАГА

Хуралдааныг эхлүүлье.

Гишүүд асуулт асууж, үг хэлэхээр нэрээ өгсөн байгаа.

Аюушийн Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Энэ 2025 оны цэцийн 11 дүгээр дүгнэлттэй холбоотой Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очироос энэ цэцийн дүгнэлттэй холбоотой асуулт асууя. Яах вэ энэ цэцийн дүгнэлт маань өөрөө ингээд 16 хуудас бүхий ийм материал. Тэгээд яалт ч үгүй би ингээд бүгдийг нь уншихаар бас дахиад л нэг ийм 2 үзүүртэй зүү шиг ийм дүгнэлт байгаад байгаа байхгүй юу. Тэгээд би Сандаг-Очир гишүүнээс яг тодорхой болгож хүний хэлээр ойлгомжтой болгож асуулт асуух гэсэн юм.

Нэгдүгээрт болохоор бид чинь орон нутгийн сонгууль дээр тухайн хүн суманд болон аймагтаа нэгэн зэрэг дэвшиж болохгүй гэж заасны дагуу нэр дэвшилтүүд явагдсан. Гэхдээ зарим хүмүүс бол нэг хуулийн давхцал байгаа учраас нэг хууль дээрээ болно гэж заачихсан, нөгөө хууль дээрээ болохгүй гээд заачихсан буюу яг одоо Сонгуулийн тухай хууль дээр нь бол нэр дэвшиж болно оо гээд гарчихсан нь нээлттэй байгаад байдаг.

Гэтэл нөгөө төрийн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 40.1.2 дээр болохлоор болохгүй гээд заагаад өгчихсөн байгаад байдаг. Ингээд ийм зөрчилтэй хуулийн улмаас тухайн суманд болон аймагтаа нэр дэвшсэн иргэдийн зүгээс гэдэг юм уу эсвэл бусад хүмүүсээс цэцэд хандсан байгаа юм. Яг энэ 40.1.2 чинь Үндсэн хууль зөрчсөн юм уу үгүй юм

уу гэдэг ийм шийдвэрийг гаргаж өгөөч. Дүгнэлтийг гаргаж өгөөч гэж. Гэтэл цэц маань сонсоход юу гэсэн бэ гэхээр 1 дүгээрт яах вэ 40.1.2 бол ердөөсөө Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэж нэг хэлчхээд, хуульд нийцсэн байна гэж нэг хэлчхээд нөгөө талдаа сумд болон аймагтаа сонгогдох нь бол бас нээлттэй эрх нь байна гээд ерөнхий дүгнэлттэй бас хэлчхэж байгаа байхгүй юу. Тэгээд яг аль нь юм бэ?

Тэгээд цэц юу гэж дүгнэсэн бэ гэхээр энэ хуулийн зохицуулалтаа энэ хоорондоо зөрчиж байгаа асуудлыг хооронд нь нийцүүлэх шаардлагатай байна гэхчхсэн байгаа. Тэгээд алийг нь алинд нь нийцүүлэх юм бэ гэдэг нь ердөө ингээд тодорхойгүй болчхоод байна. Тэгээд суманд болон аймагт зэрэг сонгогдчихсон төлөөлөгчдийн хувьд одоо яг яана гэсэн үг вэ гэдэг нь бас дахиад л нээлттэй. 2 хууль нь хоёулаа нэгэн зэрэг хүчин төгөлдөр байгаад байгаа байхгүй юу. Тэгээд одоо яг яах юм бэ гэдэг нь ингээд л дахиад л ойлгомжгүй нээлттэй үлдчихлээ.

Тэгээд одоо яг яах юм бэ? Энэ хуулийн зөрчлийг нь арилгах ёстой. Гэтэл хууль нөхөн үйлчлэхгүй учраас давхар сонгогдсон байгаа хүмүүс байна уу үгүй юу? Нөхөн сонгууль зарлагдсан юм уу үгүй юу? Ер нь энэ маргаантай асуудал хэрхэн яаж шийдвэрлэх юм бэ гэдэг нь одоо ингээд бас энэ цэцийн бөөрөнхий дүгнэлтээс болж дахиад ийм ойлгомжгүй үлдчихлээ. Тэгээд хүний хэлээр ойлгомжтой яг энэ асуудлыг яаж шийдвэрлэх вэ, ямар гаргалгаа байна вэ нэгэн зэрэг сонгогдсон хүмүүс байна уу үгүй юу гэдэг дээр хариулт хүсье ээ. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Цэц дээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан гишүүний хувьд Ариунзаяа гишүүний асуултад хариульъя. Зөв өө Ариунзаяа гишүүн асууж байгаа. Цэц бол Үндсэн хууль зөрчөөгүй байна гэдэг дүгнэлтийг гаргасан. Таны асууж байгаатай холбогдуулж аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулиар аймгийн хурлын төлөөлөгч, сумын иргэдийн Хурлын Төлөөлөгч шат шатын иргэдийн хуралд давхар нэр дэвшиж болох зохицуулалт байгаа. Харин Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд бол давхар шатын иргэдийн хуралд нэр дэвшихийг хориглочихсон байгаа. Тухайн үед 2024 онд Сонгуулийн хуульдаа орон нутгийн сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаад амжаагүй. Ингээд өнөөдөр энэ 2 хууль хоорондоо зөрчилтэй яваа юм аа. Энэ зөрчилтэй байдлаас үүдэж өнөөдрийн энэ маргаан асуудал үүссэн юм аа.

Тийм учраас Цэцийн дүгнэлт бол аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч бол аймагтаа сумын иргэдийн Хурлын Төлөөлөгч сумандаа бай гэдэг давхар сонгууль ажилтай байж болохгүй гэдэг ийм цэцийн дүгнэлтийн агуулга бол энэ юм аа. Үүнтэй холбоотойгоор 2024 оны 10 сард болсон орон нутгийн сонгуульд бас 60 гаруй мандат дээр ийм давхар сонгогдсон аймаг, нийслэл, сум, дүүрэг. Нийслэл дээр байхгүй. Аймаг сум дээр байгаа.

Өнөөдрийн энэ цэцийн маргаантай холбоотойгоор бас 40 гаруй тойрогт ийм нөхөн сонгууль хийгдэхээр энэ 6 сард хүлээгдэж байна. Ингээд СЕХ-оос бас бичиг ирчихсэн байгаа. 6 сарын 22-нд энэ аймаг нийслэлд давхар сонгогдчихсон сум аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч нар дээр нөхөн сонгууль явуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Харамсалтай нь бас сонгуулийн төсөв юм уу хүрэлцэхгүй байгаа учраас бас Засгийн газраас нөөц сангаас төсөв зарцуулж өгөөч гэдэг ийм

бичгийг ирүүлчихсэн. Ирэх 7 хоногт Төрийн байгуулалтын байнгын хороогоор энэ асуудлыг авч хэлэлцэнэ ээ.

Тэгэхээр ер нь бол аймаг, нийслэл, аймаг, сум, нийслэл, дүүрэгт давхар, орон нутгийн иргэдийн Хурлын өөрөө удирдах ёсны байгууллагад сонгуульт ажилтай байж болохгүй гэдэг ийм л хуулийг хэрэгжүүлэх болгоно.

Тэгэхээр бид нар Цэцийн дүгнэлттэй холбогдуулж цаашдаа аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын Сонгуулийн тухай хуулиа Нэгжийн хуульдаа нийцүүлж өөрчлөх хэрэгцээ шаардлага үүсэж байгаа гэдгийг бас хэлье. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

**Х.Булгантуяа:** Энэ хуулийн давхардлуудыг арилгах маш их чухал байгаад байгаа юм аа. Ер нь манай энэ гол гол хуулиуд дээр одоо сая ингээд л энэ хуулийн давхардлыг арилгахаас үүдээд нэлээн сая Сандаг-Очир дарга хэлж байна. Хэд хэдэн тойрог дээр дахин сонгууль явуулахаас өөр аргагүй боллоо гээд. Ингээд манай том хуульчид маань өөрснөө ажилласаар байгаад хоорондоо зөрчилтэй хууль батлаад улсын төсвөөс дахиж дахин сонгууль хийх энэ нөхцөл байдлыг бид нар өөрснөө үүсгэж байна. Бид нар өөрснөө үүсгэж байна. Орон нутаг дээр нийтдээ хэд орчим тойрог дээр 40 орчим тойрог дээр орон нутаг дээр дахин сонгууль хийх нь ээ.

Ингээд энэ үр дагавруудыг Цэцийн дүгнэлт бол үр дагаврыг арилгах асуудлыг хариуцдаггүй. Гэхдээ ер нь цаашид ингээд яах юм Улсын Их Хурлаас хоорондоо зөрчилтэй хуулиуд гаргаад дараагийн Цэцийн дүгнэлт дээр бас танилцуулах гэж байгаа нь Үндсэн хууль дээр заасан огнооноос зөрөөтэйгөөр Улсын Их Хурлын Дэгийн тухай хууль дээр заачихсан байгааг бас ҮХЦ танилцуулах гэж байгаа тийм ээ.

Тэгэхээр Улсын Их Хурал өөрөө ийм алдаа гаргачхаад дараа нь хуулийн зөрчил үүсгээд, дараа нь үүнээс үүдээд албан тушаалтнууд эс үгүй бол ингээд иргэдийн хурлаас сонгогдсон төлөөлөгч нар эс үгүй бол татвар төлөгчид өөрснөө хохироод суугаад байх юм уу? Энэ асуудлыг ер нь цаашид яаж шийдэх ёстой юм?

Дээрээс нь нэмээд тухайн үед Улсын Их Хурал өөрөө энэ хуулийг хэлэлцүүлэхгүй байж байгаад сонгууль дөхчихсэн байсан. Энэ хариуцлагыг ер нь ингээд цаашид хэн хариуцах ёстой юм бэ?

Улсын Их Хурлын дарга нь юм уу тухайн Байнгын хорооны дарга нь юм уу? Үүн дээр Цэцийн дүгнэлт дээр цаашид ийм алдаа дахиж гарахгүй байх. Сонгогдсон төлөөлөгчид эрх нь зөрчигдөхгүй байх, улсын төсвөөс дахиж ийм хохирол учрахгүй байх дээр ямар нэгэн гарц гаргалгаа дүгнэлт өгсөн зүйл байгаа юу гэдгийг 1 дүгээрт асууя Сандаг-Очир даргаас.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүн хариулъя.

**Ц.Сандаг-Очир:** Тиймээ Үндсэн хуультай зөрчилтэй мөн бусад хууль хоорондоо зөрчилтэй хуулиуд бас Улсын Их Хурлаас батлагдаж байгаагийн жишээнүүд бол сүүлийн үед тодорхой гарч байна. Энэний үр дагавраар цэцийн дүгнэлтүүд дандаа Үндсэн хууль зөрчсөн гэдэг ийм тогтоолууд гарч байгаа. Ганц

өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа энэ Үндсэн хуулийн нэгжийн хуулийн 40 дүгээр заалт зөрчөөгүй байна гэдэг ийм дүгнэлт гаргасан.

Таны ерөнхийдөө тогтож асууж байгаа асуулт бол Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуулиудын холбогдох хууль зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн. Яалт ч үгүй Үндсэн хууль дээр Ерөнхий сайдыг 3 хоногийн дараа хэлэлцэж 10 хоногийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ гэсэн байтал Их Хурлын тухай хуулиараа бид нар 7 хоногийн дараагаас хэлэлцэж эхэлж 10 хоногийн дотор гээд хэлэлцэх хугацааг 4 хоногоор бууруулчихсан байх жишээтэй. Энэ нь ингээд Үндсэн хууль зөрчихсөн гээд ингээд Цэцийн дүгнэлт гарчихсан. Одоо энэ Цэцийн дүгнэлтийн дараа хэлэлцэх тогтоол дээр бас энэ асуудал яригдана. Тэгээд тийм учраас бид нар бол ингээд бас Үндсэн хуультайгаа зөрчилтэй хуулиудыг баталсаар л байна. Тэгээд энэн дээр хаа хаанаа л анхаарах хэрэгтэй байна Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газар, холбогдох Байнгын хороод, Хяналт шалгалтын газар гээд ингээд ер нь бүх шатандаа л бас эрхэлж байгаа ажилдаа хайнга гэдэг юм уу зарим нэг цаг хугацааны асуудалд цаг хугацаа нь тулж саяын нэгжийн хууль нь Орон нутгийн сонгуулийн хуульд 6 сараас доошгүй хугацааны өмнө нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй гэсэн энэ хуульдаа захирагдаад л ингээд нэмэлт, өөрчлөлт оруулж амжаагүй. Их Хурлын гишүүд Улсын Их Хурлынхаа сонгуульд анхаараад орон нутгийнхаа сонгуулийг гээгдүүлээд нэмэлт, өөрчлөлтийг нь хийгээгүйгээс болоод нэгжийн хуульд нийцүүлээгүйгээс болоод ингээд ийм маргаан үүсчхэж байгаа юм.

Тэгээд үүнээс болоод өнөөдөр бас ингээд л тэрбум орчим төгрөгийн санхүүжилт нэхэгдээд сонгуулийн үйл ажиллагаанд шаардлагатай гээд Сонгуулийн хороо нэхээд л сууж байгаа шүү дээ.

Тэгээд ийм сөрөг үр дагаврууд гарч байна гарч байна. Тийм учраас цаашдаа бид нар аль болох ийм хуулийн хийдэлтэй, цоорхойтой Үндсэн хуулийн зөрчилтэй хууль батлахгүй байхыг л аль болох бид нар хаа хаанаа анхаарч ажиллах л хэрэгцээ шаардлага байна л гэж үзэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн алга байна байна.

**С.Эрдэнэбат:** Тийм ҮХЦ-ээс хууль зөрчөөгүй байна гэдэг дүгнэлт гаргасан юм шиг байна. Гэхдээ Монгол Улсын нутаг дэвсгэрийн онцлог, хүн амын тархай, бутархай байдал энэ зүйлийг харгалзаж байж, энэ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль болон иргэдийн хурлын сонгуулийн юунд авч үзэхгүй бол зарим сумд ялангуяа хязгаарлагдсан сум орон нутагт бол иргэдийн хуралд нэр дэвших кандидат тун цөөн. Үндсэндээ бараг хамгийн олон ах дүүтэй гэдэг юм уу ийм хүмүүсээ хүртэл нэг нь яаж ийж байгаад нэр дэвшүүлдэг. Тэр чинь муу сайн ч гэсэн бас Монгол Улсын төрийн бодлогыг хэрэгжүүлж байгаа анхан шатын нэгжийн байгууллагыг бол үндэсний энэ онцлогтой уялдуулж нийслэл аймаг өөр байж болох юм. Нийслэлийн хувьд бол. Сум, аймгийн хувьд бол сумын нэг төлөөлөгч аймагт давхар нэр дэвшээд гарч ирэхэд тодорхой квот гэдэг юм уу онцлог бүс нутаг хязгаарлагдсан байдаг гэдгийг нь харгалзаж үзэх талаар хүмүүс маш их санал тавиад байсан.

Тэгэхээр энийг нь хуулиудын 2 хуулийн хоорондын зөрчил байгаа байх. Цаашдаа ер нь өөрчлөх нийцүүлж шийдэх тал дээр ер нь Цэц дээр ямар асуудлууд

яригдсан бэ? Таны Их Хурлыг төлөөлж очсон гишүүний хувьд ямар санал байна вэ гэдгийг тодруулж асуумаар байна?

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Яах вэ ер нь өргөдөл гаргагчийн зүгээс бол миний сонгох сонгогдох эрхийг хааж байна гэж л гомдол гаргаж байгаа юм. Би орон нутгийнхаа сумын иргэдийн хуралд сонгогдох эрхтэй нөгөө талаараа бас аймгийн иргэдийн хуралдаа бас сонгогдох эрхтэй. Гэтэл одоо нэгжийн хуулиар хориглосноороо би зөвхөн нэг л аймагтаа л төлөөлөгч л байж болно гэвэл сонгууль сумынхаа иргэдийн хурлын төлөөлөгч байж болохгүй гэдэг энэ нь миний сонгогдох эрхийг зөрчиж байна гэдэг энэ асуудлыг өргөдөл гаргачихвал гол нь дурдсан байдаг.

Цэц бол энэ нь өөрөө нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага. Сонгогдох эрхийг зөрчөөгүй байна аа. Та бол орон нутгийнхаа сумын иргэдийн хуралд сонгогдчихсон. Сонгогдох эрхээ эдэлсэн байна Үндсэн хуулиар олгогдсон. Тэгээд та сонголтоо хий.

Хоёр шатын сонгуульд хоёуланд нь ялалт байгуулчихсан бол нэг бол аймгийн иргэдийн хурлын төлөөлөгчөө байна гэвэл сумынхаа иргэдийн хурлын төлөөлөгчөө өг, аль эсвэл сумынхаа хурлын төлөөлөгчөөр байна гэвэл аймгийнхаа иргэдийн төлөөлөгчийн хурлыг өг гэдэг ийм л сонголтыг хийх ийм байгаа юм.

Тийм учраас Үндсэн хуулиар олгогдсон таны сонгогдох эрхийг зөрчөөгүй байна гэж. Цэц ингэж үзсэн. Тэр 2 хууль хоорондоо зөрчилтэй байгаа нь үнэн. 2024 онд Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах өргөн баригдаж явж байгаад ингээд бас цаг хугацаанд хавчигдаад нэмэлт, өөрчлөлтөө оруулж чадаагүйгээс болоод өнөөдрийн энэ хууль хоорондын зөрчилтэй асуудал үүсчээд байгаа юм аа.

Тийм учраас бид нар цаашдаа нэгжийн хууль суурь хуульдаа нийцүүлж энэ орон нутгийн сонгуулийн хуулиа зайлшгүй энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулж зөрчөөгүй гэж гарсантай холбож бас цаашдаа нийцүүлж өөрчлөх засаж зөрчилгүй хууль болгох ийм ажлыг хийх шаардлага үүсэж байгаа гэдгийг бас хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Энэ Үндсэн хуулийн энэ 11 дүгээр дүгнэлтийг бүрэн хүлээн зөвшөөрч байна аа. Нэлээн бас ажлын хэсэг нь сайн ажилласан байна. Шинжээчийн дүгнэлт Ганзоригийн Хууль зүйн сургуулийн багшийн дүгнэлтийг бас үзлээ. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр ажилласан Сандаг-Очир гишүүний тайлбарыг бас харлаа. Ер нь сайн байна. Ерөнхий ер нь барих зарчим бол бид нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатын байгууллага нь шийдвэрлэж үл болно оо гэсэн Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2 дээр байгаа энэ л заалт. Энийг бид бүрэн хүлээн зөвшөөрч цаашдаа бас энэ асуудлыг бас дахиж ийм юм ярихгүйгээр их сайн ингээд гомдлын хүрээнд практикийн хүрээнд шийдчих нь зүйтэй гэж харж байгаа. Миний зүгээс бол 2 зүйлийг бас энэнтэй холбогдуулж холбогдох улсуудаас нь асууж бас яримаар байгаа юм.

Нэгдүгээрт энэ аймгийн төвд ойрхон байгаа сумдын асуудал. Би 2006, 2007 оны үеийн ЗГХЭГ-аас орон нутгийнх нь хэлтэс нь өөрсдөө явуулсан НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтарч явуулсан энэ судалгааг харж байхад бол 57 сум байна гэж байгаа юм.

Ерөөсөө 57 сум том хот юм уу аймгийн төвийн дэргэд ингээд байж байдаг. Тэгээд бараг хүнгүй болчихсон шахуу. Тэгээд хүүхдүүд нь аймгийн төвийнх нь сургуульд явчихдаг жишээтэй. Ийм сумд байгаа тохиолдолд бид бас энэ дээр цаашдаа ийм сумдыг аймгийн төвтэй нь нэгтгэх том одоодоо Багануурын дэргэд бол Баяндэлгэр гээд сум байж л байна шүү дээ. Тэрэн дээр таталцаад л тэр Баяндэлгэрт 1 зуугаадхан хүүхэдтэй Багануур луу бүгд яваад байдаг. Тэгэхээр ийм асуудлыгаа бас ингээд нэг шийдчих боломжийг хэрхэн харж байна вэ?

Хоёр дахь асуудал бол энэ Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль. Энэ нөхөд өө энэ хуулиа бас сайн хармаар байгаа шүү. Тэр хуулийг ингээд харахаар 16 дугаар зүйл дээр нь хот тосгоны зөвлөл гэж юм байгуулчихсан. Бүрэн эрх нь гээд нэг 10 эрх байж байгаа юм. Тэр нь өнөөгийн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн нутгийн өөрөө удирдах байгууллага буюу ИТХ-ын бүрэн эрх рүү халдчихсан ийм заалтуудтай. Хот төлөвлөлтийг нь авна, өмчийн эрхийг нь авна. Ийм заалтууд орчихсон ийм яваад байгаа. Бид үйлчлэлийг 1, 1 жилээр л хойшлуулаад байгаа болохоос биш энэ бас Үндсэн хуультай өөртэй нь нөгөө шууд холбогдох маргаан дагуулсан асуудал байгаа шүү.

Тэгэхээр зэрэг бид энэ төсвөө ярилцаж баталдаг, иргэдээсээ шууд сонгогддог. Өнөөдөр мажоритар тогтолцоогоор бүгд сонгогдож байгаа шүү дээ. Шууд ардчиллыг хэрэгжүүлдэг хорооны нийтийн хурал, багийн нийтийн хурал гэж байна. Ийм асуудал байсаар атал Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг өөрчлөхдөө бас энэ дээр нэлээн хариуцлагагүй хандчихсан гэж би бас өмнөх Улсын Их Хурлыг бас шүүмжлэх гээд байгаа юм. Энэ дээр бид бас энэ асуудлыг бас энэ дээр сайтар ярилцаж энэ асуудлыг ул үндсээр нь шийдэж жил жилээр үйлчлэлийг нь хоцроогоод яваад байх биш Үндсэн хуультай нийцүүлэх ийм шаардлагатай байгаа юм аа. Энэ дээр ҮХЦ ямар байр суурьтай байгаа юм? Мөн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандаг-Очир дарга энд бас ямар байр суурьтай байгаа юм? Энэ асуудлыг хөндөж асуумаар байгаа юм. Та бүхэн мэдэж байгаа 14 дагуул хоттой байна тэр нь хотын зөвлөлтэй байна. Тэгвэл Нийслэлийн төлөөлөгч юу хийх юм. Ийм асуудал үүсчхээд байгааг бид мэдэж байгаа ч гэсэн мэдээгүй юм шиг л царайлаад яваад байгаа шүү. Энийг бас бид хөндөж ярих цаг болсон гэдгийг хэлье.

Ингээд асуултдаа хариулт авъя. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Наранбаяр гишүүн 2 асуудал хөндөж байна. Тэгээд яг одоо хэлэлцэж байгаа Цэцийн дүгнэлттэй холбоогүй асуудал байна, хамааралгүй асуудал байна аа. Цэцийн дүгнэлттэй холбоотой. Цэцийн дүгнэлт бол шат шатны орон нутгийн төлөөллийн байгууллагад давхар сонгогдож болох эсэх асуудлыг дурдсан. Таны асуудал өөрөө нэгжийн асуудал хот байгуулалтын асуудал яриад явчихжээ. Тэгээд энийг цаашдаа бас жич ярихаас өөр аргагүй. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль бол мөн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу

энэ 6 сарын 1-ээс хэрэгжих ёстой. Ноднингийн 6 сарын 1-нд хэрэгжих байсан хойшлуулсан, ахиад энэ жил ахиад юу болохыг сайн мэдэхгүй байна. Яг хэлэлцэж байгаа асуудалтай хамааралгүй асуудал байна. Цаашдаа. Тэгээд энэ асуудлыг бас хэлэлцээд явах байх гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Энэ чинь хөл толгой нь олдохоо байгаад байна л даа. Тэгээд Цэцээс одоо шийдвэр гардаг тэрийг нь биелүүлдэг ч юм уу үгүй ч юм уу. Бас гайхаад л сууж л байна л даа. Тэгээд Цэцийн бага, дунд, их суудлын шийдвэрүүд, дүгнэлтүүд гардаг. Тэгээд энэ иргэдийн Хурлын Төлөөлөгчид чинь хаашаа юм бэ? Бүх юмыг давхар хийгээд байдаг тийм универсал улсууд юм уу? Ер нь иргэдээ төлөөлдөг юм уу? Эсвэл тэнд оччихоод ямар нэгэн албан тушаал авах гээд байж байдаг юм уу? Баахан л янз бүрийн менежерүүд янз бүрийн компанийн захирлууд байдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд тийм хүмүүс чинь иргэдээ төлөөлж чаддаг юм уу? Тэрийг Их Хурлаас та төлөөлөөд юу гэж яриу аа? Энийг бас их сонирхмоор байх юм.

Тэгээд ер нь МАН энэ хууль энэ цэц мэцийг ер нь юу болгоод байгаа юм бэ? Энэ Цэцийн шийдвэр чинь биелэгддэг юм уу, биелэгддэггүй юм уу? Энийг тэгээд 1 хэлчихсэн болоод ингээд өнгөрч байх ёстой юм уу? Энийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга танаас бас нэг сонсчихмоор байх юм. Харин та төлөөлөөд оччихсон байгаа гэдэг нь сайн байх. Бодвол Их Хурлын төлөөлөл очсон л байх л даа. Тэгээд энэ яах юм? Улаанбаатар хотоор дүүрэн менежерүүд байна шүү дээ. Тэр чинь иргэдийг төлөөлөөд байгаа юм уу эсвэл компанийн захирлууд юм уу энийгээ юу гэж үзээд байгаа юм? Тэр чинь худалдагдаад байгаа юм биш үү? Аймаг дээр ч гэсэн тийм л байна шүү дээ. Тэр аймгийн Засаг даргын л хариуцдаг барьдаг тэрний доор гүйж байдаг хэдэн улсууд л байдаг. Энэ чинь зөв юм уу, буруу юм уу. Саяхан бид нар л энэ Улсын Их Хурлын дарга нь намын дарга байж болохгүй гэдгийг тэгээд хаа хаанаа зөвшөөрөөд ингээд ийм болчихлоо.

Уул нь зөв л чиг рүүгээ яваад байх шиг байх юм. Энэ дээр та бүхний байр суурь ямар байгаа юм. Эсвэл бас энд хамаарахгүй асуудал энэ тэр гээд л төөрүүлээд л явах юм уу?

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Яг маргаан үүссэн асуудал дээр Улсын Их Хурлыг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байгаа. Тэгээд яг маргааныхаа хүрээнд л тайлбараа өгч байгаа юм. Таны асууж байгаа асуулт бол төлөөлөгч хүн давхар ажил албан тушаал хашаад байгаа асуудлыг та хөндөж байна. Цэцийн одоо хэлэлцэж байгаа дүгнэлт бол тухайн орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад шат шатын буюу аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч сумын иргэдийн Хурлын Төлөөлөгч давхар байж болох эсэх асуудал. Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгч, дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгч байж болох эсэх асуудлыг л ярьж байгаа юм. Тэгээд Цэц бол байж болохгүй. Нэгжийн хууль бол хууль зөрчөөгүй байна. Үндсэн хууль зөрчөөгүй байна гэдэг ийм л дүгнэлт гаргачхаад байна шүү дээ. Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн дүгнэлт гаргасан.

Тэгэхээр Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч нийслэлдээ л бай, дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгч дүүрэгтээ бай. Таны яриад байгаа шиг универсал юм шиг дүүрэгтээ, нийслэлдээ давхар сонгогдчихоод, сумдаа, аймагтаа

давхар сонгогдчихоод ингээд явдаг нь буруу байна л гэж ингэж Цэц үзсэн. Тийм учраас аймаг нь аймагтаа, сум нь сумдаа, нийслэл нь нийслэлдээ, дүүрэг нь дүүрэгтээ иргэдийн Хурлын Төлөөлөгчөө хийгээд яв гэдэг энэ нэгжийнхээ хуулийг барьж ажилла. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын орон нутгийн сонгуулийн хууль нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн байна аа.

Тийм учраас цаашдаа бид нар энэ Цэцийн дүгнэлттэй холбогдуулж энэ орон нутгийн Сонгуулийн хуулиа нэгжийн хуульдаа нийцүүлж өөрчлөх хэрэгцээ шаардлага байна. 2024 онд өөрчлөх гээд хууль нь өргөн баригдаж явж байгаад цаг хугацаанд шахагдаад нэмэлт, өөрчлөлтөө хийж чадаагүйгээс болоод өнөөдрийн энэ цэц дээр маргаан үүсчихсэн юм байна лээ л гэдгийг хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жуковын Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Би энэ Цэцийн гишүүнээс асуух уу? Сандаг-Очир даргаас асуух юм уу.

Энэ чинь ингэж хэж байгаа юм байна шүү дээ. Аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч аймагтаа байна. Сумын иргэдийн Хурлын Төлөөлөгч сумдаа байна гээд ингээд ерөнхийдөө шийдвэр гаргачхаж байгаа юм байна. Миний бодлоор бол сумын хурлын Төлөөлөгчөөс аймгийн Хурлыг сонгох ёстой юм. Нэгэнт ард түмний мандат авчихсан хүн сумаасаа аймгийн иргэдийн хурлыг явуулж нэг шатны сонгуулийг бид нар хэмнэх ёстой гэж би үздэг юм. Яагаад гэвэл аймгийн Хурлын Төлөөлөгч очоод сумынхаа тухай ярьдаг. Сумын хурлын Төлөөлөгч ч гэсэн сумынхаа тухай ярьдаг. Хоёулаа 1 зүйлийн тухай ярьдаг, хоёулаа 1 хүмүүстэй очиж уулздаг. Тийм давхардчихсан бүтэц бий болчихоод байгаа байхгүй юу 1992 оны Үндсэн хуулиар.

Тэгэхээр бид нар нэр бүхий гишүүд ерөнхийдөө энэ дээр бас хууль санаачилъя гэж бодож байгаа. Нийслэлийн иргэдийн хурлыг дүүргээс сонгодог болъё. Дүүргийн иргэдийн Хурлын Төлөөлөгч дотроос сонгодог болъё. Аймгийн иргэдийн хурлыг сумын хурлын төлөөлөгчөөр сонгож энэ нэг шатны сонгуулийг хэмнэж сумын хурлыг үнэ цэнтэй болгоё. Дүүргийн хурлыг үнэ цэнтэй болгоё. Тийшээ хүмүүс сонгогдож байгаад дараа нь аймгийн хуралд очдог болгох ёстой гэсэн ийм бид нар шинэчлэл рүү явах ёстой юм. Энийг хийхэд болохгүй болчих гээд байна л даа. Энэ Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтээр чинь. Сум нь сумдаа байх ёстой, аймаг нь аймагтаа байх ёстой гэх юм бол энэ их сонин болоод явчхаж байгаа юм.

Үндсэн хууль дээр зүгээр нийслэлийн орлогч, төлөөлөгчийг 4 жилээр сонгоно оо л гэж байгаа юм. Тэрнээс хаанаас сонгоно гэсэн үг байхгүй, хэн сонгоно оо гэсэн үг байхгүй 4 жилийн хугацаатай сонгоно оо л гэж байгаа юм. Бүр тэгж байгаа шүү Үндсэн хууль дээр.

Тэгэхээр Үндсэн хуулийнхаа зарчим энэ тэрийг цаашдаа ийм хуулийн шинэчлэл хийх юм бол яах юм бэ? ҮХЦ ахиад унагаах юм уу? Энэ дээр нэг хариулт өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Цэцийн дүгнэлтээс агуулга нь шал өөр асуудлууд яриад байна л даа. Тэр аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчийг сумын иргэдийн Хурлын

Төлөөлөгч сонгоно энэ тэр гэхээр ингээд орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг хэрхэн яаж байгуулах асуудлууд яриад. Энэ цэцийн маргаан, энэ цэцийн дүгнэлт чинь давхар иргэдийн Хурлын Төлөөлөгч байж болохыг хориглочихсон байгаа нэгжийн хууль нь өөрөө Үндсэн хуультай зөрчилдөөгүй байна л гэж үзсэн заалт шүү дээ. Харин Орон нутгийн сонгуулийн хууль нь өөрөө зөвшөөрчихсөн байгаа нь өөрөө Үндсэн хуультай зөрчилдсөн байна аа. Тийм учраас энэ нэгжийн хууль, орон нутгийн сонгуулийн хуулиа зайлшгүй бид нар өөрчлөх, засах, нэгжийн хуульдаа нийцүүлэх Үндсэн хуульдаа нийцүүлэх хэрэгцээ шаардлага байна. Таны наад ярьж байгаа асуудлууд цаашдаа орон нутгийн сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал яригдах үед хууль санаачлагчийнхаа эрхийн хүрээнд хэрхэн ямар хууль санаачлаад явах нь таны эрхийн асуудал аа.

Нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал бол нээлттэй байгаа. Тийм учраас тэр үед нь энэ асуудлуудаа яриад явах асуудал аа яг энэ Цэцийн дүгнэлттэй холбогдуулж бол энэ ярьж байгаа асуудал чинь хамаарахгүй асуудал байна л гэж би хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Харин энэ цэцийн дүгнэлт дээр ингээд биччихсэн байгаа байхгүй юу. Давхар байхыг хориглохгоод байна шүү дээ. Бидний шинэчлэлийн зорилго юу вэ гэвэл сумын хурлаас сонгох юм бол давхар болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Цэцийн дүгнэлт чинь давхар байхыг хориглож байна. Тэр цаашдаа ийм хуулийн төсөл энэ тэр санаачлаад явах юм бол хад мөргөх юм болов уу даа гэсэн ийм бодлоор л асууж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэвэгдоржийн Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Энэ дээрээс нэг 2, 3 асуулт байна. Энэ яг сонгогчдын өмнө бас хэлэхэд жоохон хэцүү л асуудал болчихоод байгаа юм. Одоо нөгөө Их Хурал тийм ээ. Нэмэлт, өөрчлөлтийг нь хийж чадаагүй цаг хугацааны юунд орчихсон гээд ингээд. Тэгэхээр энэ чинь бас л бид нарын л хариуцлага энд байгаа, ажиллаж байгаа, бас энэ хууль цалин аваад ажлаа хийж байгаа Тамгын газар энэ тэрийн бас асуудал болчихоод байгаа юм.

Тэгээд яах вэ нэгэнт ийм юм болчихсон. Тэгээд үүнийг дагаж гарч ирж байгаа үр дүн бас сөрөг үр дүнгүүд байна. Одоо ингээд л дахиад сонгууль зарлачихсан. 1 тэрбум гаран төгрөгийн санхүүжилт хэрэгтэй гээд энэ сонгуульд хэрэгтэй гээд. Дахиад л нөгөө нэг улс төржилт дахиад л нөгөө сонгууль ингээд болох гээд байна л даа.

Дээрээс нь энэ дээр энэ сонгогчдын эрх ашиг дахиад зөрчигдөж байна гэж би үзэж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр тухайн суманд нэг сум дээр жишээ авахад тухайн сум нь өмнө нь эрх барьж байсан намынхандаа хариуцлага тооцоод нөгөөдөх талд нь саналаа өгчхөж байгаа юм.

Тэгэнгүүт тэр санал өгсөн хүмүүс дотроос одоо манай аймгийн зарим сумдууд байна л даа, 2 нь аймагт, аймгийн 2 мандаттай газар 2 нь сонгогдчихөж байгаа юм. Тэгээд одоо том юм гээд аймгийнхаа тал руу аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчөө үлдээгээд сумнаасаа хасагдчихаар эргээд нөгөө сумд чинь нөгөө ялагдсан нэг суудлаар ялагдсан нам чинь иргэдийн хурал дээр олонх болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр нөгөө сонгогчдын өөрсдийн сольж ажлыг нь хийлгэх сайжруулах гэсэн энэ хүсэл зориг чинь ингээд бас л алга болчихоод байгаа юм. Тэгэхээр энийг цэц дээр бас яаж тооцсон юм оо. Энийг тооцоод нэгэнтээ л Их Хурал нь шийдэж чадаагүй нэмэлт, өөрчлөлтөө хийж чадаагүй байж байгаад ийм алдаа гаргачихсан юм чинь энийг бас цаг хугацааных нь хувьд нь яг тэр сонгогдсон хүмүүсийн буруу биш. Тэр чинь хуулиа баримтлаад л нэр дэвшээд л сонгогдсон. Тэгэхээр цаг хугацааг нь бас жоохон цааш нь харах ийм байсан юм болов уу гэж ингэж бодож байгаа юм.

Дээрээс нь энэ сумын иргэдийн Хурлын Төлөөлөгч хүн, аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч байж болно шүү дээ. Би тэгж боддог. Аймгийн төлөөлөгч аймгийнхаа хурал дээр аймгийн Засаг дарга аймгийн иргэдийн хурлын бодлого шийдвэр, хийх гэж байгаа ажил. Мөрийн хөтөлбөр энэ тэрээ мэдээллээ авч ирээд сумынхаа иргэдийн хурал дээр бас төлөөлөгчийнхөө хувиар суудаг. Тэндээ аймаг чинь тийшээ явах гэж байгаа юм байна лээ шүү. Нийслэл чинь тийм ажил хийх гэж байгаа юм байна лээ гэдэг мэдээллүүдийг өгөөд явах. Мэдээлэлжүүлэх тал дээрээ би бас эерэг гэж ингэж харж байгаа юм аа.

Тэгэхээр асуулт нь бол энэ яг тэр одоо тэр 1 суудлын зөрөөтэй ялж ялагдаад тэгээд нөгөөдөх нь ингээд сонголтоо хийгээд явчихсан чинь, нөгөө талд нь сонгогчдын санал өгч олонх болгоогүй тал энэ хуулийн дараа олонх болчихоод байгаа юм. Энэ асуудал яригдсан уу гэдэг ийм асуултыг асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэндийн Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Туваан гишүүний асуултад хариулъя. Яг цэц дээр ийм асуудал яригдаагүй. Гэхдээ гарсан дүгнэлттэй холбогдуулж тухайн 2 шатын сонгуульд нэр дэвшээд ялчихсан төлөөлөгчийн хувьд бол нэг шатынхаа иргэдийн Хурлын Төлөөлөгчийг сонгох ийм нөхцөл байдал үүсэж байгаа. Тэрний үр дагавраар цаана нь сумд яг ийм нөхцөл үүсэж байгаа юм байхыг үгүйсгэхгүй. Хэд хэдэн сум дээр бас ийм нэг хүний зөрөөтэй сонгуулийн үр дүн гарчихсан бүрэн эрхээ хэрэгжүүлээд явж байгаа тохиолдлууд байгаа юм байна лээ байгаа юм. Зүгээр би сонгуулийн хорооныхноос авсан мэдээллийн хүрээнд тэр сонгуулиуд дээр нөхөн дахин сонгууль болно оо гэсэн үг.

Яагаад гэхээр таны хэлдгээр давхар сонгогдчихсон хурлын төлөөлөгч дээд шатныхаа буюу аймгийнхаа иргэдийн хурлын төлөөлөгч байна гэдэг сонголтоо ер нь бол 100 хувь хийсэн юм байна лээ. Тэгэхээр цаана нь голцуу сумын иргэдийн хурал дээр дахин сонгуулиуд болох нөхцөл байдлууд бий болоод байгаа. Тэр давхар сонгогдсон төлөөлөгч нарын буруу биш. Харин энэ дээр Их Хурал Тамгын газар бид нар бас буруугаа хүлээн зөвшөөрөх ёстой. Өөрсдөө ийм хийдэлтэй, хууль зөрчилтэй, хууль баталчихсан. Янз бүрийн шалтаг шалтгаан ярьж байгаад ингэж байгаад хуулийг нь баталж өгөөгүйгээс болоод өнөөдөр бид нар дахин сонгууль түүнийг дагасан төсөв санхүүгийн асуудал ч хүртэл гарч яригдаж л байна.

Тийм учраас ийм сөрөг үр дагаврууд гарч байгаа гэдгийг хэлье. Тэгээд тийм цаашдаа бол одоо бид нар ийм зөрчилтэй гэдэг юм уу хууль батлахгүй байхыг л хаа хаанаа анхаарахгүй бол Булгантуяа гишүүний асуудал дээр ч хүртэл энэнээс л үүдэлтэй шүү дээ. Үндсэн хуулийн зөрчилтэй зүйл заалт Ерөнхий сайдыг огцруулахтай холбоотойгоор илтэд энэ хууль ийм байгаад ингээд л бид нар батлаад

л явчихсан ийм асуудал. Одоо ингээд л Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуульдаа Үндсэн хуульд нийцүүлж нэмэлт, өөрчлөлттэй хийх гээд л ингээд л явж байна. Араас нь хөөгөөд л.

Тэгээд илтэд ийм Үндсэн хуулийн зөрчилтэй хуулиудыг бид нар баталчхаад тэгээд нийгэмд ийм сөрөг үр дагавар үүсгэхээд төсөв санхүүгийн болоод үйл ажиллагааны улс төржилтийн магадгүй орон нутгийн эрх барих засаглал өөрчлөгдөх хэмжээний асуудал ч үүсэхийг үгүйсгэхгүй. Ийм асуудлууд бий. Энийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Одоо бид нар бушуухан нэгжийн хуульдаа нийцүүлж Үндсэн хуульдаа нийцүүлж орон нутгийнхаа сонгуулийн хуулийг өөрчилж засаад явахаас өөр аргагүй. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 11 дүгээр дүгнэлттэй танилцаж дууслаа.

16.10 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

### Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох асуудал

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч танилцуулна. Монгол Улсын Ерөнхийлөгч Ерөнхий сайдаар нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нарыг урьж байна аа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх танилцуулна аа. Хүрэлсүх таныг Ерөнхийлөгч таныг индэрт урьж байна.

**У.Хүрэлсүх:** Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд олонх суудал авсан МАН-аас Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх саналыг 2026 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид ирүүлсэн байна аа.

Монгол Улсын үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хуралд олонх суудал авсан нам эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч Улсын Их Хуралд оруулна гэж заасны дагуу Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд ийнхүү танилцуулж байна аа.

Ням-Осорын Учрал нь Улаанбаатар хотод төрсөн, 40 настай, эхнэр, 4 хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр 2007 онд Их засаг их сургуулийг эрх зүйч мэргэжлээр 2010 онд Их Британийн Лимкоквин технологийн их сургуулийн Лондон хотын салбар, Их Британийн Бухенхамын их сургуульд Бизнесийн удирдлага, олон улсын менежментийн магистр, 2013 онд ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын

Монгол Төвөд Будда судлалын институтэд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд эрх зүйч мэргэжилтэй байна аа.

Ням-Осорын Учрал нь 2010-2016 онд Роял Академи, Роял олон Улсын Дээд Сургуулийн Ерөнхий захирал, 2012-2014 онд Нийслэлийн МАН-ын хорооны Улс төрийн хэлтсийн дарга, 2012-оос 2016 онд БЗД-ийн ИТХ-ын төлөөлөгч, 2015 онд Монгол Улсын Шадар сайдын зөвлөх, 2016 онд Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн зөвлөх, 2016 оноос өнөөг хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020-2022 онд Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, 2022-2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, 2024-2025 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, ЗГХЭГ-ын дарга, 2025 онд Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, 2025-2026 онд Монгол Улсын Их Хурлын дарга, 2025 оны 11 дүгээр сараас МАН-ын даргын сонгуульт ажлыг давхар хашиж байна аа.

Ням-Осорын Учрал нь 2010 оноос хойш сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, улс төрийн болон төрийн хууль тогтоох байгууллага гүйцэтгэх засаглалын түвшинд ажилласан төрийн албаны туршлага, мэдлэгтэй бөгөөд төрийн удирдах албан тушаалд ажиллах бүрэн боломжтой хэмээн үзэж Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулахаар Улсын Их Хуралд санал болгож байна аа.

Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль холбогдох хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэхийг хүсэж байна аа.

Эрхэм гишүүдийн төрийн их ажилд өндөр амжилт хүсье ээ. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Ерөнхий сайдын томилох саналыг танилцуулсан Монгол Улсын Ерөнхийлөгч танд баярлалаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрхэм Монгол Улсын Ерөнхийлөгч өө, Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн болно оо.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт Ерөнхий сайдаар томилох саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг уншиж танилцуулсан Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир танд талархлаа.

Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Ням-Осорын Учрал хүрэлцэн ирсэн байна. Ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох асуудлаар хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Алтанхуягийн Үйлстөгөлдөр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Цэдэн-Ишийн Ганзориг Ерөнхийлөгчийн зөвлөх, Жаргалсайханы Мөнхболд Хуулийн бодлогын газрын дарга зэрэг хүмүүс ирсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Нэрсийг тасалъя. Батсуурь гишүүний нэр орж уу? Батсуурь гишүүнийх байна, нэрсээ тасалъя. Ирцээрээ Ренчиндоржийн Батболд гишүүн асуулт асууя.

**Р.Батболд:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Учрал гишүүнээс нэг асуулт л асууя.

Ер нь Занданшатар гишүүн Ерөнхий сайд бол ажлаа муу хийснээс юм уу эдийн засгийн байдал унаад эс үгүй бол нийгмийн тогтворгүй байдал үүсээд ч юм уу ингээд ажлаа өгсөн гэж ойлгохгүй байгаа. Цэвэр бас улс төрийн асуудал явсан байх аа. Тэгэхээр одоо яг үүн дээр үндэслээд та кабинетаа юу гэж бодож байгаа вэ? Гадаад байдал тун эгзэгтэй байгаа. Дотооддоо эдийн засгийн маш том цохилт ирэх ийм хүлээлттэй байгаа. Тэгэхээр энэ үед бас сайд нараа солиод гэдэг юм уу ингээд сандал суудлын хэрүүлтэй болгочих вий дээ гэдэг зүгээр эрсдэлтэй ийм асуудал байгаа. Тийм болохоор кабинетаа та ер нь юу гэж бодож байгаа вэ?

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** 2024 оны парламентын сонгуульд МАН олонх болж засгийн газраа байгуулсан. Тэгэхээр Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг Их хурлаар баталсан. Тухайн үед хамтарсан Засгийн газар байгуулагдсан учраас хамтарсан Засгийн газрыг бүрдүүлж байсан улс төрийн намуудын зорилтуудыг уялдуулаад 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан.

Тэгэхээр Оюун-Эрдэнэ даргын тэргүүлж байсан Засгийн газар ч тэр, Занданшатар даргын тэргүүлж байсан Засгийн газар ч тэр цаашдаа бол энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Их Хурлаас батлагдсан 4 жилийн хөтөлбөр. Тэгэхээр бид бол цаашдаа тухайн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын бүтцээ хэрхэн харах вэ гэдэг бол бидний өмнө бас томоохон сорилт болоод байна. Тэгэхээр миний хувьд бол би бас Батболд гишүүн тантай бас санал нэг байгаа. Өнгөрсөн хугацаанд улсын жилийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчийг цомхотгох зорилт тусгагдсан юм. Түүнтэй холбогдуулаад сая орон нутгаар иргэдтэй уулзаад төрийн албан хаагч нартай уулзахаар тэр 9 хувийн цомхотголд чинь чиг үүргийн шинжилгээ дутуу хийгдсэнээс болоод нүдээ олохгүй байна аа. Жишээ нь орон нутагт цаг уурын хэлтэс гээд байхад гол цаг уур ч 2 хүн нь халагдаад нөгөө жолооч, туслах гээд мэргэжлийн бус хүмүүс нь үлдчихсэн тохиолдлууд хүртэл байна аа. Үнэхээр экспортоор нэмэгдүүлье гэвэл зарим боомт дээр хүн хүчээ бүр нэмэх шаардлага байна, цомхотгох биш. Зарим газар бүр татан буулгах газрууд байна. Зарим газар бол 9 хувиа 20 хувийн хэмнэлт хийх ч бололцоо байна аа. Тэгэхээр чиг үүргийн шинжилгээ дутуу хийснээс болоод ингэж шууд тайрч хаяхаар энэ үр дүнд хүрэхгүй гэдэг зүйлийг хэлж байсан. Тэгээд бид бол өнгөрсөн хугацаанд энэ Үндсэн хуульд Засгийн газрын бүтэц өөрөө тусгагдаагүйгээс болоод Засгийн газар байгуулах болгондоо бүтцийн өөрчлөлт нэрийдлээр өмнөх ажлаа хийж байгаа төрийн албан хаагч нарыг цомхотгодог.

Тэгэхээр төрийн албан хаагч нарыг дахиж цомхотгож хэлмэгдүүлэх асуудал үүсэх вий гэдгээс болгоомжилж байгаа. Жишээ нь Засгийн газрын бүтэц дээрээ зарим яамдуудыг нийлүүлээд, зарим агентлагийг нийлүүлбэл нөгөө бүтцийн өөрчлөлт нэрийдлээр өөр нэртэй болоод жишээ нь Төрийн захиргаа удирдлагын газар гэж байлаа гэхэд тэрийг нь Стратеги төлөвлөлтийн газар ч гэдэг юм уу нэрлэхихэд шууд тэр газрын дарга нь нөгөө бүтэц өөрчилсөнтэй холбогдуулаад халагддаг. 2 яам нийллээ гэхэд 2 газар хоорондоо нийлчихээр дундаас нь цомхотгол хийгддэг.

Ингээд нөгөө шинэ сайд нь өөрөө тэр төрийн албыг бүхэлд нь шууд цомхотгох өмнөх ажлаа хийж байсан энгийн төрийн албан хаагчийг хаа нэгэн газраас хэн нэгнийг авчраад шууд томилоод ингээд нэг бөөн халаа сэлгээ болох юм руу явна гэдэгт би эмзэглэж байгаа юм. Энэ аюултай асуудал. Тэгээд нөгөө нүүлт суулт боллоо гэхэд л жишээ нь нэг яам нөгөө байрнаас нүүгээд нийллээ гэхэд л сүүлийн хэд хэдэн жишээнээс харахад зөвхөн нүүлт суудлынх нь зардал 50 сая төгрөг болчихоод байгаа юм л даа. Тэгээд энэ хаврыг нэг нүүдэл суудал болдог нэг халаа сэлгээ болдог шинэ сайд нарын багийг баахан бүрдүүлдэг нэг ийм байр суудал үүсчих вий дээ гэдгээс болгоомжилж байгаа юм. Харин нөгөө өнгөрсөн Засгийн газар өмнөх засгийн газрууд нөгөө бүтцийн өөрчлөлт хийгээгүй явсан учраас төрийн албан хаагч нар хуулиараа хамгаалагдаад байсан юм байна лээ.

Жишээ нь Занданшатар даргын Засгийн газар бол 3 үндэсний хороолол буулгасан болохоос биш өөр бүтцийн өөрчлөлт хийгээгүй. Ингээд яваад ирсэн.

Тийм учраас би томилогдсоныхоо дараа бас та бүхэнд байр сууриа бүрэн илэрхийлье. Өнөөдрийн байр суурь халаа сэлгээ гэхээсээ илүүтэйгээр асуудал тулгарчхаад байгааг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Шинэ Ерөнхий сайдыг эдийн засгийн ноцтой нөхцөл байдал угтаж байгаа Персийн булангийн дайнтай холбоотойгоор маш их том хүндрэлүүд бий болж байна. Аж үйлдвэрлэлд шаардагддаг нефть химийн бүтээгдэхүүний хомсдол Ормузын хоолойноос болж гацаж байгаа. Тийм учраас дэлхий даяараа аж үйлдвэрлэлийн нэлээн ноцтой хямрал бий болно. Нефть бүтээгдэхүүний аж үйлдвэрлэл энэ дэлхийн нийт үйлдвэрлэлийн чинь 6 хувьд байдаг. Энэтэй холбоотойгоор ажилгүйдэл дэлхий даяар бий болох юм байна.

Дээрээс нь хүнсний хомсдол бий болно. Яагаад гэвэл карбамид буюу нефть газаас гаргаж авдаг азотын бордоо энэний 3-ны 1 нь Ормузын хоолойгоор явдаг. Үүнээс болоод гацсантай холбоотойгоор энэ карбамидын үнэ 40 хувиар өссөн байгаа. Үүнээс шалтгаалж энэ бордоо хомстсонтой холбоотойгоор энэ хүнсний хямрал дэлхий даяар бий болох юм байна. Нефтийн үнэ 2 дахин өсөж байгаа. Жишээ нь өнгөрсөн сард 688 доллар байсан дизель түлшний үнэ яг энэ сард 1385 доллар болж яг нэг дахин өсчихсөн байна, нэг дахин. Үүнээс шалтгаалаад төмрийн хүдрийн олборлолт 40 хувиар, нүүрс 40 хувиар, зэс 30 хувиар, алтны олборлолт 20 хувиар шууд зардлыг нь өсгөөд ингээд явах нөхцөл байдал бий болж байна. Үүнтэй холбоотойгоор манайх уул уурхайн орон учраас энэ төсвийн орлого гацах багасах ийм нөхцөл байдал руу орж байна. Энэ жил дээрээс нь дахиад бид нар Оюу толгойн 2 тэрбум долларыг бид нар энэ 34 хувийнхаа төлбөр болох зээл олгох 2 тэрбум долларыг бид нар энэ жил төлнө.

Дээрээс нь 600 сая долларын хүүгийн төлбөр бас төлөх ёстой. Энэ асар том зардал байгаад байгаа юм. Энэ төлбөрийн тэнцэлд маш том хүндрэл авч ирнэ. Тэгээд орлого тасардаг, төлбөрийн тэнцэл мууддаг.

Тэгээд дээрээс нь энэ уул уурхайгаас олж байгаа орлого нь багасдаг. Энэнээс шалтгаалаад маш том асуудлууд бий болж байгаа. Ханш унана, бараа бүтээгдэхүүний үнэ өснө, долларын ханш, валютын ханш өснө. Шатахууны үнэ бас өссөнтэй холбоотойгоор ард иргэдийн хэрэглээ тэр бүх зүйлд өснө. Уур бухимдал бий болно. Энэ бүх зүйлээс болоод өнөөдөр энэ асуудал чинь нэлээн хүндрээд ирэх юм байна аа.

Тийм ч учраас энэ хүндрэлийг харсан учраас эдийн засагч Ерөнхий сайд Занданшатар нь ер нь энэнээсээ холдъё гэж бодсон байх. Ийм л асуудлууд бий болох нь. Тэгээд энэ дээр ямар юм шийдэх юм бэ?

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Бодит нөхцөл байдлыг Пүрэвдорж гишүүн их тодорхой хэллээ. Энэ олон улсын мөргөлдөөн эдийн засагт үүсэж байгаа эрсдэл бол шууд тоон дээр илэрч байгааг та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр би бас Эдийн засаг хөгжлийн сайд байсан. Тухайн үед бас төсвийн хүрээ оруулж ирж байх цаг үеэ санаж байна л даа. Жишээ нь дэлхийн зах зээл дээрх нэг баррель газрын тосны үнэ 2 дугаар сард л 67 байсан шүү дээ. Өнөөдөр 110, 112 бараг болчихоод байна шүү дээ. Тэгээд цаашдаа бол энэ оны төгсгөл хүртэл 150-аас 200 ам.доллар хүртэл өсөхөөр ийм байна нөхцөл байдал.

Тэгэхээр газрын тосны бүтээгдэхүүний үнэ өснө өө гэдэг бол үнийн өсөлтийг хөөрөгдөнө. Тэгэхээр энэ нөгөө бензин шатахууны үнэ чинь өөрөө бүх юмны үнэ. Тийм учраас бол яг энэ ковидын нөхцөл байдал шиг биднийг томоохон сорилт

хүлээж байна. Тэгэхээр ийм сорилтын үед илүү хурдтай ажиллах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгаа юм. Тэгэхээр дэлхийн улс орнууд бол энэ үндэсний сөрөн тэсвэрлэх чадвараа бэхжүүлэх зорилгоор ийм шуурхай штабуудыг байгуулж ийм онцгой тохиолдол гэж үзээд зарим улс оронд хүртэл онц байдал хүртэл тогтоогоод ажиллаж байгаа ийм цаг үед бас Ерөнхий сайдын энэ өндөр хариуцлагатай албыг авах үүргийг бас олонхыг бүрдүүлсэн манай намын нөхөд маань намын даргын хувьд ажиллаач гэдэг ийм л үүрэг даалгавар өгсөн.

Тэгэхээр энэ сорилтыг бол давж туулахын тулд ажиллана. Би өнгөрсөн хугацаанд бол Их Хурлын даргаар ажиллаж байхдаа ОХУ-д БНХАУ-д айлчлал хийж бас тодорхой асуудлуудыг бас байр сууриа илэрхийлж байсан. Тэгэхээр нийлүүлэлтийг бол зогсоохгүй. Хятадад хүртэл сүүлд би очиход говийн бүс дээр энэ томоохон төслүүдийг хэрэгжүүлж байгаа учраас шатахуун хангалтыг Хятадаас нэг 30 хувийг нь шийдээч, нийлүүлэлтийг огт битгий таслаач гэдэг байр суурийг бол бас тодорхой илэрхийлсэн. Одоо Ерөнхий сайдын хувиар бол энэ 2 хөрштэй энэ хэлэлцээрүүдийг үргэлжлүүлнэ. ОХУ-даа бол энэ хэлэлцээрээ үргэлжлүүлээд явна.

Мэдээж иргэдээ үнийн өсөлтөөс хамгаалахын тулд бол Засгийн газраас шаардлагатай гэж үл үзвэл зарим салбарт тодорхой татааснуудыг өгөх үнийн өсөлттэй холбоотой ААН-үүдийн эргэлтийн хөрөнгө дутагдаж болзошгүй байгаа бол эдийн засгаа илүү халаах бодлого хэрэгжүүлнэ.

Тийм учраас зарим эдийн засгийг халаах ажлын байр нэмэгдүүлэх, өрхийн орлого нэмэгдүүлэх салбарууд дээр Засгийн газраас баталгаа гаргая. Эргэлтийн хөрөнгийн зээлийг нэмэгдүүлэх чиглэл рүү анхааръя гэдэг ийм бодолтой байна. Мэдээж Их Хурлын даргаар ажиллаж байхад бол Монголбанкнаас энэ шатахуун импортлогч нарт зориулж тусгай ханшаар валют олгох эсвэл нөгөө форвард хэлэлцээр хийх замаар ханшийн савлагаанаас хамгаалах асуудлууд дээр бид нэлээдгүй ярилцсан. Тэгээд одоо Их Хурал дээр бол Засгийн газраас өргөн мэдүүлчхээд байгаа хууль бол орж ирж байгаа.

Тэгэхээр энэ бол энгийн бусад энгийн цаг үе шиг ерөөсөө биш. Тэгэхээр ер нь бид нар нөгөө сөрөг хүчинтэйгээ биш асуудалтай шууд нүүр тулж байгаа юм. Тийм учраас бидний хамтын ажиллагаа бол би чухал байна гэж харж байна. Ялангуяа манай инфляц 2 оронтой тоонд хүрээгүй гэдэг мөртөө 430 бараа бүтээгдэхүүнээс чинь 10 хүрэхгүй бараа бүтээгдэхүүний үнэ л өрхийн орлогод шууд нөлөөлж байгаа шүү дээ.

Тийм учраас өргөн хэрэглээний бараа тэр дотроо эм тариа, эмнэлгийн хэрэгсэл, тэгээд л хүнс шатахуун гээд тодорхой өрхийн амьдралд шууд нөлөөлж байгаа бараа бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлтөөс иргэдийг хамгаалах арга хэмжээнүүдийг авна. Ялангуяа эм эмнэлгийн хэрэгсэл дээр бол шууд ханган нийлүүлэгчээс гэрээ хэлцэл хийх асуудлыг өмнө нь Эдийн засгийн сайд байхдаа ч явуулж байсан. Тэгэхээр энэ ажлаа бол үргэлжлүүлнэ. Тэгээд хурдтай шуурхай л ажиллаж гарна гэдгийг хэлье. Цогц арга хэмжээгээ танилцуулна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэмж тодруулна.

**Б.Пүрэвдорж:** Тэгэх дээр Их Хурлын дарга байж байхад ярьдаг. Одоо бол хийдэг ажил дээр очиж байгаа шүү дээ. Сая ярьж байгаа юман дотор чинь худлаа зүйл байна. Өөрөөр хэлбэл БНХАУ бол Венесуэлээс өдөрт 500 мянган тонн, Иранаас 1 сая 500 мянган тонн буюу өдөрт 2 сая тонныг авдаг байхгүй юу даа. Тэр нь хоёулаа пийлдчихсэн. Одоо тэнд бол маш их шатахууны өөрсдийнх нь асуудалтай байгаа. Жишээ нь өнгөрсөн сард Ховд аймгийн Ярантын боомтоор шатахуун импортолдог байж байгаад бүгдийг нь нам зогсоочихсон байгаа. Тэгэхээр бид нар юу байдаг юм тэндээс эндээс авна гэж ярьж байхын оронд авдаг газраасаа илүү харилцаагаа сайжруулаад тэндээсээ баталгаатай авах тухай юм бодох хэрэгтэй. Яг энэ шатахууны асуудал дээр манай Жангабыл гишүүн сайн зөвлөж өгөөрэй. Ер нь бол ам ажлын зөрөө байж болохгүй шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Их Хурлын даргаар 4 сар хүрэхгүй хугацаанд л ажиллалаа л даа. Өнгөрсөн хугацаанд бол Засгийн газарт бас 3 удаа гүйцэтгэх засаглалд ажилласан учраас харьцангуй бас ажил шинэдэхгүй байх гэж бодож байгаа. Гол нь хамтын ажиллагаа бол их чухал. Тэгэхээр би бас тантай санал нэг байна. ОХУ-ын Роснефтьтэй байгуулсан урт хугацааны гэрээний дагуу үнийг нь Сингапурын биржийн дунджаар биш тогтмол үнээр тооцох хэлэлцээрийг ажлаа аваад эхний 3 сарын хугацаанд эрчимжүүлэх чиглэлээр ажиллана.

Тийм учраас энэ дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдыг өнгөрсөн хугацаанд бас яриа хэлцлүүд нь явж байгаа юм байна лээ. Тэгэхээр би ОХУ-д ажиллахдаа ч гэсэн тухайн үед энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд бас хамт энэ айлчлалын бүрэлдэхүүнд явсан. Тэгээд холбогдох хүмүүстээ бол энэ тодорхой саналуудыг бол тавьсан. Тухайн үед бол мэдээж парламентын даргын хувиар уулзалтуудыг хийсэн. Одоо бол гүйцэтгэх засаглалын тэргүүний хувиар ажлаа шахаж бол эхний 3 сард эрчимжүүлнэ гэдгээ хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Одсүрэнгийн. Номинчимэг гишүүн Учрал даргад бас амжилт хүсье ажилд нь. Энэ өмнөх Занданшатар даргын Засгийн газар байгуулагдаж байх үед хэлж байсан үгийг би бас дахин хэлмээр байгаа. Ер нь ард олон бидний сонгосон иргэд бол гуравхан л энгийн зүйлийг биднээс хүсдэг. Элбэг дэлбэг хангалуун амьдармаар байна эдийн засгийн хувьд, эрүүл аюулгүй орчинд амьдармаар байна. Эрүүл мэндийн үйлчилгээ нь сайн, утаа түгжрэл багатай ийм орчинд амьдармаар байна.

Гуравдугаарт шударга нийгэмд бас амьдармаар байна аа. Хуулийн засаглал үйлчилдэг хүний эрх шударга ёс үйлчилдэг ийм нийгэмд амьдармаар байна гэдэг ийм л 3 юмыг ер нь хүсдэг.

Тэгээд энэ 3 зүйлийн нэг зангилаа болсон зүйл бол ялангуяа эдийн засаг болон энэ шударга ёсны зангилаан дээр бид нарын энэ парламент дээр хамгийн чухал анхаарах Засгийн газрын ч гэсэн анхаарах ажил бол энэ төрийн өмч, төрийн болон орон нутгийн өмч болон төрийн орон нутгийн өмчит компанийн асуудал байгаа. Учрал дарга бол яг энийг ЗГХЭГ-ын дарга байхдаа манлайлж энэ хуулийг бол Улсын Их Хуралд оруулж ирсэн. Улсын Их Хурал энэ дээр ажиллаж байгаа.

Тэгээд Занданшатар даргын кабинет ч гэсэн яг энэ ТӨК-удыг цэгцлэх, бүтээмж менежментийг нь сайжруулах талаар нэлээн далайцтай үйл

ажиллагаануудыг эхлүүлээд бас явж байсан гэж хардаг. Тэгээд энэ эдийн засгийн хувьд төрийн өмч ТӨК-удын асуудал бол ерөөсөө л хувийн бизнесийн орон зай руу хэт орж бизнесийн хувьд энд хувийн хэвшлийг дэмжихгүй, өрсөлдөөнийг боомилсон ийм үйл ажиллагаа байгаа.

Нөгөө талаараа шударга ёсны хувьд энэ ТӨК-уд бол ерөөсөө л авлига хээл хахууль, цавчаа одоо юу гэдэг юм бүхэл болохгүй одоо нийгэмд үүсээд байгаа шударга ёсны асуудал энд бас ул суурь нь болоод байгаа. Цаашилбал энэ намын санхүүжилт сонгуульд оролцох төрийн нөөц бололцоог ашиглах гэх мэт энэ асуудлууд бол энд бөөгнөрч байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр Учрал дарга энэ хууль эрх зүйн реформыг ЗГХЭГ-ын дарга байхдаа хийж байсан. Та Засгийн газар дээр очихоороо ялангуяа энэ ТӨК-удын засаглал, менежментийг сайжруулах, нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах асуудлууд дээр ямар бодлого барьж, яаж ажиллах вэ гэдэг дээр бодлогоо бас хэлнэ үү гэж хүсэж байна аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** ТӨК төсвийн эдийн засагтай харьцаа 61 хувьд хүрсэн байна. Нэг ёсондоо бол хувийн хэвшил төрийн оролцоогүйгээр төртэй хамааралгүйгээр бизнесээ явуулах тийм нөхцөл бололцоо алга. Тухайн үед намайг Эдийн засаг, хөгжлийн сайд байхад төсвийн хүрээ оруулж ирж байхад. ДНБ тэнцвэржүүлсэн орлогын харьцааг 37 хувь байсныг тухайн үед 30 хувь болгож бууруулж байсан. Энэ харьцаа 28-д хүрэх ёстой. Энд татварын шинэчлэл хийгдэх ёстой. Тэгж байж тэр орон зайд өөрөө хувийн хэвшил ажиллах орон зайг бид нар төсвийн хүрээн дээр оруулж ирсэн.

Тэгэхээр эндээс харахад юу вэ гэхээр ТӨК-ийн тоо ТӨК-ийн хувийн хэвшилтэй ажиллаж байгаа оролцоо бол асар их өндөр. Тэгээд энэ бол тэгээд дуусдаггүй яриа болчихсон байна. Энэ дуусдаггүй яриагаа дуусгая л гэж би бодож байгаа. Өнгөрсөн хугацаанд бол Хэрэг эрхлэхийн дарга байхад энэ ТӨК-удыг хариуцаж байхдаа ТӨК-ийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль, Нийтийн өмчийн хууль 2-ыг Их Хуралд өргөн мэдүүлчихсэн. Засгийн газар дээр ахалж ажиллаад боловсруулж өргөн мэдүүлсэн. Одоо энэ хуулиудын хэлэлцэх эсэхийг шийдчихсэн байгаа.

Тэгэхээр Их Хурлын гишүүд та бүхнийг энэ хуулийг хаврын чуулганаар баталж өгөөсэй гэж хүсэж байна. Баталсны дараа ТӨК-уд болоод орон нутгийн өмчит компаниудаар баримтлах үндсэн чиглэлийг Засгийн газар хуулиараа оруулж ирэх юм. Хуулиараа оруулж ирэхэд хэдэн сонголт байгаа юм. Нэгтгэх, өөрчлөх, зохион байгуулах, татан буулгах эсвэл нээлттэй болгох. Нээлттэй болгохын тулд тухайн үед би бас хэлж байсан. Энэ хууль дээр одоо жишээ нь нээлттэй болгохын тулд зардал шийдэх ёстой. Нөгөө андрайтер авах нөгөө бирж дээрээ гаргах бэлтгэлийг хангахад зардал шийдэх ёстой. Үгүй бол энэ компаниудын чинь үнэлгээг хүртэл хийлгэж чадахгүй байна аа.

Тийм учраас хөрөнгө оруулалтын хуулиуд дээрээ өөрчлөлт оруулах шаардлага байна. Зарим хууль дээр. Жишээ нь бирж дээр гаргахын тулд нөгөө олон улсын аудит оруулах үнэлгээ хийлгэхийг чинь зөвхөн Монгол компани хийнэ гэдэг энэ хуулийн гацаагаа шийдэхгүй бол бирж дээр гараад өрсөлдөөн нэмэгдэхэд

бололцоо байхгүй байна гэж. Тэгэхээр ийм нэг эрх зүйн ийм шинэчлэл хийх ёстой байгаа юм. Тэгж байж илүү амьтай үргэлжилнэ.

Тэгэхээр нөгөө Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг дагасан бараг 30 гаруй хууль боловсруулж тухайн үед Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Одоо тэр хуулийг АН-ын бүлэг Их Хурлын гишүүд нэгдээд тэр хуулиа оруулчихвал бүгдээрээ нэг хамт байж байгаад энэ 126-уулаа сууж байгаад энэ дуусдаггүй яриагаа нэг дуусгачихъя.

Тэгвэл тэгээд Эдийн засгийн эрх чөлөөний хууль, нөгөө нэг ТӨК-ийн хууль хэлэлцэх эсэх нь байгаа. Тэрийг Гантөмөр дарга бас тухайн үед Эдийн засгийн сайд байсан учраас бид нар өргөн мэдүүлсэн шүү дээ. Тэрнээс чинь хойш бараг жил болох гэж байна. Тэгэхээр энэ хуулиа гаргачихъя. Гүйцэтгэх засаглалын тэргүүнээр хэрвээ та бүхэн дэмжвэл би мэдээж ТӨК-ийг нэгтгэх нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, нээлттэй болгох дээр үргэлж дэмжинэ.

Тийм учраас эрх зүйн орчны хувьд бүрдүүлээд нэг чиглэл оруулж ирээд шийдээд Их Хурлаараа бодлогоо гаргаад явчих нь илүү зохимжтой юм аа. Гэхдээ энэ чинь бүх компанийг хэрэггүй гэж үзэхгүй шүү дээ. Тэгэхээр энийг би бодлогыг нь тэр яг аль аль компани дээр ямар зохион байгуулалт хийх вэ гэдэг бодлогыг өөрөө оруулж ирнэ. Энэ бол өнгөрсөн хугацаанд миний судалсан хийж байсан ажлууд байгаа учраас шинэ кабинет яг аль аль компани дээр ямар арга хэмжээ авах вэ гэдгээ оруулж ирнэ. Тэгээд Номинчимэг гишүүн боо бас энэ хуулийг ажлын хэсгийг ахалж байгаа.

Тэгээд Номинчимэг гишүүн, Сайнзориг гишүүн, Үүрийнтуяа гишүүн нар энэ хуулиа хаврын чуулганаар батлаад хурдан хугацаанд өгвөл Засгийн газраас бол оруулж ирэхэд бэлэн шүү. Үүнийг үргэлж дэмжинэ гэдгээ хэлье ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** 2 асуулт байна.

Нэгдүгээрт, өнөөдөр Улсын Их Хурлын чуулганаар Засгийн газраас өргөн барьсан 2 хуулийг татсан байгаа. Эдийн засгийн өршөөлийн тухай хууль, 2 дахь нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг татсан. Тэгээд энэ 2 хуулийг татаж сайжруулах төлөвлөгөөтэй татав уу эсвэл өмнөх Ерөнхий сайдын шийдвэрээр энэ хуулийг татав уу гэдэг энэ дээр асуулт байна. Тэгээд энэтэй уялдуулаад энэ 2 хууль маань бас Зөвшөөрлийн тухай хуультай нэлээн уялдана. Эдийн засагт төрийн оролцож байгаа хамгийн том хэлбэрүүдийн нэг бол Зөвшөөрлийн тухай хууль байгаа. Тэгээд Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилттэй энэ хуулийн төсөлтэй ажлын хэсгийн ахалж байгаагийн хувьд бол зөвшөөрөл олгож байгаа 4 зуугаад зөвшөөрөл тус бүрээр нь ярилцсан. Тэгэхээр зөвшөөрөл олгогч байгууллагуудын хувьд бол бас хуулийг буруугаар хэрэглэдэг, дутуу, тайлбарладаг, хуульд шаардаагүй зүйлүүдийг шаарддаг ийм зүйлүүд нэлээн анзаарагдаж байгаа.

Тэгэхээр энэтэй холбогдуулаад цахимжуулах зайлшгүй шаардлагууд байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч гэсэн төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулна гээд. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яаман дээр болон license.mn гээд цахим платформ бий болчихсон байхад зарим яамдууд одоо болтол энийг ашиглахгүй, зориуд санаатайгаар, зарим нь бүүр

АТГ-аас хүртэл энийгээ цахим болгоо гэдэг шаардлагуудыг тавьж байна. Энэ нь өөрөө эрсдэлийг нэмэгдүүлж байна гээд байгаа мөртөө асуудлаа шийдэхгүй байна. Тэгэхээр энэ чиглэлээр та Ерөнхий сайд болоод яг энэ цахимжуулалт дээр энэ яамдуудыг хэр шахах вэ? Энийг тодорхой хугацаа тавиад шахаад энэ хуулийн хэрэгжилтийг илүү хялбар болгох шаардлага харагдаж байгаа.

Хоёрдугаарт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг сая өнөөдөр Хууль зүй болон Эдийн засгийн байнгын хороо хамтарсан Байнгын хороогоор хэлэлцсэн. Тэгэхээр энэ дээр нэг зорилт нь болохоор хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх харьцааг зорилтот түвшин 76.2 байсныг одоо энэ онд 77 болгоноо гэж. 2025 онд 77 болгоно гэж зорилтот түвшин тавьсан боловч энийгээ буулгаад суурь түвшнээсээ буулгаад 72.5 болгосон байгаа юм. Энэ нь нөгөө талаасаа бас төсвийн зарлагыг 2023 онд төсвийн ДНБ-ий 32-той тэнцэх байсан зардлыг тэнцэж байсан. Зардлыг шинэ Засгийн газар 38.3 хувь болгож жишээлбэл Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын үед нэмэгдүүлж байсныг энэ 2025 онд 35.1 болгож ингээд бууруулсан байгаа юм.

Тэгээд МАН-ын мөрийн хөтөлбөр дээр болохоор төсвийн зарлагыг ДНБ-ий 25 хувьд хүргэнэ гээд заачихсан байгаа.

Тэгэхээр энэ чиглэл рүүгээ явах уу, хэд хүргэж чадах вэ гэдэг ийм 2 хүсэлт байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Стандарт тохирлын үнэлгээний хууль бол Зөвшөөрлийн хуультай яг таг уялдах ёстой. Яагаад вэ гэвэл Зөвшөөрлийн хуулиар 110 зөвшөөрөл мэргэжлийн холбоонд шилжих, тусгай зөвшөөрөл бараг 20 орчмоор багасах. Энгийн зөвшөөрлийн тоо нэмэгдэх тэгээд түүнд бичигдээгүй бусад төрлийн үйл ажиллагааг зөвшөөрөлд тооцохгүй. Бусад бүх төрлийн үйл ажиллагааг чөлөөтэй хэрэглэх бололцоо бүрдүүлнэ. Тэгэхээр Стандарт тохирлын үнэлгээний хууль бол өөрөө нөгөө нэг үндсэн стандарт тохирлын үнэлгээнүүдийг нь тавьж байж хүн амын эрүүл ахуй аюулгүй байдалд бусад тэр нөгөө аюулгүй байдлыг хангах талаас нь хэрэгжиж байж энэ амьтай байх юм.

Тийм учраас Стандарт тохирлын үнэлгээний хуулийг бол таны ажлын хэсэг Зөвшөөрлийн хуулийн ажлын хэсэг ажиллаж байгаа учраас шинэ Засгийн газар бүрдээд эхний ажил байна гэдгийг танд хэлье. Зөвшөөрөл мэдэгдлийн хуулийг бол Цахим хөгжлийн сайд байхаасаа хойш ажиллаж, боловсруулж, тэгээд яг өргөн мэдүүлэх гэхээр ерэн хууль дунд нь Засгийн газар дээр гээгдчих гээд байдаг байсан юм. Тэгээд сая Их Хурлын даргын хувиар сонгогдсоныхоо дараа гишүүнийхээ бланк дээр Хассуурийн Ганхуяг болон бусад гишүүдтэй хамтран өргөн мэдүүлсэн.

Харин 90 хуулийг та бараг 20 гаруй хэлэлцүүлэг хийгээд ажлын хэсгийг их сайн ахалж ажиллаж байгаад би их талархалтай байгаа. Та энэ хуулийг баталж өгвөл Их Хурлаар энэ ажлын анхны хэлэлцүүлэг нь хийгдээд батлагдчихвал аймаг, орон нутаг, улсын түвшинд энэ зөвшөөрлийн хуулийг шахна аа. Хүнд суртал гох дэгээг мултлах энэ дүрэм журмыг саад тээгээс арилгах ажлуудыг гүйцэтгэх засаглалын хувьд бол шахаж ажиллана гэдгээ хэлье. Эдийн засгийн эрх чөлөөний

хууль яагаад татагдсан бэ гэвэл энэ хууль уг нь 21 хууль дагадаг байсан юм. Дагасан байсан юм тухайн үед. Тэгсэн чинь нөгөө яамдуудаас санал авч тойрсоор байгаад яам болгон нөгөө хувийн нөгөө эрх мэдлийн асуудал гэж. Энэ чинь эрх мэдлийг нь татаж авч байгаа ойлголт учраас ингээд нэг баахан санал өгсөөр байгаад сүүлдээ тэр зөвшөөрөл Эдийн засгийн эрх чөлөөний хууль орж ирэхдээ нөгөө Хүүхэд асрах хууль гээд нэг хууль дагачихсан орж ирсэн.

Тэгэхээр нөгөө Их Хурлын гишүүдийн шүүмжлээд байгаа нь аргагүй шүү дээ. Энэ хууль чинь дагасан хуулиудтай орж хэрэгжих ёстой. Тэгэхээр Ардын намын бүлэг ч тэр, АН-ын бүлэг ч тэр нэгдээд энэ эдийн засгийн эрх чөлөөний хуулийн концепц дээрээ нэгдчихвэл энэ хуулиа авч орж ирээд хэрэгжүүлэх бололцоо бүрэн байгаа гэж ингэж бодож байгаа бодож байгаа. Тэгээд энэ зөвшөөрөл байхгүй болчихсондоо биш энэ чинь бараг 2957 стандарт хэрэгжиж байгааг нь цомхон болгоод стандартуудыг нь тавьчих юм бол хүн амын эрүүл ахуй аюулгүй байдалд тийм сөргөөр нөлөөлөөд байхгүй. Ер нь хөдөлмөрлөө хийе бүтээе гэсэн хэн бүрийг дэмждэг ийм л Засгийн газар бүрдэх ёстой л гэж би гол бодлогоо барьж ажиллаж байгаа гэдгийг бол хэлье ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сархадын Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Хуралдаан даргалагч Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Бид гадааддаа хямралтай байгаа энэ нөхцөлд дотроо бас улс төрийн хямралгүй байх нь их чухал. Энэ чинь бид нар төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын гишүүд маань өнөөдөр хуралдаанаа хийж төрийнхөө ажлыг шуурхай хийж байгаад бас талархалтай байна. Бид цаашдаа бас яг энэ ийм байдлаар ажиллах ёстой. Энийг бас биднээс эргэж харж байгаа шүү гэдгийг та бүхэнд бас хэлье ээ.

Учрал даргын хувьд кабинетад ажиллаж үзсэн, угаасаа Засгийн газар танд шинэ зүйл ерөөсөө биш. Та Засгийн газрын кабинетыг гол галт тогоог нь ЗГХЭГ-ын даргыг хийж үзсэн хүн. Тэргүүн Шадар сайд буюу одоо жишээ нь хөгжлийн бодлого төлөвлөлт түүний хэрэгжилтийг үнэлэх энэ асуудлыг хариуцаж байсан чиглэлийн яамыг хариуцаж байсан учраас кабинеттай холбоотой туршлага танд хангалттай байгаа гэдэгт ерөөсөө эргэлзэхгүй байна.

Яах вэ Ерөнхий сайдын ажил бол шинэвтэр байж болох юм. Гэхдээ энэ бол хийгээд явахад бүрэн боломжтой гэж байгаа юм. Одоо энэ хямралын тухайд ярих юм бол бид бүгдээрээ л байнга өглөө болгон чих тавьж байна. Өглөө болгон мэдээлэл үзэж байна. Тэнцвэртэй мэдээлэл авах гэж бүгдээрээ л хичээж байна л даа. Дайн нэг эхэлсэн бол хэзээ дуусах нь мэдэгддэггүй ийм л цаг үед бид нар амьдраад байгаа юм.

Орос, Украйны жишээ нь энэ дайн чинь бол 7 хоногийн дотор дуусна гэсэн. Одоо хар л даа, 4 жил боллоо. Энэ Израил, Иран руу жишээ нь дайрч эхлэхэд бол бид 3, 7 хоногийн дотор энийг бол учрыг нь олчихно оо гэсэн байхгүй. Энэ цаашаа хэзээ дуусах нь бүү мэд. Олон улсын энэ стратеги судлаач нар энэ дайн мөргөлдөөн судлаач нар энийг бол хэзээ дуусахыг нь хэлж мэдэхгүй байна гэж байна. Дагалдах эдийн засгийн хүндрэлийг ч гэсэн хэлж мэдэхгүй байна гэж байгаа юм л даа.

Тэгэхээр энэтэй холбоотой яаралтай цогц төлөвлөгөө орж ирэх юм байна. Энэ төлөвлөгөөг бид ирэх 7 хоногт хэлэлцэх үү гэдэг. Та танилцуулж бид хэлэлцэх үү гэдэг 1 дүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт түрүүн Гантөмөр дарга асууж байна лээ. Их чухал тодорхой асуулт асууж байна лээ. Танай намын одоо жишээ нь сонгуулийн мөрийн хөтөлбөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих үү гэж. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бол 2 намын мөрийн хөтөлбөр нийлчихсэн байж байгаа хэвээр явж байгаа. Тэгэхээр энийг хэрэгжих үү гэж асууж байна зөв.

Энд бас тодорхой зүйлийг хариулаач гэсэн. Би бас тодорхой зүйл асууя гангийн үйлдвэр хэзээ ашиглалтад орох вэ? Зэс боловсруулах үйлдвэр хэзээ ашиглалтад орох вэ? Нефть боловсруулах үйлдвэр хэзээ ашиглалтад орох вэ? Энэ эрчим хүчтэй холбоотой хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бас ийм шинэ станцууд байна. Хөрөнгийн хувийн хэвшлийн. Эдгээр жишээ нь станцууд хэзээ ашиглалтад орох вэ? Эхнээсээ. Манай энэ эрчим хүчний цахилгаан эрчим хүчний хямралыг давахад хэрхэн жишээ нь нөлөөлөх вэ гэсэн маш тодорхой зүйлүүдийг та бас Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа хүний хувьд санал болгож оруулж ирж байгаа хүний хувьд та бас энийг сонгогчдод бас дуулгах нь зөв байх гэсэн бодолтой байна.

Гурав дахь асуулт. Та чөлөөлье гэдэг зүйлийг өөрөө санаачилсан. Их Хурлын гишүүд бид энийг бол зөн манлайлал гэж үзэж байгаа. Энэнтэй холбоотой таны байр суурь хэвээр.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Зулпхар гар гишүүний асуултад хариулъя.

Мэдээж Засгийн газар дээр импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа том томоохон төслүүдийг урагшлуулах ажил бол бас амжилттай явж байгаа төслүүд ч бол байгаа. Тийм учраас энэ ажлыг бол бас би үргэлжлүүлээд явна гэдгийг хэлье. Зүгээр саяын асуудлууд дээр ган боловсруулах үйлдвэрийг бол ажлаа авангуутаа энэ ажил руу бол ханцуй шамлаад орно. Миний авсан мэдээллээр бол 2026 оны өнөөдрийн байдлаар нэг газрын тос боловсруулах бүтээн байгуулалт нь бодит гүйцэтгэл бол 51 хувь хүрсэн гэсэн. Тэгээд үүн дээр гадаад зээлийн ашиглалтын нэг хууль бас оруулж ирчхээд байгаа юм байна. Тэгээд үүн дээр би нэг санхүүжилтийн асуудлууд дээр нь илүүтэй бол бас анхаарна. Зэс боловсруулах үйлдвэрийг бол энэ чинь бараг 2024 он гэхэд л бид нар нөгөө 2027 он гэхэд оруулна гэж л төлөвлөж байсан. Одоо бол энэ хугацаа хойшилсон байхыг үгүйсгэхгүй байна.

Тийм учраас зэс боловсруулах үйлдвэрийг би бас тэргүүн ээлжид анхаарахаар эрэмбэлж байгаа. Энэ төслүүд бол бүгдээрээ нөгөө Эрдэнэс Монгол Нэгдэл дээр тухайн үед харьяалагддаг байсан. Тэгээд намайг бас Хэрэг эрхлэхийн дарга байхад би эдгээр төслүүдийг хариуцаж байсан. Багануурын тэр нөгөө Пиролизын үйлдвэр гээд бас Пиролизын үйлдвэр бол бас тухайн үед хэд хэдэн гаднын хөрөнгө оруулагч нар санхүүжилтийн хэд хэдэн санал тавьж байсан. Тэгэхээр энэ Пиролизын үйлдвэрийн ажил руу орно. Тэрнээс биш бүх аз бүх ажлыг төсвөөр хийх гээд байх юм байхгүй. Гол нь хөрөнгө оруулагч нарт ээлтэй орчныг нь бүрдүүлээд өгөх юм бол гаднын хөрөнгө оруулагч нар орж ирэх бололцоо бол бүрэн дүүрэн байдаг.

Тийм учраас л ер нь энэ ажлаас эхэлье гэдэг зорилгоор энэ чөлөөлье гэдэг санаачилгыг дэвшүүлсний зорилго бол энэ. Жишээ нь энэ зөвшөөрөл бол энэ гаднын хөрөнгө оруулалтыг татахад маш том тус дөхөм өгнө. 90 гаруй хуульд өөрчлөлт ороод эхлэхээр дүрэм журам хүнд суртал буурна. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар ч гэсэн орон нутаг өөрсдөө дэд бүтцийн төслийг нутгийн өөрөө удирдах байгууллага түншлэлийн төслөөр хэрэгжүүлэх хуулийг та бүхэн батлаад өгсөн шүү дээ төсөв дагуулаад. Тэгэхээр энэ түншлэлээр бол зарлачихна. Ийм бололцоо бол байгаа.

Тийм учраас зөвхөн төсвөөс авч томоохон төслүүдийг хэрэгжүүлдэг биш эрх зүйн орчин нь өөрөө ээлтэй. Нөгөө хэлсэн бол хэлсэндээ хүрдэг, хууль буцааж хэрэглэдэггүй байх энэ үндсэн зарчмаа бариад явна гэдэг ийм зорилготой байгаа.

Тэгэхээр тэр чөлөөлөлтийн гол бодлого бол миний баримталж ирсэн бодлого. Тийм ч учраас Их Хурал дээр энэ хууль давсан дүрэм журмуудыг цэгцлэх, хууль тогтоомжийн давхардал, зөрчлийг арилгах чиглэлийн эрх зүйн шинэчлэлийг хийхээр гараанаас олон хуулиудыг гаргасан. Яг одоо бол илүүтэйгээр гүйцэтгэх засаглалын түвшинд саад тотгор учруулж байгаа. Энэ хөрөнгө оруулагч баялаг бүтээгч нартаа илүү ээлтэй орчныг бүрдүүлэхээр ажиллана.

Тийм учраас нөгөө хуульгүйгээр дүрэм журмуудыг давхардуулаад гаргачхаад байдаг тэгээд олон шат дамжлага дамждаг. Ийм гацаа саад болсон олон асуудлууд засаг дээр үүсгээд байдаг. Тэгэхээр би энийг үе шатуудыг нь бууруулна. Сая нөгөө сэргээгдэхийн төсөл дээр ч гэсэн нөгөө шатлалуудыг нь бууруулсан шүү дээ. Яг үүнтэйгээ адилхан Засгийн газар дээр энэ хуульд авсан журмуудыг цуцлах ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ. Ингээд гаднын хөрөнгө оруулалт орж ирэхэд ээлтэй баялаг бүтээгч нарт ээлтэй ийм л орон болохын төлөө бүгдээрээ хичээх ёстой.

**Ж.Бат-Эрдэнэ:** Аюушийн Ариунзаяа.

**А.Ариунзаяа:** Учрал даргад амжилт хүсье. Ерөнхий сайдаар томилогдохоор болж байгаа. Орж ирж байгаа, мэдээж дэмжинэ. Цахимын сайд, Хэрэг эрхлэхийн сайд, Тэргүүн Шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд гэх зэрэг бүхий л энэ албан тушаалууд дээр байсан яг мерит зарчмаараа явж байгаа. Нас хэдий залуу боловч улс төрийн насаар нь авч үзэх юм бол тэргүүн эгнээний ах нарын тоонд орж байгаа. Тэгэхээр улс төрийн агуулгаараа бол мэдээж бүхий л асуудлуудаа мэдэж байгаа. Миний зүгээс юу гэж хэлэх гэсэн бэ гэхлээр бид Занданшатар даргыг Ерөнхий сайдаар томилогдож байх үед гишүүдийн зүгээс 2 гишүүний бланк дээр нэг гарын үсэг цуглуулж нэг зарчмын шаардлага тавьсан юм аа.

Нэг нь болохлоор Болормаагийн бланк дээр тухайн сайд нарын бүүр олон удаа сайдаар томилогдсон бүүр ийм өртэй юм шиг байнга сайдаар томилогддог нэр хүнд муутай хүмүүсийг битгий томилооч ээ.

Хоёр дахь нь болохоор Баасанжаргалын бланк дээр бас энэ жендерийн хуулиа бариач гэсэн ийм албан шаардлагыг бол гаргаж байсан. Энэ удаад нэг их албан шаардлага албан бланк гээд байхгүй ээ. Жендерийн асуудлыг бол Жендерийн тухай хууль 2011 онд батлагдсан. Жендерийн тухай хуулийн 10.1.1 дээр улс төрийн албан тушаал Засгийн газар бол 15 хувь нь эмэгтэйчүүд байх ёстой гэсэн

ийм хууль 2011 онд батлагдаж байсан тэгээд 15 хувь гэдэг чинь одоогийн байгаа 22 сайдын 3 л юм байгаа юм. Одоогийн байгаа сайд нар дээр ганцхан хүнийг нэмээд л уг нь бол хуулийн энэ шаардлага нь биелчих юм. Тэгэхээр энэ агуулгаараа ОУПХ ч гэсэн яг Засгийн газарт байгаа эмэгтэй сайд нарын тоогоор тухайн улс орны энэ хөгжлийг бас үнэлж байдаг ийм үзүүлэлт учраас жендерийн хуулиа бас даган мөрдөөч гэсэн ийм хүсэлт илэрхийлж байна. Тэгээд энэ нэг их өөрөө сайд болох гээд байгаа юм шиг нэг их хүмүүс буруу мушгиж ойлгоод байдаг үгүй шүү дээ. Зүгээр л энэ хуулиа хууль тогтоогчид өөрсдөө мөрддөг байгаач ээ. Мөрдөхгүй юм бол бусдаас энэ хэрэгжилтийг нэхэх нэр нүүргүй л баймаар юм л гэдэг агуулга явж байгаа юм.

Хоёр дахь агуулгаараа бол мэдээж хүнд цаг үе ирж байгаа гэж бүгдээрээ л хэлж байна. Ойрх Дорнодын энэ нөхцөл байдалтай холбоотой. Иймээс богино хугацаанд сайн ажиллахын тулд та бас туршлагатай, мэргэжлийн сайд нартай байх нь зүйтэй гэдэг дээр бол би санал нэг байгаа. Ийм учраас заавал шинэ сайд нар гэхгүй гэхдээ салбар даа хүлээн зөвшөөрөгдсөн үнэлэгдсэн алга ташилтаар хүлээн авах ийм сайдаар байвал зөв юм аа. Энэ бол таны бүрэн эрх үндсэн хуулиар та өөрөө кабинетаа бүрдүүлнэ. Мөнхбаатар сайд жишээлбэл ХЗДХ-ийн сайдаар томилогдож байхад салбар нь хэчнээн сайхан хүлээж авч байлаа. Боловсролын сайдаар Энх-Амгалан сайд бас ажиллахад салбар нь хэчнээн сайн мундаг хүлээж авч байлаа. Гэхчлэн үүн дээр анхаарсан нь зүйтэй болов уу гэсэн ийм саналтай байна. Болохгүй бол тэгээд заавал давхар дээлтэй гэлтгүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Энэ хариуцлагатай цаг үе байна. Тийм учраас ажилдаа хурдан шуурхай орох хэрэгтэй. Миний хувьд бол аливаа ажлыг гардаж авсан бол бас хурдтай шуурхай ажиллаж, ажлынхаа ард гарахын төлөө байдаг хүн. Тийм ч учраас энэ удаа ч гэсэн хурдтай шуурхай ажиллана. Энэ шуурхай хурдтай байдалд дасан зохицож чадах сайд нарыг л танхимдаа урина. Хүйс нэг их хамаатай биш байх гэж бодож байна. Тийм улс төрийн капиталын нэгдэл бол өөрөө Засгийн газар.

Тийм учраас сайн менежер байх ёстой. Миний хурдыг гүйцэх ёстой. Тийм тэгээд суралцах хугацаа байхгүй. Сайд суралцдаг алба биш. Маргааш нөгөөдөргүй 3 дахиад ингээд Засгийн газрын 8 цагийн хурал явагдах ёстой. Тэгээд тэрнээс энэ нэг тийм хүн бэлтгээд байдаг ажил биш учраас өмнө нь сайдаар ажиллаж байсан Их Хурлын гишүүн байсан бас нэг ачаа үүрч чаддаг нэг цог золбоотой нэг хэдэн хүн л уримаар байна. Тэгээд мэдээж Засгийн газар хурдтай ажиллахыг л би шаардана. Ерөөсөө хурд хэрэгтэй шүү тэрнээс биш цаг хугацаа биднийг хүлээхгүй байна. Тэгээд би бид сөрөг хүчинтэйгээ өрсөлдөөд байх юм байхгүй. Бидэнд нэг л том айдас ирж байна. Энэ олон улсын байдал.

Тийм учраас тэр асуудалтайгаа нүүр тулна. Асуудалтайгаа нүүр тулна. Өнгөрсөн хугацаанд бол бид нар маш олон сорилт бэрхшээлийг туулаад л гарч ирсэн. Одоо ч гэсэн бид нар туулж чадна. Тулаад ирсэн зовлон бэрхшээлийг туулаад гарна хамтын хүчээр. Тэгээд бүгдээрээ хичээж ажиллахыг хүсэж байна. Тэгээд Их Хурлын гишүүд маань бас дэмжиж байгаад баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Би таныг бол энэ 15 хувийн хязгаарт гэдэг юм уу энд баригдахгүй илүү ч олон эмэгтэйчүүдийг авах байх гэж бодож байна. Зүгээр сануулахад та Ерөнхий сайдын хувьд Жендерийн үндэсний хорооны даргаар бас давхар байдаг учраас ядаж энэ хуулиа биелүүлээрэй гэдгийг хүсье. Тэгээд таныг давуулна гэдэгт итгэлтэй байна л даа. Нөгөө талаасаа би таныг зүгээр нөгөө саяхан бас Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүн. Би бол ганцхан хүнийг л өөрийн хүслээр томилсон юм шүү дээ гэж хэлж байгааг сонсоод надаа бол үнэхээр таалагдаагүй үнэнийг хэлье. Тэгээд энэ агуулгаар бол та бас өөрөө бас яг үнэхээрийн тантай шуурхай сайн ажиллаж хамгийн гол нь галыг өөр дээрээ үүрдэг байх ийм сайдаар байх хэрэгтэй шүү. Тэрнээс биш өөрөө гал өөртөө дуудаж засгийн нэр хүндийг доошоогоо татдаг эргүүлээд аливаа гал ирлээ гэхэд Ерөнхий сайд руугаа бүр Улсын Их Хурал руугаа бүр цаашлаад Ерөнхийлөгч рүүгээ шиддэг ийм сайдаар байгаад хэрэггүй шүү дээ. Улс төрийн шахаагаар энийг л хүсье дээ. Амжилт хүсье баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** За үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд.

**С.Эрдэнэболд:** Монгол Улсын 35 дахь Ерөнхий сайд. Нэг талаасаа энэ түүхэн том үүрэг бөгөөд хариуцлага ирж байна гэсэн үг. Тэгээд өмнөх 2 Ерөнхий сайдын чинь хувьд 23, 24 яам, сайд дараагийнх нь болохоор 20, 21 гээд ингээд дандаа 20 давсан яам сайд нартай байсан. Одоо бол ерөөсөө энэ олон улсын нөхцөл байдал эдийн засгийн нөхцөл байдал бол цомхон чадварлаг гэдэг шалгуурыг л тавьж байгаа. Тэгэхээр Учрал Ерөнхий сайдын өв буеу улс төрийн легаси бол 15-аас хэтрэхгүй сайд нараар танхимаа бүрдүүлбэл сайн байна аа.

Тэгээд Ариунзаяа гишүүний хэлээд байгаа зөв шүү дээ. 10 жилийн өмнө Жастин Трюдо нийт сайд нарынхаа 50 хувийг эмэгтэйчүүдээр бүрдүүлж байсан. Ер нь бол яг хүсэл мөрөөдөл гэж байдаг бол зорилготой зоригтой хүний өгцөө авчихсан ямар нэгэн шантаажид орохгүй Засгийн газраа байгуулах ёстой.

Хоёрдугаарт улс төрийн манлайлал талаасаа мэдээж ингээд Ерөнхий сайдын хувьд олон төрлийн үйл явдал цагийн байдал дунд явдаг. Тэгээд улс төрөө бодоод заримдаа хуулиас түрүүлээд, хуулиас даваад шийдвэрүүд гарах тохиолдол асар их байдаг.

Тийм учраас тэр нь эргээд зөвтөгддөггүй. Өнөөдөр ингээд манай үе үеийн Ерөнхий сайд нар хэвлэлээр үнэн худлаа нь мэдэгдэхгүй бие биеийгээ давах гэсэн зарим нь ичгэвтэртэй зүйл ярьж байна шүү дээ. Энэ утгаараа бол энэ улс төрийн хандлага манлайлал гэдэг бол нэг л зарчимтай байдаг. Тэр бол үнэний бөгөөд шударга ёсны зарчим гэж байна. Ерөнхий сайд гэдэг нэг талаасаа аль нэг намын дарга ч гэсэн нөгөө талаасаа Монгол Улсын эрх ашгийн тэргүүн хамгаалагч учраас энэ эрх ашгийг 1 дүгээрт тавьж байх ёстой.

Гуравдугаарт энэ хууль хэрэгжүүлэх ажил бол ерөөсөө Засгийн газрын үндсэн ажил. Тэгэхээр өнөөдөр ингээд Монгол Улсын төрийн өндөр алба хашиж байсан хүмүүс хашиж байгаа хүмүүс өдөр болгон гэмт хэргийн цуврал кино орой болгон ярьж байгаа мэт хэвлэлээр бие биеийгээ баримт сөхөж ярьдаг боллоо.

Тэгэхээр Ерөнхий сайдын хувьд бол энэ шударга ёсыг тогтоох хуулийг хэрэгжүүлэх тэргүүн зорилгын хүрээнд энэ иргэдийн хууль шүүхдээ итгэж ядаж байгаа төрдөө итгэж ядаж байгаа энэ зүйл дээр энэ дээр бол дандаа шийдвэртэй

алхмуудыг хийх ёстой. Хэн нь үнэн яриад байгаа юм, хэн нь худлаа яриад байгаа юм. Өнөөдөр хотын дарга гэхэд л үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг террорист гэж хочилж байна шүү дээ. Ийм зарчимтай улс төрч төрийн албан хаагч гэж байж болох уу. Тэгэхээр та энэ хотын даргадаа хариуцлага тооцоорой. Тэр үнэн худлаа яриад байгаа мэдэгдэхгүй байгаа хүмүүстээ ч гэсэн бас нэг тийш нь болгоорой. Тэгэхгүй бол 100 хоногийн дотор 100 хоногийн дотор танаас ард түмэн хүлээлт нь дуусна шүү.

Дөрөвдүгээрт, эдийн засгийн үр өгөөжийг тооцохдоо энэ аливаа төсөл хөтөлбөрүүдийг ярихдаа дандаа энэ иргэдийн мэдэх эрхийг хангаж оролцоог нь хангаж явмаар байна аа. Тэгэхгүй болохоор ингээд том дүнтэй татвар төлөгчдийн мөнгийг 1 эрх мэдэлтэй дарга нар лоббидоод гаргаад ирчихдэг. Ингээд судалсан судлаагүйн завсар төсөл хөтөлбөрүүд ороод ирдэг. Ар дээр нь баахан популизм үүсдэг. Улсын эдийн засаг нуран унадаг. Төгсгөлд нь хэлэхэд энэ чинь нэг минут сунгаж болох уу, болохгүй юу? Нэг минут сунгачихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Эрдэнэболд гишүүнд нэг минут сунгая.

**С.Эрдэнэболд:** Төгсгөлд нь хэлэхэд Учрал гишүүнийг бас 27 жилийн хугацаанд мэдэх юм байна. Тэгэхээр бас улсын Ерөнхий сайдын ажлыг хичээж хийнэ байх гэж найдаж байна. Хоёрхон үгийг хэлье. Монголын ард түмний мэргэн үг азарганы дэл хашаа байна, адууны зүг тийшээ гэж үг байдаг. Улсын гүйцэтгэх засаглалыг тэргүүлж байгаа хүний ааш аяг авир бол Монголын улс төрд нөлөөлдөг. PR хийгээд популист нэвтрүүлэг хийгээд гэмт хэргийн цуврал гаргаад л байвал иргэд нь талцаад л итгэл үнэмшилгүй болоод л тэгээд нүглийн хар сүүдэр улсыг нөмрөөд энэ хэрүүл маргаан нь явсаар байгаад хөгжил дэвшлээ боомилдог түүхийг бид нар мэдэж байгаа.

Тийм учраас арай жоохон тийм гэгээлэг, алсын харууцтай, тооцоотой, үндэслэлтэй, судалгаатай яваарай. Арслан мэт ноёныг барс мэт түшмэл дагана, барс мэт ноёныг чоно мэт түшмэл дагана, Чоно мэт ноёныг үнэг мэт түшмэл дагана гэж энэ зарчим зарчим хүлээн зөвшөөрлийн асуудал. Өөрсдийгөө үнэг мэт долдой хүмүүсээр хүрээлүүлээд байх юм бол та Ерөнхий сайд биш Монгол Улсын түүхэнд бас.

Үг хэллээ.

Одонгийн Цогтгэрэл дарга.

**О.Цогтгэрэл:** Гишүүддээ оройн мэнд хүргэе.

Бас тэгээд юуны өмнө АН-аас тавьсан зарчмын шаардлага олон намын парламентыг аль нэг намын дарга удирдах нь буруу гэдэг шаардлагыг хүлээж аваад бас шийдвэр гаргаад процесс явж байгаад бас талархлаа бас илэрхийлье. Учрал даргын хувьд ингээд Ерөнхий сайдаар томилогдохоор орж ирж байна. Бас онцгойлон хэлэх зүйл байна аа. Гол нь өнөөдрийн тулгамдаж байгаа асуудлыг томъёолоод хэлбэл 2 зүйл дээр байна. Энэ улс орон чинь энэ авлига хээл хахуульдаа живчихлээ гэдэг асуудал онц ноцтойгоор яригдаж байна 1 дүгээрт.

Хоёрдугаарт нь энэ эдийн засгийн гадаад дотоод нөхцөл байдал. Ийм 2 тулгамдсан асуудал бид нарт ирж байна. Яг энэ асуудлуудад Учрал даргын хувьд

би бас тодорхой байр суурь зарчмаа илэрхийлж байсан гэж бодож байна. Авлигатай тэмцэнэ гэж хэлж байсан эдийн засаг дээр чөлөөлөлт жижиг төрийг, бага татварыг, олон зүйлийг бас байр сууриа зарчмын хувьд илэрхийлж байгаа гэж бодож байгаа. Тэгэхээр энэ бүгдийг, энэ 2-ыг хийх үндсэн арга зүй чинь Ерөнхий сайдаар томилогдсоны дараа Засгийн газрын бүтцийн тухай хууль бүрэлдэхүүн 2 дээр энэ бүхэн маань илэрч харагдана илэрч харагдана.

Тэгэхээр эдгээрийг Ерөнхий сайдаар томилогдохоосоо өмнө эдгээр асуудал дээр бас тодорхой байр суурийг нь тодорхой сонсох шаардлагатай байна. Засгийн газрын бүтэц дээр ямар зарчим барьж байгаа юм, бүрэлдэхүүн дээрээ ямар зарчим барьж байгаа юм. Таны өмнө ярьж байсан 2 зарчим чинь хэвээрээ байгаа юу гэдэг. Яагаад бас энэн дээр ингээд онцгой ач холбогдол бас өгч байна вэ гэвэл Занданшатар даргыг Ерөнхий сайдаар томилогдоход бас энэ асуудлуудыг бид нар ярьж байсан. Яг үнэндээ бүх зүйл бахь байдгаараа. Бахь байдгаараа биш эргээд дэд сайд зэрэг эргээд орон тоо нэмэх асуудал бүр яг эсрэгээрээ явж байсан. Тэгээд ч АН-ын бүлгээс тодорхой нөгөө зарчмын байр суурь хаачив аа. Томилогдохдоо хэлж байсан байр суурь хаачив гэдэг зарчмын байр суурийг бид нар нэхэж улс төрийн бодлого олон олон зүйлүүдийг огцруулах шаардлагатай гэдэг хүртэл байр суурийг илэрхийлж байсныг та бүхэн бас мэдэж байгаа байх.

Тийм болохоор энэ удаад Бат-Эрдэнэ дарга АН-ын бүлэг нэг хоногийн завсарлага аваад энэ асуудал дээр бид нар ярилцмаар байна. Учрал даргыг манай бүлэгт орж ирж бас тодорхой хэмжээний асуултад хариулж энэ зарчмын байр сууриудаа бас дахин нотолж дараа дараагийн үйлдлүүд дээрээ тодорхой байр суурь илэрхийлж өгөөч ээ. Асууж тодруулах зүйл АН-ын бүлэгт байна гэж бодож байна. Тэгээд Бат-Эрдэнэ даргыг АН-ын бүлэгт нэг хоногийн завсарлага өгөөч гэж хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нөхцөл байдал ямар ч байсан Засгийн газраа маш яаралтай бүрдүүлээд орж ирэх шаардлагатай байгаа. Сая бас үгэндээ хэлж байх шиг байна.

Маргааш нөгөөдөр гээд 3 дахь өдөр Засгийн газрынхаа хуралдаанаа хийгээд явахад бэлэн болгоод үндсэндээ бол бас төрийн үйл ажиллагаа тогтвортой ажиллах ийм зарчмыг бол Учрал даргын хувьд бол Учрал гишүүний хувьд бол хэрвээ Ерөнхий сайд болсон бол ингээд зарчмыг бол бариад явъя гэсэн ийм саналыг гаргасан. Тийм болохоор АН-ын бүлэгт нэг цагийн завсарлага өгье.

АН-ын бүлэг завсарлага авсантай холбогдуулаад хурлаа цааш нь үргэлжлүүлье.

Түрүүний хэлэлцэж байсан асуудлуудаа үргэлжлүүлээд явъя аа. Хэлэлцэх асуудал 4 байна тийм үү?

## ЗАВСАРЛАГА

**Ж.Бат-Эрдэнэ:** Товлосон асуудлыг ажлын цагт багтааж хэлэлцэж дуусаагүй бол чуулганы хуралдааныг сунгаж болно оо гэсний дагуу 18 цаг болсон тул чуулганы хуралдааныг үргэлжлүүлэх гэж сунгахаар болж байна аа.

АН-ын бүлгээс авсан нэг цагийн завсарлагын хугацаа дуусаж байна. Гишүүдийг чуулганы танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна аа. Завсарлагын

хугацаа дууссан тул АН-ын бүлгийн гишүүдийг чуулганы танхимд урьж байна. АН-ын бүлгийн авсан нэг цагийн хугацаа дууссан тул АН-ын бүлгийн гишүүдийг чуулганы танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна. Хугацаа аль хэдийн дууссан.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг нэг цагийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан. Завсарлагатай холбоотой АН-ын бүлгийн даргаас үг хэлэх үү? Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** АН-ын бүлэг дээр Ерөнхий сайдад нэр дэвшигч Учрал даргаас бас гишүүд тодорхой асуулт асууж, байр сууриа бас илэрхийллээ. Бид нар бас энэ асуудалд их улс төржилтийн өнцгөөр гэхээсээ урьдаар бүлгийн хурлаа хийгээд нэг тийм нээлттэй бишээр асуудлуудад хандаж ярилцъя гэж бас ингээд цаг хугацааг хэмнээд бас товчхон ярилцлаа. Гол утга санаа нь АН-аас тодорхой зарчмын байр суурь өмнөх Ерөнхий сайдын үед өгчихсөн байсан. Төрөө цомхон болгоё оо, засаглалын бүтцээ өөрчилъе өө, энэн дээр анхаараач ээ гэдэг. Зүгээр дэд сайд гэдэг үгээр овоглогдож байгаа болохоос төрийн бүтэц зохион байгуулалттай холбоотой энэ данхар төртэй гэж яригддаг төртэй холбоотой энэ шаардлага маань бид нарын хувьд хэвээрээ байгаа шүү. Маргааш өнөөдөр томилогдоод та маргааш бүтцийн асуудлаа оруулж ирэхдээ бас яг өмнөх Ерөнхий сайд шиг энэ асуудалд хандаад явах уу гэдэг 1 дүгээрт нь энэ байр суурь дээр бид нар тодруулга авсан нь яг үнэндээ тодорхой тоймтой бас хариулт авсангүй. Тэгээд маргааш ямар байдлаар асуудал орж ирэхийг бас харъя 1 дүгээрт нь.

2 дугаарт нь гишүүд бас санаа зовниж асууж байна. Энэ сүүлийн 10 жилийн энэ авлига хулгайн асуудал чинь хэрээс хэтэрсэн. Сүүлд баримттай, нотолгоотой төрийн өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүс бүр байж боломгүй тоо дүнтэй зүйлүүдийг ярьдаг болсон. Энэ асуудал ингээд эвлэрээд нэгдээд энэ хулгайг нуун дарагдуулаад явах уу? Та энэн дээрээ тодорхой ямар бодлого барьж байгаа вэ гэдэг тодорхой асуултуудыг бас ингээд асуусан. Тэгээд АН-ын бүлгийн завсарлага дуусаж байна. Тэгээд өнөөдөр томилогдоод маргаашаас тэгээд дараа дараагийн үйл ажиллагаа явах үед бас байр сууриа илэрхийлээд, байр сууриа шаардлагатай бол нэгтгээд явна аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Ерөнхийлөгчийг томилох тухай уучлаарай. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух ажиллагаагаа цааш нь үргэлжлүүлъе. Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Монгол Улсын 35 дахь Ерөнхий сайдаар томилогдох гэж байгаа Ням-Осорын Учрал танд ажлын амжилт хүсээд баяр хүргэе, бас дэмжиж байгаагаа илэрхийлъя. Би давхардуулахгүйгээр хэд хэдэн асуулт асууя. Та Евроазийн худалдааны чөлөөт хэлэлцээрт очсон. Тэгэхэд энэ чөлөөт бүсийн асуудал баруун аймгуудын түүхий эдийг Дундад Ази, Истаны орнуудаар экспортлох, мах экспортлох тал дээр Оросын Худалдааны Сайд нарын Зөвлөлийн худалдаа хариуцсан хүнтэй уулзсан. Тэгэхээр энэ Цагаан нуурын чөлөөт бүсийн ажлыг эхлүүлэх үү? Ер нь тэнд баруун 5 аймагт бас газар олгоод, түүхий эдээ гадагшаа экспортлох, мал махны экспорт дээр тийм ямар бодлого баримталж байна? 1 дүгээрт.

2 дугаарт, 40 жил яригдаж байгаад сонгууль болгон шоу болдог Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах уу?

3 дахь асуудал эрүүл мэндийн салбарын талаар асууя. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбарын цалингийн асуудал одоо бензин шатахууны өсөлт, инфляцын өсөлт, өргөн хэрэглээний барааны өсөлттэй холбоотой бараг нэмэгдээгүй байна. Нэмэгдсэн гээд ярьж байгаа мөртөө хүрэлцэхгүй байна. Наяад хувь нь цалингийн зээлтэй, хүүхдээ сургаж байгаа. Тийм учраас энэ цалин нэмэгдэх үү? Нөгөө талаар Бүсийн оношилгооны төв гэдэг асуудлыг аймаг болгонд оношилгооны төв байгуулах уу? Ер нь байр нь бэлэн байгаа чухал оношилгооны аппарат, MRI, ангиогийн аппарат, бас чухал шаардлагатай аппарат тавиад эмч нарыг мэргэжил дээшлүүлэх талаар ямар бодлого барьж байна? Эм эмнэлгийн хэрэгсэл дутагдалтай байна. Одоо хэвтсэн эмчлүүлж байгаа өвчтөнүүд бүгд гаднаас эм авчирч байна. Энэ дээр ямар бодлого барьж байна?

4 дэх асуудал шатахууны хомсдолтой болчихоод байна. Нөгөө нефт боловсруулах үйлдвэр маань ашиглалтад ороход бас нэлээн хугацаа шаардах юм шиг байна. Дунд оврын шатахуун боловсруулах үйлдвэрүүд ард иргэд барьсан, зээл аваагүй тийм юм байгаа юм байна. Сэргэлэн сумын нутагт 3 мянган тонн Төв аймгийн шатахууны нөөцтэй өдөрт нь 100 тонн шатахуун үйлдвэрлэх хүчин чадалтай ийм үйлдвэр барьсан байна. Энийг Петро Чайна ч юм уу тэр Дэнчингийн Зүүнбаянгийн юунаас бас газрын тос нийлүүлбэл шууд шатлан гаргаад өдөртөө 100 тонны шатахуун гаргана гэж байна. Энэ талаар та мэдээлэл авсан уу? Энэ цаашдаа ийм юм дэмжих үү ер нь. Төрөөс энд хөнгөлөлттэй зээл олгох уу? Бас энэ ашиглалтад орсноор зарим уурхайнууд шатахуунууд тасалдахгүй боломж байна гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Сайдтай ОХУ-д ажиллах үеэрээ уулзсан. Евроазийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг Их Хурал соёрхож баталсантай холбогдуулан Нот бичгийг нь гардуулсан. 369 бүтээгдэхүүнийг энэ 200 сая хүнтэй зах зээл рүү гаргана. Үүнийг бэлтгэхийн тулд Алтанбулагийн чөлөөт бүс дээр бас бид нар нэг ложистикийн төвүүд байгуулах ажлуудыг бол эхлүүлнэ. Мөн нөгөө мах махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур гээд мах нядалгааны цех бусад ханган нийлүүлэх ажлуудыг хийх чиглэлээр бол гол дэмжлэгүүдийгээ үзүүлж явна. Тэгэхээр Евро Азийн хэлэлцээрийг амилуулах ажлуудыг бол одоогоос бэлтгэл ажлыг хангана. Би өөрөө анх энэ хэлэлцээрийг очиж Беларус турсан. Сая Их Хурлын дарга байхдаа соёрхож баталсан учраас энэ удаагийн хэрэгжилтийг анхаарч, энэ эдийн засгийг төрөлжүүлэх бодлогоо хэрэгжүүлнэ гэдгийг бол бас хэлье.

Юун дээр бол аймаг болгонд Бүсийн оношилгооны төв байгуулах ажлуудын оронд бүсчилсэн байдлаар орон нутгийн эмнэлгүүдийгээ илүү чадавхжуулах шаардлагатай гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас бүсийн оношилгооноос илүүтэйгээр орон нутгийн бүс эмнэлгүүдийгээ илүү чадавхжуулах илүүтэй бас анхаарна. Асгатын мөнгөний орд дээр Эрдэнэс Монгол дээр энэ Асгатын мөнгөний ордыг тухайн үед намайг бас нөгөө Хэрэг эрхлэхийн дарга байхад бол миний авсан мэдээллээр нөгөө хайгуулын ажил нь хийгдэж байгаа. Тэгэхээр тэр жорк стандартаар нөөцийг нь тогтоох хөрөнгө оруулалт татахаар тухайн үед ажиллаж

байсан. Одоо энэ ажлаа бол эрчимжүүлээд явна гэж та бас ойлгож болно асгатын мөнгөний.

Шатахууны хомсдолын асуудал дээр бол бага оврын газрын тосны үйлдвэрүүдийг бол судлах ажлыг хийж байгаа гээд намайг ОХУ-д айлчлах үеэр энэ Засгийн газраас мэдээлсэн. Тэгэхээр Дорноговийн үйлдвэрийн газрын тосны үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нь хангаад илүү гарах бүтээгдэхүүнүүдийг гэрээний дагуу олгох боломжтой гэж үзэж байгаа. Тийм учраас үүн дээр би ажил аваад энэ бага оврын газрын тосны үйлдвэрүүдийг судалгааны ажлыг эрчимжүүлээд танд эргэж мэдээлье.

Эрүүл мэндийн салбар дээр бол эмийн чанар, чанарын асуудал, тэр дундаа энэ инфляцад нөлөөлөөд байгаа зарим эмийн үнийг бууруулах, иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах арга хэмжээг авахын тулд бид нэг 2 ханган нийлүүлэх байгууллагатай өмнө нь уулзалт хийж байсан. Тэгэхээр шууд эмийг худалдаж авах дундаа ямар нэг зуучлагчгүйгээр худалдаж авах, зарим эмийн үнийг буулгах асуудлыг арга хэмжээг авахгүй бол ковидын үед хүртэл үнэ нь өсчихсөн байсан. Тэрнээс хойш огт зарим үнийн эмийн үнэ огт буугаагүй юм байна лээ. Тэгэхээр үүн дээр хэд хэдэн газартай бол шууд ханган нийлүүлэх компанитай нь ажиллаад явах бололцоотой гэдгийг бас ЭМЯ-аас энэ Их Хурал дээр байгуулсан ажлын хэсгийн хүрээнд мэдээлэл авч байсан.

Тэгэхээр би өөрөө бас энэ эрүүл мэндийн салбарын жаргал зовлонг бас мэдэх хүний хувьд энэ эмийн чанарыг сайжруулах асуудал руу гол анхаарлаа хандуулна. Цахимын сайд байхад бид нар нөгөө Е-Монгол дээр аль ч эмнэлэг дээр очоод нөгөө эрүүл мэндийн шинжилгээг нь шууд авчихдаг болгочихсон. Дээрээс нь нөгөө эмийн үнүүд бүгд нээлттэй болчихсон. Нөгөө импортолж орж ирдэг эмүүдийн үнүүдийг ямар үнээр зарагдаж байгаа вэ гэдгийг нь шууд хянадаг болчихсон энэ систем ажилласан учраас үүнийг олон нийтийн хяналтад авчирч бас эрүүл мэндийн салбартаа гол анхаарлаа хандуулна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Буланы Бейсен гишүүн тодруулъя.

**Б.Бейсен:** Тэгэхээр би тэр эрүүл мэндийн салбарын хувьд тэр бүсчилж эрүүл мэндийн оношилгооны төв байгуулна гэдэг чинь бас учир дутагдалтай. Хотын эмнэлгүүдийн ачаалал буурахгүй, аймаг болгонд одоо нэгдсэн эмнэлгийн байр нь бэлэн байж байгаа тэр тэнд зүгээр тоног төхөөрөмжөөр хангаад эмч нарыг нь сургачихвал бас боломжтой болчихоод байгаа юм. Нөгөө талаар та Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дахь Эко стандарт гэдэг компани бол өдөрт 100 тонн шатахуун боловсруулах том хэмжээний одоогоор 3 мянган тонн юуны нөөцтэй юм байна. Тэгэхээр энд үзэхгүй бол тэр аюултай хог хаягдлыг ерөөсөө хаяхгүй 70 хувьд нь түлш гаргаад, 30 хувьд нь газрыг битүү замын битүүмж өгөхөөр ийм юм байгаа юм байна. Энийг одоо энэ УУЯ-аас хүн явуулаад ч юм уу та Засгийн газраас хүн явуулаад энийг нэг үзвэл бас уурхайнуудад шатахуун гаргаж өгвөл уурхайд ажил тасалдахгүй байх гэж бодож байна аа. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үг хэллээ. Өлзийхүүгийн Шижир.

**Ө.Шижир:** Оройн мэнд. Залуу хүн эрч хүчтэй, урам зоригтой, цог золбоотой ажиллах байлгүй дээ гэж итгэж найдаж байна. Таны хувьд ажилтайгаа танилцана гэж байхгүй. Та яагаад гэвэл сүүлийн нэг жил 9 сарын хугацаанд 3 удаа сайд, нэг

удаа Улсын Их Хурлын дарга, одоо Ерөнхий сайд болж байна. Энэ нь бол 20, 30 жил улс төрийн амьдралд явсан хүний карьерыг та 1.9 жил хийчхэж байгаа юм. Таны одоо он од нь гийсэн жил энэ 2 жил болж өнгөрч байх шиг байна. Гэхдээ тэгээд хэлэхгүй ярихгүй бас нэг байж бас болохгүй байна аа.

Нэгдүгээрх нь Засгийн газар бол чиг үүргээрээ гэмт хэрэгтэй тэмцэх бас хэрэгжүүлэх үүрэгтэй энэ Үндсэн хуульд заачихсан. Тэгтэл 2025 оны 9 дүгээр сараас эхлээд Амарбаясгалан, Занданшатар гэдэг 2 хүн МАН-ын даргад дэвшинэ гэснээс хойш өнөөдөр өдрийн хоолондоо арай чүү хүргэж байгаа ард иргэд үнийн өсөлтөд дарлуулж байгаа иргэд үхрийн мах нь 30 мянга гарчихсан үед махаа худалдаж авч чадахгүй иргэдэд та нар онц сонирхолтой олон ангит гэмт хэрэгтэй киног нэг нэг өдрөөр ээлжилж ярьж өгсөн. Нэг нэгнийхээ булайг увайгүй дэлгэсэн. Та хэрвээ энийг ярих юм би энийг чинь ярина гэдэг сүрдүүлэг хийсэн. Өнгөрсөн хугацаанд та хэдийн зөрчил хэрүүл маргаанууд хулгай дээрэм эхлээд 2016 онд засаг авахдаа сая сая төгрөгөөр ЖДҮ-ийн сан 500, 600 сая төгрөгөөр 900 сая төгрөгөөр яригддаг байсан бол өнөөдөр та нарын гэмт хэрэг сая сая доллароор, хулгай дээрэм чинь сая сая доллароор, бүр сүүлдээ хүн амины хэрэг ярьдаг болсон. Танай намын зөрчил энэ бүгдийг хоорондоо ил болгосон. ЖДҮ-лэлийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан гэх энэ сангууд зүгээр энэ өнөөдрийн та нарын хоорондоо ярьж байгаа гэмт хэргүүдийн чинь хажууд зүгээр интро, зүгээр богинохон хэмжээний танилцуулга. Одоо та нар хоорондоо ярьж байгаа гэмт хэргүүдээ хар даа. 100, 100 сая доллароор ярьж байна. Чинийх 120 сая доллар бол минийх хорьхон сая доллар гэдэг агуулгатай юм ярьж байна.

Гэмт хэрэг хүн амины гэмт хэрэг ярьж байна. 10 жил засаглахаараа та нар ингэтлээ задарсан байна, ингэтлээ томорсон байна, авлига, хулгайтай эвлэрэхгүй гээд Ардын намын дарга нь яриад байдаг. Бие биеийнхээ авлига хулгайг ингээд бие бие ээлжлээд дэлгээд байдаг. Тэгээд та энэ хүмүүстээ ямар хариуцлага тооцох юм. Хуулийн хүрээнд ямар ажил хийх юм, гэмт хэрэгтэй яаж тэмцэх юм. Өнгөрсөн хугацаанд хангалттай бие биеийгээ дэлгэлээ шүү дээ. Хангалттай бие биеийгээ ярилаа шүү дээ. Сүүлдээ энэ өдөр тутмын үнийн өсөлтөд үхрийн мах нь 30 мянга давчихсан байгаа энэ үед иргэд чинь та нар энэ олон ангит гэмт хэрэгтэй киног үзээд үзсээр байгаад сүүлдээ дадлаа шүү дээ. Ямар давгарчихсан нам юм бэ.

Одоо бензин шатахууны үнэ хомсдож байна, зогсчихсон уул уурхайн төслүүдээ яах юм. Төрийн болон хувийн хэвшлийн. Одоо бид нар алт, зэс, нүүрс зараад энэ гурвынхаа өсөлтөөр л амьдарч байна шүү дээ. Энэ төслүүдээ яаж хэрэгжүүлэх юм, ямар бодлого байгаа юм танд. Тэгээд эдийн засаг өсөж байна гэдгээ манай энэ хэдхэн бүтээгдэхүүн өсөж байна гээд яваад байх юм уу. Татвар төлөгчдийн орон зайг яаж нэмэх юм. Татвар төлж байгаа хэдхэн татвар төлөгчид хүн амынх биш нэмж татвар төлөгчийг бий болгох дээр ямар бодлого байгаа юм. Алт, зэс, нүүрсэн дээрээ ингээд байгаа байдал дээр нь үнийн өсөлтөд нь баясаад суугаад байх юм уу. Эхлээд энэ асуудал.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлнэ ээ. Улс төрийн эрх мэдлийн хүрээнд ч тэр, захиргааны эрх мэдлийн хүрээнд ч тэр хэрэгжүүлнэ. Тэгэхээр улс төрийн нам өөрөө ёс зүйтэй сахилга хариуцлагатай байж байж төр өөрөө сахилгатай ёс зүйтэй байна. Тийм ч учраас би намын даргын хувьд хяналтын хороо, ёс зүйн хороо гээд механизмуудаа ажиллуулж байгаа. Цаашид гүйцэтгэх

засаглалын тэргүүний хувиар гэмт хэрэгтэй тэмцэх ажил бол үргэлжлэх ёстой. Харин гэм буруугаа тогтоолгох, хууль хяналтын байгууллагаар шалгуулах гэм буруугүй бол гэм буруугүй, гэм буруутай бол гэм буруутайгаа тогтоолгох ажлыг бол мэдээж энэ яриад байгаа хүмүүс өөрсдөө хууль хяналтын байгууллагын өмнө хариуцах хэрэгтэй. Тэрнээс биш та бид бол хэн нэгнийг гэм буруу нь тогтоогдоогүй байхад хэн нэгнийг цоллох түрүүлж дуугарах эрх биш. Тухайн 2, 3 хүний хооронд үүссэн асуудлыг бол хууль хяналтын байгууллагаар би шалгуул гэж байгаа.

Намын даргын хувьд бол хяналтын хороо, ёс зүйн хороогоороо хариу арга хэмжээнүүдийг аваад тайлбар мэдээллийг нь сонсоод явж байгаа. Тэгэхээр авлигатай тэмцэх гэж бол хүнтэй тэмцэх зөвхөн асуудал биш энэ чинь өөрөө системтэй тэмцэх асуудал. Тэгэхээр өнөөдөр авлигын тэр төсөөллийн индекс чинь 10 байр хойшилчихлоо гээд шалтгаан нь юу юм. Уг шалтгааныг нь олж ойлгох ёстой. Тийм учраас авлигатай тэмцэх хамгийн сайн шийдэл бол энэ дижитал засаглал. Хүнээс хамааралгүй шийдвэр гаргах. Тэр зөвшөөрөл лицензүүдийг манай Засгийн газрын үед 100 хувь цахимжуулж зөвхөн цахимаар зөвшөөрөл лиценз олгодог болно оо. Энийг зөвхөн биг дата дээр суурилоод хиймэл оюунаар олгох ажлуудыг хийнэ. Өнгөрсөн хугацаанд 820 мянган мэдээлэл таны хэлж байгаа энэ олон зээлийн сангийн мэдээллийг шилэн ажиллагааны хүрээнд 820 мянган мэдээллийг ил болгосноороо өнөөдөр хиймэл оюун дээр ChatGPT ажиллаж кирилл үсгээр бичихэд агуулгын хувьд хариулж байгаа. Энэ бол Монгол Улс мэдээллийг ил болгосон ач тус. Тэгэхээр энэ их өгөгдлийг боловсруулах ажлыг би бас хийлцэж энд багийнх нь нэг гишүүн байсны хувьд цаашдаа хүний оролцоогүйгээр шийдвэр гаргуулах алхмыг хийнэ.

2-т авлигыг бууруулахын тулд Шүгэл үлээгчийн хууль, Олборлох салбарын ил тод байдлын хууль батлуулна. Дээрээс нь энэ иргэний журмаар энэ ял завшаад байгаа байдал буюу нийтийн албан тушаалтны хөрөнгө хураах механизмыг дэмжих ёстой энэ хуулийг хийхэд. Ингэж байж цаашаа бол алхам урагшилна гэж би ойлгож байгаа. Тийм учраас тэр шилэн ажиллагаа, нээлттэй ил тод байдал, нэгэнт мэдээлэл нь нэгтгэгдээд өгөгдөл болгоод болгочихсон учраас түүн дээр нь хиймэл оюун ажиллаж шийдвэр гаргадаг хүнээс хамааралгүй ийм эрх зүйн орчныг сайн дэвшил болгож ажиллуулна гэдгийг хэлмээр байна. Тэгээд олборлох салбар энэ уул уурхайн салбар ч гэсэн олон жил яригдаад энэ биржийн хууль гарсан. Энэний үндсэн дээр бол бас ийм системийн шинэчлэл хийгдсэнээрээ бас том дэвшлүүд бол гарсан. Тэгэхээр энэ ажлуудыгаа бас урагшлуулна. Тэгээд эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлт гэдэг энэ бодлогоо бол хэрэгжүүлнэ. Эдийн засгийн чөлөөлөлтийн хүрээнд хөрөнгө оруулалт, банкны хууль, зөвшөөрөл, мэдэгдлийн хууль гээд бараг өнгөрсөн хугацаанд ажилласан 100 гаруй хуулийн өөрчлөлт байгаа дагасан. Тэгэхдээ хууль тогтоомжийн давхардал хийдэл.

Одоо бол дуусдаггүй олон яриануудыг дуусгана аа манай засгийн газрууд. Дуусдаггүй олон яриагаа дуусгая. Харин үүнийг маань бас зөвийг нь та бүхнийг дэмжээрэй гэж би хүсэж байгаа юм. Эдийн засгийн чөлөөлөлтийн хүрээнд. Эрх зүйн орчны чөлөөлөлтийн хүрээнд энэ Засгийн газар дээр байгаа мянга гаруй журам гээд Хууль зүйн сайд яриад байсан. Тэрийг би өөрөө ажлаа авсныхаа дараа маш яаралтай хугацаанд энэ хуульд авсан журмуудыг нь цуцална.

Ингээд Засгийн газар бол цахим И-кабинетын горимд шилжинэ ээ. Хурдтай шуурхай ажиллана. Тэгээд ингээд ногоон хөгжлийн чөлөөлөлт авлигын эсрэг чөлөөлөлт гэсэн 4 чөлөөлөлтийн бодлогоо хэрэгжүүлнэ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учралд нэг минут.

**Н.Учрал:** Тэгээд мега төслүүдийг эрэмбэлэх ажлыг хийсэн. Би түрүүн хэлсэн 4 гол төслийг тэргүүлэх ээлжид тавьж байна аа. Гангийн цогцолбор, тэр Багануурын пролизийн үйлдвэр, зэс хайлуулах цогцолбор тэргүүн ээлжид тавьж байна. Дээрээс нь сэргээгдэхийн төслүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ. Одоо 10 аймагт нээлттэй сонгон шалгаруулалтыг нь Засгийн газар байгуулагдсаны дараа шууд зарлана. Түүнд садаа тотгор учруулаад байгааг хуулиудыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр өөрчлөлт оруулсантай яг адилхан үе шатуудыг нь шууд бууруулна. Ингээд өрх болгон цахилгаан үйлдвэрлэгч гэдэг зорилго руу би явах ёстой гэж ингэж бодож байгаа. Дээрээс нь эдийн засгийг төрөлжүүлэх бодлогоо хэрэгжүүлнэ. Евро Азийн хэлэлцээрийг амилуулахтай яг адилхан Солонгостой, Хятадтай зарим төрлийн бараа бүтээгдэхүүнүүдээр тэр гаалийн тариф дээр хэлэлцээр хийх ёстой. Ингээд эдийн засгийг төрөлжүүлэх ажлуудыг хийнэ. Энэ бол өөрөө ХАА-н салбар дээр илүү түшиглэнэ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Өлзийхүүгийн Шижир гишүүн.

**Ө.Шижир:** Та бол угаасаа Ерөнхий сайдаар тодрох нь ойлгомжтой, томилогдох нь ойлгомжтой. Тэгэхээр томилогдсоных нь дараа ярина гэдэг ийм байр суурьтай байж болохгүй ээ. Тэгээд Учрал сайдын хувьд цахим шилжилт тэгээд цомхон үр ашигтай бүтэц ингээд ярьдаг. Тийм учраас таны тэргүүлэх Засгийн газар дэд сайдтай байх уу, байхгүй юу гэдэг асуудлыг тодорхой хариулж өгөөч ээ.

2 дугаарт 20 гаран сайдтай дахиад ийм олон яамтай бүтэц оруулж ирэх юм уу, оруулж ирэхгүй юм уу гэдэг дахиад асуудлаа хэлээч ээ?

3 дугаарт би түрүүн татвар төлөгчдийн орон зайг яаж нэмэгдүүлэх юм бэ гэж асуусан. Өнөөдөр татвар төлж байгаа ААН-үүдээсээ карманг нь хуу хамаад дансыг нь хааж битүүмжилж байгаад маш бүдүүлгээр бараг дээрэм хийж татварыг нь авдаг. Тэгээд буцаагаад хэдэн компанийг нэмж татвар төлөгчөөр бүртгэх юм бэ гэдэг тийм бодлого байдаггүй. Байгаа хэдээсээ л хуу хамаад байдаг. Нэмж татвар төлөх төлөгч бий болох ийм эрх зүйн орчныг яаж бүрдүүлж өгөх юм бэ? Энэ дээрээ та тодорхой хариулт өгөөч ээ? Яагаад гэхээр та өмнө нь 4 удаа сайд, нэг удаа Их Хурлын.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Ерөнхий сайдаар томилогдвол чиг үүргийн шинжилгээ хийнэ. Ерөнхий чиг үүргийн яамдаас бусад салбарт ер нь дэд сайд байх нь зохимжгүй гэж бодож байгаа. Бүтэц бүрэлдэхүүний хувьд агентлагийн хувьд яамдуудын дэргэд байгаа хөгжлийн төвүүд гээд зарим чиг үүргийг шууд аутсорсинг хэлбэрээр мэргэжлийн холбоонд шилжүүлнэ. Төрийн үйлчилгээг эрх зүйн үр дагаваргүй төрийн бүх үйлчилгээг либералчилна. Хэрэгтэй, хэрэггүй хороодыг татан буулгана. Нэг зоригтой ажлууд бол хийнэ ээ, хурдтай ажиллана. Үүнийг маань харин та бүхэн дэмжиж өгөхийг хүсье.

Шийдвэр гаргахад тодорхой эрх ашиг нь зөрчигддөг зарим бүлгийн гэхдээ үүнийг даваад гарах ёстой. Энэ бол нийгмийн хүлээлт нийгмийн хүлээлт. Тэгээд хэдүүлээ зориг гаргаад хамтраад шийдье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Учрал гэдэг хүн буруу суудал дээр, буруу микрофоноор олон зөв юм ярьсан. Би чөлөөлөлт гэдэг энэ үгийн ард байгаа бодлогыг чинь дэмжиж байгаа. Одоо зөв суудал дээрээс зөв микрофоноос энэ үгээ хэлээд өөрөө гардан хэрэгжүүлдэг тэр ажил руу очих гэж байна. Үнэхээр энэ хөрөнгө оруулалт төрийн нүүр харахгүйгээр, төрийн гар харахгүйгээр өөрийнхөө амьдралыг авч яваад, ажлын байр бий болгоод улс орны эдийн засгийг босгоод, татвар төлөөд, дээр нь иргэдийг орлогожуулж байгаа энэ хүмүүс дээр учирч байгаа хүндрэл бэрхшээлүүдийг алга болгож чөлөөлж өгье өө гэж байгаа энэ зорилгоо амжилттай хэрэгжүүлээрэй. Үнэхээр энэ улс орныг нуруундаа авч явж байгаа маш олон хүмүүс гартаа хөлдүү гавтай дөнгөтэй урагшлах гэж оролдож байгаа. Гав дөнгөөс нь салгаад өгвөл хэнээс ч гуйхгүйгээр энэ улс орныг сэв хийтэл босгоод яваад байх хэмжээний бодол санаа хөдөлмөрч зан чанар тэдэнд байна аа.

Яг энэнтэйгээ адилхан би танаас бас дахиад нэг 1 юм хүсэх гэж байгаа юм. Монгол Улсын Засгийн газрыг кабинетаар нь ажиллуулдаг болгоорой. Анх тэр нэг хамтарсан Засгийн газар байгуулаад Элбэгдорж гэдэг хүн хамтарсан Засгийн газар байгуулж хийхэд 2 намаас ингээд барьцаалж байгаа юм шиг Ерөнхий сайдаа шалгадаг юм уу, хянадаг юм уу, яадаг юм хажууд нь Шадар сайд тавьж байгаад Улсын Их Хурлын жижгэрүүлсэн хувилбарыг Засгийн газар дээр байгуулсан юм Бага хурал шиг. Кабинетын зарчим гэдэг бол Ерөнхий сайдын кабинет. Ерөнхий сайд салбар хэнийг хариуцуулах вэ гээд тэр 2 хүн шийдээд л, бодлогоо гаргаад, бусад сайддаа мэдэгдээд цаашаа урагшилдаг болохоос биш Улсын Их Хурал шиг хуралдаад олонхоороо шийддэг тийм жижиг хурлын хэлбэр Засгийн газарт угаасаа зохихгүй, угаасаа гүйцэтгэх эрх мэдэл ингэж ажилладаггүй.

Монгол Улс одоо 2 хуралтай хуралдаж байгаа. Улсын Их Хурал гээд нэг хуралтай, Засгийн газар гээд нэг Бага хуралтай. Засгийн газарт ажил хийдэг хүмүүс байдаг болохоос хуралдаад суудаг гоё яриад суудаг хүмүүс ерөөсөө байдаггүй юмаа. Тийм учраас ажил хийж чаддаг хүмүүсээр энэ Засгийн газраа бүрдүүлээрэй. Дээр нь гадаад дотоод байдал гээд олон зүйлийг бүх хүмүүс ярьж байна. Монгол Улсын сөрөн тэсвэрлэх чадавхтай холбоотой, Ерөнхийлөгчийн санаачилсан энэ сөрөн үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулахтай холбоотой энэ бодлогын хүрээнд бас нэг зоригтойхон шиг дэвшилттэй ажил хийгээрэй.

Би танд 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 заалтын дугаарыг дурдаж өгөх гэж байгаа юм. 4.2.1.8 та тэмдэглээд аваарай. 4.2.1.13, 4.2.1.14, 4.2.1.16.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үг хэллээ. Ингэхэд бол бас Тэмүүжин гишүүний хэлсэнтэй уялдуулаад Засгийн газрын гишүүн юу Ерөнхий сайд Засгийн газрынхаа гишүүдийг өөрөө оруулж ирж байгаа шүү дээ. Тийм болохоор тэнд хурал гэхээсээ илүү өөрөө хариуцлага үүрдэг энэ нэг системийг бид нар бий болгох ёстой юм байгаа юм. Кабинетаараа гэхээсээ илүү. Дуламын Бум-Очир гишүүн.

**Д.Бум-Очир:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Орой болж байх шиг байна оройн мэнд хүргэе. Учрал гишүүнийг дэмжиж байгаагаа юуны өмнө илэрхийлмээр байна. Бидний ойлгож байгаагаар боловсролын салбарт сургууль цэцэрлэгүүдэд маань би бүр төсвийн хямрал нүүрлэххээд байна гэдгийг хэлмээр байна. Тэгээд Учрал гишүүнийг Ерөнхий сайд болоод боловсролын салбарт үүсээд байгаа энэ

төсвийн хямралаас багш ажилчдыг, сурагчдыг, сургууль цэцэрлэгүүдийг чөлөөлж өгөөсэй гэж хүсэж байгаа юмаа. Сургууль цэцэрлэгүүд маань хуваарилагдсан төсвөөрөө багш ажилчдынхаа цалинг тавьж чадахгүй хэмжээнд хүрч байгаа, хүрч цалингаа тавьж чадахгүй байдалд хүрэхээр юу болсон бэ гэхээр манай Боловсрол шинжлэх ухааны дэд байнгын хороон дээр Боловсролын яамнаас бас энэ чиглэлээр бичиг явуулаад хариулт ирсэн. 11, 12 сарын жилийн сүүлийн саруудын мөнгийг цалингийнх нь мөнгийг аваад нөхөж өгөөд явж байгаа. Тэгээд жилийн эцэст одоо энэ сургууль цэцэрлэгүүд чинь цалингаа тавьж чадахгүй ийм хэмжээнд хүрэх эрсдэл үүсчхээд байна аа.

Дээр нь нэмээд байгаа мөнгөөрөө эд нар маань цалингаа тавиад нийгмийн даатгалын өрөнд ороод байж байна. ЭМД-ын өрөнд ороод байж байна. Багш нар маань одоо эмнэлэгт үзүүлэх бол яах вэ. Нийтдээ 908 тэрбум буюу бараг 1 их наяд төгрөг хэрэг болохоор шаардлагатай болохоор байна гэдэг ийм тооцоог Боловсролын яам манай байнгын хороонд албан бичгээр ирүүлсэн байна. Тэгэхээр 1 их наядыг хаанаас яаж гаргаж энэ боловсролын салбарт үүсээд байгаа төсвийн хямралыг арилгах вэ? Энийг та бодож болгоох болов уу гэж бодож байна.

Дараагийн нэг зүйл бол дээд боловсролынхоо асуудлаар их дээд сургуулиудтайгаа холбоотой хэдэн зүйлийг яримаар байна аа. Энэ төрийн өмчийн гэгдэх их дээд сургуулиуд маань нэг статусын гажуудалд орчхоод байгаад байна аа. Төрийн өмчийн гэхэд төсөв авдаггүй, нөгөө нэг урсгал зардал юмнууд нь цөөхөн төгрөг өгдөг байсан тэрийг бүр өгөхөө больсон. Тэгсэн мөртөө аудитын болоод бусад шаардлага тавихаараа төсөв авдаг байгууллагуудад тавьдаг шаардлагыг тавиад байдаг. Ингээд нэг төрийн ч юм шиг, төрийн биш ч юм шиг энэ их дээд сургуулиудаа бид нар цаашид хөгжих тэлэх бүх боломжийг нь боомилсон ийм эрх зүйн орчин бий болчихжээ. Их дээд сургуулиуд маань шинжлэх ухааны байгууллага мөн ч юм шиг, биш ч юм шиг сургуулиуд маань ярьж байна л даа удирдлагууд. Бид нар одоо 60, 70 жил шинжлэх ухаанд зүтгээд одоо дөнгөж энэ шинэ эрх зүйн орчноор эрдэм шинжилгээний байгууллага гэдэг статус авах гээд зогсож байна гэж. МУИС өнгөрсөн жил авсан энэ байдлыг янзалж өгөөрэй гэж хүсмээр байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** Оройн мэндийг хүргэе ээ. Өнөөдөр бас Дэлхийн эмч нарын өдөр бас тохиож байх шиг байна аа. Монгол Улсын хүний гавьяат эмч Монгол Улсын Их Хурлын гишүүн Бейсен гишүүн тэргүүнтэй эмч гишүүддээ бас энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Мөн бас Учрал даргаас эрүүл мэндийн салбартай холбогдолтой сая бас одоо зүүн бүсийн гишүүд тойрогтоо бас нэлээн ажилласан. 27, 28 удаагийн сумдын болон сонирхлын бүлгүүдийн уулзалтуудыг зохион байгуулсан. 140 гаруй багц саналыг бас бид бүхэн бас бэлдэж танд өгөхөөр бас бэлдсэн байгаа. Тэгэхээр шинэ Засгийн газрын ажилдаа бас тусгаад тодорхой хариултуудаа өгөөд явах болов уу гэж бодож байна.

Хамгийн нэн тэргүүнд бас давхардсан, ялангуяа эрүүл мэндийн салбартай холбогдолтой асуудал дээр өнгөрсөн Засгийн газарт эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг 30-39 хувиар нэмэгдүүлэх, багшийн цалинг 50-76 хувиар нэмэгдүүлэх. Ингээд ахмадын тэтгэврийн бас тодорхой нэмэгдлийг багцалж оруулж ирсэн. Үүнтэй холбогдолтой нэлээн асуудал яг орон нутаг дээр бас байгаа. Та бас орон нутагт ажиллахдаа энийг бас нэлээн мэдэрсэн байх аа? Тэгэхээр Засгийн

газрын бас эхний ажлуудын нэг нь энэ цалин хөлсний нэмэгдлийг яг бодитоор авч үзээд ингээд нэг шийдлүүд гаргахгүй бол бас болохгүй байна. Тэгэхээр эндээс эхлэх байх аа гэж бодож байна. Энэ нэмэгдлүүд үргэлжлээд явах уу энэ дээр бас тодорхой ямар байр суурь бас өнөөдөр бас боломжтой бас хэлчих нь зөв байх аа гэж бодож байна.

Үүнийг дагаад дахиад соёлын салбарынхан бусад төрийн албаны албан хаагчид та тухайн сум орон нутгийн ЗДТГ-т ажиллаж байгаа бас ажилтан албан хаагчид бид бас хаанаас нь гарсан юм бэ? Ингээд ялгаж салгаж байгаа зарим салбарыг илүү нэмэгдүүлж байгаатай холбогдолтой асуудлыг бас маш ихээр хөндсөн. Тэгэхээр энэ асуудлыг бас цогцоор нь ер нь цаашдаа эрүүл мэнд, нийгмийн, боловсролын салбарын мөн төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбогдолтой асуудал дээр таны Засгийн газар ерөнхий бас ямар бодлоготой байх вэ гэдэг байдлаар бас эхний асуултаа бас асууя.

Эрүүл мэндийн салбарт анхан шатны үйл ажиллагаа явуулж байгаа тэр 9 хувийн цомхотголтой холбогдолтой асуудал маш их давтагдсан бас иргэдийн асуултад. Тэгээд энэ дээр бас та нэлээн сайн мэдээлэлтэй байгаа юм байна. Үйлчилгээний 3 ажилтан жолоочийнхоо жолоочоо хасах уу, цэвэрлэгчээ хасах уу, лаборантаа хасах уу гэдэг ийм сонголт дээр сумын эрүүл мэндийн нэгдлийн дарга нар яах вэ гээд биднээс бас асууж байна аа. Дээрээс нь архив бичиг хэрэг олон хүмүүсийг хиймэл оюун ухаанд шилжсэн. Одоо энэ архивын хүн хэрэггүй энэ тэр гэдэг ийм инээдтэй тайлбаруудыг бас хэлж байна аа. Бүх юм нэг удаагийн хэрэглээ болсон. Тийм болохоор ариутгалын хүн хэрэггүй болно оо болсон энэ тэр гээд иймэрхүү инээдтэй тайлбаруудыг бас гаргаад энэ цомхотголыг орон нутагт бас зохимжгүйгээр бас зохион байгуулж байгаа асуудал дээр бас та мэдээлэлтэй байх шиг байна. Энийг бас анхаарч ажиллах нь зөв байх аа гэсэн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Ганхүлэг гишүүний асуултад хариулья аа. Тэгээд эрүүл мэндийн салбар дээр Эрүүл мэндийн сайдын багц дээр бараг 1.2 их наяд төгрөгийн цалингийн зардал батлагдсан хэдий ч одоогоор бараг 268 тэрбум төгрөгийн нэмэлт шаардлагатай байгаа юм байна гэдэг би мэдээлэл авсан. Цаашдаа бол бид нар энэ төрийн албан хаагчдын цалинг жил бүр инфляцтай уялдуулж индексжүүлж байхгүй бол яг өнөөдөр шиг л ийм нөхцөл байдалтай тулгарна аа. Тийм учраас ирэх оны төсөв өргөн мэдүүлэхдээ дээрээс нь 5 дугаар сарын 1-ний өмнө төсвийн хүрээ жилийн төлөвлөгөөг өргөн мэдүүлэхдээ би энэ төрийн албаны цалин хөлсийг энэ индексжүүлж нэмдэг зөв систем рүү нь аваачихын төлөө ажиллана. Тэрнээс биш бараг 30 гаруй хуулиар төрийн албан хаагчдын цалин хөлс ялгамжтай тогтоод байна. Тэгэхээр энэ 30 гаруй хуулиар ялгамжтай тогтоод байгаад эхлэхээр энэ шударга бус байгаад байна. Тийм учраас төрийн албанд бол цаашдаа энэ олон хуулиар биш шударга тогтолцоог бий болгох ёстой. Тийм учраас энэ индексжүүлэх асуудлыг бол шийдэж явна гэдгийг бол бас хэлье.

Тэгэхээр одоо жишээ нь зарим эрүүл мэндийн салбарт гэхэд орон нутагт байгаа эмч нар хомсодсон орон нутагт эмч нар очих нь хомсодсон. Тэгэхээр тэр орон нутагт ажиллаж байгаа эмч нарыг урамшуулах системийг яаж хэрэгжүүлэх вэ, дээрээс нь энэ орон нутагт ажиллаж байгаа эмч нарын хэрхэн нийгмийн баталгааг нь хангах вэ гээд ийм өөр хөшүүрэг хэрэглэхгүй бол яг энэ нэг батлагдсан байгаа 37 хуулиар төрийн албан хаагчдыг дотор нь янз бүрээр цалин хөлсийг нь тогтоочоод

тэгээд 1 жил болгон тэдэн хувиар цалинг нь нэмье гээд шийддэг. Гэсэн хэдий ч энэ чинь өөрөө шударга бус. Дээрээс нь бид нар чинь эрүүл мэндийн салбарт нөгөө гүйцэтгэлийн үнэлгээг нэвтрүүлж байна гэсэн. Гэсэн мөртөө яг хэмждэг индикаторууд нь бас тодорхой биш ингээд яваад байхаар салбарт бас гажуудал үүсээд байгаа юм байгаа. Тэгэхдээ мэдээж одоо эрүүл мэндийн салбарт энэ асуудлуудаа цаг хугацаанд нь бас сайд Чинбүрэн сайд бол бас ингээд нэлээн олон бас дэвшлүүдийг гаргасан юм байна лээ. Тэгээд цаашдаа бол би энэ төрийн албан дотор тэр дундаа энэ төрийн үйлчилгээний албан хаагч нар дээр энэ ялгамжтай байдлаар цалин тогтоодгийг зогсоох тэгээд тэр 37 хуулийг нь цуцалж нэг одоо хуулиар шударга тэгш нэг зарчим үйлчилдэг байдал руу шилжүүлнэ гэдгийг бас хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэг минут нэмэх үү?

**М.Ганхүлэг:** Бүсчилсэн хэлбэрээр 2024 онд бид бас сонгууль хийгээд ер нь цаашдаа Монгол Улсын гол хөгжлийг бүсчилсэн энэ загвар луу оруулна гэдэг тухай бас амлалтуудыг өгсөн. Түүнтэй холбогдолтой зүүн бүс нутгийн хувьд бас түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болох эрчимжсэн ХАА-н чиглэлээр гол бас хүлээлтүүд бас нэлээн байгаа. Энэ хүрээнд бас ярьж байгаа асуудлууд дээр бас таныг анхаарлаа хандуулж ажиллаасай гэдгийг бас ажил авч эхлэх гэж байгаа энэ цаг үеэс нь эхэлж бас сануулъя гэж бодож байна.

Ялангуяа энэ бас Евро Азийн хэлэлцээртэй холбогдолтой зүүн бүс нутгийн Ульхан, энэ Баянхошуу, Хавирга, Бичигт тэргүүтэй томоохон энэ боомтууд урд хойд хөрш рүүгээ ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг гаргах босоо тэнхлэгийн зүүн босоо тэнхлэгийн төмөр зам гээд олон яригдсан асуудлууд тодорхой бас үр дүн гарахгүй бас байгаа. Тэгээд энэ дээр бас онцгойлон анхаарал хандуулж ажиллахыг цаашдаа бас нэлээн шаардаж бас ажиллана гэдгийг бас танд бас.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганхүлэг гишүүн санал хэллээ. Бадарчийн Хэрлэн.

**Б.Хэрлэн:** Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгэхээр энэ Евро Азийн эдийн засгийн холбоотой холбогдуулаад би нэг 2 зүйл тодруулж асууя гэсэн юмаа. Тэгэхээр та Монгол Улсын Тэргүүн шадар сайдаар ажиллаж байхдаа бас Эдийн засгийн хөгжлийн сайдаар ажиллаж байхдаа Монгол Улс болон Евро Азийн эдийн засгийн холбоо хоорондын худалдааны түр гэрээг байгуулсан. Тэгэхээр энэ гэрээг байгуулснаар Монголд тэр бүр үйлдвэрлээд байдаггүй тэгээд дийлэнх нь ХАА-н чиглэлийн 367 бараа бүтээгдэхүүнийг Евро Азийн холбооны эдийн засгийн холбооны 5 улс оронд татваргүйгээр гаргах ийм боломж бүрдсэн байгаад байдаг. Тэгэхээр 15-50 хувийн татвар төлж мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур гэх жишээтэй ийм хүнсний хүнс, ХАА-н чиглэлийн ийм бүтээгдэхүүнүүдийг гадагш нь гаргаж худалдах ингэснээрээ ЖДҮ-лэл эрхэлж байгаа энэ чиглэлийн ААН-үүд өсөж бойжих орлого ашиг нь нэмэгдэх ийм сайхан боломж нэмэгдсэн байгаад байгаа юм. Сая 2026 оны 2 сард ОХУ-д айлчлах үеэрээ та энэ худалдааны түр гэрээг бас ажил хэрэг болгох тал дээр бас нэлээн тодорхой ажлуудыг хийх хэрээр ярьсан байсан. Тухайлах юм бол нөгөө тарифын бус саад тотгорууд энийг энэ гэрээг яг ажил болгоход бас саад болоод байна тэгээд энийг зохицуулна шийдвэрлэнэ гэсэн ийм зүйл ярьсан байсан. Тэгэхээр яг энэ тухай дээр тарифын бус энэ саад тотгоруудыг багасгах, энэ одоо 2 улс хоорондын худалдааг илүү түргэн шуурхай төвөггүй болгох тухай дээр тодорхой ямар арга хэмжээ авах гэж байгаа бол гэдгийг 1 дүгээрт тодруулж асууя гэж бодож байна.

2 дугаарт нь монголын ЖДҮ-лэл Хүнс, ХАА-н чиглэлийн ЖДҮ-лэл эрхлэгчдийг та бас цаашдаа хэрхэн яаж дэмжье гэж бодож байна вэ? Тэгэхээр энэ цагаан алт тэгээд хүнсний хувьсгал шинэ хоршоо гэсэн энэ хөдөлгөөн хөтөлбөрүүдтэй энийгээ хэрхэн яаж цааш нь үргэлжлүүлж ЖДҮ-лэл эрхлэгчтэйгээ дэмжих ийм бодолтой байгаа вэ? Энийг би тодруулж асууя гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Монгол Улс Евро Азийн 5 улстай түр хэлэлцээрийг байгуулснаараа 3 жилийн хугацаанд 369 бараа бүтээгдэхүүнийг тарифгүйгээр экспортлох бололцоог бүрдүүлсэн. Жишээ нь үхрийн мах 50 хувь тарифтай байсныг тэглэсэн. Хонины мах чинь 15 байсан байх тэр тэглэсэн. Ингээд 369 бүтээгдэхүүн тэглэсэн анх. Энэ хэлэлцээрийн хамгийн сайн дэвшил юу юм бэ гэхээр бараг 81 орчим хувийг нь ийм нөгөө импортолж дотооддоо үйлдвэрлэдэггүй бараа бүтээгдэхүүнүүд эзэлж байгаа юм, харилцан зөвшөөрч байгаа. Тийм учраас дотоодын зах зээлээ нэг талаасаа хамгаалах нөгөө талаасаа бол нөгөө экспорт хийхэд буюу бараг 97 хувь нь ХАА-н салбарын бүтээгдэхүүн экспортлох бололцоог бол бүрдүүлсэн. Одоо бид юу хийх вэ гэвэл Евро Азийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг баталсантай холбогдуулаад хамтарсан төлөвлөгөө батлах юм энэ орнууд. Ингээд тарифын бус татварыг шийдвэрлэх асуудлууддаа бид тохирч байгаа. Дотооддоо хэрэгжүүлэх төлөвлөгөөнүүдийг.

Тэгэхээр эдийн засгийг төрөлжүүлэх хамгийн сайн дэвшил энэ Евро Азийн чөлөөт худалдааны хэлэлцээр. Тэгэхээр дотооддоо бид нар хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө батлаад явна. Энэ төлөвлөгөө дотор бол нөгөө гарал үүслийн гэрчилгээ байна. Нөгөө харилцан тохирлын үнэлгээгээ зөвшөөрөх. Евро Азийн чөлөөт худалдааны гишүүн орнуудын материалыг ашиглан Монголд үйлдвэрлэсэн барааг Монголын гаралтайд тооцох боломжтой болгох, сав баглаа боодол, гарал үүслийн тооцоонд орохгүй байх, 50 хувиас хэтрэхгүй гадаад орц ашиглахыг зөвшөөрснөөр үйлдвэрлэлд уян хатан нөхцөлийг бүрдүүлэх гээд хэд хэдэн асуудлуудыг тохирч байгаа. Ингээд энэ хамтарсан замын зураг нь гарсны дараа бол энэ хэлэлцээр илүү үр дүнд хүрнэ. Одоогоор энэ чинь бүх улсын парламентаар 5 орны парламентаар батлагдсан одоо зөвхөн Армениас бусад бүх орнууд нь парламентаараа ороод соёрхож баталчихсан.

Тэгэхээр энэ хэлэлцээр өөрөө энэ Ерөнхийлөгчийн санаачилж байгаа цагаан алт хүнсний хувьсгал энэ атрын 4 дүгээр аянууддаа бол илүү уялдана гэж бас ойлгох боломжтой. Тэгээд энэ бас үр дүндээ хүрснээрээ эдийн засаг төрөлжинө өө гэдгийг хэлье ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Учрал даргыг дэмжиж байгаа. Нэг хэдэн зүйлийг бас захиж бас хэлье ээ. 1 дүгээрт түлш шатахууны маш эгзэгтэй үед томилогдож байгаа. Нэн яаралтай одоо энэ түлш шатахуун нэгэнт ойлгомжтой суурь үнэ учраас бүх юм хөдлөх ийм бас эрсдэл байгаа. Тийм учраас энийг дагасан иргэд ААН байгууллагаа хамгаалах төлөвлөгөөг маш оновчтой, шуурхай, нийгмийн хамгааллын болон энэ сөрөг үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө яаралтай оруулж ирнэ гэж бодож байгаа. Тэгээд энийгээ бас тэр төр, олон нийт, иргэд, нийгмийн түнш байгууллагуудтайгаа маш сайн ярилцаж оруулж ирээрэй. Тэгэхгүй бол төрийн нэг

шийдвэр гардаг нөгөө талд нь янз бүрээр улс төржиж ч хандах юм. Хэт ингээд хаваржин зунжингаа улс төржсөөр байгаад бас ажил хийлгэхгүй ийм зүйлүүд бас тулгарах эрсдэлтэй учраас бас зориуд энийг хэлж байгаа юм.

2 дугаарт та бас түрүүн нэлээн ярилаа. Энэ бүтэц зохион байгуулалт гэдэг нэг гоё нэрийдлийн дор энэ нэг төрийн албыг бид нар чинь тэгээд л нэг тодорхой хугацааны давтамжтай л дуусгаж байна даа. Үнэхээр чадалтай мэдлэгтэй зарим хүмүүс нь яадаг вэ гэхээр нэг төрд байхынхаа оронд нэг түр зуур ашиглаад авъя тэгээд нэг сурч авъя эс үгүй бол, эс үгүй бол нэг виз хүртэл нэг ашиглаж аваад явъя гэсэн л нэг ийм хандлага руу явчих бас эрсдэл байгаа. Тийм учраас энийг бид нар урт хугацааны бодлогын хүрээнд төрд тогтвортой ажлаа хийж чаддаг, шуурхай хийж чаддаг уураг тархи болсон хүмүүсийг цаашид итгэл үнэмшил өгөх энэ тал дээрээ бас нэлээн анхаараарай гэдгийг хэлнэ. Мэдээж засгийн бүтэц тодорхой хэмжээгээр хөдөлж таарах байх гэдгийг хэлмээр байна.

3 дугаарт нь иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх тал дээр хүлээлт бас их өндөр байна аа. Бид нар чинь энэ жил боловсролын жил, ирэх жил эрүүл мэндийн жил гэдэг байдлаар нэг 2 суурь салбарынхаа цалин хөлсийг нэг хөдөлгөөд авъя гэдэг үүднээсээ ажилласан. Дутуу алсан могой шиг орхисон. Энэ одоо хамгийн түрүүний асуудал болж орж ирэх байх. Цалингийн бүтцийн хувьд өөрчилж болох ч гэсэн цаашдаа шинэ хуучин нэр томъёо бодож олоод, шинэ цалин хуучин цалин гээд янз бүрийн байдлаар нэг түр зуур аргалаад ингээд өнгөрөөх ийм шийдвэрүүдийг цаашид битгий гаргаарай гэдгийг хүсмээр байна. Үнэхээр одоо зарим зүйл байгаа бол үнэнээ хэлээд, нөгөө талаар зөвхөн цалингаас гадна энэ төрийн албан хаагчийг авч үлдэх тэр орон сууцын хөтөлбөр гэдэг зүйл дээр нэлээн л их ярилаа. Одоо яг ний нуугүй хэлэхэд хэчнээн төрийн албан хаагч хэзээ яаж орох юм гэдэг зүйл хүртэл бас маш тодорхойгүй байгаад байна. Энэ тал дээр ялангуяа хөдөө орон нутагт сая дөнгөж саяхан надтай нэг Монголын хамгийн зах хязгаар нутгийн нэг сумын эрхлэгч орж ирээд ярилаа. 5 багш дутуу химийн хичээл ороогүй 4 жил болж байна гэж байна. Тэгэхээр тэр сум эмч байхгүй тэгээд гэх мэтчилэн энэ зүйл дээр тэр орон сууц нийгмийн хамгааллын асуудлыг маш тодорхой болгож дуншиж байгаа энэ хөтөлбөрүүдээ маш ойлгомжтой болгох зүйлийг хийгээрэй гэдгийг захимаар байна аа. Нэг минут нэмээд авчихъя дуусгачихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэг минутаа сунгая.

**С.Эрдэнэбат:** Тэгээд танхимын бүтцийн хувьд мэдээж салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн ийм хүмүүс нь байх нь зөв байх аа. Олон хүн сайд болох гоё гүйлдэж л байгаа байх. Гэхдээ сайд болно гэдэг нэг талаар тухайн салбарынхаа асуудлаас гадна бусад салбаруудтайгаа уялдаж ажиллах ийм хариуцлага маш чухал байдаг. Доороо одоо магадгүй хавь ойр гэдэг юм уу, ойр дотнынхоо цуглуулчхаад, эс үгүй бол зөвхөн өөрийнхөө тойргийг нэг малласхийгээд ингээд яваад байвал энэ их явцгүй. Таны нэлээн том дүр зургаар харж байгаа ажлыг бол одоо хамтдаа ачаа үүрээд зарим үед өөрийгөө золиослоод ч гэсэн ингээд зарим зүйл дээр хойшоо суугаад нийтлэг эрх ашгийн төлөө явчих бас ийм баг бүрэлдэхүүн чухал байх гэдгийг хэлмээр байна. Тэгэхээр ард түмний ярьж хэлж байгаа зүйлийг мэдэрдэг зүгээр аргалаад өнгөрдөг биш ерөнхийд нь ярьчихдаг биш тийм багаар бүрдүүлээрэй гэдгийг хүсмээр байна аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Амгаланбаатарын Ганбаатар.

**А.Ганбаатар:** Учрал гишүүнд баяр хүргэе. Ардын намын дарга ингээд Монгол Улсын Ерөнхий сайд болох нь тодорхой харагдаж байна аа. Яах вэ түрүүнд бүлгийн хурал дээр би танаас асуусан. Цаг хугацааны хувьд намар ч юм уу, дараа жил ч юм уу онолын хувьд гэдэг юм уу хувьсгалын тохироо нь тэртээ тэргүй Ерөнхий сайд дээр тодрох нь магадлал өндөр байсан. Тэгээд өөрөө та хариулсан арай хүсээгүй хугацаанд авах шиг боллоо. Арай эрт авчихав уу гээд. Тэгээд таны өмнө эдийн засгийн хүндрэл нөгөө талд нь идэж уусан энэ авлигалын асуудал гээд ийм 2 асуудал тулж байна аа. Түрүүн би асуусан асуултаа дахиад асууя. Эдийн засгийн хүндрэлийн хувьд та асуудал шийдлээ гаргаад явах байх. Энэ дотор таны тэр чөлөөлье дотор татварын дарамтаас яаж чөлөөлөх юм бэ? Татварын багц хуулиуд хэлэлцэгдэхээр орж ирсэн байсан энэ дотор ерөөсөө тоо тавигдаагүй байна л даа. Тухайлбал тэр НӨАТ-ын 2015 онд гаргасан тоо байж байгаа 50 саяас тэгээд 50 саяын тоог ерөөсөө хөдөлгөөгүй. Энийг дээшээ та хэд хүргэж чадах юм бэ? Ядаж 1 тэрбум хүргэх юм бол энэ ААН-үүд чинь нуруу нь жоохон амрах гээд байна л даа. НӨАТ-ын асуудал дээр. Аргаа бараад өнөөдөр Баярмаа гишүүн тэргүүтэй хүн амын орлогын албан татварын нэг хувьд хүргэх ийм хуулийн төсөл өргөн барьж байна. Энэ дээр ч гэсэн орлогын албан татварынхаа наяд хувийг татварт өгч байгаа иргэдийн нурууг бас яаж чөлөөлөх юм бэ гээд. Ингээд татварын багц хуульд таны чөлөөлье бодлогын хүрээнд ямар ямар асуудлуудыг шийдэх вэ? Тоотой хэлэх боломж байна уу?

Занданшатар сайдын Хууль зүйн сайд томилогдож байхад би бас хэлж байсан нэг үг байдаг юмаа. Хэрвээ энэ асуудал авлигын асуудлыг гаргаж ирээд үнэхээр Их Хурлаар оруулаад шийдэж чадах юм бол ард түмэнд харуулах юм бол та баатар болно оо гээд Ардын баатар. Хийж чадахгүй бол ардын мянгуужин болно гэсэн үг. Энхбаяр сайд өнөөдөр мянгуужин болоод үлдэх юм шиг байна аа. Тэгээд энэ Хууль зүйн сайдаа та ямар хүнээр сонгох юм. Эсвэл энэ хүнийгээ үргэлжлүүлж ажиллуулаад энэ илд сэлмийг нь гаргах юм уу? Сүүлд авсан судалгаан дээр байгууллагыг нь би санахгүй байна. Ард иргэдийн авлигалтай тэмцэх тэмцэл авлигал хээл хахууль хамгийн том асуудал гэдэг хариулдаг байсан нь бүүр хойшоо үсрээд 5, 6 руу орчихсон байж байна. Үнийн өсөлт, амьжиргааны түвшин, ажлын байр гэдэг асуултууд л санааг нь зовоож байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр энэ авлигал чинь ард түмэн хүмүүст дасчихжээ. Эрх баригчдын авлигалыг ерөөсөө дасчихлаа. Авлигалыг шийдэж чадахгүй юм байна энэнийхээ оронд амьжиргаагаа хөөе гэдэг асуудлаар ард түмэн орчихсон байна.

Тэгэхээр та намын дарга, Ерөнхий сайд засгаа байгуулахад мэдээж эвсэж таарна. Тэр эвсэлд нэр орж байгаа хүмүүс дотор чинь нэр холбогдсон хүмүүс явж байгаа, явагдаад байна. Тэгэхээр авлигатай та яаж тэмцэх юм бэ ийм Ерөнхий сайд байж чадах уу энэ асуудлыг шийдэх. За баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Засгийн газраас Татварын багц хуулийг өргөн мэдүүлсэн байгаа. Хувь хүний орлогын албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль энэ 7 хоногт чуулганы хэлэлцэх асуудалд байгаад өчигдөр татаж авчихсан юм байна тиймээ гэж ойлголоо шүү дээ. Тэгэхээр миний хувьд баримталж байгаа зарчим бол татвар төлдөг нь хохирдог, төлдөггүй нь хождог энэ тогтолцоог л шударга болгох өөрчлөлт хийх хэрэгтэй тийм. Тэгэхгүй бол одоо төлөөд байдаг нь хохироод байдаг төлдөггүй нь болохоор хожоод ингээд яваад байдаг. Тийм учраас би энэ татварын барьсан багц хуулийг бол Засгийн газар татаж аваад дахиад

оруулж ирэх хэрэгтэй. Их Хурал дээр Соронзонболд гишүүний ажлын хэсэг ажилласан. Тэр ажлын хэсэгтэйгээ нэгдээд энэ татварын шинэчлэлийг бол бас өргөн агуулгаар нь хийх хэрэгтэй. Энэ татварын шинэчлэлийг дамжуулж, үүний цаана өөрөө, асар өндөр ач холбогдол байгаа юмаа. Ийм чөлөөлье гээд байгаа санаачилгыг нь ч гэсэн гол зорилго үүнд чиглэж байгаа учраас бид нар Татварын хуулийг татаж аваад буцаж оруулж ирэх нь илүү зохимжтой юм байна. Тэгж байж яг нэг нийгмийн хүлээлтдээ хүрэх дээрээс нь яг аливаа зүйлийг хийе, бүтээе, хөдөлмөрлөө гэсэн хэн бүрийн нуруун дээр байгаа ачааг илүү хөнгөлөх, чөлөөлөх ийм боломж бол үүснэ гэж ойлгож байгаа. Тэгэхээр өргөн барьсан хуулиа татаж аваад эргээд оруулж ирнэ гэдгийг танд хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Отгоншарын Батнайрамдал.

**О.Батнайрамдал:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Учрал даргыг Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшиж байгааг дэмжиж байгаа хувь хүний хувьд дэмжинэ ээ. Яг энэ цаг мөчид бас нэлээн олон гишүүн хэлчих шиг боллоо. Гадаад хүчин зүйл нэлээн сорилттой нефтийн газрын тосны үнэ дэлхийн зах зээл дээр бас нэлээн өсөлттэй. Энэ нь буцаад жишээлбэл дараа сараас эхлээд дизелийн үнэ литр тутамдаа бараг 2 мянган төгрөгөөр нэмэгдэх үүнийгээ дагаад инфляц гээд нэлээн олон асуудлууд тулгарах нь ээ.

Тэгэхээр Ерөнхий сайд таны хувьд яг энэ хүнд мөчид зарлагаа хэрхэн танах вэ, орлогоо хэрхэн бодитоор нэмэгдүүлэх вэ гэсэн л толгойны өвчин гарч ирнэ л дээ. Орлого дотроос орлогын угаасаа нийт орлогын 80 хувийг нь нүүрс зэс л бүрдүүлж байгаа. Тэгээд тэрэн дундаа зэс дээр ОТ дээр хийж байгаа хэлэлцээр буцаад энэ хүнд цаг мөчид бас маш том нэмэлт орлого олох боломж болно оо. Парламентын зүгээс сүүлийн жилийн туршид ОТ дээр Хянан шалгах түр хороо явлаа сонсголоо хийлээ. Олон нийт ОТ дээр явсан сүүлийн 17 жил явсан үйл явдлыг нэлээн сайн ойлгож мэдээллээ авлаа. Улсын Их Хурлын 120 дугаар тогтоолыг ч гэсэн бид нар хамтдаа энэ танхимд сууж байгаад баталсан. Та Улсын Их Хурлын дарга байхдаа 120 дугаар тогтоолыг баталж энэ тогтоолыг харах юм таны гарын үсэг байдаг. Буцаад энэ 120 дугаар тогтоол хэрэгжүүлэх үүрэг нь Ерөнхий сайдын хувьд дахиад өөр дээр нь ирж байна. Тэгэхээр энийг бас илүү ерөөлтэй гэж харж байгаа. Өөрийнхөө баталсан тогтоолыг тэгэхээр өөрөө хэрэгжүүлэх үүрэг танд бас ийм хариуцлага бас ирж байна аа.

Тэгэхээр ОТ-н хэлэлцээр үе үеийн Засгийн газрууд үүн дээр алхам хийхээс бол ачаа гэж харж ухардаг байсан. Энэ бодит үнэн. Харин энэ удаа ОТ-н хэлэлцээр Монгол Улсын эрх ашгийг хангахад энэ эдийн засгийн хүндрэл цаашдаа явахад маш том боломж шүү. Монгол Улсын эдийн засаг дээр явж байсан хямралууд Рио Тинто дандаа ашигтай байсан. 2009 онд, 2015 онд хэлэлцээрүүд явахад эдийн засгийн хямралыг стратегитай ашиглаж өөртөө давуу байдалтай гэрээ байгуулсан. Яг энэ тактикийг буцаад өөрсдийнхөө хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газар ашиглах ёстой. Цаашдаа цастай бороотой байх нь. Энэ мөчид ОТ дээр бид нар заавал үр дүн гаргаж явах ёстой. Энэ нь буцаад Засгийн газарт буцаад бид нарын тулгарах хүндрэх бэрхшээлд.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэг минут Батнайрамдал гишүүнд сунгая.

**О.Батнайрамдал:** Нэмэлтээр маш том боломж олгоно оо. ОТ өнөөдөр 4-5 тэрбум долларын орлого олж байна. Цаашдаа ч эндээс ахина. Зэс алтны үнэ

дэлхийн зах зээл дээр рекорд түвшиндээ хүрч байна. Хамгийн гол нь яг эзэн нь болох 3.5 саяын хангалттай мэдээлэлтэй болсон. Тэгэхээр энд анхаарлын төвд хангалттай авчирсан. Тэгэхээр энэ дээр заавал үр дүн гаргаарай. Та энэ дээр ОТ дээр өөрийнхөө баталсан тогтоолыг хэрэгжүүлэх дээр өв үлдээсэн хэлэлцээрийг эцэслэх үү. За ингээд нэмж асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Батнайрамдал гишүүнд баярлалаа. ОТ-н бүлэг ордоос Монгол Улсын эрх ашгийг хамгаалах, хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх талаар Их Хурлын 120 дугаар тогтоол гарсан. Тэгэхээр Батнайрамдал гишүүн сонсгол хийж энэ ОТ-н түр хороог байгуулж ажилласан. Тэгээд үүний хүрээнд ОТ-д төсөл дээр цаашдаа бид нар хэрхэн хэлэлцээр хийх вэ, илүү одоо Монголын талын өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг дээр баримтлах удирдамжтай болсон Түр хороо. Энэ удирдамжийг өгсөн. Тэгэхээр энэ удирдамжийн дагуу Засгийн газар ажиллана. Энэ удирдамж дээр энэ Засгийн газарт чиглэл өгсөн энэ тогтоол дээр нэг маш чухал заалт байгаа нь юу вэ гэвэл тэр өгөөжийн 53 хувь нь Монголын тал байна аа. Энэ 53 хувийг л бид нар хангуулахын тулд хэлэлцээрийгээ, хож хож гэсэн зарчим дээр хийнэ гэж та бүхэн бас ойлгож бол болно.

Тэгэхээр Занданшатар даргын тэргүүлсэн Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа, байр суурь бол ОТ дээр цаашдаа минийх ч гэсэн энэ засгийнхаа бодлого үйл ажиллагааг ижилхэн ийм байр суурьтайгаар аваад явна. Хэлэлцээрийг бол өнгөрсөн хугацаанд бас одоо хийж байсан. Тийм ч учраас энэ ОТ-доо илүү өгөөжөө эрт хүртэх 53 хувьдаа хүрвэл хүртэх чиглэлээр санхүүгийн модель гаргаж дахиж хэлэлцээрт орж энийгээ үр дүнд хүргэх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Тэгэхээр хэлэлцээрийг мэдээж цаашаа үргэлжлүүлээд явна. Харин та Батнайрамдал гишүүн та болон энэ ажлын хэсгийн гишүүдээс хүсэхэд яг өгөөжид жишээ нь яг ямар ямар төлбөр татвар хамаардаг юм бэ гэдгийг тодорхой хуульд тусгаж өгөөч ээ.

Монгол Улсын Үндсэн хууль бол нөгөө газрын хэвлийн баялгийн дийлэнх нь ард түмний мэдэлд байна гэхээр 51 хувь мэдэлд байна гээд байдаг. Тэрэн дотор усны төлбөр орох юм уу, газрын төлбөр орох юм уу, орлогын албан татвар нь орох юм уу өөр ямар төлбөр татвар орох юм бэ гэдгийг хуульд тодорхой тусгаж өгч хэвлэл дараа нь хэлэлцээр хийхэд бол маш их амар хялбар болно. Тийм учраас хуульдаа бас өөрчлөлт оруулаарай. Тэгээд цаашаа бол зөвхөн энэ ОТ-оос гадна бусад том төслүүдтэй бол бид нар энэ хуулийнхаа дагуу өгөөжөө яриад явж бол болно. Гэхдээ бид аливаа асуудалд дандаа шинжлэх ухаанчаар хандаж байх ёстой. Одоо хөрөнгө оруулагч нарыг үргээдэг энэ байдлаа зогсоёе оо. Гуйж урьж авчирчихаад хөөгөөд гаргадаг болчхоод байна шүү дээ. Тэгэхээр хөрөнгө оруулагч нарыгаа урьж авчирсан бол хүндэтгээд ингээд хөрөнгө оруулагч нартаа ээлтэй улс бол манай улс болох ёстой шүү дээ. Тийм учраас энэ хүрээндээ нөгөө худалдааны нэг цонхыг нэвтрүүлнэ. Худалдааны нэг цонхыг тэгж байж бас олон нийтдээ энийг танилцуулж байж бол цаашаа хөрөнгө оруулалт татах ажлууд бол бас эрчимжинэ. Тэгээд хууль буцааж хэрэглэхгүй тухайн хуулийн хүрээнд хэлэлцээр хийсэн бол хүчин төгөлдөр үйлчилнэ гэдгийг хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батнайрамдал гишүүн нэг минут.

**О.Батнайрамдал:** Нэр дэвшигч яг болоод орж ирж байх үед бас яг таны тэр үгийг сонсох гэсэн юм л даа. Энэ дээр маш олон хүний том түүхэн хүлээлт байгаа юмаа. Тэгэхээр бид нар тогтоол нэгэнтээ батлагдсан энэний хэрэгжилт заавал хангагдах ёстой. Тэгэхээр энэ хангагдтал парламентын зүгээс бид нар бүх шаардлагатай алхмыг хийж бас таныг шахаж ажиллах болно оо. Энэ өөрөө бас түүхэн шийдэл байх ёстой. За товчхон бас нэг асуулт асуумаар байна. Бид нар боловсролын реформ гээд л олон зүйл ярьж байгаа. Гэтэл энэ хиймэл оюуны эрин үед чинь бид нар дараагийн 4 жилдээ энэ боловсролын системийг реформ хийж амжаагүй байтал тэр чигээрээ хиймэл оюун бидний бодоогүйгээр өөрчиллөө шүү дээ. Тэгэхээр энд энэ хиймэл оюуны эрин үед та бас шинэ залуу цахим хөгжлийг хариуцаж байсан сайдын хувьд Ерөнхий сайдын хувьд яг ямар алхам хийх вэ? Эндээс маш олон залуучууд бас хариулт хүлээж байгаа гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Засгийн газрыг бол И-кабинет манай энэ зарим гишүүд байна. Одонтуяа сайд гээд бид нар чинь нөгөө кабинетад байхад рийл таймаар бүх мэдээллийг хардаг болсон. Одоо үүнийг өгөгдөлд сууриалаад шийдвэр гаргана. Хүн оролцохгүйгээр энийг хийж дуусгана аа. Тэгж байж энэ шуурхай горим дээр энэ хурдан хугацаанд шийдвэр гаргалт явахгүй энэ техник ажилд хэт их цаг зараад байгаа байхгүй юу. Хүн оролцох шаардлагагүй энэ техник ажилд. Тэгэхээр үүнийг хийнэ. Дээрээс нь хиймэл оюун дээр баримтлах ийм үндсэн чиглэлээ чиг зүгээ тодорхой болгоно. Дээрээс нь зөвхөн технологийн салбарт судалгаа хийж байгаад 1-2 аймаг дээр энэ эдийн засгийн тусгай бүс байгуулах ажлуудыг эрчимжүүлнэ. Тэгэхээр ер нь бол хиймэл оюуныг дэмжих чиглэлийн бодлого зорилтуудыг гол тэргүүлэх чиглэл болгоно оо.

**Ж.Бат-Эрдэнэ:** Салдангийн Одонтуяа.

**С.Одонтуяа:** МАН-ын дарга Ерөнхий сайдад горилогч Улсын Их Хурлын дарга асан Учралд бас хандаад хэд хэдэн үг хэлье гэж бодож байна. Бямбацогт дарга аа, та дараа нь болчхож болох уу? Би Учрал даргад чухал юм хэлэх гэсэн юм. Би танд амжилт хүсье. Гэхдээ та нэг зүйлийг онцгой анхаарахгүй бол таны ажил мөн өмнөх Ерөнхий сайдуудын л араас орно. Энэ юу вэ гэхлээр танай нам бол ерөөсөө энэ албан тушаалын хэнээ эрх мэдлийн шуналаар хэлхэлдсэн хүмүүсийн цуглуулга болсон байна. Энийг та намын даргын хувьд өөрчлөхгүй бол энэ таны ажил хэзээ ч амжилтад хүрэхгүй. Дахиад л жилийн дараа таныг энэ хэнээтнүүд чинь дараагийнх нь сайд болно гээд таныг огцруулахад бэлэн ийм байдалд танай намынхан орсон байна аа. Хамгийн ойрын жишээ бол анх 2024 оны сонгуулиар АН-ыг засагт урихдаа юу гэсэн бэ гэхээр одоо энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр байгуулагдсан энэ бүх Улсын Их Хурал, Засгийн газар бид нар үр дүнд хүргэхийн тулд хамтарч ажиллаач ээ гэж урилга ирүүлсэн. Энэ урилгыг бид бас хүлээж авахдаа үнэхээр бас улс орны хөгжлийг бодоцгооё оо гээд ингээд бид сайн ажилласан. Танай гишүүд юу гэж ярьж байгаа вэ гэхээр АН-ынхан сайн ажилласан үнэн. Гэхдээ манайд чинь сайд болох маш олон хүсэлтэй хүмүүс байна шүү дээ гэж. Тэгэхээр танай намын энэ удаа дараагийн хагарал бол улсын хөгжлийг чөдөр мэт тушиж байна аа гэдгийг та нэг сайн ойлгочхоорой. Тэрнээс биш энэ эдийн засаг янз бүрийн нөхцөл байдал мөнгө төгрөггүйдээ биш. Тийм учраас энэ өмнөх 2 Засгийн газрыг АН биш Ардын намын албан тушаалын донтой хүмүүс огцруулсан шүү гэдгийг та үргэлж санаж явах хэрэгтэй.

2 дугаарт АН-аас болоод Улсын Их Хурал гацчихлаа гээд ярьсан. Гэтэл Занданшатар даргыг огцруулах болохоор бүгдээрээ орж ирээд кнопоо дараад огцруулчхаж байгаа байхгүй юу. Энэ чинь бол зүгээр улс орны эрх ашгаа бодсон биш, намын эрх ашгаа бодсон биш зүгээр л ерөөсөө нөгөө албан тушаалын л хэнээ. Энэ засгийг огцруулж дараагийн сайд нар гаръя гэсэн. Би 2012-2016 онд санаж байна. МАН-ынхан ирчхээд картаа хийдэггүй байсан. Эхлээд та нар олонх ирцээ бүрдүүлчих ээ, тэгээд бид нар ирц хүрэхээр картаа хийе гэдэг байсан. За ингээд чуулганы хаалгыг таглаад дивантай буйдантай эсэргүүцэл гээд ингээд хуралдуулдаггүй ийм юм зөндөө л байсан. Тэгэхээр энэ удаагийн юу бол энэ танай намын огцруулсан шүү гэдгийг та бас үргэлж санаж явах хэрэгтэй.

Нэг чухал асуудал юу вэ гэхээр хагаралдах үедээ нэгнийгээ бүүр хулгайч худалчаар нь дуудаад бүүр ёстой энд байхын суухын аргагүй болгох юмаа. Гэтэл одоо та нар бас ингээд цаашаа нэгдээд янз бүрийн юмаа халхлах гэж байгаа сураг байна. Ийм тохиолдолд сөрөг хүчин бид нар ард иргэдтэйгээ нийлээд энэ бүх хяналтыг...

**Ж.Бат-Эрдэнэ:** Салдангийн Одонтуяа гишүүнд нэг минут.

**С.Одонтуяа:** Би танаас намын даргын хувьд та энэ мөрийн хөтөлбөрөө ер нь үзсэн үү? Хэдэн хувийн биелэлттэй байна аа? Энийг өнгөрсөн энэ 2 жилийн хугацаанд бид нар биелүүлж амжих уу? Танай нам гэдгийг асуумаар байна. Дээрээс нь энэ эрүүл мэндийн салбартаа та МАН-ынхаа сайдыг тавих ёстой. Яагаад гэхлээр үеийн үед ингээд л янз янзын сайд нар очоод энэ салбарыг чинь самарч дуусаж байна шүү дээ. Дээрээс нь Эрчим хүчний сайдаа МАН өөрсдөө авах ёстой. Ингэж байж та нар хариуцлагаа хүлээнэ. Тэрнээс биш зүгээр өө тэр нам, энэ нам гээд ингээд чихээд явах юм болохгүй гэдгээ би танд зөвлөө. Яагаад гэхлээр энэ 2 бол өнөөдөр хамгийн чухал салбарын нэг болчхоод байгаа. Тэгээд ер нь бол энэ дэлхийн олон улсын байдал энэ хөрш орнуудтайгаа зөв зүйтэй харьцахгүй бол нэг өдөр энэ ганцаараа хөгжөөд, ганцаараа бие даагаад шийдвэр гаргадаг юмнууд чинь олон улсад явахаа больчихлоо. Тийм учраас энэ хөрш орнуудтайгаа бүсийн бүс дамнасан энэ хөгжил орнуудтай.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Цэндийн Баатархүү. За Учрал гишүүн.

**Н.Учрал:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. 11 сарын 17-нд намын даргаар Их Хурлаараа сонгогдсон. Ингээд 2024 онд орон нутгийн болон Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн намынхаа мөрийн хөтөлбөрийг үнэлэх ажлыг эхлүүлсэн. Ингээд мөрийн хөтөлбөрийн нэгж байгуулсан. Нэг ёсондоо амласан амлалтаа хэрэгжүүлдэг эргээд хянадаг шаарддаг болох ёстой. 2024 онд хамтарсан засаг байгуулагдахад тухайн үед би энэ хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг ахлаад АН-ын мөрийн хөтөлбөрийн 2 бараг бүтэн бүлгийг өнөөдрийн энэ Их Хурал баталчихсан байгаа 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан юм. Засгийн газрын өнөөдрийн үйл ажиллагааны хөтөлбөр бол 33 хувийн гүйцэтгэлтэй гэдэг ийм дүн гарсан юм байна ер нь бол. Хэрэгжилтийн явц нь бол 55 хувь хүрчихсэн ийм гүйцэтгэлтэй байгаа юм байна. Энийг бол зүгээр Засгийн газар өөрөө нөгөө гүйцэтгэлийн үнэлгээгээ хийсэн.

Манай намын мөрийн хөтөлбөр дээр бол би түрүүн Байнгын хорооны хурал дээр бол бас хэлсэн. Намын мөрийн хөтөлбөрийн үнэлгээгээр 29 хувьтай гэж дүгнэсэн юм байна лээ. Энэ өөр өөр дүгнэлтүүд нэг ёсондоо Засгийн газрын

хөтөлбөр хамтарсан засгийг бүрдүүлж байсан намуудын нэгдсэн хөтөлбөр. Тухайн үед би ахлаад Гантөмөр сайд Эдийн засгийн сайд байхад бид нар оролцоод хийж байсан. Тэгэхээр энэ бол аль нэгэн нам эвслийн биш. Энэ бол хамтарсан Засгийн газрын үед боловсруулагдсан буюу бараг 70 хувь нь уялдаж байсан байхгүй юу. Тэгээд бидний зовлон ижилхэн. АН байна уу, Ардын нам байна уу энэ бид нарын зовлон ижилхэн. Тэгэхээр мэдээж энэ зовлон ижилхэн учраас тэр зовлонг шийдэх гэж асуудлыг шийдэх гэж бид нар явж байгаа байхгүй юу. Тэгэхээр манай зүгээр эрх барьж байгаа намын хувьд асуудал тулгардаг, унаад босдог, алддаг, онодог, гэхдээ сорилт бэрхшээлийг дандаа туулж ирсэн ийм л нам.

Тэгэхээр би энэ эрх барьж байгаа намын хувьд би энэ намыг амьд организм гэж бодож байгаа. Амьд организм нөгөө өвчнөө анагаагаад ингээд явдагтай адилхан. Тэгэхээр 11 сарын 17-нд намын даргаар Учрал гэдэг хүн сонгогдсон тэр цагаас хойш миний он цаг хугацаа эхэлсэн. Тэгэхээр энэ цаг хугацаандаа би эзэн байна аа. Тийм учраас энэ цаг хугацаан дээр хэн нэгэн намын нэр хүндийг гутаах, улс орны эрх ашгийг хойноо тавих, сандал суудал ярьж явж байгаатай би эвлэрэхгүй. Тийм учраас таны яг хэлж байгаа энэ авлигатай тэмцэх энэ ёс зүй, сахилга хариуцлагыг тэргүүн ээлжид тавих бодлогоо намын даргын хувьд ч тэр, гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд ч тэр бол цаашид зарчмаа болгож ажиллана. Тэгэхээр энэ зарчмаа бол урдаа тавина аа гэдгийг би бас танд хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэндийн Баатархүү гишүүн алга байна, байна уу?

**Ц.Баатархүү:** Ерөнхий сайдад нэр дэвшигчдэд амжилт хүсье. Цахим хөгжил хөгжлийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэхийн сайд, Тэргүүн шадар сайд, Монгол Улсын Их Хурлын дарга одоо ингээд Монгол Улсын Ерөнхий сайд болох гэж байна аа. Бараг Гиннесийн номд орохоор маш хурдтайгаар албан тушаалуудыг ээлжлэн суух гэж байна. Тэгэхээр Монголын нийгэм эдийн засгийн сайн зүйл нь ч тантай хамааралтай саар муу зүйлүүд чинь бас тантай хамааралтай гэдгийг сануулах нь зөв байх аа.

1 дүгээр асуулт бол Монгол Улсын Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орох уу? Засгийн газрын гишүүдийг сонгож урьж ажиллуулахдаа ямар гол 3 шалгуураар сонгох юм бэ? Сүүлийн үед энэ Улсын Их Хурал, Засгийн газарт нэг зүйл ажиглагдаж байна аа. Ерөнхий сайдууд нь өөрчлөгддөг, Засгийн газрын гишүүд нь үлддэг. Өмнөх Засгийн газрын бүрэлдэхүүнээс танай Засгийн газарт үлдэж ажиллаж байгаа сайдуудыг салбараа маш сайн удирдсан гэж үзэж болох уу? 3 дугаарт нь танай Засгийн газрын сайд авлига албан тушаалын хэрэгт холбогдвол та ёс зүйн манлайлал үзүүлж, Засгийн газраараа огцрох уу гэдэг асуултад тодорхой хариулж өгөөрэй.

2 дугаарт нь нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд бие биедээ хэдэн 100 саяар нь авлига өгсөн хээл хахууль дамжуулсан тухай ярих боллоо. Энийг үнэн мөнийг нь тодруулж иргэд олон нийтэд байгаа эргэлзээг тайлах энэ төрийн нэр хүнд ер нь энэ Улсын Их Хурлын нэр хүнд гэдэг зүйл бол хамгийн доод түвшинд очиж байна аа. Тэгэхээр энэ дээр ямар бодитой шийдэмгий алхам хийх юм бэ? Хэвлэл мэдээллээр улсын өмнө тулгамдсан асуудал нь биш албан тушаалаа булаацалдаж байгаа ноёдын, маргаан мэтгэлцээн бие биедээ өгсөн авсан гэдэг зүйл нь өөрөө асуудал болж байна аа. Энэ асуудлыг нэг мөр цэгцлэх тодорхой шийдэл гаргах уу гэдгийг асууя.

3 дугаарт нь салбаруудын бодлогын уялдаа алдагдсан гэдэгтэй санал нийлэх үү? Өнөөдөр Улаанбаатар хот гэдэг Улаанбаатар хотын захиргаа удирдлагууд BRT төсөл, метро төсөл, 2.5 их наяд төгрөгийн үнэтэй Туулын хурдны зам, дүүжин тээвэр гээд дэлхий дээр байдаг хамгийн өндөр өртөгтэй бүхий л төслүүдийг явуулах гэж оролдож байна аа. Гэтэл зам тээврийн салбар чинь бид энэ тухай мэдээлэл байхгүй ээ. Хот мэднэ гэж байна аа. Энэ мэтчилэн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баатархүү гишүүнд нэг минут.

**Ц.Баатархүү:** Энэ мэтчилэн энэ салбаруудын бодлогын уялдааг сайжруулах тал дээр Засгийн газар ямар алхмыг хамгийн түрүүнд хийх юм бэ? Үнэхээр Улаанбаатар хот гэдэг Туул голын 2 талаараа хуваагдсан. Богдыг тойрсон уулын амыг нь Байгаль орчны яам өгдөг. Хойд талд нь хот газар олгодог гэсэн атлаа хотын ерөнхий төлөвлөгөө барилга барих зөвшөөрөл өгдөг. Тэр нь өөрөө хууль бус байдаг, гэрчилгээ нь гардаггүй ийм маш замбараагүй байдалтай Улаанбаатар хот шилжсэн байна. Та бас Улаанбаатар хотоос сонгогдсон Чингэлтэй, Сүхбаатараас сонгогдсон гишүүний хувьд энэ нийслэл Улаанбаатар хотын асуудалд хэрхэн анхаарал хандуулах юм бэ гэдэг ийм 3 бүлэг асуулт асуултыг асууя баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Засгийн газрыг бүрдүүлэхдээ Засгийн газрын гишүүдийгээ нэгд ёс зүйтэй байхыг шаардана. 2-т бол хурд чухал байна. Цаг хугацаатай уралдаж ажиллах хэрэгтэй. Тийм тэгээд дуусдаггүй яриануудаа дуусгах хэрэгтэй. Сайхан ярьсаар байтал одоо үр дүн бага гарч байна аа гэж иргэд олон нийт шүүмжилж байгаа шүү дээ. Тэгэхдээ мэдээж асуудлыг шийдэхэд туршлага хэрэгтэй. Тийм учраас эдгээр 3 зүйлийг чухалчилна туршлага буюу энэ улс төрийн капиталтай байх хэрэгтэй. Тухайн салбарыг удирдана гэдэг бол өөрөө менежерийн ажил. Менежер гэдэг хүн бол чаддаг хүнээр нь чаддаг ажлыг нь хийлгэдэг хүнийг хэлж байгаа шүү дээ. Тэгээд менежмент гэдэг бусдаар ажлыг хэрхэн зөв хийлгэх вэ гэдэг. Зөв ажлыг олж өгөх нь буюу тэр лидершип бол өөрөө Ерөнхий сайдын манлайлал түүнийг хэрхэн хийх вэ гэдэг нь тухайн менежерийн чиг үүрэг.

Тийм учраас энэ сайн менежер байх ёстой гэдэг ийм шалгуурыг тавихад мэдээж үүнд туршлага зүй ёсоор яригдана гэж ойлгож байгаа. 2-т тэр төрийн албаны хуулийг та бид нөгөө хамтарсан засагт байх үеэсээ ярьж тухайн үед хууль боловсруулагдаж дууссан шүү дээ. Одоо олон жил ярилаа. Паблик сервис, сиви сервис нийтэд үйлчилдэг алба нийтийн эрх ашгийн төлөө, төрийн цагдаа гэж алга байна шүү дээ. Төрийн эмч төрийн багш гэж алга байна шүү дээ. Тэгээд нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг тэр албыг тэр паблик сервис сиви сервисийг тодорхой болгож өгөх төрийн албаны цогц реформ үүн дээр хоосон улс төржихгүйгээр хамт ойлголцоод явбал энэ хууль тухайн үед бараг боловсруулж дууссан шүү дээ. Шаардлагагүй чиг үүргүүдийг аутсорсинг хэлбэрээр шилжүүлээд явъя гээд. Тэрийг Баатархүү гишүүн өөрөө маш сайн мэдэж байгаа. Тийм учраас энэ төрийн албаны цогц шинэчлэл, дээрээс нь энийг заавал хууль хүлээх хэрэггүй, хууль хүлээх хэрэггүй. Энэ чиг үүргийн давхардлыг арилгах ажлуудыг Засгийн газар өөрийнхөө түвшинд хийгээд явна. Тэгээд олон нөгөө намайг Хэрэг эрхлэхийн дарга байхад өөрийн чинь цахимын сайд байхад бид нар энд яагаад энэ нэг чиг үүрэг ингээд 2 хуваагдчихаад байна аа гээд ярьдаг байсан. Тэгээд яг тэрийг шийдэх арга замыг та ч мэдэж байгаа, би ч мэдэж байгаа. Одоо үр дүнд хүрнэ. Энийг харин зоригтой хийгээд явна гэдгийг бас хэлье

Манай улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл 1 төсөвтэй. Тийм учраас төсвийн сахилга бат хариуцлагыг нэгд сахих ёстой. Тийм учраас энэ нийслэл дээр үүсээд байгаа асуудлууд дээр би ажлаа авсныхаа дараа тодорхой ажлын хэсэг байгуулж, дүгнэлт гаргаж, шаардлага тавьж ажиллана. Энэ дээр энэ асуудал дээр. Тийм учраас бид нар үргэлж бодож байх ёстой. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс шүү. Гэтэл төрийн өмчийн компаниуд болоод төсвийн орлого чинь нийлээд эдийн засгийн харьцаанд 61 хувь хүрчхээд байгаа чинь л өөрөө асуудлын гол нь юмаа гэдэг дээр үнэлэлт дүгнэлт хийж бол ажиллана. Төрийн бодлогын уялдааг эх өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтаар шийдвэрлэх бүрэн бололцоо байгаа. Тэгэхээр эрх зүйн үр дагаваргүй тэр төрөөс олгодог зөвшөөрөл лиценз бүх асуудлуудыг тэр эх өгөгдөл рүү шилжүүлээд шийдвэрлэх системийн хувьд бэлэн. Энийг удаан бас өнгөрсөн хэд нэлээн олон жил ноцолдлоо. Одоо бас гарт энэ эрх мэдэл нь ирж байгаа учраас би энийг ард иргэдийнхээ талд байж шийдвэрлэнэ. Иргэдийнхээ талд байж. Хүнд зориулсан биш агуулгаар нь харж шийдвэрлэнэ. Тэгээд үр дүнгээ хэмжүүлээд явуулна. Тэгээд KPI-аа тавьж байгаад ажлаа үнэлүүлнэ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хажекберийн Жангабыл.

**Х.Жангабыл:** Гишүүдэд оройн мэндийг хүргэе ээ. Монгол Улсын Ерөнхий сайдаар нэр дэвшигч Учрал сайддаа бас баяр хүргэе ээ, ажлын амжилт хүсье ээ. Учрал сайд та бүхнийг бол чадна, хийж чадна. Гишүүд түрүүн бүгдийг нь хэллээ. Та туршлагатай бас ажлын их онцлог ажил хийх тийм онцлогтой. Гэхдээ маш хүнд нөхцөлд та ажил авч байна. Энэ Ойрх Дорнодтой холбоотой дизель түлшний үнэ 4 дүгээр сард 2 дахин нэмэгдсэн байна. Миний мэддэгээр сүүлийн 25 жилд ингэж 2 дахин үнэ нэмэгдсэн ийм нөхцөлийг би хараагүй л дээ. Тэгэхээр манай улсын төсвийг бүрдүүлдэг уул уурхайн компаниуд тэр чигтээ дизель түлшээр л амьдардаг шүү. Дизель түлш л хэрэглэдэг. Тэнд бол ажилладаг оператор компаниуд, одоо цахилгаан гаргадаг генераторууд, тээвэр хийж байгаа тээврийн компаниуд бүгд дизель шүү. Тэгэхээр энэ уул уурхайн нөгөө бүтээгдэхүүн дизель түлштэй хамааралтай болохоор яаж эд нар энэ бүтээгдэхүүнээ гаргаж экспортлох юм бэ? Тэгэхээр энэ төсөв бүрдэх асуудал бол асар их хүндэрнэ. Тэгэхээр энэ асуудлыг бол яаж шийдэх юм бэ? Төсөв бүрдэхгүй бол бүх юм асуудал ойлгомжтой.

Тэгэхээр миний харж байгаагаар бол энд гарц байгаа. Урьд өмнө бид бол ОХУ-аас 90 хувь, үлдсэнийг нь БНХАУ бусад улсуудаас авдаг байсан. Одоогийн байдлаар БНХАУ газрын тосны бүтээгдэхүүнээ экспортлохоо хориглочихсон байна шүү дээ. Одоо бол бид 100 хувь ОХУ-аас л авна. Тэгэхээр ОХУ-ын ярьж байгаа энэ онгоцны түлшний гэрээг яаралтай хийх хэрэгтэй 1 дүгээрт.

2 дугаарт. Та ойрын хугацаанд ОХУ-д төрийн айлчлал хийж энэ асуудлыг шийдэх тал дээр та эхний ээлжид ажиллах хэрэгтэй болов уу гээд бодож байна. Тийм боломж бололцоо байна уу? Ийм асуулт байна. Дизель түлшний үнийг тонн тутамд мянган доллар дотроо тохирох ОХУ-тай тийм ажлыг яаралтай хийх хэрэгтэй. Тийм боломж бололцоо байна уу ийм асуулт байна аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Сая бол Их Хурлын даргын хувиар БНХАУ-д болоод ОХУ-д айлчлал хийсэн. ОХУ-д айлчлал хийх үеэрээ бол бас энэ саналуудаа ярьж байнгын

холбоотой энэ салбарын сайд болоод Засгийн газрын зүгээс холбоотой ажиллаж байгаа. БНХАУ-д бол нефтийн бүтээгдэхүүн тогтвортой нийлүүлэх Засгийн газар хоорондын хэлэлцээр хийхээр санал бол бас илэрхийлсэн. Тэгэхдээ одоо бол мэдээж Ерөнхий сайдын хувиар очиж бас энэ албан ёсны саналуудаа тавьж гэрээ хэлцэл хийх саналуудаа тавьж дахиж ярилцах шаардлага бол үүснэ. Онгоцны түлшний гэрээг Засгийн газраар оруулж Улсын Их Хуралд танилцуулахаар бэлдсэн байгаа гэж надад мэдээлэл өгсөн.

Тэгэхээр би ажлаа аваад Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороогоор энэ асуудлыг оруулна. Тэгээд Хятад талд би энэ саналуудаа хэлэхэд бол бас нөгөө Петрочнагийн асуудлыг шийдээч ээ л гэж байгаа юм. Тийм учраас тэр бол бас хууль эрх зүйн асуудал. Тэгээд ер нь бол хурдан хугацаанд энэ гацаад байгаа асуудлуудыг зориг гаргаад шийдэхээс өөр арга зам байхгүй ээ. Тэгэхээр би шийдлүүдээ хэлээд явна. Нийлүүлэлтийг гацаах ёсгүй, зогсоох ёсгүй, үнэ барина гэдэг бол тун хэцүү. Тэрийг бол одоо бас үнэнийг хэлэх ёстой тун хэцүү. Зүгээр нийлүүлэлтээ бол гацааж болохгүй учраас бүх арга замуудыг эрэлхийлнэ. Тэрнээс биш үнийг ингээд хүчээр барих ч юм уу эсвэл захиргааны хэв шинжтэй тийм арга хэмжээ хэрэглэлээ гээд үнэндээ гүйцэгдчихнэ. Бид нар чинь нэг ийм захиргааны шинжтэй арга хэмжээ хийдэг тэгээд үнэнд гүйцэгддэг.

Тэгэхээр бол цаашдаа илүү үнэн дээр илүү өрсөлдөөн бий болгож байж бүх салбарт ингэж үнэ үнэнтэй нүүр тулж явахгүй бол хүчээр ингээд захиргааны шинжтэй арга хэмжээнүүд авлаа авлаа гээд энэ чинь нэг өдөр л үнэндээ гүйцэгдчихлээ шүү дээ. Эрчим хүчний салбараас авхуулаад тийм. Тэгэхээр нийлүүлэлтийг гацаахгүй байх дээр бол асуудлыг илүү анхаарч явна гэдгийг бас энэ танд онцгойлж хэлье. Тэгээд та бас энэ салбарын хүн учраас мэргэжлийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлж хамтарч ажиллахыг бас хүсэж байна аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жангабыл гишүүн нэг минут.

**Х.Жангабыл:** Тийм. Энэ асуудлыг улс төрийн байдлаар шийдэх хэрэгтэй л дээ ОХУ-тай. ОХУ бол бүх каналаар бүтээгдэхүүнээ зарж байгаа өнөөдрийн байдлаар. Тэгэхээр улс төрийн байдлаар ярьж, үнийг нь буулгах тийм боломж бололцоо байдаг болов уу л гэдгийг асуугаад байгаа юм. Урьд өмнө бол ийм кэйсүүд байсан шүү дээ. Төрийн тэргүүний хүрээнд төрийн айлчлал хийж, ярилцаж ийм алхам хийвэл зүгээр болов уу л гэж бодож байна. Оролдоод үзэх хэрэгтэй. Угаасаа бидэнд бол газрын тосны бүтээгдэхүүний нөөц ч одоохондоо байхгүй байна. Газрын тосны үйлдвэр ч гэсэн ашиглалтад ороогүй байна. Одоо хүнд нөхцөлтэй байна шүү дээ. Одоохондоо бид нар бол энэ хямдарсан 3 сарын.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Шинэбаярын Бямбасүрэн.

**Ш.Бямбасүрэн:** Гишүүддээ энэ оройн мэнд хүргэе ээ. Нэр дэвшигч Учрал гишүүнээс асуултууд асууя. Энэ бүсчилсэн хөгжлийн бодлогоор явна гэж хэлээд манай улс чинь бодлогоо гаргаад зарлачихсан. Тэгсэн хэр нь ерөөсөө сонгуулиа хийх бүсчилсэн хэлбэрээр явуулснаас өөрөөр бол ер нь тодорхой ажил хийгээгүй байгаа. Манай энэ зүүн бүс дээр түүхэн аялал жуулчлал эрчимжсэн мал МАА-н бүс болно оо гээд зарлачихсан. Яг энэ рүүгээ чиглэсэн ажил хөрөнгө оруулалтууд бол юу ч хийгдэхгүй байна. Тэгэхээр энийг ер нь хэдүүлээ цаашдаа юу гэж харах вэ. Төвлөрлийг задлах тал дээр ер нь бодит шийдэл гаргах уу Таны Засгийн газраас

эсвэл ингээд дахиад л улс төрийн амлалт ингээд мэдэгдэл ингээд хийгээд явах уу гэдгийг бас асууя.

Ер нь аймаг сумдуудад эрх мэдэл төсвийн эрх мэдлийг нь ер нь өгөх тал дээр нь хэрхэн ажиллах вэ? Энэ дээр ер нь ямар тодорхой алхмууд хийх вэ гэж бас асуумаар байна. Өнөөдөр бас та гишүүдийн асуултад хариулахдаа энэ ТӨК-иудын асуудлыг энэ дуусдаггүй яриан дээр дуусгана энэ алдагдал үр ашиггүй байдлыг ер нь байхгүй болгоно оо гэж байна. Энэ дээр ер нь ямар хугацаанд та ер нь энэ бодлогоо ер нь хэрэгжүүлэх вэ? Бид нар одоо ард түмэн бол өнөөдөр үндсэндээ үр дүн л нэхэж байна шүү дээ. Маш их тийм улс төрийн гоё ганган хээнцэр үгнүүд улс төрийн мэдэгдлээс үнэхээр залхаж байгаа ирээдүй цаг дээр ярьдаг. Тэгэхээр энэ дээр ямар хугацаанд энэ асуудал руу орох вэ гэдгийг бас асуумаар байна.

Тэгээд энэ асуудлыг цэгцлэхгүйгээр өнөөдөр авлигалын асуудлыг цэгцэлж барахгүй. Авлигалаа тэгэхээр бас хэдүүлээ яах вэ гэдгээ бас асуумаар байна. Авлигал бол дээд шатдаа бол энэ ТӨК-иудаар дамжуулаад гаарсан. Анхан дунд шатанд бол үнэхээр бүүр дээд цэгтээ хүрсэн. Бизнес эрхлэгчдийн нуруун дээр бол яг энэ албан бус татвар болоод байгаа энэ авлигал бол бүүр утгаа алдсан шүү дээ ер нь бол. Бүх бизнес эрхлэгч залуучууд нэг юм санаачлаад очёё гэхээр бичиг зөвшөөрөл дээр очоод гацдаг тэрэн дээр нь шантаажилдаг. Энэ бол ерөөсөө бүүр Монголын нийгэм дэх зүгээр энгийн үзэгдэл болсон. Энийг ер нь цэгцлэх тал дээр танай Засгийн газар ямар арга хэмжээ авах вэ гэдэг асуулт асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** ТӨК-иуд дээр хийх ажил яг хууль батлагдах юм бол Засгийн газраас баримтлах чиглэлийг оруулж ирэх яг ийм хуультай юм. Хуульгүйгээр Засгийн газар өөрийнхөө түвшинд хийж хэрэгжүүлж бас болохгүй зүйл байхгүй. Гэхдээ үүн дээр нэгтгэх, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах гэсэн механизмууд хэрэглэхээс биш яг нөгөө нээлттэй компани болгох хувьчлах тэр асуудал бол мэдээж Их Хурлаар орох ёстой. Энэ бол нийтийн өмчийн асуудал. Тийм учраас Нийтийн өмчийн хууль ТӨК-ийн бүтээмж, засаглал, ил тод байдал сайжруулах хуулийг Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг батлаад өгөхийг хүсэж байгаа. Би Их Хурлын дарга байхдаа энэ чуулганы нээлт дээр ч гэсэн энэ асуудлыг бол ярьж байсан.

Би одоо өөрийнхөө түвшинд гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд ТӨК-иуд дээр аудитуудыг оруулна, урсгал зардлуудыг танана. Зарим компаниуд дээр нөгөө KPI-г нь тавьж байгаад зүгээр гүйцэтгэх захирлуудтай, яг хувийн компаниудтай адилхан нөгөө гэрээт гүйцэтгэлийн гэрээнүүдийг байгуулаад ашиг орлого нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авна. Тэрнээс биш одоо энэ улс төрийн томилгоонууд бол хэн ч очоод тэнд ялгаа байхгүй. Тийм учраас бол энэ ашиг орлоготой ажиллуулах бололцоог нь бүрдүүлэх зорилгоор бол тэр гүйцэтгэх захирлууддаа бол шууд KPI-аа тавьж байгаад Сео контракт гээд угаасаа л хувийн компаниуд хийдэг шүү дээ. Яг л тэрнийхээ жишгээр л явъя л даа. Орлоготой ажиллуулбал мэдээж нөгөө гэрээнийхээ гүйцэтгэлээр санхүүжээд явдаг ийм л ажлуудыг хийгээд явах нь бас зөв байх аа гэж бодож байгаа. Тэрнээс биш цаашдаа энэ зүгээр ингээд нэг хэн нэгнийг сольж тавиад үр дүнд угаасаа хүрэхгүй, хүрэхгүй.

Тэгэхээр 100 хоногийн план буюу 100 хоногийн төлөвлөгөөгөө ажил авсныхаа дараа зарлана. 100 хоног дээрээ би өөрөө KPI-аа тавина. Одоо энэ 5 жилийн чиглэлд ч гэсэн 10 үндсэн үзүүлэлттэй гээд индикаторуудыг тавьж байгаад явж

байгаа шүү дээ. Тэрэн шиг Засгийн газрын ажил салбарын яамдуудаар нь тэр индикаторуудаа тавьж байгаад л ийм үр дүнд хүрнэ ээ. Тэгэхдээ энэ нь өөрөө хэмжигдэхүйц байна аа үр дүн нь гээд явахгүй ингээд уриа лоозон хийгээд тэгээд нөгөө ажил хийсэн үү, үгүй юу форум хийсэн, панел хийсэн, тэдэн юм хийсэн, уулзалт хийсэн гээд байдаг. Яг хууль батлагдсан уу, үгүй юу гэдгийг нь яг татан буугдсан уу, үгүй юу гэдгийг нь яг хэмжих нэгж нь болох ёстой л юм байна лээ. Тэрнээс ингээд хэмжиж болохгүй баахан ийм том том зорилт тавьчихаар үр дүнд хүрэхгүй.

Бүсчилсэн хөгжлийн хүрээнд бол олон төслүүдийг хэрэгжүүлэхээр одоо Засгийн газрын түвшинд бол бэлтгэл ажлыг нь хангаад явсан бараг 29 төсөл байгаа юм байна лээ. Тэгээд би энэ бүсчилсэн хөгжил бол өөрөө Засгийн газрын энэ 4 жилийн та бидний баталсан хөтөлбөрт тусгачихсан зорилт хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэхдээ яаж хэрэгжүүлэх вэ, тэр стратеги нь байлаа ч гэсэн нөгөө тактикийн түвшинд яаж хэрэгжүүлэх вэ гээд компаниар би бол нэг тийм Сео нь болчихоод байна шүү дээ. Тэгэхээр яаж хэрэгжүүлэх вэ гэдэг тактикаа өөрчилж явах нь тэр гүйцэтгэх захирлын үүрэг яг байдагтай адилхан. Би тэрийг өөрөө 100 хоногийн хугацаанд яаж хэрэгжүүлэх вэ гэдэг эрэмбийг нь тогтооно. Тэгээд та бүхэнд бол би энийг танилцуулаад явъя гэж бодож байгаа. Зүгээр татварын хуулийг татаж авч байгаа энэ шалтгаан бол орон нутагт явсан иргэдтэй уулзсан уулзалтын үеэр иргэдийн зүгээс хэлээд байсан асуудал. Тэр татварын бүсчилсэн урамшууллыг орон нутаг дээр гэхэд л тэр нэг км-ийн зай гээд асуудлууд байна аа. Тэгэхээр бүсчилсэн урамшууллыг татварын механизмаар бүрдүүлж байж орон нутаг руу чинь явахгүй бол энэ төвлөрөл буурахгүй гэсэн. Тэгэхээр татварын шинэчлэлээ татаад татварын шинэчлэлийг хийхийн тулд Татварын хуулиа татаж аваад бүсчилсэн хөгжлийг дэмжих бодлогыг илүү хэрэгжүүлж Татварын багц хуулийг...

**Ж.Бат-Эрдэнэ:** Бямбасүрэн гишүүн.

**Ш.Бямбасүрэн:** Яах вэ одоо ингээд Засгийн газрын тэргүүн бас нэг ажил Их Хурлын гишүүн хийхээр өөдөөс ингээд хууль яриад байхаар бас түвэгтэй л байна. Ер нь бол тэгэхдээ энэ нэг аймаг сумдад өгөх эрх мэдлийг бол шилжүүлэх эрх бол байгаа Засгийн газар. Тэгэхээр энийг бас хэрэгжүүлж ажиллахыг бас хүсэж байна.

Ахиад нэг асуулт дутуу байсан. Ер нь энэ уул уурхайгаас хамааралтай эдийн засгийн бүтцээ ер нь багасгахдаа ер нь яг аль салбар дээр ер нь төвлөрч ажиллая гэж бодож байна вэ? Энэ дээр бас нэг тодорхой хариулт хэлээд өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн. Баатархүү гишүүн сая ярьж байгаад асуулт сонссонгүй тиймээ. Болдын Уянга.

**Б.Уянга:** Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр өнөөдөр бүгдээрээ энэ дэлхийн улс орнууд ер нь энэ дэлхийн хэмжээнд эдийн засагт тодорхой бус нөхцөл байдал үүссэн гээд их олон гишүүд давтаад давтаад ярьж байх шиг байна аа. Гэхдээ бас улс төр гэдэг одоо энэ их агуулгаараа тогтсон тийм хэм хэмжээ хэв маяг тэр чигтээ өөрчлөгдсөн гэдгийг бас санах хэрэгтэй. Тэгээд яах вэ зүгээр хөрш зэргэлдээ орнууд ер нь бүхий л улсууд энэ бүсээ чангалж байх шиг байна. Их л орон олон арга хэмжээнүүдийг эдийн засгаа тогтвортой байлгах улс төрийн харилцаагаа бас жигд байлгах дээр нь анхаарч хэрэгжүүлж байгааг та анхаарч байгаа байх аа.

Тэгэхээр яг энэ дэлхийн эдийн засаг улс төрийн нөхцөл байдал ийм тогтворгүй хүнд нөхцөлд та Ерөнхий сайдын ажлыг авах гэж байна. Бас өөр нэг зүйлийг заавал хэлье гэж бодсон юм. Тэгэхээр Монгол Улсын хэмжээнд дэд бүтэц болоод ер нь л энэ эдийн засагт хэрэгтэй чухал олон төслүүд гацсан хэвээрээ байгаа энэ үед бас Ерөнхий сайд болох гэж байна аа. Тэгэхээр миний бодлоор хамгийн эхлээд энэ эрчим хүчний найдвартай байдалд их анхаарах ёстой юм шиг тэгээд цаасан дээр байсаар л байгаа энэ станцуудаа барих ажлыг эхлүүлэх ёстой. Үйлдвэржилт энэнээс л эхэлнэ гэж бодож байгаа. Гэхдээ өнөөдөр яг энэ таныг томилогдох энэ үед болохоороо нэг зүйлийг заавал дурдаад бас нэг асуултыг асууя.

Тэгэхээр ер нь бол Монгол Улсын хэмжээнд ОТ төслөөс гадна гуравдагч хөршийн хөрөнгө оруулалттай дараагийн том хөрөнгө оруулалтын гэрээг Орано Майнингтай хийж чадсан. Их гал дунд явж байгаад энэ гэрээг хийсэн. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын гэрээг хийхдээ Монголчууд өөрсдөө ажиллаад өөрсдөө хөрөнгө оруулалтынхаа загварыг босгоод тэгээд ер нь өөрсдөөсөө их хэмжээний мөнгө хөрөнгө гаргахгүйгээр АМНАТ-өөс тусгай төлбөр гэдэг зүйлийг авдаг болоод ингээд цааш цаашдаа том уул уурхайн төслүүд хэрэгжих боломжийг бүрдүүлж чадсан сайн туршлага болсон гэж үздэг ээ. Тэгэхээр яг энэ стратегийн ордуудаа бодоод үзэхээр бид нарт хөдлөөгүй байгаа хэд хэдэн ордууд байна. Тэгээд мэдээж ашигт малтмалын үнэтэйгээ холбоотойгоор цааш цаашдаа хөдлөх байх. Тэгэхээр ер нь цаашдаа стратегийн ордууд дээр төрийн эзэмшлийн хувь хэмжээ гээд л яригдаад эхэлнэ. Тэгэхээр та цаашдаа энэн дээр ямар бодлого ер нь баримтлах вэ?

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулья.

**Н.Учрал:** Дэлхийн улсууд энэ Ойрх Дорнодод үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулаад emergency mode гэж энэ ер нь ийм онц байдал онцгой горимд шилжиж байна. Шуурхай арга хэмжээнүүдийг авах ийм шуурхай штабын зарчмын дагуу ажиллаж эхэлж байна. Хэдхэн хоногийн өмнө Өмнөд Солонгос улс энэ асуудалд нөхцөл байдалтай холбоотой emergency буюу онцгой горимд шилжсэн байна. Тэгэхээр бид бол цаг алдахгүй ажилдаа орох шаардлага үүсэж байна. Тэгэхээр Засгийн газар бол ийм цаг үед асуудалтай нүүр тулж сөрж давна. Тэгэхээр ийм онцгой горимд шилжиж ажиллахаас өөр арга байхгүй болно оо гэсэн үг. Тэгэхээр ийм цаг үед ер нь ямар арга хэмжээ авах ёстой юм бэ гэхээр хөрөнгө оруулагчид баялаг бүтээгч нар хөдөлмөрлөө, хийе бүтээе гээд санал санаачилга гаргаж байгаа хэн бүрийг дүрэм журам саад тээгээс чөлөөлж өгөх ёстой. Чөлөөтэй бизнесээ эрхлэх, чөлөөтэй хөдөлмөрлөх боломж боллоцоог нь олгож байж энэ мөчлөгийг сөрж гарна. Тэгж байж эдийн засгаа идэвхжүүлнэ.

Тэгэхээр манай энэ Засгийн газрын гол бодлого бол хийе бүтээе хөдөлмөрлөө гэсэн хэн бүрийг дэмждэг ийм л чөлөөлөлтийн бодлогыг илүү дэмжинэ гэсэн үг. Тэгэхээр би сая Уянга гишүүн бас энэ Орано Майнингтай хийсэн гэрээний жишээг дурдаж байна. Тэгээд энэ нэлээн л бас их улс төр дагуулсан сэдэв хэдий ч Орано Майнингийн хөрөнгө оруулалтын гэрээ бол дэлхийд манай улсыг хөрөнгө оруулалтын зөв орчинтой улс гэдэг ийм таниулгыг өгсөн хэлцэл. Жишээ нь АМНАТ-өө орлуулснаараа энэ гэрээний жишиг бол бусад хөрөнгө оруулалтын гэрээний зөв үлгэр болсон.

Монголчууд анх удаа өөрсдөө санхүүгийн модель дээрээ суугаад Due diligence маягаар стратегийн ордуудтай хэлэлцээр хийж болдог юмаа гэдгийг эд нар харуулж байна аа. Нэг үеэ бодвол санхүүгийн хэлэлцээр хийж чаддаг болсон

монголчууд. Одоо энэ жил 146 сая ам.доллар-ын хөрөнгө оруулалт Орано Майнингтай хийсэн гэрээний дагуу энэ жил хийгдэнэ. Байр сав зам дэд бүтцийн ажлууд нь 146 сая доллар орж ирэх гэж байна. Энэ жил хийгдэнэ гээд. Түүн шиг жил болгон энэ хөрөнгө оруулалт нэмэгдээд ирэхээр энэ бол эдийн засгийг идэвхжүүлнэ гэсэн үг. Тийм ч учраас цаашдаа бид нар хөрөнгө оруулалтын орчинд ээлтэй байх ёстой. Тэр улс төрчид бид ч гэсэн манай улс энэ хөрөнгө оруулалтын орчныг бол нээж байгаа юм байна. Баялаг бүтээгч нар хөрөнгө оруулагч нартаа хэлсэндээ байх юм байна гэдгээ аль нэг улс төрийн нам эвслээс үл хамаараад зоригтой хэлэх ёстой.

Тэгэхээр одоо энэ Орано Майнингтай бид нар 28 жил дуусгаагүй яриаг дуусгасан. Тэр дуусгаагүй олон ярианууд байна шүү. Тэгэхээр дуусгаагүй олон яриануудыг бол эцэслэнэ гэж ингэж бодож байгаа. Тэгээд ийм цаг үед эм бол гашуун байдаг гэхдээ өвчинд тустай. Тэгэхээр гадаад нөхцөл байдал ийм хямралтай байхад зөв шийдвэрүүд гашуун байх байх. Олон нийт заримдаа алга ташихгүй байх гэхдээ ийм цаг үеийг давахад гашуун бөгөөд шаардлагатай яваандаа энэ өвчнийг анагаах шийдвэрүүдийг гаргахаас өөр замгүй болж байна гэдгийг та бүхэн бас ойлгоосой гэж хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганзоригийн Лувсанжамц.

**Г.Лувсанжамц:** Нэр дэвшигчийг дэмжиж байна аа. Хурдтай эрчтэй ажилладаг дэвшилтэт үзэл баримтлалтай тийм бодлого хэрэгжүүлээд явж байгаа. Их Хурлын даргаар ажиллаж байх хугацаандаа чөлөөлье гэсэн бодлогыг хэрэгжүүлээд бодитоор эдийн засгийн эрх чөлөөг тэлэх зөвшөөрлийн ерөнхий хууль өргөн барьсан. Одоо Энхтүвшин гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг эрчимтэй ажиллаж байгаа.

2 дугаарт уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг бас өргөн барьсан үүнийг бас дэмжиж байна. Өнгөрсөн жилийн 12 сарын 26-нд Улсын Их Хурлын 119 дүгээр тогтоолоор ногоон шилжилтийг эрчимжүүлэх, ногоон санхүүжилтийг дэмжих чиглэлээр хууль эрх зүйн орчныг сайжруулах журмуудыг шинэчлэх ажлуудыг эхлүүлсэн. Тэгээд энэ дээр хамтарч ажиллаж байгаадаа бас баяртай байгаа.

Засгийн газрын тэргүүний хувьд энэ бодлогоо яаж үргэлжлүүлэх вэ? Хэмнэлт буюу дулаалгын бодлогыг хэрэгжүүлэх үүн дээрээ суурилсан сэргээгдэх эрчим хүчний тархмал болон өрхийн бичил эх үүсвэрийг нэмэгдүүлэх ямар арга хэмжээг Засгийн газрын тэргүүний хувьд авах вэ?

2 дугаар асуултад сая Уянга гишүүний асуулттай давхцаж байгаа учраас чөлөөлье бодлогыг дэмжиж байгаа. Төр гай болох биш зай болох ёстой. Салбаруудыг зах зээлийн зарчмаар хөгжих боломжийг нээх, даргын гарын үсгийг харж зөвшөөрлийг хүлээж суудаг биш мэдэгдэл болон стандартад суурилсан байдлаар үйл ажиллагаа эрхлүүлээд явдаг. Эдийн засгийн эрх чөлөөг нээнэ гэсэн бодлогыг дэмжиж байгаа. Энийгээ үргэлжлүүлэх юм байна.

2 санал байна. 1 дүгээрт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль дээр ажиллаж байгаа. Дээрээс нь Хот төлөвлөлтийн тухай хуулийг өргөн барихаар ажиллаж байна. Энэ 2 хуулиар төрийн албан хаагчдын энэ тайлан төлөвлөгөө гэсэн болсон болоогүй зүйлүүдийн ажлыг хөнгөвчлөх хуулийн өөрчлөлтүүдийг хийхээр Ж.Энхбаяр сайдтай хамтраад ажиллаж байгаа. Тайлангаас чөлөөлөх төрийн албан хаагчдыг тайлангаас чөлөөлөх ажил дээр бас дэмжлэг үзүүлээч ээ гэж хүсэж байна.

Татварын багц хуулийг эргэж татаад дахин өргөн барина гэж байна. Энийг дэмжиж байна. Попорсон зүйл ярихгүй байгаад их баяртай байна. Зарим гишүүд сайд нар орлогоо бууруулна гэж ярьдаг төсөв ярихлаар зарлагаа нэмээд ороод ирдэг. Зарчимтай баймаар байна. Орлогоо бууруулж байгаа бол зарлагаа ч бас бууруулна гэдэг зүйлийг ярих ёстой. Энэ чиг баримжаатайгаар ажиллаасай гэсэн тийм санал байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Нэг асуулт байна. Учрал гишүүн.

**Н.Учрал:** Эрх чөлөөний 4 чөлөөлөлтийн бодлогыг дэвшүүлж байгаа. Гэхдээ энэ бол үр дүн гарах ажил. Тэр юу вэ гэвэл би эдийн засгийн гайхамшиг бүтээж чадахгүй, ид шид бүтээж бол чадахгүй. Харин Лувсанжамц гишүүний хэлж байгаатай яг адил төр гай болохгүй зай болно. Салбар болгонд төр оролцох юмандаа оролцоно, оролцохгүй юмандаа оролцохгүй. Хүн ардынхаа эрүүл аюулгүй байдлыг хангах чиглэлээр хяналтаа тавих болохоос биш салбар болгонд асуудлаас илүү холдож асуудлыг өөрөө шийд гэдэг зарчмыг бол хэрэгжүүлнэ. Тэгж байж энэ сорилтыг давж гарна. Хийе, бүтээе, хөдөлмөрлөө гэсэн хэн бүрийг дэмжсэн бодлого энэ бол Эрх чөлөөний 4 чиглэлд. Тэгэхээр энд эдийн засгийн чөлөөлөлт, Эрх зүйн чөлөөлөлт, ногоон хөгжлийн чөлөөлөлт, авлигын эсрэг чөлөөлөлт гэж. Тэгэхээр ногоон хөгжлийн чөлөөлөлтийн хүрээнд сая Чингэлтэй дүүрэг дээр нэг 83 айл 20 квт хүртэлх нар салхины батарей хуримтлуур тавиад дулаан, цахилгаанаа шийдээд болж байгаатай яг адилхан өрх болгонд цахилгаан үйлдвэрлэгч байх бодлогыг дэвшүүлнэ.

Цаашид бол 20 квт гэж босго тавиад ч байх юм байхгүй. Илүүдэл гарснаа төвийн шугамдаа нийлүүлээд өрх болгонд цахилгаан үйлдвэрлэгч болох эрх зүйн орчин одоо ч байгаа. Энийг дүрэм журмаар хориод байх шаардлага байхгүй. Тэгэхээр Эрчим хүчний сайдын тушаал сая гарсан. Хүн шиг 20 квт-ыг ч гэсэн бараг тэр босгыг ч авах хэрэгтэй. Дээрээс нь сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийн дэд бүтэц барих хөрөнгө оруулагч нарт нээлттэй сонгон шалгаруулалт зарлана. 10 аймагт сэргээгдэхийн станц барих нээлттэй сонгон шалгаруулалт зарлана. Үүнийг Засгийн газар 100 хувь дэмжинэ, бүх талаар дэмжинэ. Дээрээс нь ийм үед эрчим хүчний хараат бус байдлыг бууруулах бодлогын хүрээнд тэр татварын нэг хувиар хувийн хэвшлийнхнийг орон даяар цахилгаан машины цэнэглэх станцуудыг барихыг нэг хувиар хийхийг нээж өгнө. Ингээд улс орон даяар цахилгаан машин цэнэглэх станцуудыг барих ажлыг эхлүүлцгээе. Ингээд дэвшилтэт ажлууд руугаа оръё. Энэ бол цэвэр чөлөөлөлт байна аа. Эрчим хүчний салбарт чөлөөлөлтийг хийх хэрэгтэй. Лука гишүүний ярьж байгаа энэ тайлангаас чөлөөлөх ажил Их Хурлын хууль дээр энэ Сандагаа гишүүний хууль дээр дагаад орсон. Тэгэхдээ хууль гарахаас үл хамаараад Засгийн газар once only буюу ижил агуулга бүхий тайланг зөвхөн нэг удаа авна. Төрийн албан хаагч нартаа хэлэхэд нэг тайланг мянга авдгаа болино. Орон нутагт очоод уулзахаар юу хийж байна вэ гэхээр тайлан явуулж байна гээд сууж байгаа. Тэр тайланг нь дээшээ явуулахаар дээр нь уншдаг ч хүн алга. Тэд юу хийж байна вэ гэхээр дээд талынхаа дарга нарт бас тайлан бичээд сууж байна. Тэр дарга нар нь тэр тайланг нь уншихгүй байна. Ингэж бие биеийнхээ ажлыг уддаг больё оо. 1480 гаруй үйлчилгээг E-Монгол дээр оруулаад хурал системээр мэдээлэл солилцуулж чаддаг ажлыг бид хийж цахим засаглалын индексээр 28 байр урагшилсан. Системийн хувьд бид бэлэн. Одоо систем нь бэлэн болчихоод байхад тушаалаар юм нэхдэгээ больчихъё оо.

Тэгэхээр once only гэдэг зарчим Засгийн газар хэрэгжүүлнэ. Тэр цахимаар тэргүүн ээлжид шийдэх буюу зөвшөөрөл лицензүүдийг зөвхөн цахимаар шийднэ гэдэг зарчмаа хэрэгжүүл. Ингээд хүнээс хамааралгүй алхмуудыг хийе гэдэг ийм зорилтыг дэвшүүлж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Лувсанжамц нэг минут.

**Г.Лувсанжамц:** Баярлалаа. Тодорхой алхмуудыг тодорхой хэллээ. 100 хоногийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөн дээр бас оруулаад явах болов уу гэж бодож байна. Сэргээгдэхийг дэмжих, ногоон хөгжлийг эрчимжүүлэх дээр таны өргөн барьсан хамт боловсруулсан 119 дүгээр тогтоол дээр суурь нөхцөл нь байгаа. Дулаалгаа хэрэгжүүлж байж хэмнэлтээ бий болгож байгаад үлдсэн хэрэглээгээ сэргээгдэх эрчим хүчээр шийднэ гэсэн 15 дугаар зүйл, 16 дугаар зүйл дээр байгаа. Агаарын бохирдлын төлбөрийг ногоон санхүүжилт рүү чиглүүлэх дээрээс нь дулаалгын төслийн хэрэгжилтүүдийг хийх бор хуучирсан ийм бор шийдлүүдээсээ бид нар ногоон технологи руу шилжээд явах хэрэгтэй байгаа. Тэгээд энэ дээрээ бас эрчимтэй ажиллаасай гэж хүсэж байна. Амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Бадамдоржийн Пунсалмаа.

**Б.Пунсалмаа:** Баярлалаа. Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигчээс надад 2 асуулт байна. 1 дүгээрт та өөрийнхөө байгуулах Засгийн газартаа цомхон төр цомхон Засгийн газар байгуулах зарчмыг баримтлах уу эсвэл одоогийн байгаа энэ данхар бүтцээ хэвээр нь үргэлжлүүлэх үү? Ер нь Засгийн газрын түвшиндээ ямар эрс өөрчлөлт хийх вэ?

2 дугаар асуулт нь эдийн засгийн өсөлт болон иргэдийн амьжиргааны талаар Монгол Улсын эдийн засаг ер нь өсөөд байгаа юм л даа ДНБ гэхэд сүүлийн 10 жилд 5 дахин өсчихсөн байхгүй юу. Гэхдээ энэ өсөлт өрхийн орлого иргэдийн цалин болж очихгүй байна. Агаарын бохирдлыг бууруулж чадахгүй байна. Боловсрол, эрүүл мэндийг сайжруулж чадахгүй байна. Тэгэхлээр бусад улс орнууд Велл Ви индекс буюу амьдралын чанар гэдэг юмыг ДНБ-тэйгээ хамт тооцдог юм байна. Тэгэхлээр ер нь эдийн засаг өсөөд ирэхийнх нь хэрээр л энэ цалин хөлс өрхийн орлого нь өсдөг бусад амьдралын чанар нь сайжирч байдаг энэ чанараа давхар тооцоод, жил болгон хэлэлцээд ингэж эдийн засгаа авч явдаг юм байна. Хэрвээ бид нар энэ систем рүү 10 жилийн өмнө шилжчихсэн байсан бол тухайн үед 10 жилийн өмнө 2 сая төгрөгийн цалинтай иргэн өнөөдөр 10 сая төгрөгийн цалинтай болох боломжтой байж. Тэгэхлээр миний асуулт бол та өнөөдөр Засгийн газрын Ерөнхий сайд болох гэж байгаа хүн ийм эрс өөрчлөлт хийж чадах уу?

ДНБ өсөхийнх нь хэрээр тэр нь цалин хөлс өрхийн орлого олж ордог очдог, байгаль, байгалийн агаарын чанар, боловсрол, эрүүл мэндийн чанарт нөлөөлж чаддаг ийм одоо эрс өөрчлөлтийг хийж чадах уу? Өнөөдөр монголчуудад тийм л Ерөнхий сайд хэрэгтэй байна. Тэгэхлээр энэ тал дээр танаасаа нэг 2 асуултыг асууж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Тийм 10 жилийн дотор нийт GDP энд нийт дотоодын нийт бүтээгдэхүүн чинь 89.9 их наяд болтлоо өссөн. Тэгээд өрх рүү ороогүй. Бид нар хуримтлал үүсгэсэн үедээ түүнийгээ зарцуулахдаа нөгөө олсныхоо хэрээр үрсэн.

Тэгээд ийм л нөхцөл байдалтай өнөөдрийг угтаж байна. Олсныхоо хэрээр үрсэн. Саяхан л бид нар 33.5 их наядын орлоготой адилхан тэрнийхээ хэмжээнд зарсан. Тэгээд нийт ДНБ-ээ нэмээд олохгүй орлогыг төлөвлөөд зарлагадаад байхаар бид яг нөгөө ийм эдийн засаг хямраад ирэхэд тодорхой үйлдэл бол бас хийж чадахгүй байдалтай байна аа. Тийм учраас бол энэ ард түмний ахуй амьдралд энэ нөлөөлөхгүй байна. Инфляц 2 оронтой тоонд хүрээгүй гэх гээд байдаг хэдий ч яг ард түмний амьдрал цөөхөн хэдэн бүтээгдэхүүн дээр өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн дээр явж байгаа учраас тэр нь илүү мэдрэгдээд байна аа. Тийм учраас би энэ 16 багц арга хэмжээг иргэдийг үнийн өсөлтийг хамгаалах арга хэмжээний тухай энэ тогтоолыг бол баталсан юмаа.

Тэгэхээр таны хэлж байгаа тэр вел берн индекс дээр хэмжих тал руу бол энэ төсвийнхөө хүрээний мэдэгдлийг оруулж ирье гэж бодож байгаа. Өмнө нь жил яг намайг Эдийн засаг хөгжлийн сайд байхад би нэг зүйлд их баярладаг. Тэр юу вэ гэхээр тэр мэргэшсэн ДНБ тэнцвэржүүлсэн орлогын харьцааг 37 хувь байсныг 30 хувь болгосондоо л их баярладаг. Дээрээс нь гадаад зээлээр санхүүжих боломжтой зүйлийг алдагдал гэж тавьсандаа эдийн засгийг идэвхжүүлсэндээ их баярладаг. Энэ бол ерөөсөө нөгөө улс төржилт попролт биш байхгүй юу. Алдагдалгүй төсөв байх ёстой гэдэг яг үнэндээ тийм биш. Тодорхой алдагдал байж эдийн засгаа идэвхжүүлж л байдаг, мөчлөг сөрсөн бодлого гэдэг бол үнэ рүү л чиглэдэг. Тийм учраас нэг ийм бид нар тийм улс төржилт попролтоос холдоод үнэнээ ярьдаг болох ёстой. Тэгээд 5 дугаар сарын 1-ээс өмнө барих төсвийн хүрээний мэдэгдэл дээр би яг таны хэлсэн энэ өрх рүү энэ эдийн засгийн өсөлтийг аваачих чиглэл рүү яг ийм мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх ёстой гэж ингэж үзэж байгаа юм.

Дээрээс нь жилийн төлөвлөгөөгөө яг ингэж оруулж ирнэ. Тэгэхээр түрүүн хэлсэн шиг тэр уухад хэдийгээр гашуун байх боловч урт хугацаандаа зөв байх энэ бодлого руу орохгүй бол өнөөдрийн алга ташилтын төлөө ингээд Ойрх Дорнодын асуудал ийм болчихсон үнэндээ энэ бензин шатахууны үнэ өсөөд байна гэдэг чинь юм бүхний үнэ л өснө шүү дээ адилхан. Ийм хүнд үед бас үнэнийг нуух хэрэггүй. Үнийг тэгж барихад үнэхээр хэцүү. Нийлүүлэлтээ л гацаахгүй байх ёстой шүү дээ. Эсвэл нэг хэдэн сар хүчээр барья гээд захиргааны арга хэмжээ авлаа гээд энэнийхээ үр дүнг нь иргэд өөрөө л хүртдэг шүү дээ. Тэгээд үнэ тогтворжуулах хөтөлбөр ч гэдэг юм уу манай зөндөө л хөтөлбөрүүд байна шүү дээ. Тэгээд эд нар чинь явж явж байгаад иргэд нуруундаа л үүрч байна. Тийм учраас үнэнийг ярьдаг ийм бодлого руу би бас орох нь зөв байх гэсэн бодолтой байна.

Тэгээд 5 дугаар сарын 1-нд төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн мэдүүлнэ. Засгийн газрын хувьд Засгийн газар ажилдаа ороод чиг үүргийн шинжилгээгээ бүрэн дуусгана. Өмнө нь ч хийгдэж байсан. Чиг үүргийн шинжилгээгээ бүрэн дуусгана. Одоо энэ Зөвшөөрлийн хуулиар 110 зөвшөөрлийг мэргэжлийн холбоонд өгөх бололцоотой болгоод эхлэхээр агентлаг яамдын дэргэд байгаа хөгжлийн төвүүдээс багадаа бараг 20 орчим нь татан буугдах боломж үүсэх юм байна лээ. Тэгэхээр энийг би 100 хоногийнхоо төлөвлөгөөг нэгдсэн байдлаар гаргаад яг зүгээр л нэг хувийн хэвшлийн нэг компанитай адилхан КPI-аа тавьж байгаад л та бүхэнд нээлттэй харуулаад л ингээд явъя л гэж бодож байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Лувсаннъямын Гантөмөр.

**Л.Гантөмөр:** Тэгээд одоо Учрал сайд 100 хоног бол дэмий байх аа. Та бол тийм шинэ Засгийн газрын тэргүүн гэж өөрийгөө бодож ерөөсөө болохгүй. Яг 10 жил

эрх барьсан тэр МАН-ын Засгийн газрын үргэлжлэл гэдгийг бол их хатуу ойлгох хэрэгтэй. Тийм учраас бол ард түмэн болоод сөрөг хүчин танаас нэг л зүйлийг шаардана. Энэ амлалт. Би тэгээд танд Төрийн байгуулалтын байнгын хороон дээрээс асуусан нь тэр. Амлалтаа энд сууж байгаа МАН-ын 68 гишүүн өдөр болгон унших хэрэгтэй. Ард түмнийг яаж уриалан дуудаж саналыг нь авсан бэ та нар. Тэрийгээ биелүүлж байж тэр сонгогчид дээрээ очно оо гэж итгэл төгс очих хэрэгтэй. Тийм учраас би амлалт их тодорхой асуугаад байгаа юм Учрал сайд аа.

Өнөөдөр эмч нарын өдөр юм байна лээ. Олон улсын эмч нарын өдөр. Монголынхоо бүх эмч нарт баярын мэнд хүргэе. Та яг энэ эрүүл мэндийн салбар дээр авсан амлалтуудаа хэлж өгмөөр байна монголчуудад. 2024 оны сонгуулиар бид нар эрүүл мэндийн салбар эмч нарыг ингэнэ гэж амласан. Би олон амлалт нэхэхээр бас та тогтоогоогүй байх л даа. Энийг их тодорхой хэлмээр байна нэг.

2 дугаарт ер нь бид нар их худлаа ярианд төгсөрсөн, маш их худлаа ярьдаг болсон. Жишээлбэл сая ДНБ 5 дахин нэмэгдлээ гэж байгаа 10 жилд. Яг 10 жилийн өмнө ДНБ 1 оногдох нэг хүнд оногдох ДНБ хэдэн америк доллар байсан бэ? Өнөөдөр хэдэн америк доллар байгаа вэ? Энэний зөрүүг ДНБ-ний өсөлт гэж хэлдэг юмаа. Төгрөгийн ханшаа унагаад унагасан ханшаа уянгалан том том ярихаар бид нар ингээд төөрөгдөөд байгаа юмаа. Тийм учраас би танаас нэг зүйлийг асуух гэж байгаа юм. Одоо бид улирал болгоноор ДНБ-ий өсөлтийг гаргадаг, яг яаж гаргадаг юм? Энэ аргачлалыг одоо монголчуудад хэлж өгөх хэрэгтэй. Өнгөрсөн 10 сар бол бүтэн худлаа ярьсан, огт ажил хийгээгүй. Мега төсөл гэхлээр мангас шиг юм ярьцгаасан, бүгд зугтаасан. Өнөөдөр харин Учрал сайд би гангийн үйлдвэртэй болно, зэсийн үйлдвэртэй болно, нүүрс химийн үйлдвэртэй болно гэж хэлж чадаж байгаад нь талархаж байгаа юм. Хоёрхон жилийн өмнө ийм юм хийнэ ээ гээд явж байсан алхаж байсан улс төрийн хүчин өнөөдөр жил хүрээгүй хугацаанд хойшоо ухарч ерөөсөө болдоггүй юмаа.

Тийм учраас бол миний хүсэж байгаа зүйл би одоо танаас нэмээд асуумаар байгаа юм. Асгатын ордыг яах . Түрүүн Бейсен гишүүн асууж байна лээ. Зүүн босоо тэнхлэгийг яах юм? Одоо бид нарын...

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Гантөмөр сайд бол бас Эдийн засаг хөгжлийн сайд байсан. Гантөмөр сайдаас би ажлыг нь авсан. Тэгээд та бид 2 бол хамтдаа төсвийн хүрээг 2 жил ээлжилж оруулж ирлээ. Макро тоонуудаа бас гаргаж байсан хүмүүс. Тэгээд тухайн үед би боддог. Зүгээр ер нь олсныхоо хэрээр үрж болохгүй гэдэг ийм л зарчимтай байсан. Тэгээд тухайн үед нийт тэр тэнцвэржүүлсэн орлого дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 37 хувь байсан нь өөрөө манай засгийн үед бол бид нар татварын шинэчлэл хийх буюу энэ олон мега төслүүдийг явуулахад орон зайг гаргаагүй. Тийм учраас ТӨК-иуд бол энд нөгөө төрөөс заавал хамааралтай буюу эдийн засгийн харьцаа чинь 61 хувь учраас төрөөс төсвөөс ТӨК-аас хамааралтай энэ харьцаан дээр яваад байсан. Тийм учраас бол би үүн дээр ер нь юу гэдэг юм Засаг болгон өөр өөрийнхөө алдааг засаад амжилтаа ахиулаад явж байх ёстой. Тийм ч учраас Засгийн газрын тухайн 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт туссан байсан мега төслүүд гэж бид нар тусгасан ажлуудаа би импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх энэ том төслүүдээ явуулах ёстой гэдэг байр суурьтай байгаа. Тэр гангийн үйлдвэр тэр Багануурын Пиролизийн үйлдвэр тэр зэс хайлуулах цогцолбор эд нарыгаа би явуулна. Жишээ нь Асгатын мөнгөний орд дээр тухайн үед

та мэдэж байгаа. Эрдэнэс Монгол дээр тухайн үед хариуцаж байсан. Тэгээд одоо бол би сүүлд энэ талаар тодруулахаар Эрдэнэс Монгол нэмэлт арга хэмжээ аваад хайгуулын ажил нь хийгдэж байгаа гээд надад хэлсэн. Би энийг очоод шалгана. Тэгээд тэр нөгөө Жорк стандартаар нөөцийг нь тогтоох хөрөнгө оруулалт татахаар ажиллаж байгаа гэсэн. Ажиллаж байгаа ажил нь ямар байгаа юм. Одоо ингээд хойшлуулахыг нь хойшлуулаад, эрэмбэлэхийг нь эрэмбэлээд дэмжээд явъя гэдэг ийм бол бодолтой байгаа.

Би түрүүн таныг ингээд хэлэхээр ЗТЯ-аас энэ Дэлгэрсайхан сайд байна. Зүүн босоо төмөр зам буюу нөгөө Чойбалсан Бичигтийн 420 гаруй зам ТЭЗҮ-г нь дуусгасан гэсэн тиймээ. Тэгэхээр бид нар зам тээврийн салбарт агаарын тээврийн либералчлал хийсэн шиг төмөр зам дээр бас л хийх ажил одоо тулгарч байгаа байхгүй юу. Тэгэхгүй алийн болгон ингээд яваад байх вэ. Тийм учраас ТЭЗҮ боловсруулж дууссан бол одоо бид Эдийн засаг хөгжлийн яаманд энэ хүргүүлээд энэ төслөө түншлэлээр сонгон шалгаруулалтыг нь зарлаад эхлүүлэх хэрэгтэй. Одоо энэ чинь хурдан ажилдаа ормоор байна шүү дээ. 400 энэ 20 гаруй зам километр зам энийг би хийх ёстой гэж бодож байгаа. Би яг тантай санал нэг байна. Тэгэхээр би ажлаа аваад аль аль төслөө явуулах юм бэ. Яг үнэхээр зам тээврийн салбарт агаарын тээврийн салбарын либералчлал хийсэн шиг төмөр зам дээрээ бас хийе л дээ одоо. Тэгээд түншлэлийн төслүүд дээр одоо тэр нэг яамны жагсаалтад ордог, тэгээд л нэг засгаар хэд хэд оруулдаг тэр олон үе шатын дамжуулах энэ их хүнд суртлуудыг нь болиод бүх ажлаа эрэмбэлж байгаад явуулахыг нь явуулаад ингээд хурдан хугацаанд шийдье гэж би бол одоо бодож байгаа.

Тийм учраас маш хурдан хугацаанд шийднэ. ҮСХ бол тэр ДНБ-ний өсөлтийг зарлаад явж байгаа. Тан руу ч, над руу ч тэр макро тоонуудыг ингээд илгээдэг байсан. Улирлын ДНБ-ийг тооцохдоо бол өмнөх оны эхэн үеэс тухайн улирлын хувьд 2 дугаар улирлын ДНБ-ийг тооцохдоо 2 улирлаар нь нөгөө 3 дугаар улирлын GDP тооцохдоо бол 3 улирлаар нь, 4 дүгээр улирлын GDP-г тооцдог 4 улирлаар нь гээд л эцсийн бүтээгдэхүүн үйлчилгээг л өссөн байдлаар ингээд л тооцоод л явдаг шүү дээ. Тэгэхээр одоо бид энэ тооны өсөлтүүд яагаад иргэдийн амьжиргаанд очихгүй байна вэ гэдэг дээр үнэлэлт дүгнэлт өгөх ёстой. Жишээ нь бид нар чинь Гантөмөр сайд бид сайд хамтарч ажиллаж байхад бид нар чинь нэг хүнд ноогдох ДНБ-ийг нэг 10 мянган доллар болгоно оо гээд л том зорилт...

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүнд нэг минут нэмж өгье.

**Н.Учрал:** Тэгээд 10 мянган долларт болгоно оо гээд бид хамтдаа зорилт тавьсан. Тэгэхээр энэ зорилт хэвээрээ. Үүн рүү л явна. Одоо 2025 онд бараг нэг 7300 орчим доллар байгаа. Тэгэхээр цаашдаа бол бид нар энэ 10 мянган доллар луу хүргэнэ гэдэг зорилтоо л тавих ёстой. 2025 онд бол энэ чинь нэг 7300 байсан бол 2015 онд бараг 10 жилийн өмнө 4 мянга хүрэхгүй л байхгүй юу 3900 орчим. Тэгэхээр цаашаа энийг 10 мянган долларт хүргэнэ ээ. Нийт Жи Ди Пи-гээ 100 их наяд болгоно оо гээд. Тэгэхээр би ингээд тоон зорилтууд тавья гэж бодоод өмнө сая Засгийн газрын 5 жилийн үндсэн чиглэл дээр яг үндэсний 10 үзүүлэлт индикатор нь яг энэ байна. Салбарын үзүүлэлтүүд нь энэ байна гээд ингээд тоогоор тавьсан шүү дээ. Одоо энэ 5 жилийн чиглэлийг биелүүлэх ингээд үүргийг бид хүлээж байгаа байхгүй юу. Тэгэхээр сая ч гэсэн яг энэ 5 жилийн чиглэл боловсруулсан учраас намын тэр амласан амлалтууд...

**Ж.Бат-Эрдэнэ:** Гантөмөр гишүүн.

**Л.Гантөмөр:** Тийм. Тэгээд би танд нэг Байнгын хороон дээр бас нэг юм асуусан. Яг нүүрс зарж байгаа хүмүүс 3-ны 1 коксжих нүүрсийг ингээд хил гаргаад зарахад яг ашиг нь яг хэдэн төгрөг байгаа юм бэ? Энд 1 дүгээрт хариулмаар байна.

2 дугаарт ер нь та бүхний ярих яриа бол хэмжээтэй Учрал сайд аа. Энэ амлалтан дотор яйжганана, энэнээс хэтэрч ярьж болохгүй. Энэ амлалтад байгаа зүйлийг хийх нь та нарын ариун үүрэг өөр юу ч биш. Тийм учраас бол одоо шинэ юм бодож олъё. Одоо нүүрээ сольё, одоо тэгье ингэе гэдэг биш манипуляц хийх биш ерөөсөө энэ амлалтынхаа ард гарах тухайд үнэнчээр ажиллаач ээ л гэж хүсэж байгаа юм. Тэгэх юм бол Монгол Улс бодитойгоор өөрчлөгдөнө, бодитойгоор өөрчлөгдөнө. Тийм учраас бол бүсчилсэн хөгжлийн бодлогоос битгий няцаач ээ гэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Учрал гишүүн.

**Н.Учрал:** Одоо төсвийн хүрээн дээр бол нүүрсийг чинь бид нар дунджаар 70 доллар гэж тооцсон. Биет хэмжээ 90 сая тонн байгаа шүү дээ. Тэгэхээр зүгээр энэ нүүрс чинь дотроо олон төрөлтэй. Жишээ нь нөгөө татвар хураамж, олборлолт, тээвэрлэлт энэ тэрийг нь хасаад явахаар нэг 25-30 долларын нэг ашиг л гарч байгаа байхгүй юу ер нь бол гэж тооцож байгаа. Тэгэхээр энэ цэвэр ашиг нь ийм тооны хэмжээтэй л байгаа. Тэгэхээр мэдээж дотроо олон төрөл. Бүсчилсэн хөгжлийн бодлого дээр бол ухраагүй ээ. Энэ бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. Би бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ. Тэр сая бүсчилсэн хөгжил хариуцаж байгаа салбарын тэр сайд ч гэсэн тэр 29 төсөл хэрэгжүүлнэ гээд нэг дээр танилцуулга хийж байсан. Тэр асуудлыг нь би очиж танилцаад үүн дээр нэгдсэн байр сууриа илэрхийлээд явна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жамбын Батсуурь гишүүн. Нэг байгаа бил үү? За Гантөмөр гишүүн.

**Л.Гантөмөр:** Үгүй ингээд Ерөнхий сайдаар томилогдох гэж байхад нь л асууж авахгүй бол хэдүүлээ тэгээд буцаад олж авч чадахгүй шүү дээ энэ хүнийг чинь. Ер нь Их Хурлын гишүүдтэй яг протоколгүй уулзахыг хориглоё гэж бодож байгаа. Тийм хууль өргөн барина. Тэгээд яг ийм протоколтой юмаа л ярьдаг байх хэрэгтэй. Та тэгэхээр наад нүүрсээ МАК байгаа, Энержи Ресурс байгаа, Өсөх зоос байгаа. Одоо бид нарын мэддэг 3 компани. Энэ 3 компанийн энэ улирлынх нь нэг тонн нүүрснээс олж байгаа ашгийг бодитойгоор гаргаад Монголын ард түмэнд хэлээрэй. 25 доллар гэдэг чинь зохиож байгаа юм шүү та нар. Цаанаас чинь ингээд мэдээллийг би түрүүн Анар энэ тэрд анхааруулаад байсан шүү дээ. Худлаа мэдээллээр битгий ханга аа та нар гээд байгаа нь тэр. Тийм шүү болгоомжтой хандахгүй бол бид нар ингээд агаарын тоо яриад байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Дээр нь энэ шатахууны худалдааг ер нь Гадаад яаманд үүрүүлбэл яадаг юм бэ. Наад Аж үйлдвэрийн яам чинь бол яг гадаад худалдаа мэдэхгүй шүү дээ. Энэ худлаа болоод байгаа байхгүй юу.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгэхлээр Учрал дарга 11 сарын 15-аас хойш би МАН-ын дарга болсон. Үүнээс хойш бүх зүйлийн эзэн байна гэж ингэж хэлж байна. Мэдээж шударга ёсны бүтээн байгуулалтын мөрийн хөтөлбөрийг

нь хийх эзэн нь байна гэдгээ зарлаж байх шиг байна. Тэгээд эзэн нь байхын тулд одоо буруугаа хүлээж сурах хэрэгтэй байна аа. Энэ даан ялангуяа энэ гишүүддээ хэлж сургахгүй бол буруу буруу бүгдээрээ бусдын буруу. Бага хурлаараа Засгийн газраа унагачхаад л АН буруу, өөрсдөө Засгийн газраа унагачхаад л АН буруу, ирцээ бүртгэж бүрдүүлж чадахгүй АН буруу, төсвөө баталж чадахгүй АН буруу, батлаад өгчхөнгүүт нь АН буруу батлаад өгчихлөө гээд ингээд бүүр үйлийн лайтай ийм нэг өөрсдөдөө сайн зүйлийг наах гэсэн ийм донтой болчихсон байна.

Дээр нь та бүтээн байгуулалтын эзэн болохын тулд Улсын Их Хурлын дарга байхдаа орон нутагтаа томилолтоор ажилласан. Монголын ард түмэн одоо МАН-ын шинэ үе гарч ирж юу ярьдгийг, ямар бүтээн байгуулалт хийх гэж байгааг сонссон. Тийм болохлоор энэ шударга ёсон тэрийгээ яривал миний минут хүрэхгүй. Би зүүн бүстэй холбоотой хэдэн зүйлийг дахин танд сануулъя гэж бодож байна. Тэгэхлээр ер нь Монголын эдийн засгийг аваръя гэх юм сая босоо тэнхлэгийг нь сая Гантөмөр дарга хэлчихлээ. Буйр нуурыг эргэлтэд оруулаач ээ. Аялал жуулчлал гэж Хайнан, Фукуок гээд Монголын ямар их баялаг тийшээ явж байна вэ зун, өвөлгүй. Одоо Сүхбаатар аймаг Сүхбаатар сум, Матад гээд 100 гаруйхан километр замыг тавихад тэр сайхан том элсэн хүрээтэй Хайнанаас дутахгүй энэ Буйр нуур бол эргэлтэд ороход Монголын эдийн засгийг аврах ийм том боломж байна. Энийг та онцгой анхаараач ээ гэж хэлэх гэж байгаа юм.

Дээр нь Монгол Улс бас түүхэндээ далайд гарах ганцхан гарцтай байсан. Ерөөсөө Тяньжинь. Тэгээд Эрээн, Замын-Үүд гэсэн. Одоо бол Жинжоу боомттой холбогдох тун дөхсөн. Энэ 2 дахь улаан хоолой, 2 дахь эдийн засгийн гарцыг та нээж өгөх юм бол танай Засгийн газар нээж өгөх юм бол Монголын эдийн засагт аяндаа тэр доллар валют гэдэг юм чинь хангалттай хэмжээгээр урсаж орж ирэх ийм зүйлүүд байна аа. Энэ бол өөрөө улс төржилтөөс, нутаграхааас янз бүрийн салбаруудыг өмнөө хойноо тавьснаас болж энэ бүтээн байгуулалт хойшлоод байгаа юм. Тэгэхлээр энэ 2 том зүйлийг та хийж чадах юм бол Монголын эдийн засгийг сэргэх та бүтээн байгуулалтын эзэн байх ийм боломж нь бүрдэх юмаа гэдгийг танд хэлэх гэсэн юм. Энийг та ойрын хугацаанд тэр эрчим хүчний шинэчлэлтэй холбоотой энэ зүйлтэйгээ шууд хийж чадах уу гэсэн бодит асуултуудыг асуух гэсэн юм. Энийг та бас орон нутгийн томилолтоор явж байхдаа онцгой анхаарна. Энийг одоо энэ Засгийн газар эхлүүлнэ хийнэ гэж байсандаа хэвээрээ юу гэсэн асуулт.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** За энэ талаар тэр Буйр нуур дээр гээд би энэ санал санаачилгыг нь дэмжиж байгаа. Та нөгөө санаж байгаа байх. Тухайн үед чинь бас гаднын хөрөнгө оруулагч нар ирж байна. Буйр нуурын талаар танилцуулгуудыг хийгээд бид бас танилцаж энэ талаар бол бас ярилцаж байсан тиймээ. Буйр нуур дээр цаашаа боомттой яг үнэхээр хамгийн тохиромжтой газар юмаа гээд. Тэгэхээр үүн дээр бол би бас ажлаа аваад нэлээд бас сайн судлаад танд хэлье. Тэгээд би бол энэ тухайн үед яг хамтарсан Засгийн газар байгуулагдсаны дараа бол энэ асуудлаар ярьж байсан. Тэгээд Буйр дээр чинь нэг 4 Си тиймээ нэг буудал барина гэж байгаад тэр нь одоо зогсчихсон байгаа байх. Миний сүүлд тавьсан мэдээллээр бол. Тэгэхээр мэдээж ажлаа аваад тэгээд өнөөдрийн Их Хурлын гишүүдийн бас хэлж байгаа саналуудыг бол бас өөрөө нэлээд анхаараад тэгээд бас эргээд хэлэх ёстой байх. Тэрнээс биш өнөөдөр шууд тэгнэ ингэнэ гэдэг бол тооцоо судалгаагүйгээр тэгж ярих нь бас зохимжгүй болов уу гэж бодож байна. Зүгээр аялал жуулчлалын салбарыг

хөгжүүлэх энэ агуулгаараа бол бид нар цаашдаа идэвхтэй ажиллах бол ёстой гэдэг дээр тантай бол санал нэг байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батсуурь гишүүнд минут сунгая.

**Ж.Батсуурь:** Яах вэ би таны эзэн байх асуудлуудаар ярьсан. Та нэг л хариулт өгч байна л даа. Энэ бүх буруугаа бусдад өгдөг асуудлыг та ер нь яах юм бэ ерөөсөө. Энэ одоо аль хэдийн 10 хэдэн жилийн өмнө төр бариад эхэлчихсэн энэ авлигал хээл хахуулийг ард түмэн рүү чихэх юм уу, АН руу чихье гээд юу руу хийх юм. Энэ хулгай луйврын асуудал эдгээр асуудал дээр та хариулт өгсөнгүй. Дээр нь тэр далайд гарахдаа Буйр нуур бол тэр том том нисэх буудал энэ тэрийн асуудал биш ээ. Ерөөсөө л замын асуудал байгаа. Сүхбаатар сум Матад чиглэлийн замын асуудал байгаа. Дээр нь далайд гарах 2 дахь зам бол мөн замын асуудал л байгаа болохоосоо бусад нь бол бүгд хувийн хэвшлээр хийгдчих ийм боломжтой зүйлүүд байгаа гэдгийг хэлэх гэсэн юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Тийм ажлаа хурдтай, шуурхай хийнэ, хариуцлагаа хүлээнэ. Энэ бол одоо зарчим. Таны хэлж байгаа бид нар орон нутагт ажилласан, Сүхбаатар аймаг дээр ажилласан. Тэр зам дээр очиж танилцсан. Тэгээд ирэх оны төсөв дээр суулгаад санхүүжилт дээр нь дэмжлэг үзүүлнэ гэдгээ илэрхийлсэн. Тэр зам бол асар чухал гэдгийг би ойлгож байгаа. Дээрээс нь тэр зүүн бүсэд нөгөө Бичигт, Хөөт, Чойбалсангийн төмөр зам гээд энэ ажлууд дээр дэд бүтэц дээр бол би Засгийн газрын тэргүүний хувиар анхаарч ач холбогдол өгч ажиллана гэдгийг хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн.

**Ч.Лодойсамбуу:** Учрал Ерөнхий сайдыг дэмжинэ ээ. Залуу хүн бас дэвшилтэт үзэл санаатай, боловсролтой, туршлагатай бусдаасаа бас арай илүү өөр байх гэсэн өндөр хүлээлттэй байгаа, их найдаж байгаа. Тийм учраас дэмжинэ. Нэг жил 9 сарын хугацаанд бид нар 3 дахь Ерөнхий сайдаа томилох эсэх санал хураалт явуулах гээд сууж байна. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдыг ганцаараа татгалзсан санал өгөөд энд сууж байлаа. Занданшатар Ерөнхий сайдыг татгалзсан 7 хүний нэг нь болоод сууж байлаа. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд бол худал хуурмагаар засагласан айдсаар засаглах гэж оролдсон. Тийм учраас эсэргүүцэж байсан. Занданшатар даргыг дараа нь намын дарга биш байсан учраас дэмжээгүй. Намын дарга биш учраас парламент дахь олонхын бүлэгтэйгээ ажиллах бодит боломж нь бага байсан. Тийм учраас энэ тогтвортой байх дээрээ хамаг энергиэ зарцуулаад том том ажлуудаа ерөөсөө хийхгүй байсан.

Одоо Учрал дарга намын дарга. Тэгэхээр улс төрийн эрх, захиргааны эрх бүгд нь байгаа. Тэгэхээр хариуцлагаа үүрээд цогтой золбоотой, зоригтой ажиллана гэж итгэж найдаж байгаа учраас дэмжиж байгаа. Тэгэхээр одоо дарга жоохон зоригтой тодорхой баймаар байна, дэмжмээр байна. Дэд сайдгүй явна гээд шууд хэлчихмээр байна. Засгийнхаа бүтцийг үнэхээр цомхон болгоно оо гээд л хэлчихмээр байна. Тэгж хэллээ гээд нэг их энэ МАН-ын бүлгийнх нь гишүүд нь тэгвэл больё гээд намын даргаа эсэргүүцээд зогсоно гэдэгт би итгэхгүй байна. Тэгэхээр жоохон шийдэмгий баймаар байна.

Хоёрдугаарт нь энэ Нямбаатар даргатай хариуцлага тооцно оо гээд бас хэлчихмээр байх юм. Монголчууд өнөөдөр их сонин юм үзлээ Улаанбаатарчууд. Ханбогд уул, Хатан туул аа хамгаалсан иргэдийнхээ эсрэг жагсаал хотын дарга нь хийгээд байж байхыг харлаа. Эсэргүүцэж болно оо. Хийж байгаа ажлаа хамгаалж өмөөрч болно. Гэхдээ өнөөдөр бүр хэвийн биш болчихсоныг нь бид нар бүгдээрээ нүдээр үзлээ. Эсэргүүцээд очсон хүмүүсийг энийг барь, түлх, тэрийг нь булаа үг хэлсэн хүмүүсийг бүгдийнх нь гэрийн хаягийг ол, 100 зуугаараа, 10-т зуугаараа зохион байгуулалтад ороод гэрт нь оч, Улсын Их Хурлын гишүүд нэг нэгээрээ гараад ир үзье. Нүдэн дээр наад хүн чинь хэвийн биш болсон байна. Тэгээд ухаан муутай хүн 2 зүйл дээр л шууд галзуурдаг л даа. Нэг нь эрх мэдэл нь ихдэхээрээ, нэг бол мөнгө ихдэхээрээ. Хэвийн биш болсон байна. Монголд хаан дутаагүй шүү дээ хангалттай байгаа.

Тэгэхээр одоо та Ардын намын даргын хувьд, Ерөнхий сайдын хувьд яг миний энэ 3 асуудал дээр юу гэж бодож байгаа вэ? Энэ хотын даргатай хоршиж ажиллах уу? Нэг. Засгийн газрын бүтцийг цомхон болгоод зардлаа багасгаад явах уу? Дэд сайд.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Ер нь хүндээ ч юу байх вэ дээ тэгээд яам олонтой, агентлаг цөөдөө гэхээсээ илүү яг оновчлох ёстой гэдэгтэй би өөртэй чинь санал нэг. Түрүүн би байр сууриа хэлсэн. Дэд сайд бол хариуцлагатай албан тушаал. Мэдээж нөгөө олон улсад Засгийн газрын комисс бусад хэлэлцээрүүдэд оролцдог хариуцлагатай албан тушаал. Гэхдээ энэ цаг үед би ерөнхий чиг үүргийн яамнаас бусад нь шаардлагагүй гэж үзэж байгаа.

Хоёрт яамдын дэргэд байгаа Хөгжлийн төв агентлагууд дээр чиг үүргийн шинжилгээ хийж байгаа. Үүн дээр бол нэлээдгүй олон бүтцийн өөрчлөлт хийгдэнэ. Яамдыг нэгтгэх нийлүүлэх асуудлаар хэд хэдэн хувилбарыг Хэрэг эрхлэхийн дарга байх үеэсээ авхуулаад тухайн үеийн Ерөнхий сайд нар энэ ажлыг судалгаанууд хийлгээд боловсруулж байсан. Тэгэхдээ одоо маргааш орж ирээд яамд нэгтгээд нийлүүлбэл төрийн албан хаагч нар маань энд бас нэг дунд нь хэлмэгдчих вий гэдэг юм бол байгаа, байгаа юмаа. Тэгэхээр хэд хэдэн хувилбарууд байна. Үүнийгээ би мэдээж тэнд чинь томилогдоод манай энэ эрх баригч намын хувьд бас Удирдах зөвлөлөөрөө, бүлэг дээрээ танилцуулаад эцэслээд дээрээс нь Засгийн газарт урих шаардлагатай улс төрийн намуудад бас урилгаа илгээгээд ингээд явна. Түүний дараа би танай намын бүлэгт бас нөхцөл байдлаа яг эцэслэж танилцуулна.

Тэгэхээр би өөрөө ч томилогдоогүй байгаа учраас яг эцсийн байдлаар ингээд шууд түс тас гээд хэлэх чинь цаг хугацааны хувьд болохгүй байна шүү дээ. Тэгээд дээрээс нь энэ чинь бас өөрөө яг энэ бүтэц дээрээ суух шаардлагатай байна аа. Тэгэхгүй бол одоо ингээд нэг сандал суудал зөөгөөд, ширээ сандал болоод нэг баахан одоо яам агентлаг нэгдсэний хэрээр тэнд чинь хэдэн хүн ажилгүй болоод ингээд ийм байдал үүсчих вий гэдэг дээр болгоомжилж байгаа учраас өнөөдөр эцсийн байдлаар шууд түс тас гэж хэлэх бололцоо алга аа л гэдгийг. Тэрнээс биш цомхон чадварлаг тэр ухаалаг төр гэдэг зарчим дээр би яг байна. Та тэрийгээ би үйлдлээрээ харуулна тийм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Равжихын Эрдэнэбүрэн. Лодойсамбуу гишүүн тодруулъя.

**Ч.Лодойсамбуу:** Уг нь яг хариулах гэж байхад Бат-Эрдэнэ дарга жаахан яараад байх шиг байна. Энэ Нямбаатар даргатай холбоотой юм би асуусан юм. Би яах вэ бүр тодорхой асуучихъя. Яг таны бодлыг асуучихъя нэр дэвшигч ээ. Хатан туулаа хамгаалсан хүмүүс энэ Туул голдоо жоохон санаа зовоод мэдээлэл нэхжээ. Мэдээлэл нь ил тод биш байна энэ ямар учиртай юм бэ. Эргэлзээд бүрэн гол усгүй болох юм биш биз дээ гээд айжээ. Айгаад хотын даргаасаа баахан асуулт асуусан чинь өөдөөс нь жүжигчин гэж хэлэх юм, тэмцсэн хүмүүсийг жүжигчид гээд л доромжлох юм, асуусан сэтгүүлчийг угаадас гэх юм, өөдөөс нь очоод эсэргүүцэхээр намынхаа гишүүдийг турхираад наадхаа боль, юмыг нь хураа булаа, хөөж явуул гээд зодуулахад бүүр зод гэж турхирах юм. Энэ нь ер нь зөв үү? Энэ ер нь байж болох уу? юу болж байна вэ? Яг энэ таны бодлыг асууж байгаа шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Би энэ индрээс нэг үг хэлсэн. Дарга хүн бол ард түмнээ иргэдээ хэзээ ч битгий дээрээс нь харж бай. Нэг л тохиолдолд дээрээс нь харж бай. Унаж боссон хүнийг татаж босоход л дээрээс нь харж бай. Тийм учраас дарга нар ард түмэнтэйгээ иргэдтэйгээ, компани ААН-үүдтэйгээ дээрээс нь харж харьцахыг би эргээд зөвшөөрөхгүй ээ. Ард түмнээ хүндэлж, иргэдээ хүндэлж, тэдний үйлчлэх тэдэнд үйлчилгээ үзүүлж байгаа хэлбэрээр ажиллах ёстой гэдэг зарчмыг намын даргынх нь хувьд бүх шатын удирдлагууддаа шахаж шаардаж ажиллана. Тийм учраас наад үүсээд байгаа асуудлууд дээр байгаль орчинд нөлөөлөх үнэлгээг нь би харах шаардлагатай. Ажлын хэсэг байгуулъя, очиж танилцъя. Нөхцөл байдлыг нь харж байж тэгээд байр сууриа бүрэн илэрхийлэх ёстой.

**Ж.Бат-Эрдэнэ:** Лодойсамбуу гишүүн.

**Ч.Лодойсамбуу:** Баярлалаа дарга. Өнөөдөр АН-ын бүлгийн санаачилгаар хэлэлцүүлэг хийгээд нөгөө байгаль орчны үнэлгээ энэ тэрийг нь сонслоо л доо. Тэгээд үнэлгээнүүд нь их олон янз юмаа. Тэд нарыгаа өөрсдөө хариулж мэдэхгүй юмаа. Тэгээд зарим дүгнэлтүүд нь шийдвэр нь гараад мөнгө нь шилжсэний дараа албажсан энэ тэр байх юмаа. Үнэхээр завхарсан юм байгаа юм байна аа мэдээлэл нь бол. Одоо тэгэхээр дахиад араас нь ингээд судлах гээд байх ямар ч шаардлага алга байна гэж. Тэгээд та сая хэлж байна. Нямбаатар дарга бүр дээрээс нь харах нь битгий хэл хүн харагдахгүй байгаа нүдэнд нь юу ч харагдахгүй байна шүү дээ. Бүр ингээд л тэгээд би явлаа шүү, гишгүүлээд үхвэл үхээрэй гээд л яваад байна шүү дээ. Тэгээд одоо яг энэ даргатай ингээд цаашдаа хоршиж ажиллах уу гэдэг хамгийн эхний асуултын үед асуусан асуултдаа хариулт авъя. Зарчмын хувьд таны хэлж байгааг бүрэн дүүрэн дэмжиж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Наад бол ёс зүйн асуудал. Тийм учраас манай Хяналтын хороо Ёс зүйн Хороо өөр өөрийн ажиллах арга хэлбэр механизмтай. Хэрвээ янз бүрийн санал гомдол ирвэл энэ асуудлыг ярьдаг. Төрийн байгууламжийн хувьд Монгол Улс нэгдмэл улс. Төсвийн хувьд ч тэр, засаг захиргаатай удирдах, удирдуулах ёсоо хүндэтгэх ёстой. Тийм учраас хариуцлага нэхнэ шаардана. Би ард түмнийхээ талд, иргэдийнхээ талд байнга зогсоно.

**Ж.Бат-Эрдэнэ:** Равжихын Эрдэнэбүрэн гишүүн.

**Р.Эрдэнэбүрэн:** Оройн мэнд. Орой болсон байна аа, маш товчхон 2 товчхон асуулт асууя нэр дэвшигчээс. Дэлхий даяар ингээд нөгөө нефтийн асуудал яригдаж байгаа бүгдээрээ нефтийн хямралд орчихсон байгаа ийм үед томилогдох гэж байна. 4 сарын 1-ээс эхлээд ОХУ нефтиэ экспортлохгүй гэдэг ийм шийдвэр гаргасан гэсэн мэдээлэл гарсан. Энэнээс болоод энэ зах зээл, уул уурхай, бизнесменүүд чинь бүгдээрээ яах юм бол гээд ингээд хараад сууцгааж байна. Төлөвлөж чадахаа больсон энэ зун юм юу хийх юм бол гээд. Тэгээд энэ өмнө нь Дамдинням гишүүн яваад сайд яваад асуудалгүй болсон оросуудтай удаан хугацаанд тохирсон энэ тэр гэж ярьж байсан. Тэгэхлээр өнөөдөр та энэ иргэддээ хандаад асуудалгүй байгаа боломжтой цаашаа ингээд үргэлжлээд явна гэхээр тийм мэдээлэл байна уу? эсвэл бид нар гараад дахиад ингээд цаашаа ярилцаад явна гэх гэж байна уу? Яг нэг шууд хэлчих энэ зах зээлд дохио өгчих тийм мэдээлэл байна уу, байхгүй юу гэдгийг нэг хариулаад өгчхөөч.

2-т нь сая ингээд нэлээн хоорондоо маргалдаантай байлаа. Энэ үедээ бол маш олон сая доллароор яригдсан ийм авсан, өгсөн ийм ярианууд их яригдлаа. Одоо ингээд МАН-ынхан чинь буцаад нэгдээд явах гэж байх шиг байна. Нөгөө ярьж байсан юмнууд маань чив чимээгүй болоод ингээд цаашаа явах юм бол ер нь цаашдаа энэ Монголын төрд ямар үр нөлөө үзүүлэх вэ гэж бодож байгаа юм. Ийм 2 асуулт асуух гэсэн юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Энэ Эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлт гээд байгаа бодлого бол нэг чөлөөлөлт нь авлигын эсрэг чөлөөлөлт л дөө. Авлига ашиг сонирхлын гэмт хэрэгт холбогдсон, ёс зүй, сахилга хариуцлагагүйн улмаас нэр хүндэд нь болоод гэмт хэрэгтэй холбогдсон ийм асуудлууд үүсвэл нам нам дотроо сахилга хариуцлагаа тооцоод явах нь зөв. Тэрнээс биш Улсын Их Хурал гэдэг бол өөрөө хууль баталдаг болохоос хулгайч төрүүлдэг байж болохгүй ээ гээд би хэлсэн. Энэ үгэндээ би эзэн болж байгаа. Хууль хүн бүрд тэгш үйлчилнэ. Дүрэм зарчим бол хүн бүрд тэгш үйлчилнэ. Тэгэхээр цаашдаа ч гэсэн нам дээрээ ч тэр, та бүхэн ч тэр энэ асуудлыг анхаарах хэрэгтэй.

Дээрээс нь манай нам гэх юм байхгүй. Ер нь энэ улс төрийн нам эвслүүд шат шатад ч гэсэн энэ парламентын сонгуульд ч гэсэн нэр дэвшүүлэхдээ тэр 1 дүгээр асуудал тэр ашиг сонирхлын асуудал, энэ ёс зүйн асуудлыг 1-д тавьж байж шүүн тунгааж байж парламентад тэр нэр дэвшүүлж байх, нам нам дотооддоо тэр ёс зүй сахилга хариуцлагын асуудлыг 1-ээр тавьж байж явж байх нь зөв өө гэж үзэж байгаа. Энэ бол бүх намуудын хариуцлагын асуудал. Тэгэхээр дотоод дотооддоо шинэчлэлээ хийгээд явах ёстой. Нам намаа цэвэрлээд, цэгцлээд ингээд урагшлах ёстой гэж би бол ийм байр суурьтай бол байгаа. Тэр бензиний асуудал дээр бол бид нар газрын тосны бүтээгдэхүүний үнэ өсөж байгаа. үүнээс болоод бүх л үнэд хамаарч байгаа, нөлөөлж байгаа учраас таны яг хэлсний дагуу бас асуултад хариулахад манай энэ Шадар сайд Ганхуяг тиймээ 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тэр ОХУ Шадар сайдтай уулзсан юм байна. Ингээд албан ёсоор ОХУ-ын бензиний экспортод бүрэн хориг тавих шийдвэрийг албан ёсоор зарласан хэдий ч манай улсад энэ хамаарахгүй шүү гэдгээ албан ёсоор мэдээлсэн. Тэгэхээр нийлүүлэлтийн талд гацаа саад үүсэх нь бага. Тэгэхээр нийлүүлэлт дээрээ бид нар бүрэн анхаарна. Үнэ дээр бол баталж чадахгүй ээ гэдгийг үнэнээ хэлэх ёстой. Тэгэхдээ бусад улс оронтой адилхан тэр emergency mode буюу тэр онцгой горим руугаа шилжээд бид нар шуурхай арга хэмжээнүүдийг аваад явна. Ийм л байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жанчивын Галбадрах гишүүн.

**Ж.Галбадрах:** Оройн мэнд хүргэе. Дэмжиж байгаа, хурдтай эрчтэй боловсролтой учраас хүлээлт бас өндөр байгаа. Танд амжилт хүсье. Тэгээд Засгийн газрын, Засгийн газар тэгээд сайдууд хэчнээн хичээж ажиллаж байгаа ч гэсэн үр дүн гарахгүй байгаа тал гараад байгаа. Тэгээд үүний гол шалтгаан нь салбар хоорондын уялдаа холбоо муу байгаатай холбоотой байна гэж харж байгаа. Сая Лодой гишүүн бас хэллээ. Хот гэтэл Засгийн газраас хамааралгүй нэг бие даасан нэг вант улс шиг л байна тиймээ. Та ер нь хоттой яаж ажиллах вэ гэдэг тэр дарга нь хэн байх нь хамаа байхгүй. Ер нь хотдоо манай Засгийн газар маань нийслэлтэйгээ яаж ажиллах юм бэ гэдэг талаар асууя.

Мөн Их Хурал, Засгийн газрын уялдаа холбоо ч их сул байна. Баахан ажлын хэсэг байдаг, байнгын хороод байдаг, тэгээд Засгийн газрын гишүүдийг дууддаг, агентлагийн дарга нарыг нь дуудаж ирээд л баахан яриад л бид нар асуултууд тавьдаг, ярьдаг, тэгээд нөгөөдүүл нь хариулсан болоод ингээд явдаг. Тэгээд эргээд гүйцэтгэлээ ерөөсөө тайлагнадаггүй, хянадаггүй. Ер нь бид нарт энэ хариуцлагын тогтолцоо эргэх холбооны тал дээр та ямар шинэчлэл өөрчлөлтийг хийх вэ гэдгийг бас асууя.

Тэгээд үндсэн асуулт байна. Би бол бас боловсролын салбарыг төлөөлсөн эксперт хүн. Өмнөх Засгийн газар бол хүний хөгжлийг мега төслийн хэмжээнд авч үзнэ ээ гэж амласан, ажилласан. Та үүнийг үргэлжлүүлнэ биз дээ гэж итгэж байгаа. Бид ч гэсэн энэ талаар Учрал даргатай нэлээн санал солилцож бас ажлын хэсэг бодлогын хороог бас ахалж ажилласан. Тэгээд Монгол Улсад ядуурал үнэхээр бодитой нүүрлэсэн байна аа. Иргэдийнхээ боловсролыг дээшлүүлэхгүйгээр энэ ядуурлын тойргоос гарахгүй ээ. Бусад улсын туршлага бол үүнийг л баталдаг. Ард иргэдийнхээ боловсролд хөрөнгө оруулалт хийж хувь хүн бүр нь бие даах чадвартай, өөрийн амьдралаа өөрөө аваад явчих тийм чадварт сургах тал дээр л бид анхаарч байж бид нар Монгол Улсын хөгжил ирнэ гэдгийг хардаг. Та боловсролын талбарт яг юуг 1 дүгээрт тавьж юунаас эхлэх вэ? Боловсролд олон жилийн турш бугшсан олон асуудал байна. Үүнийг богино хугацаанд ч юм уу, сонгуулийн энэ хугацаанд шийднэ гэж попорч худлаа ярьдаг үе үеийн сайдууд байсны л хор гайгаар энэ ингээд цогцоороо шийдэгдэхгүй байна аа.

Одоо өнөөдөр төрийн өмчийн сургуульд 200 гаруй мянган хүүхэд нэг ангид 40, 50, 60-уулаа сууж байгаа. 10 мянга гаруй орчим багш дутагдалтай байгаа. Ийм учраас зарим хичээлийг үзэхгүй ялангуяа байгалийн ухааны хичээлийг үзэхгүй төгсөж байгаа ийм нөхцөлд бид нар чанартай боловсролын тухай огт яригдахгүй ээ. Тэгээд үүнийг бид ингээд хүлээн зөвшөөрөөд суугаад байгааг та бас юу гэж хардаг вэ? Тэгээд Монгол улсын 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөнд бид нар боловсролын салбарын КРІ Эдийн засгийн яаман дээр орж очоод бас энэ 19 мянган багш дутагдах талаар тодорхой төсөл хөтөлбөр гаргаж өгсөн байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулья.

**Н.Учрал:** 21 аймаг нийслэлтэйгээ хамтын ажиллагаагаа уялдуулж ажиллана. Сахилга хариуцлага нэхэн шаардана. Их Хурлаар батлагдсан үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн төлөвлөгөө, дээрээс нь Засгийн газрын дэвшүүлж байгаа бодлого зорилтыг аймаг орон нутаг, нийслэл, бүх шатад дэмжиж, ажлаа уялдуулж ажиллах

хэрэгтэй. Монгол Улс бол төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс шүү гэдгийг үргэлж санаа гэдгийг би шат шатын удирдлагууддаа намын даргынх нь хувьд ч тэр, гүйцэтгэх засаглалын тэргүүнээр сонгогдож ажиллах гэж байгаагийн хувьд ч тэр бас хариуцлагаа ярьж ажиллана гэдгийг бас хэлье ээ.

Тэгэхээр энэ бол мэдээж одоо үр дүн шахах шаардах ажил. Тэгэхээр ер нь цаашдаа нэг зүйл их бодитой байх ёстой. Сая 5 жилийн чиглэлийг оруулж ирэхэд нөгөө үндсэн үзүүлэлтүүд салбарын үзүүлэлтүүд гээд хэмжиж болохуйц байдлаар тавьсан. Жишээ нь бид нар эдийн засгийн өсөлтийг тооцоход ХАА-н салбарт хэдэн нэгж хувиар одоо энэ эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх юм бэ гэдгийг тооцож тэр макро тоонуудыг төлөвлөдөг. Яг үүнтэй адилхан бид тухайн олон улсад барьж байгаа индексүүд дээр тухайн салбар ямар нөлөө үзүүлэх юм бэ гэдэг дээр нь дандаа нэгж хувиар тавьсан 5 жилийн чиглэл баталсан. Яг үүнтэй адилхан би бүх шатад энэ KPI-ыг тавьж үнэлнэ ээ. Үүнийгээ нээлттэй дашбоардоор олон нийтэд харуулна аа. Ингээд олон нийтийн хяналт дор арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авна гэдгийг бас хэлье.

Боловсролын салбар дээр хамгийн эхлээд авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол 2019 онд тухайн үед Их Хурлын гишүүний хувиар санаачилж, Энх-Амгалан гишүүн ажлын хэсгийг нь ахалж батлуулсан Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль хэрэгжүүлнэ. Анх гүйцэтгэлийн үнэлгээг энэ хуульд хийсэн. Туслах багшийн орон тоог бий болгосон ийм хууль. Нэг ёсондоо бол багшийн хөгжлийг дэмжих асуудлыг шийдвэрлэж байж энэ багш нараа дэмжиж байж багшаараа дамжуулж байж энэ боловсролтой нийгмийг бүтээнэ гэж зорьж байгаа.

Хоёрт бол хүүхэд бүр нөгөө хамгийн ойрын сургуульдаа, хамгийн ойрын цэцэрлэгтээ явах бололцоог л бид нар бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм. Тэрнээс биш сум болгонд 10 жилийн сургууль барилаа гээд тэнд очиж хэн багшлах вэ. Очих багшийнх нь нийгмийн баталгаа цалин хөлс дээр нь ямар нэгэн урамшууллын механизм хийхгүйгээр хүүхдийн хичээлийн хоцрогдлыг хоцрогдлоос чөлөөлөх тэр дэлхий нийтийн мэдлэгийн хоцрогдлоос чөлөөлөх тийм ажил хийгдэхгүй. Тийм ч учраас тэр орон нутагт байгаа сумд байгаа сургууль соёлын ч сургуулийн чанар хүртээмжийг дээшлүүлэхийн тулд нэгд бол одоо Улаанбаатар хот дээр хэрэгжүүлж байгаа нөгөө Гүүглийн референс сургууль гээд байгаа. Хүүхэд бүр компьютероороо дамжуулаад клауд орчноос мэдээлэл түгээж, улс орны өнцөг булан бүрд тэр мэдлэгийн хоцрогдлоос чөлөөлөх ажлыг хийх зорилт байна.

Хоёрт бол цэцэрлэгийг шийдсэн арга шиг хотхоны сургууль гэдэг зарчмыг хэрэгжүүлэх нь зөв гэж би үздэг. Ингээд хамгийн ойрын сургуульдаа хүүхдүүд орох буюу Их Хурлаас баталсан Боловсролын ерөнхий хуульд бага сургууль байгуулах эрхийг олгосон. Бага сургууль дээр тавигдах шаардлагыг буулгана. Нэг ёсондоо залуу гэр бүлүүд залуу бизнес эрхлэгч нар бага сургууль байгуулж үйл ажиллагаа явуулах хувьсах зардлаар нь түүнийг дэмжих бие дааж хөгжих яг цэцэрлэг шиг зарчмаар цаашдаа боловсролын салбарын хүртээмж хоцрогдлыг арилгахгүй бол сургууль барилаа гээд багшгүй болсон ийм нөхцөл байдал байна аа. Тийм учраас энэ салбарт хийж хэрэгжүүлэх олон ажлууд байгаа. Тэр Галбадрах гишүүн Их Хурал дээр ажлын хэсгийг ахалж байгаа учраас таны дэвшүүлсэн бодлого үйл ажиллагаа...

**Ж.Бат-Эрдэнэ:** Галбадрах гишүүнд нэг минут.

**Ж.Галбадрах:** Баярлалаа. Маш тодорхой зүйлийг ярьж байна. Таны дэвшүүлж байгаа яг энэ зүйлтэй бид яг энийг л ажил хэрэг болгох гэдэг нь л бид нарын хувьд хамгийн чухал байна. Тэгэхээ KPI-уудыг их тодорхой тавьсан. 5 жилийн төлөвлөгөөнд бол оруулсан. Нэг ангид байх хүүхдийн тоог 40-өөс дээш оруулахын тулд 108 сургууль, 95 цэцэрлэг, 19 мянган багш дутагдаж байгааг бид нар ямар 4 арга хэмжээ авбал энэ багшийн бодит хоцрогдлыг арилгаад зөвхөн тоон хомсдол төдийгүй чанарын хомсдолыг арилгах вэ гэдэг тал дээр би Эдийн засаг хөгжлийн яамны газрын дарга нартай бас тооцоо хийж байгаа, Сангийн яамныхантай нэлээн ярьж тохирч тооцооллыг өгсөн байгаа. Энэ дээр таныг бас онцгой анхаарч өгөөд дэмжээд ажиллаарай гэж хүсэж байна аа. Танд амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жудагийн Баярмаа гишүүн.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ оройн мэндийг хүргэе. Та бол сүүлийн үед чөлөөлөх гэж их ярьж байгаа. Тэгээд энэ дотроо Эдийн засгийг чөлөөлөх, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гээд. Уг нь бол эдийн засгийг чөлөөлөх асуудал чинь тэртээх бараг 35 жилийн өмнө зах зээлийн нийгэмд шилжсэнээр бий болчихсон байх учиртай. Зах зээлийн нийгэмд шилжинэ гэдэг чинь өөрөө эдийн засаг тэр чигээрээ чөлөөлөгдөж байгаа гэсэн үг тиймээ. Тэгээд харамсалтай нь энэ нь чөлөөлөгдөөгүй учраас ингээд ийм хууль өргөн барихдаа тулаад явж байна аа. Эдийн засгийн индекс офф экономик фрийдом гээд тиймээ эдийн засгийн эрх чөлөөний индекс гээд байдаг. Энэ дээр бол 60 оноотой буюу бараг л чөлөөгүй, эрх чөлөөгүй улс гэж явдаг байгаа. Ийм ангилалд орчихсон явж байдаг. Тэгээд энэ дээр юуг авч үздэг вэ гэвэл мэдээж төрийн зардал тиймээ маш их хэмжээнд өндөр байдаг. Мөн элдэв төрлийн зохицуулалт, хууль, дарамт шахалт их байна гэж үздэг. Мөн иргэдийн өмчийн эрх баталгаагүй байна гэж үздэг.

Төсвийн зардал бол ДНБ-ний бараг ойролцоогоор 30 орчим хувьтай тэнцүү байгаа. Төрийн өмчийн оролцоо бол асар их байгаа. Мэдээж бид бүхэн ам болгоноо ам нээх болгондоо л ярьдаг. Засгийн газрын бүтэц бол асар их давхардалтай байгаа гээд. Тэгэхээр энэ бүгдийг шийдэхийн тулд үндсэн 3 чиглэлээр та реформ хийх ёстой тиймээ. Яг жишээлбэл бүтцийн реформ нөгөө бид нарын дандаа ярьдаг Засгийн газрынхаа энэ бүтцийг та багасгах уу? та нэг залуу хүн байна даа нөгөө Хавьер Милей шиг ийм дорвитой өөрчлөлт хийж чадах уу? Засгийн газрынхаа тоог бие биедээ барьцаалагдахгүйхэн шиг 9 яам болгодог ч юм уу ийм дорвитой өөрчлөлтийг та хийх хэрэгтэй. Энийг хийхгүй бол таны энэ бодож байгаа юм хэрэгжихгүй.

Дараагийн реформ зах зээлийн реформ. Хувийн хэвшлийн хийж чадах бүх юмыг хувийн хэвшлээр нь хийлгэх хэрэгтэй. Төрд хувийн хэвшлийн хийж чадаж байгаа ямар ч ажлыг даалгахгүй байх хэрэгтэй. Та энийг маш зоригтой хийж чадах хэрэгтэй. Мэдээж дараагийнх нь бол сангийн төсөв санхүүгийн реформ. Тэгээд энэ дээр бол та мөн маш их дорвитой. ДНБ-д эзлэх энэ төсвийн зарцуулалт зардлыг бол дорвитой хэмжээнд 10 хувь хүртэл 10 хувь хүргэх ч байдаг юм уу ийм том хэмжээний өөрчлөлт орж байж та магадгүй залуу хүнийхээ хувьд легасигаа үлдээх байх аа. Энэ 3 бодитой өөрчлөлтийг хийхээс нааш таны бодож байгаа өөрчлөлт тэр эдийн засгийн эрх чөлөөнд бараг хүрэхгүй байх аа. Тэгэхээр ийм 3 асуудал дээр та ямар зүйл бодож байна вэ?

2 дугаарт авлига. АН-ын үед 2015 онд 92 дугаар байранд байсныг нь 20 байр урагшлуулаад 72-г билүү аваачсан байдаг. 72 дугаар байранд аваачаад засгийг

өгсөн. Тэрнээс хойш Ардын нам 10 жил засаглалаа. Үр дүнд нь 50 байраар ухарлаа. Тэгэхээр та яг энэ авлигатай тэмцэх энэ чиглэлээр юу хийх гэж бодож байна аа? Одоо овоо ингээд авлигатай тэмцээд байгаа юм шиг энэ өмнөх Засгийн газрын тэргүүн...

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярмаа гишүүнд нэг минут.

**Ж.Баярмаа:** Тэгэхээр одоо ингээд та бүхэн чинь эцсийн дүндээ энэ чуулганы санал хураалтад оролцож байгаа байдлыг харахаар ердөө АН-аас үл хамаарч Ардын нам доторх тэмцэл зодоон бол энэ бүх юмны учиг байсан нь бол сая харагдсан. Тэгэхээр та энэ авлигатай тэмцэх ажлаа үргэлжлүүлэх үү? Занданшатар Ерөнхий сайдын эхлүүлсэн ч юм уу, яг жинхэнээсээ хийж эхэлж байна уу даа гэж харсан энэ ажлыг хийх үү? Авлигатай хамгийн эрчимтэйгээр тэмцэхийг санаархсан энэ Энхбаяр сайдыг та чөлөөлөх үү? Хэрвээ та чөлөөлж байгаа бол таныг бол авлигатай тэмцэж байгаа юм байна аа гэж үзэхэд маш хэцүү болно оо.

3-д сая гишүүд зөндөө асуучихлаа. Энэ Нийслэлийн Засаг дарга чинь юу болоод байна аа. Улсын Их Хурлыг бүүр дарамталж байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүд ээ нэг нэгээрээ гараад ир үзье гэж байна шүү дээ. Үгүй энэ чинь одоо юу вэ. Улсын Их Хурал буюу парламентын бүрэн эрхэд бараг халдаж байгаа юм биш үү? Хүний гэрийн гадаа оччихсон Оюунгэрэл ээ гараад ир үзье. Үгүй ээ юу вэ. Энэ чинь Их Хурлын гишүүдийг үг хэлэхийг ингэж дарамталж байгаа юм чинь...

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэлэв үү. Учрал гишүүн.

**Н.Учрал:** Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлнэ, авлигатай тэмцэх ажлыг бол бодитой ажил хэрэг болгохоор ажиллана. Нэг ёсондоо бол тогтолцооны асуудал. Би өнгөрсөн хугацаанд бол хүнээс хамааралгүй шийдвэр гаргах энэ дижитал засаглал, цахим засаглалын индексийг урагшлуулах ажлуудыг олон бас нэг сүүлийн бас нэг 3, 4, 5 жил бараг хийгдлээ л дээ. Тэгээд ийм учраас өнгөрсөн хугацаанд тэр 820 мянган мөр өгөгдөл ил болсон. Тэр шилэн ажиллагаа гээд энэ ажлуудыг бол хийсэн, хэрэгжүүлсэн. Цаашдаа ч гэсэн энэ ажлаа илүү үр дүнд хүргэхээр би танд хэлсэн. Шүгэл үлээгчийн хуулийг батлан гаргана. Олборлох салбарын ил тод байдлын хуулийг батлан гаргана, байгалийн нөөцийг бүрэн хамруулж ил тод болгоно. Дээрээс нь энэ АН-ынх бүлгийн мөн Алтангэрэл гишүүн өмнөх засгийн үед өргөн барьж байсан энэ ял завшаад байгаа асуудал, нийтийн албан тушаалтнууд тэр хөрөнгө хураах механизмыг ч гэсэн тодорхой болгох ёстой гэж би зорино.

Дээрээс нь Засгийн газар бол авлигатай тэмцэх чиглэлээр энэ Нээлттэй засгийн түншлэлийн гишүүний хувьд би бас дорвитой алхмуудыг бол хийнэ. Мэдээллийг нуухгүй. Дээрээс нь ашиг сонирхлын түрүүн бас гишүүд хэлж байсан. Тэр хариуцлагатай алба хашиж байгаа сайд нар тэр ашиг сонирхлын зөрчил үүсгэвэл хэрхэн хариуцлага тооцох вэ гээд. Тэгэхээр энэ улс төрийн намын даргын хувьд ч тэр, гүйцэтгэх засаглалын даргын хувьд ч тэр, тэргүүний хувьд ч тэр хариуцлага бол тооцоод шат шатад нь ашиг сонирхол, авлигаас урьдчилан сэргийлэх асуудал дээр ажиллана. Та хэлсэн Эдийн засгийн эрх чөлөөний хууль бол өөрөө үндсэн анхдагч тэр суурь хуулиар зохицуулагдахаас гадна Үндсэн хуульд заасан бизнес эрхлэх хувийн өмчтэй байх, тэр газар эзэмших юу байдаг юм бусад төрлийн тэр эдийн засгийн эрх чөлөөг олгосон эрх чөлөөний заалтууд руу нь хэн нэгэн бүдүүлгээр халдаад байдаг учраас тэр 60-д яваад байна гэдэг ийм үзүүлэлт

гарчхаад байна. Тийм учраас тухайн үед 21 хуулийг дагуулж байсан юм. Тэр Үндсэн хуулийн суурь зарчмыг үгүйсгэсэн олон хуулиуд байна аа.

Тийм учраас энэ давхардал хийдлийг арилгах ёстой гээд.

Тэгээд сая засгаас барьсан буцаагаад татсан хуулийг би тэр дагасан хуулиудынх нь өөрчлөлтөө оруулж байж эдийн засгийн эрх чөлөөгөө иргэд бүрэн хангах нөхцөлийг нь бүрдүүлж өгөх ажлуудыг шат дараалалтай хийнэ. Тийм ч учраас тэр чиг үүргийн шинжилгээ, саяын татварын бодлого, тэр зөвшөөрөл, мэдэгдэл гээд эдгээр асуудлыг цогцоор нь оруулж ирж ирэх оны төсвийг дагуулсан реформын шинжтэй ажлуудыг зэрэгцүүлж хийнэ гэдэг ийм төлөвлөгөөтэй бол байгаа. Тэгээд ер нь бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан энэ эрх, эрх чөлөөнүүдээс хиймэл оюун дээр шинжилгээ хийхэд 228 хууль дээр эдийн засгийн эрх чөлөө нь зөрчигдөж байна гэсэн дүгнэлт гарсан 228. Тэгээд энэ их том тоо байхгүй юу. Тэгэхээр энийг эрх зүйн чөлөөлөлтийн хүрээнд чөлөөлж өгөхгүй бол хувийн хэвшил, гаднын хөрөнгө оруулалт, баялаг бүтээгч нар бол Монголд бизнес эрхлэх бололцоо байхгүй байна аа л гэсэн ийм л дүгнэлт шүү дээ.

Тийм учраас энэ эдийн засгийн эрх эрх зүйн ногоон хөгжлийн авлигын эсрэг чөлөөлөлт гэдэг бол энэ эрх чөлөөний 4 зам гэж томъёолоод байгаа юм л даа. Тийм учраас энэ чөлөөлөлтийн бодлого гэдэг бол өөрөө их том дэвшил авчрах бодлого. Тэрийг заавал хууль гэхгүйгээр гүйцэтгэх засаглалын түвшинд шийдвэрлээд явах асуудлуудаа шийдээд бас явна гэдгийг хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярмаа гишүүн.

**Ж.Баярмаа:** Нийслэлтэй холбоотой асуултыг асуухаас өөр замгүй байгаад байна. Та хариулах хэрэгтэй байх. Энийгээ ташрамд нөгөө 14 мега төсөл маань юу болж байгаа вэ? Ер нь бол мега үлгэр байсан нь тогтоогдсон шүү дээ бараг шахам. Зарим нэг нь бол санхүүгийн эх үүсвэрээ ч олоогүй байсан төслүүд байсан. Зарим нэг нь одоо хаанаа юу болсон бүү мэд. Яг тэрэнтэй агаар нэг энэ нийслэл гэдэг чинь тусдаа вант улс болчихсон байна шүү дээ. 24 мега төсөл хэрэгжүүлэх гээд явж байна. Тэгэхээр энэ засаглалын хуваарилалт чинь яг юу болоод байна аа? Монгол Улс чинь нэгдмэл төрийн байгуулалттай улс байгаа. Гэтэл нийслэл гэдэг чинь түүгээрээ бараг улсын төсөвтэй хэдэн хувьтай нь ч юм бараг тэнцэх хэмжээний асар их хөрөнгө мөнгө их наядаар нь ингээд мега нэртэй төслүүдээр мега хулгай хийгээд байгаа юм уу гэдэг ийм хэмжээнд хүртэл иргэд хардаж байна шүү дээ. Үгүй тэгээд энэ хардсан, санал бодлоо илэрхийлсэн иргэдийг ингээд ерөөсөө барьж авч бараг алах нь ээ. Энэ зүгээр үү, энэ эрүүл үзэгдэл үү?

**Ж.Бат-Эрдэнэ:** Даваагийн Цогтбаатар.

**Да.Цогтбаатар:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Ардчилсан нийгэмд төрж өссөн Монгол Улсын Ерөнхий сайд томилогдох гэж байгаа тул бас дэмжиж байна аа, чадах байх. Одоо бол бодитой ажлуудаа ярья. Манайхан баахан бодлого ярилаа. Цагаан байрны улаан намынхан 3 дугаар ээлжийнхэн нь хоолондоо орох гэж байна. Удирдагч нь та өөрөө. Жишээ нь энэ Эрдэнэс Монгол гээд нэг компани байна. Яам юм уу гэхээр яам биш, Засгийн газрын ХЭГ юм уу гэхээр бас биш. Холбогдох одоо тэр Эрдэнэт зэс гэдэг юм уу, Эрдэнэт гэдэг юм уу, ЭТТ гэдэг юм уу бүгдээрээ ажлаа хийж чадаж байна. Гэтэл энэ компанид жилд 6, 700 тэрбум төгрөг төвлөрүүлээд үрждэг үр дүнд хүрдэггүй. Тэгээд иргэд нь очоод мэдээллийг нь ил тод байлгая гээд

ингээд яриад явдаг. Жишээлэхэд энэ иргэн Даваагийн Мөнх-Эрдэнэ бол шүгэл үлээгээд мэдэх эрхийг нь хангаад яваад байдаг, сайн муугаараа хэлүүлээд яваад байдаг. Тэгээд энэ иргэдээ сонсдоггүй энэ дарга нь зандаг нийгэм дээр та Ерөнхий сайд болж байна, байр сууриа нэг илэрхийлээч ээ гэж хүсэж байна.

Хоёрт аль ч нам хамаагүй бүгдээрээ дарга болоод бүгдээрээ ингээд нэг ийм болсон болоогүй багаа бүрдүүлж ирнэ гээд бүгдийг нь халдаг, халаад явахаар одоо жишээлэхэд улсын хэмжээнд 2023 онд 21 тэрбум, 2024 онд 40 тэрбум төгрөгийг улсын төсвөөс тэтгэмжээр өгчихсөн байна. Нэг удаагийн тэтгэмжээр. Гэтэл энэ чинь төрийн өмчийн компаниуд дээр энэ тоо зөндөө явна, төсвөөс өгнө. Энэ чинь бүгдээрээ Монгол Улсаас гарч байгаа. Одоо та Монгол Улсын Ерөнхий сайд болж байна. Энэ тал дээр бас нэг таныг асуумаар байна. Энэ төрийн өмчит одоо энэ сууж байгаа компаниуд дээр сууж байгаа дарга нар бол эхнэрийгээ зөөж байна, хүүхдүүдээ зөөж байна, сургууль, цэцэрлэг гэр лүү нь. Хэмнэе гамная гэдэг бодолтой нэг ч дарга байхгүй бүгдээрээ ингээд гудамжинд алхаж чадахаа байчихсан, автобусанд сууж чадахаа байчихсан. Та нараас том цалинтай. Наранцогт дарга Эрдэнэс Монгол дээр сууж байхдаа жилийн 393 сая төгрөг авч байсан юм байна. Дараагийнх нь дарга оччихсон нуугаад байна. Хувь хүний нууц гэнэ. Улсын байгууллагад АТГ-т мэдээллээ гаргаж өгөөд дарга хийх гэж очиж байгаа бол тэнд юуг нь нуух гээд байгаа юм. Иргэдээсээ та яг юу нуух гээд байгаа юм. Энэ тал дээр бас нэг байр сууриа илэрхийлээд өгөөч.

Уг нь бол одоо энэ бид нар энэ их тансаглалаар чинь уг нь эмч нар, багш нар цалин бага байна гээд жагсаад байна шүү дээ. Ахмадууд ч гэсэн цалин 1.5 сая болгоод өг гээд жагсаад байна. Эд нар луу хийчихгүй юм уу? Өвдсөн нэг хүн гадагшаа явж чадахгүй байхад МИАТ-ийнхэн тэгээд энэчээ татвараа төлөөд л гадагшаа зугаалаад явж байдаг ийм аймаар үргүй зардалтай компаниудыг татан буулгамаар байна шүү дээ, хувьд өгмөөр байна. Энэ тал дээр таны байр суурийг сонсчоод тэгээд араас нь АТГ-ынхантай энийг ярьж даа. 30 секунд байгаа юм уу. Одоо энэ АТГ гэж нэг бас нэг газар байна. Дарга нь сураг сонсох юм бол казино тоглоод яваад байдаг юм шиг байгаа юм. Эсвэл улс төрөөс нэг команд өгөхөөр өөр ажлаа хийж хүн намнадаг. Цагаан байрны хулгайчууд бүр эрээ цээрээ алдсан шүү дээ. Бүгдээрээ 100 сая төгрөг биш 100 сая доллар авлигын хэргийг илчилдэг болсон. Яагаад ажлаа хийхгүй байгаа юм. Эсвэл өвдвөл, эсвэл өөрөө хүсвэл, эсвэл хугацаа нь дуусвал чөлөөлдөг юм байна. Энэ АТГ-ын даргыг чөлөөлдөг яаралтай хуулийг оруулж ирэхгүй би өөрөө санаачилъя Учрал дарга аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** Тэр Эрдэнэс Монгол Үндэсний баялгийн сангийн хуулийн дагуу баялгийн сангийн удирдлагыг хэрэгжүүлдэг байгууллага гээд хуульд тусгагдсан. Энэ бол ер нь баялгийн сангийн нэгдэл. Тэгээд алдагдалтай ажиллаж байгаа компаниудаар санхүүгийн менежмент хийдэг тэгээд таны ярьж байгаа зүйл дотор бас тодорхой хүн яриад байх шиг байна. Би тэнд хэн яаж ажиллаж байгааг одоо очоогүй учраас мэдээлэл байхгүй. Тэгэхээр би худлаа ярьж яах вэ. Очоод энэ компанийн менежмент ямар түвшинд байгаа юм гэдгийг өөрөө очиж мэдээллүүдийг авна. Нэг л зарчмаар үйлчилнэ. Би түрүүн хэлсэн шүү дээ. КРІ дээр суурилсан тэр гүйцэтгэх захиралтай контракт байгуулаад яваад тэр ашиг орлогоороо цалинждаг, компанийг ашигтай оруулбал урамшуулал авдаг энэ зөв зарчим руу явуулах ёстой. Тэгээд үнэхээр ашиг олж байвал урамшуулал авч болно оо. Тэр компаниуд нь уул уурхай гэдэг л зарчим шүү дээ. Тийм учраас энийг бол очиж бас тодорхой

мэдээллүүдийг авч нөхцөл байдлыг сонсож дүгнэлтээ гаргах нь зөв байх гэж бодож байна.

Би Цахимын сайд байхад Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиар ТӨК-иудын ТУЗ, гүйцэтгэх захирал, хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллыг нээлттэй болгох хуулийг хийсэн шүү дээ. 68 нэр төрлийн мэдээлэл нээлттэй байгаа. Shilen.gov.mn дээр байгаа шүү дээ. Энэ shilen.gov.mn дээр энэ 68 нэр төрлийн мэдээллийг ил болгохгүй байгаа бол харин Засгийн газар хариуцлага тооцно шүү. Тэгээд Цогтоо гишүүн ээ тиймээ, би энэ хууль дээр байгаа цалин хөлс урамшуулал бүгдийг нээх ёстой. Энийг ил болгохгүй байвал харин энэ эс үйлдэл шүү. Тэгэхээр ингэнэ.

Хоёрт бид нар нэг зүйлийг бас мартаж болохгүй. Одоо ингээд улс төрчид бид хэтэрхий ингээд төрийн алба ТӨК руугаа ингээд улс төр хийсээр байгаад сүүлдээ энэ ТӨК-иудад чинь боловсролтой чадалтай залуучууд ажиллахаа больчих гээд байна аа. Үгүй тэнд очсоноос хувийн компанид ажиллая. Төвөг минь тэнд очиж янз бүрээрээ цоллуулж байхаар. Төрийн албанд чинь хүн үлдэхээ болилоо, төрийн алба чинь бүгдээрээ ийм тийм гээд цоллосоор байтал. Тэгээд цаашдаа энэ ТӨК-иудыг чинь хэн удирдах юм. Энэ төрийн албыг чинь хэн удирдах юм. Тэгээд хэдүүлээ бас энэ нэг жоохон зарим зүйл дээрээ нэг улс төрөө нэг хэмжээ хязгаартай хийж байхгүй бол өнөөдөр ч гэсэн орой үдэш хэдүүлээ ярихдаа бол сая нөгөө тэр банк дампуурах гээд байна гэхээр дагаад дампуурдаг гэдэг үг байдаг шиг ийм эдийн засгийн нарийн тоог ингэж байгаад энэ зах зээл дээр хэтэрхий их савлагаа бас үүсгэх эрсдэлтэй.

Тэгээд бид нар чинь нөгөө олон жил ТӨК компани гээд зарим нөгөө нэг үхрийн эвэр доргихоор мянган үхрийн эвэр доргидог гэдэг шиг яг ажлаа хариуцлагатай хийж байгаа зарим ТӨК-ийн гүйцэтгэх захирлуудынх нь нэр хүнд нь дагаж унаад тэгээд хүмүүс ер нь за одоо төрд ажиллах ч хэцүү юм байна, ТӨК-д ажиллах хэцүү юм байна гэдэг болчихоод байгаа юм. Тэр төрд байгаа хариуцлагатай албан хаагчдыгаа хамгаалах бодлогыг ингээд зөв хэрэгжүүлж зарим чадалтай мэдлэг ур чадвартай хүмүүсийг төрд нь авч үлдэх, ТӨК-иуд дээр хариуцлагатай сайн ажиллаж байгаа хэдийгээ бас хайрлах хамгаалах ийм бодлогыг хэрэгжүүлэхгүй бол сүүлдээ бүхлээрээ л бүтэхгүй болохгүй юм шиг болоод ер нь төр маань ТӨК-иуд маань их хүнд болж байгаа шүү. Тэгэхээр энэн дээр бас би яг гүйцэтгэлээр нь үнэлээд сайныг нь сайн, мууныг нь муу ингээд нээлттэй зарлаад ингээд явдаг зөв механизм руу шилжүүлэхийн төлөө хичээнэ ээ гэдгийг бас хэлье ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Даваагийн Цогтбаатар нэг минут. За Учрал гишүүн.

**Н.Учрал:** Засгийн газар бол тэр авлигын индексийг 10 байр хойшилчихсон байгаа. Энийг ахиулах ёстой. Үүнд хууль хяналтын байгууллагууд хамтарч ажиллах ёстой тийм. Тэгэхээр би ТӨК-ийг ч тэр, аль ч байгууллагыг ч тэр муу сайн гэж түрүүлж дүгнэж болохгүй хариуцлагатай байх ёстой. Тийм учраас ажлаа хийнэ, хариуцлагатай хамтарч ажиллаж байгаа хэн бүхэнтэй ажиллана. Хариуцлагагүй, ёс зүйгүй байгаа ажлаа хийж чадахгүй хэнтэй ч ажиллах бололцоогүй ийм л зарчим шүү дээ. Тэгээд бие биедээ шаардлага тавьж суръя, эрхээ эдэлье, үүргээ хүлээе, хариуцлага нэхье. Одоо энэ сахилга батгүй байдал, хариуцлагагүй байдлын ийм зуд болоод байна шүү дээ. Тэгээд энэ хариуцлагатай байдал руу л явъя, тэгээд би шахааж шаардаж ажиллая тэгээд та бүхэнд эргээд ажлаа тайлагнаад явна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цогтбаатар.

**Дав.Цогтбаатар:** Мэдээлэл авъя гээд бичиг явуулахаар ирүүлдэггүй ТӨК-иуд төрийн байгууллагууд дүүрэн байгаа. Та бол өөрөөсөө ил болгоно гээд хэлчих шиг боллоо. Энийгээ бас ажил хэрэг болгоодхоорой. За тэгээд тэр хуулиудыг засах эрх бол одоо танд нээлттэй байгаа. Та хуулиа Засгийн газрынхаа өмнөөс санаачлаад оруулаад ирээрэй. Нүдэн дээр нэг хүн галзуурчихдаг юм даа. Улаан коммунист болчихлоо бүр Нямбаатар гэдэг Улаанбаатар хотын дарга бүр улаан коммунист. Иргэдтэйгээ юмаа ярихгүй, зөвөөр тайлбарлахгүй, хүчиндээд улайраад зангаад байх юм. Уг нь бол өөрөө ятгах тусам нягтал гэдэг Хууль зүйн сайд хийж байсан хүн Улсын Их Хурлын гишүүн. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд нэг нэгээрээ гараад ир гэж байна шүү дээ.

Учрал дарга аа, та өөрөө Улсын Их Хурлын гишүүн таныг гараад ир тантай үзье гэж байна шүү дээ, гарахгүй юм уу. Очиж Нямбаатартайгаа учраа олохгүй юм уу. Засах тусам Үгүй ээ, юу гэлээ занга тусам хамгаал гэх юм уу, занга тусам жагс гэх юм уу. Бид нар одоо иргэдэд юу гэж хэлэх ёстой юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэвэгдоржийн Туваан алга байна. Мөнхчулууны Энхцэцэг.

**М.Энхцэцэг:** Сайн байцаана уу? Цэнгүүн гишүүн байсан шүү дээ сая дарга аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саруулсайханы Цэнгүүн.

**С.Цэнгүүн:** Таны хэрэгжүүлж байгаагаас чөлөөлье санаачилга маань маш чухал санаачилга. Тэгээд энэ хүрээнд эрчим хүчний салбарын зах зээлийн загварчлал дээр та яг ямар бодлого хэрэгжүүлэх вэ гэдгийг би асуумаар байна. Яагаад гэхээр Эрчим хүчний зохицуулах хороо маань өөрөө бие даасан үйл ажиллагаа хэрэгжүүлнэ ээ гээд хуульдаа заасан байдаг. Үе үеийн Ерөнхий сайд нар энийгээ биелүүлдэггүй байсан юмаа. Тэгээд тэр утгаараа бол чөлөөлье санаачилгатай нягт холбогдоод явах зүйл маань эрчим хүчний салбар дахь үнийг чөлөөлөх, үнийг нэмэх гэж юм уу, үнийг хасах гэдэг юм уу ийм байдлаар хүмүүс ойлгоод байдаг. Үнэ чөлөөлнө гэдэг маань төр оролцохгүйгээр эрчим хүчний зах зээл бие даасан байдлаараа зах зээлийнхээ зарчмаар өөрөө зохицуулагдаад явахыг хэлдэг.

Тэгэхээр та энийг бас ойлгож байгаа хүний хувьд өөрөө Ерөнхий сайдаар томилогдох гээд сууж байгаа хүний хувьд анх удаадаа Эрчим хүчний зохицуулах хороог бие даасан байдлаар нь ажиллуулж өгөөч ээ гэж хүсмээр байна. Энэний дараагаар ТӨК-иудын ашиг алдагдалтай холбоотой байна. Тэгэхээр ТӨК-иуд маань нэг төгрөг олохын тулд 17 төгрөг зарцуулаад байгаа юм. Энэний маш том илрэл нь юунаас харагддаг вэ гэхээр намын томилгоонуудаас харагдаж байдаг. Захиргаа дээр нь маш олон ажил хийдэггүй намын томилгоогоор очсон хүмүүс байдаг. Тэгээд ТЭЦ-үүд дээр ч байдаг юм уу эсвэл эрчим хүчний компаниуд дээр харахаар инженер техникийн албанд нь өнөөдөр хүн ажиллаж чадахаа больчихсон. Энэ асуудлыг та бас сайн хараарай гэж хүсье. Тэгээд эрчим хүчний салбарт бид нар мөнгө байхгүй гэж хэлээд байдаг. ТЭЦ 3, 4 дээр маш том том ослууд гарснаас болоод өнгөрсөн өвөл дулаангүй цахилгаангүй лаагаа бариад Улаанбаатарчууд өвөлжсөн. Тэгээд бид нар жинхэнээсээ мөнгөгүй болоод л ингээд байгаа юм юм уу гээд харахаар энэ 9 сараас хойш нийтдээ 2 сарын хугацаанд 2026 оны 2 сарын хугацаанд 465 тэрбумыг Туулын хурдны зам барих төсөлд цаасанд зориулаад манай нийслэл

гаргачихсан байна аа. Тэгээд бид нар мөнгөгүй гэдэгт би итгэхгүй байгаагийн шалтгаан нь энэ байгаа.

Яагаад тэгж байна вэ гээд тэгэхээр өнөөдөр болохоор АН-ын бүлэг дээр Туулын хурдны замтай холбоотой ТЭЗҮ болон судалгаануудтай нь танилцъя гээд нээлттэй хэлэлцүүлэг хийсэн байгаа. Тэгээд энэ хэлэлцүүлгийн хүрээнд маш олон эрдэмтэн судлаач тэгээд энэ салбарын хүмүүс үгээ хэлсэн. Гэтэл энэ хүмүүс үгээ хэлснийхээ төлөө террористууд болж байна. Энэ хүмүүстэй хамт бас Улсын Их Хурлын гишүүд нь байр сууриа илэрхийлэхээр илэрхийлсэн гишүүн болгоных нь өөдөөс Нямбаатар дарга ямар нэгэн байдлаар чичилж загнаж, уурлаж зандарч байна аа. Энэ тал дээр МАН-ын даргын хувьд та ямар арга хэмжээ авах вэ?

Бид бүхэн мэдээллээ ил тод нээлттэй болго, судалгаан дээр байгаа тоонууд чинь бодит амьдралтай нийцэхгүй байна гэдэг шаардлагыг гаргаж тавьж байгаа. Энэ бол зарчмын шаардлагууд байгаа. Тэгэхээр энэ дээр таны байр суурийг бас сонсмоор байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал дарга.

**Н.Учрал:** Их Хурлын даргын захирамжаар Энхцэцэг гишүүн, Цэнгүүн гишүүн нараар ахлуулсан энэ ажлын хэсгийг байгуулсан. Тэгээд өнгөрсөн хугацаанд манай эрчим хүчний салбарын хөгжил дэвшлийн талаар бас дэвшилтийн санаа оноо уралдуулж байгаа манай гишүүд нэлээдгүй бас ажилласан. Миний хувьд бол энэ эрчим хүчний салбар бол Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд хамгийн чухал нөлөө бүхий суурь салбар гэж үзэж манай Засгийн газрын гол бодлогын гол цөмд энэ салбар байна гэж зорьж ажиллана. Тэгээд эрчим хүчийг аль болох бага өртөгтэй байлгах нөгөө талаасаа салбар тасралтгүй найдвартай байх зардлыг бүрэн бүрдүүлэх нь зайлшгүй. Тэгээд цаашдаа энэ салбарт энэ либералчлах бодлогыг дэмжинэ. Төрийн оролцоо багатай өрсөлдөөнт зах зээл рүү шилжих эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр бол дэмжиж ажиллана. Тэгээд таны хэлж байгаагаар энэ эрчим хүчний зохицуулах байгууллагыг бас хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхийг бол би бас дэмжинэ. Шаардлагатай бол Засгийн газар дээр гишүүдийн ажлын хэсэгтэй нэгдээд хуульд бодлогоо оруулаад ирэхэд нээлттэй гэдгийг хэлье. Мэдээж олон жил ингэж явж ирсэн хэдий ч бид үнэнд гүйцэгдэж өвөл гал алдаж байна. Тэгэхээр цаашдаа эрчим хүчний салбар дээр энэ алдагдлыг нөхөх, хуримтлагдсан өр төлбөрийг үе шаттайгаар барагдуулах ийм ажлуудыг бол үе шаттайгаар хийгээд явна аа.

Дээрээс нь энэ сэргээгдэхийнхээ эрчим хүчний төслүүдийг дэмжих ийм тодорхой бодлогуудыг энэ ногоон хөгжлийн чөлөөлөлтийн хүрээнд хийж хэрэгжүүлнэ гэдгийг бол бас хэлье. Тэгээд нэг талаасаа мэдээж цаашдаа эрчим хүчний үнэ тарифыг бодит өртөгт нь нийцүүлэх л бидний зорилго учраас үүнд анхаарал хандуулна. Хот дээр үүсээд байгаа асуудал дээр би анхаарал хандуулъя. Холбогдох мэдээллүүдийг авъя. Тэгээд би энэ индрээс ч хэлсэн манай намаас томилогдсон шат шатын сонгуульт албан тушаалтнууд ард түмнийг иргэдийг дээрээс нь харж харьцахгүй шүү. Хэрвээ дээрээс нь харах тохиолдол ганцхан байна. Бүдэрч унасан хүнийг л татаж босгоход дээрээс нь хар аа. Тэгэхээр намын даргын хувьд ч тэр, гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд ч тэр цаашдаа бол би сахилгатай, хариуцлагатай, ёс зүйтэй байхыг шат шатны албан хаагч нараас нэхэн шаардана. Энэ бол хэн нэгэнд үйлчилдэг, хэн нэгэнд үйлчилдэггүй гэдэг зүйл

байхгүй учраас бүгдээрээ л шат шатдаа хариуцлагатай бай гэдгийг л шахаж шаардана. Тэгээд энэ асуудал дээр би бас анхаарал хандуулъя аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мөнхчулууны Энхцэцэг.

**М.Энхцэцэг:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Улсын Их Хурлын дарга асан Учралын хувьд маш богино хугацаанд буюу дөрөвхөн сарын хугацаанд Улсын Их Хурлын даргаар ажиллахад маш үр бүтээлтэй ажиллаж чадсан гэж дүгнэж хэлмээр байна. Тэгэхээр бид бүхэн сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг эрчимжүүлэх түүхэн тогтоолыг баталсан. Энэ хүрээнд хөгжилд саад болж байсан олон чөдөр тушаануудыг байхгүй болгосон ийм үр дүнтэй ажлыг хийсэн байгаа.

Тэгэхээр энэ тогтоолын хүрээнд мэдээж Засгийн газар олон ажлуудыг хийж хэрэгжүүлэх ёстой. Энэ хүрээнд олон айлууд сэргээгдэх эрчим хүчээр зуух яндангаа солиод, эрчим хүчээ хэмнээд амьдралынхаа чанарыг сайжруулж цаашлаад илүүдэл цахилгаанаа сүлжээнд борлуулж орлого олох мөн эрчим хүчний хэрэглэгчээс гадна үйлдвэрлэгч болж эрчим хүчний хараат байдлыг бууруулахад хувь нэмэр оруулах ийм өргөн боломжтой. Ингэж байж өнөөдөр энэ түүхэн тогтоол гэсэн утга учир хангагдах юм. Тэгэхээр энэ хүрээнд олон айлууд ийшээ шилжихэд мэдээж гол хүндрэл бэрхшээл нь одоогоор хөрөнгө оруулалт маш өндөр байгаа, маш өндөр байгаа. Тэгэхээр энэ тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Ерөнхий сайд маань ямар томоохон ажлуудыг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэхээр зорьж байгаа вэ гэсэн 1 дүгээр асуулт.

2 дугаар асуудал. Цахилгаан эрчим хүчний хувьд бид нар цаашдаа ерөөсөө өрсөлдөөнт бөөний зах зээл рүү шилжих ёстой, шилжих ёстой. Тэгж байж зах зээл дээрх байж болох боломжит доод үнэ тогтдог оо. Тэгэхээр бид нар дулаан хангамжийн хувьд бол анхдагч хуулийг өргөн барьж байгаа. Дулаан хангамж бол зохицуулалттайгаа үлдэнэ. Цахилгаан хангамжийн хувьд ерөөсөө өрсөлдөөнтэй байж байж, байж болох зах зээл дээрх доод үнэ тогтох ёстой. Тэгэхээр одоогоор бид нар нэг худалдан авагчийн загвар гээд цахилгаан станцуудаас төр цахилгааныг худалдаж аваад хэрэглэгчид хүргэдэг ийм загвартай явж байгаа. Тэгэхээр энэ загварыг бид нар цаашаа чөлөөт өрсөлдөөнтэй бөөний зах зээл рүү шилжүүлж либералчлах ёстой. Тэгэхээр энэ хүрээнд Засгийн газрын тэргүүний хувьд ямар ажлуудыг нэн тэргүүнд хийхээр төлөвлөж байгаа вэ гэсэн ийм 2 асуулт байна аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлтийн нэг чөлөөлөлт бол ногоон хөгжлийн чөлөөлөлт. Тэгэхээр ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг цаашид нэмэгдүүлнэ. Ногоон зээлийн шалгуурыг шинэчлэх хүүг бууруулах арга хэмжээнүүдийг авна. Энхцэцэг гишүүний санаачилсан энэ 3, 100 гээд байгаа хөтөлбөрийн хүрээнд тэр 100 мгвт тархмал эх үүсвэр төслийг хэрэгжүүлнэ. Түншлэлийн түншлэлээр энэ сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийн дэд бүтцийн төслүүдийг орон нутгуудад хэрэгжүүлнэ. Саяхан бас аймаг аймгийн дарга нар санамжийн бичиг зурсан. Бүх талаар нь энэ төслүүдийг нь дэмжинэ. Хувийн санхүүжилтээр хэрэгжих төслүүдэд шаардагдах хүнд суртлын тоог цөөлөх дүрэм журмуудыг цуцална. Эрх болгон цахилгаан үйлдвэрлэгч болох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор илүүдэл цахилгаанаа төвийн шугам нийлүүлээд орлого олох бололцоог бол бид нар бүрдүүлнэ. Ингээд ногоон санхүүжилт хийх, ногоон зээл авах, ногоон

бодлогыг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн баялаг бүтээгч нарын хөрөнгө оруулагч нарын бүх төслүүдэд үүсээд байгаа хүнд суртлуудыг арилгана гэдгийг бас хэлье.

Тэгээд эрчим хүчний эх үүсвэрийг мэдээж дэвшилтэт болгох, төр, хувийн хэвшил хамтарч хийх нөхцөл бололцоогоор хангуулах ажлуудыг бид нар шат шатад нь дэмжинэ. Тэгээд мөн ногоон санхүүжилтийг илүү дэмжих чиглэлээр энэ 100 мянган нарны гэр энэ орон нутагт хийж хэрэгжүүлэхийг зорьж байгаа энэ цахилгаан тээврийн хэрэгслийн дэд бүтцийг дэмжих чиглэлийн одоо олон төслүүдийг дэмжих болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** Буяагийн Тулга.

**Б.Тулга:** Гишүүд та бүгдийн энэ өдрийн, энэ оройн амар амгаланг эрье ээ. Мөн бас өнөөдөр энэ олон улсын эмч нарын өдөр юм байна. Тэгээд Монгол Улсын бүх эмч, сувилагч, эрүүл мэндийн салбарын албан хаагчдад бас баярын мэнд хүргэе ээ. Учрал даргыг Ерөнхий сайдаар нэр дэвшиж орж ирж байгаад дэмжиж байгаа гэдгийг юуны өмнө илэрхийлье. За бид нар 2024 онд сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурал дээр Монгол Улсын хөгжлийн бодлогуудыг бол баталж хэрэгжүүлж явж байгаа. Энэний нэг бол одоо шинэ сэргэлтийн бодлого. Энэ дотроо боомтын сэргэлтийн бодлогыг бол баталж явуулж байгаа. Харамсалтай нь энэ боомтын сэргэлттэй холбоотой хэд хэдэн бас шийдвэрүүд энэ сая сүүлийн Засгийн газрын шийдвэр болж гарлаа. Энэ нь өмнө нь бас боомтыг хөгжүүлэх, боомтыг төлөвлөх, боомтуудыг одоо эмх цэгцтэй болгох Монгол Улсын гаднаас орж ирэх худалдааг дэмжих валютын урсгалыг нэмэгдүүлэхэд зориулж гаргасан энэ шийдвэрийг хүчингүй болгосон шийдвэрийг 2026 оны 51 дүгээр тогтоолоор Засгийн газар гаргасан. Энэ ямар учиртай тогтоол байсан бэ гэвэл 7 аймгийн газар нутаг дээр байгаа хөрш орнуудтай хиллэдэг хилийн боомтуудын ерөнхий төлөвлөлтийг хийх зориулалтаар газар олголтыг шийдсэн. Ийм Засгийн газрын хууль ёсны шийдвэрийг саяын 51 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

Ингээд бас тухайн үед ажиллаж байсан Засгийн газрын гишүүдтэй бол бас уулзаад энэ өмнө гаргасан шийдвэрээ та бүхэн маань яагаад бас хүчингүй болгочхов оо гэж асуухад бол тэр хуралдаанд орсон Засгийн газрын гишүүд бол энэ шийд хүчингүй болгосон шийдвэр гарахад бол байлцаагүй, танилцаагүй гэнэт оруулж шийдсэн асуудал аа гэж ингэж ярьж байгаа. Тэгэхлээр энэ улс төржилт энэ попролт энэ хэрээс хэтэрсэн байдал маань эргээд Монгол Улсын эдийн засгийн, тусгаар тогтнол, эдийн засгийн өсөлт хөгжилтөд хортой ийм шийдвэр болсон байна аа. Тийм учраас энэ нэр бүхий 10 боомт дээр нийтдээ 34 мянган га газар дээр ерөнхий төлөвлөлт 10 боомт дээр шүү одоо аймгуудыг нь хэлэх юм бол Завхан аймаг, Ховд аймаг, Говь-Алтай аймаг, Сүхбаатар аймаг, Өмнөговь аймаг, Дорнод аймаг, Дорноговь аймаг гээд ийм аймгууд дээрх энэ боомтын хөгжлийн энэ бодлогыг ухраасан ийм шийдвэрийг гаргасныг Учрал сайд та буцааж сэргээх үү?

Энэ маань бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Их Хурал дээр батлагдсан Монгол Улсын хөгжлийн бодлогод туссан ийм бодлого байгаа. Тэгээд энэ зарим бас хариуцлагагүй Засгийн газрын гишүүдийн хийсэн мэдэгдлээр иргэдэд бас маш буруу мэдээлэл хүргэж эдгээр боомт дээр төлөвлөлт хийх зориулалтаар төрийн өмчийн компанид олгосон газрыг хувийн хэвшилд зарж үрсэн мэтээр мэдээлэл хийсэн нь бол тун хариуцлагагүй үйлдэл байсан юмаа. Тийм учраас энэ шийдвэрийг та буцааж сэргээх үү? Энэ шийдвэрийг гаргахад та бас Хэрэг

эрхлэхийн сайдаар ажиллаж байсан бүх деталийг бол та маш сайн мэдэж байгаа. Тийм учраас энэ...

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Тулга сайд Боомтын үндэсний хорооны дарга байсан хамтарсан Засгийн газарт ажиллаж байсан. Тэгэхээр мэдээж энэ боомтын сэргэлтийн хүрээнд экспорт нэмэгдсэн. Боомт дээр үүсдэг асуудлууд бас нийгмээр шийдэгдсэн сайн ажлууд бол тухайн үед бас хийгдэж байсан. Тэгэхээр цаашдаа бол бид нар ерөнхий төлөвлөлтийн хүрээнд хийсэн ажлуудыг дэмжээд л урагшлуулах ёстой. Энэ ерөнхий төлөвлөлтийн хүрээнд хийгдсэн. Үүн дээр сүүлд намайг Тэргүүн шадар сайд болсны дараа энэ Гашуун сухайт Ганц мод дээр тэр нөгөө гааль дээр үүсээд байгаа хүнд суртлуудыг зохицуулах, экспорт дээр саад учруулаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр ажиллаж байхад бол нөгөө энэ чинь мэдээж нөгөө дэвшилтэт технологи нөгөө жолоочгүй тээвэр явах зам дээр жолоочтой машин явуулна гээд шийдвэр гаргачихсан байсныг нь бид нар буцааж цуцлаад энэ дээр зөвхөн жолоочгүй эсвэл биржээр тээврийг л дэмжинэ гэдэг ийм шийдвэр гаргуулж байсан. Ингэж биржийгээ дэмжих ийм бодлого гаргаж ажиллаж байсан.

Тэгэхээр энэ Тулга сайдын ярьж байгаа асуудлыг бол бас ажлаа аваад одоо бол энэ өнөөдрийн бүтцээр энэ Сангийн яаманд байх шиг байна. Тэгээд энэ дээр би бас судлаад тэгээд хариу арга хэмжээнүүдийг аваад өөрт чинь мэдээлье. Тэрнээс бас яг өнөөдөр ямар нөхцөл байдалтай байгааг мэдэхгүй байна. Би 4 сарын хугацаанд бас Их Хурлын даргаар ажилласан учраас яг энэ нөхцөл байдал дээр яг ямар байгааг бас сайн мэдэхгүй байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тулга гишүүн нэг минут.

**Б.Тулга:** Тэгэхлээр энэ боомт дээр өнөөдрийн байдлаар 70, 80 орчим хувийн хэвшлийн байгууллагууд бизнесийн үйл ажиллагаа эрхлээд явж байгаа. Боомт дээр үүссэн энэ асуудлуудыг эмхэлж цэгцлэх тал дээр бас та онцгой анхаарал хандуулж ажиллахыг Танаас хүсэж байна аа. Ер нь бол Монгол Улсын боомт дээр бизнес эрхлэх энэ бололцоог бизнес эрхлэгчдэдээ, иргэддээ, тухайн боомтын орон нутгийн иргэддээ гаргаж өгч бизнесийн эрх чөлөөг нь бий болгох энэ ажил дээр та бас манлайлал үзүүлж ажиллаарай гэж танаас хүсье ээ. За ингээд танд амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Чинбаатарын Анар.

**Ч.Анар:** Оройн мэнд ээ. Ерөнхий сайдад горилогч Учрал гишүүнээс асууя аа. Монгол Улс өнөөдөр яг бодит түлш эрчим хүчний асуудалтай тулгарч байна. Дэлхийн геополитикийн нөхцөл байдлаас үүдээд. Үүнтэйгээр адилхан бодит байдал дээр эрчим хүчний хомсдолд орчихсон. Үүнийг маш олон гишүүд дурдаж байна. Өнгөрсөн өвөл бид нар 1803 мвт-ын хэрэглээнд хүрч улс даяараа хязгаарлалтад орсон. Энэ өвөл органик өсөлтөөрөө том техникийн нөхцөл олгохгүйгээр 1950 мвт-ын эрчим хүчний хэрэглээ үүснэ гэж тооцож байгаа. Одоо бидэнд 1500 мвт, Оросоос 300 мвт-ыг авдаг. Энэ жил ашиглалтад орохоор ерөөсөө Сэргэлэнгийн Сэлэнгийн 35 мвт-ыг л ашиглалтад авах бололцоотой. Тэгэхээр 150 мвт-ын эрчим хүч дутагдах жишээ нь. Тэгэхээр энэ өвөл бол бид нар гурван 7 хоног төвийн бүсийн эрчим хүчний хязгаарлалтад орох бодит нөхцөл байдалдаа орчихсон байгаа. Үүнийг та өөрөө Их Хурлын дарга байхдаа идэвх санаачилгатай санаачилга гаргаад Их Хурлын 2025 оны 12 сарын 26-нд 119 дүгээр тогтоолыг баталсан. Тэгэхээр би одоо яг эндээс

асуух гэж байгаа юм нь яг энэ зуны зөвхөн энэ зуны хугацаанд бид хэрхэн яаж энэ 150 мвт-ын эрсдэлийг нөхөх вэ? Тэгэхгүй бол энэ Засгийн газрын үед төвийн бүс гурван 7 хоногоор тогтохгүй хязгаарлалтад орохоор бодит эрсдэл үүсчхээд байна аа.

2 дугаар асуулт нь болохоороо төрийн процессын дахин инженерчлэлийн тогтоолыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 7 сарын 8-ны өдөр 78 дугаар тогтоолоор баталсан. 5 сард Засгийн газар тайлагнах ёстой. Энд бол бид та өөрөө ч дурдаж байна. Цахимжилтын хувьд бол бид нар хангалттай сайн цахимжсан. Одоо хууль эрх зүйн сэтгэлгээний хувьд шинэчлэгдэх ёстой. Гэтэл Монгол Улсын 119 дүгээр тогтоолын хувьд ч тэр, 78 дугаар тогтоолын хувьд ч тэр бодит байдал дээрээ Их Хурлын тогтоолууд 30 хувьтай л хэрэгждэг. Тэгээд институцийн залгамж чанар байдаггүй. Уул нь таныг Эдийн засаг хөгжлийн яаман дээр очиход Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар яг энэ төрийн процессын дахин инженерчлэлийг нэвтрүүлээд явна гэж бодож байсан. Та Их Хурлын дарга болсон. Одоо ингээд Ерөнхий сайд болж байна. Тэгэхээр Монгол төрийн энэ тогтолцоо бол яг лидерээ дагаж явдаг институцээ дагаж явдаггүй. Тэгэхээр та энэ 2 гаргасан тогтоолыг өөрөө анхнаас нь суурийг нь тавьсан хүн хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдэг асуултыг асууж байна аа? Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Тийм Анар гишүүн бол үнэнийг л хэллээ л дээ тийм. Тэгэхээр энэ жил бол энэ өвөл маш том асуудал бэрхшээл бидний өмнө тулгарч байгаа юм. Сэлэнгийн 70 мвт ашиглалтад орно. Тэгээд бид энэ зуныг ашиглаж сэргээгдэх эрчим хүчний төслийг явуулах зайлшгүй шаардлагатай байгаа юм. Энэ сэргээгдэхийн төсөл дээр бол нөгөө барилга угсрах тэгээд л янз бүрийн зөвшилцөл гэхээсээ илүү энэ чинь технологи учраас илүү хурдан хугацааны шийдэл. Тэгээд маш богино хугацаанд энэ зун эхлүүлж энэ сэргээгдэхийн эрчим хүчний төслийг л явуулахаас өөр зан байдал одоо байхгүй гэж хэлмээр байна. Тэгээд энэ өвөл бол хэрвээ энэ асуудлыг зундаа анхаарч шийдэхгүй бол яг таны хэлж байгаа шиг юм болно оо энэ үнээн. Тэгээд ер нь бол цаашдаа бас үнэнээ яриад ингээд явахгүй бол өвөл болохоор гэнэт хүйтэн болдог юм шиг бодож болохгүй. Тийм учраас бол цаашдаа үнэнээ ярьдаг тэгээд тэр шийдлээ эрэлхийлдэг тэгээд хурдтай маневр хийж чаддаг ийм л Ерөнхий сайд байя л гэж би хичээж байгаа юм. Бүх зүйл сайн сайхан болчих гээд байгаа юм байхгүй. Тэгэхдээ эрчим хүчний энэ хараат байдал энэ нөхцөл байдалд дүгнэлт хийгээд энэ сэргээгдэхийг чинь сая тогтоол гаргаад яваад байсан нь үүнтэй л холбоотой гэдгийг бас хэлье.

Дахин инженерчлэл дээр төрийн үйлчилгээг либералчлах ёстой. Эрх зүйн үр дагаваргүй төрийн үйлчилгээнүүдийг хорооны байрнууд дээр аваачиж нэг дээвэр доорх олон нэг цэгийн үйлчилгээ олон цэгийн ийм болчихоод байна шүү дээ. Нэг дээвэр доорх олон цэгийн үйлчилгээ болчихоод байна шүү дээ. Тэгээд энийгээ больё оо. 1480 гаруй үйлчилгээг нэгтгэж болчихсон юм чинь төрийн үйлчилгээгээ либералчлаад төрийн дотоод процессын дахин инженерчлэлийг хийсэн саяын Анар гишүүний тэр дэд хороон дээр хийгдсэн ажил. Дээрээс нь Их Хурлын сүүлийн хууль дээр энэ байнгын инновац цахим бодлогын дэд хороог бас буцаад байнгын хороо болгоё гээд зарчим оруулсан шүү дээ. Onse only гээд зарчмаар ерөөсөө л энэ тайлан мэдээг нэг удаа гаргадаг болгоод л төр өөрт байгаа мэдээллээ иргэнээсээ нэхэхгүй болоод эхлэхээр энэ ре инженеринг гэдэг зүйл чинь амьдрал дээр биеллээ олно. Тэгэхээр дахин инженерчлэлийг төрийн үйлчилгээнд хийж эрсдэл багатайг

либералчилсан цагт төрийн албан дээр хэмнэлт өөрөө мэдрэгдэж эхэлнэ. Тэрнээс биш шууд ингэж тайрч хаях биш. Тэгэхээр энэний үндсэн дээр Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн ч тэр, ре инженеринг хийсний үндсэн дээр өөрөө оновчлох ажлууд нь амжилттай хийгдэнэ гэдгийг бас бид ойлгох ёстой. Тэгэхээр Анар гишүүний энэ Чингис хааны музей дотор хийсэн арга хэмжээн дээр бол яг энэ ре инженерийн асуудлыг маш бодитойгоор хөндсөн.

Тэгэхээр би энэ ажил дээр бол заавал нөгөө хууль гаргах тэрийг хүлээнэ гээд байхаасаа илүүтэйгээр гүйцэтгэх засаглал Засгийн газрынхаа түвшинд яаж шийдэж болох вэ гэдэг ажлуудаа хийгээд явна. Тэгээд хууль дээр тулаад ирвэл бол мэдээж шийдэх шаардлагатай бол Их Хуралд хандана. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 3 жил ажиллаж байгаа. Улс орон даяар хурдан үйлчилгээ гээд ажиллаад байгаа. Энэ төрийн хурдан үйлчилгээ гэдэг чинь дэлгүүр дотор нэг ширээ тавьчихсан оператор сууж байсан тэр эрхийг аль ч хувийн хэвшлийн салбарт өгөөд аутсорсинг хэлбэрээр цалин дээр нь хэдэн хувь нэмчихэд энэ улс орон даяар төрийн үйлчилгээ явуулж байна гэж ингэж бөөн хүнд суртал үүсгээд суугаад байх шаардлагатай юу, үгүй юу гэдэг дээр бэлтгэл ажлыг хангасан. Тэгэхээр энэ ажлыг бол амилуулна. Одоо 540 хурдан цэг ажиллаж байгаа. Энэ бол цаашаа хэд ч болох бололцоотой.

**Ж.Бат-Эрдэнэ:** Анар гишүүн.

**Ч.Анар:** Таны хариултыг сонслоо. Тэгэхээр шийдвэртэй арга хэмжээ авах юм байна гэж найдаж байна. Таны дараагийн ажилд амжилт хүсэхдээ би 3 зүйл хүсэж байна.

1 дүгээрт Монгол Улсын Их Хурлын гаргаж байгаа хууль хэрэгжилт маш бага, тогтоолын хэрэгжилт бүүр бага. Тэгэхээр хуулийг хэрэгжүүлэх дээр Засгийн газар болон мөн Их Хурал анхаарах дээр цаашдаа анхаарах шаардлагатай байна. Та үүнд анхаарч ажиллаарай гэж хүсье.

2 дугаарт төрийн тогтвортой байдал тогтворгүй байна. Тогтвортой байдал гэж алга байна. Тэгэхээр нөгөө сайд дагасан бодлогууд хэрэгжүүлэхгүй яг залгамж халаатай бодлогууд хэрэгжиж яваасай гэж хүсэж байна. Их Хурал тогтоол гаргаад Засгийн газар нэг ажил санаачлаад хийгээд түрүүн Тулга сайд ч дуугарч байна. Нэг юм гарч ирээд дараагийнх нь үгүйсгээд явдаг байхгүй байхыг танаас хүсье ээ.

3 дугаарт нь та залуу хүн байна тэгэхээр энэ олон...

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ Пүрэвжавын Сайнзориг.

**П.Сайнзориг:** Учрал даргыг дэмжиж байна аа. Тэгээд хурал бага хийгээрэй, хүрз бариад л ажилдаа орёе. Хүрз бариад ажил хийж байгаа хүмүүсийг хамгаалаарай. Ийм л зүйлийг бас танаас хичээнгүйлэн хүсье. Улс орноо хөгжүүлэх урагшлуулах мөрөөдөлтэй Ерөнхий сайд байсан гээд та хожим нь битгий яриарай. Би мөрөөдлөө биелүүлж чадсан ийм шийдэмгий Ерөнхий сайд байсан юм гээд хожим нь сайхан дурсамжаа үлдээгээрэй. Тийм учраас таныг хэрхэн яаж шуурхай, зоригтой, шийдэмгий кабинетаа байгуулахаас л шалтгаална. Танд ингээд зангуу шиг хэдэн хүмүүс зүүгдэх байх аа мэдэгдээд л байна. Тэгээд энэ таны одоо энэ завь чинь яг гараанаасаа гарах уу үгүй юу эндээс л шалтгаалах байх. Энийг та бас тэгээд бодно биз дээ гэдэг би зүйлийг хэлмээр байна.

Тэгээд ер нь Монгол Улсын хөгжлийн гол дайсан энэ попролт болчихлоо. Бүх зүйлүүдийг энэ 76 татаж авч шийддэгийн гай нь Улаанбаатар хот өөрөө байхгүй юу. Төсвийг нь хураагаад авчихдаг, 330 сумд тарааж өгдөг. Тэгээд өнөөдөр энэ боломжийг нь хууль эрх зүйн орчноор бүрдүүлээд мөрийн хөтөлбөр дээр туссан зүйлүүдийг хэрэгжүүлж байгаа гээд нийслэл рүүгээ энд авчирч Улсын Их Хурлын гишүүд нь асуудлыг нь татаж ярьж байгаа юм. Энэ төрийн институт чинь энэ чиг үүргийн хуваарилалт гэж юм байх юм уу, байхгүй юм уу. Эсвэл энд нэг ухаантай мэргэн 126 хүн суучхаад олонхын эрх ашгийг ерөөсөө сонсдоггүй, цөөн хүний эсэргүүцэл болгоомжлолыг ингээд дэвэргэж ярьдаг. Энд асуудал шийдэхгүй шүү. Тэгээд ийм байх юм бол Монгол Улс эрх мэдлийн төвлөрөл эндээ бид нар живнэ. Энэ 126 хүн чинь ерөөсөө асуудлыг шийдэж байгаа юм байхгүй.

Тийм ч учраас уг нь эрх мэдлийг задлаад энийгээ дагаад төсвийг нь өгөөд мөнгөө босгоод энэ бүтээн байгуулалтаа хийе гэж өгсөн юм. Энэний араас өмнө Өмнөговь явж байгаа юм. Бондоо босгоод эрчим хүчний станцаа барих гээд. Одоо бид хэд бүгд энийг нь татаж унагая гэж байна шүү дээ. Энд л бүхнийг шийднэ гэж байна шүү дээ. Энд уг нь үндсэн хуулийн байгууламжаа яах вэ, яаж татварын бодлогоо яах вэ гээд ярьж байх болохоос биш зам гүүр ярих болох уг нь яримааргүй байгаа байхгүй юу. Тэгээд ийм л эмгэнэлтэй байдал руу бид орсон байна аа. Баячуудын хөрөнгийг хураая. Гоё сонсогдож байгаа биз. Энд ерөөсөө ийм попролт хэтэрлээ. Тэгэхдээ ийм юм байхгүй шүү дээ. Олон хүмүүс баян болоосой гэж бид нар бодлого гаргах ёстой шүү дээ. Тэгээд энэ бодлого руугаа бас Засгийн газар маань бас анхаараач ээ. Тэгээд би 4 зүйлийг л асуумаар байна.

1 дүгээрт энэ хууль тогтоомжийн агентлагийг та байгуулаач ээ, яг таны дэргэд. Энэ сайд нарын чинь яг хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж нь ямархуу дүгнэлттэй байна энэ нь яг хүний эрхийг хангаж байна уу, хэмнэлт бүтээмж байна уу гэдгийг дүгнэж байж та шаардлагуудаа тавина аа. Энэ бусад улс орнуудад Ерөнхийлөгч юм уу, Ерөнхий сайдынх нь дэргэдээ байдаг засаглалаасаа хамаараад. Ингэж байж энэ сайд нартаа шаардлага тавина аа. Энийг та бас юу гэж бодож байгаа вэ? 1 дүгээр зүйл байна.

2 дугаарт энэ нэг Эрдэнэт гэдэг ганцхан компаниас 20 хувийн АМНАТ л авч байна л даа. Ядаж энэ АМНАТ-ын бодлогыг нэг 15 болгоод 3 Эрдэнэттэй болгож болохгүй юу?

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Тийм. Би Сайнзориг гишүүнтэй санал нэг. Хөрөнгө оруулагч нар, баялаг бүтээгч нар хөдөлмөрлөө, хийе бүтээе гэсэн хэн бүрийг дэмжихийн төлөө ажиллана аа. Тэгэхээр манай Засгийн газар бүтээлч хүн бүрийг дэмжинэ. Ер нь одоо хөдөлж байвал хүн амьдарч болдог л нийгмийг бүтээмээр байна шүү дээ. Тийм ч учраас үүнд нь саад тотгор болоод байгаа тэр хүнд суртал, дүрэм журам, гох дэгээнээс чөлөөлөх бодлого бол энэ миний яриад байгаа эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлт. Тийм ч учраас одоо бол үнэнээ ярьдаг, нөхцөл байдлаа зөв оношилж чаддаг ийм л зорилго руу чиглэнэ. Тэгээд ялангуяа хувийн хэвшлийнхэн одоо бас биднийг харж байгаа байх. Нөү сюрпрайз гэж буюу энэ гэнэтийн сюрприз барихаа больё оо. Энэ хувийн хэвшилдээ, бизнес эрхлэгч нартаа, баялаг бүтээгч нартаа нэг шөнө унтаж сэрээд маргааш нэг юм сэтгэдэг тооцоогүй судалгаагүй.

Ерөөсөө энэ эдийн засгийн эрх чөлөөний хууль дээр бичсэн нэг заалт бол хэрвээ тухайн асуудал дээр төр оролцох гэж байвал, шийдвэр гаргах гэж байвал заавал эрх ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа тэр бүлгийн төлөөллийг оруулдаг. Тэгээд багадаа 5 сарын өмнө тухайн шийдвэрээ мэдээлдэг тэгээд тэр нийгмийн зөвшилцлийг бий болгодог олон нийтийн оролцоо хүсэл зорилгыг нь сонсож байж шийдвэр гаргадаг байхгүй бол Монголд хөрөнгө оруулдаг, Монголд баялаг бүтээдэг ингээд бизнес хийж байхад гэнэт нэг нөхөр гарч ирээд маргааш нь ямар шийдвэр гаргах юм билээ гэдгээс айдаг эмзэглэдэг ийм л юм руу явчхаж байгаа юм. Тийм ч учраас бол би цаашдаа энэ Засгийн газраас илүү хувийн хэвшлээ хамгаалах, баялаг бүтээгч нараа хамгаалах тал руу руу чиглэх ёстой.

Дээрээс нь улсын төсөв дээр ч гэсэн тэр нэг сум болгоны хооронд явж байгаа замын хөрөнгө оруулалтын төсөв мөнгийг тавиад байдгаа больё оо. Тийм ч учраас тэр АМНАТ-ийг орон нутагт нь хуваарилъя. Тэр орон нутгийн хөгжлийн сан дээр байгаа 10 хувийг нэг 20 хувь болгоё. Тэгээд тэр нь тэр нөлөөллийн бүсэд нь хуваарилагддаг түүгээрээ тэр сум дундын хоорондын замынхаа хөрөнгө оруулалтыг шийддэг болохгүй бол энэ улсын төсөв дээр сум болгоны хооронд зам барья гээд шийдээд суух бол утгагүй байна аа. Тэгээд тэр орон нутаг нь өөрөө шийддэг. Түүндээ хувийн хэвшил нь оролцуулдаг зам дээр би ийм л байр суурьтай байгаа. Тэр мөнгө төлөөд явдаг тэр тоололт дээр төлөөд явдаг замыг ч гэсэн түншлэлээр хувийн хэвшлээр нь явуулах дээр бид нар дэмжих ёстой шүү дээ. Тийм байр суурьтай байна.

Тэгээд түрүүн бас асуусан. Хууль тогтоомжийн агентлагийг би бол бас дэмждэг. Сая Их Хурал дээр байхдаа ч тэр энэ хиймэл оюуны шинжилгээнүүдийг хийлгээд Их Хуралд өргөн барьж байгаа хуулиудыг дүн шинжилгээ хийдэг. Энэ үнэхээр Үндсэн хуулийн зөрчилтэй байна уу? Ямар хуулиудтай давхардал, хийдэл байна түүнийг нь зөрчдөг тэр хуулиуд Их Хурлын босгыг давдаггүй өргөн барихад түүн дээр нь дүгнэлт гаргадаг. Түүн шиг Их Хуралд орж ирж байгаа хуулиуд Засгийн газраас өөрөө цэгцтэй дүн шинжилгээ хийгдсэн хуулиуд байх ёстой. Үүн дээр нь нэлээд одоо бас боловсруулах түвшинд нь хууль тогтоомжийн агентлагийг түвшинд ажиллуулах энэ механизмыг бүрдүүлэх болно гэдгийг бас хэлье ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Учрал даргад бас хариулт бас сүүлийн тэр хууль тогтоомжийн агентлаг дээрээ бас дэмжиж байгаад баярлалаа. Би нэг энэ бүс хөгжлийн асуудлыг нэг эдийн засгийн агуулгаар нэг харах боломжийг бас танд санал болгох гээд байгаа юм. Энэ уул уурхайн компаниудыг нэг аймаг бас дангаараа хувьцааг нь эзэмшиж өмчлөх асуудал туйлын буруу байгаа юмаа. Тийм учраас тухайн уурхай байгаа нөлөөллийн бүсийн аймгууд эндээс татварын орлогыг бас хуваалцдаг тодорхой хэмжээнд. Мэдээж уурхай голлон яваа аймаг нь түлхүү авна. Дээрээс нь энэ орон нутгийн өмчит тэр компаниудын хувьцааг яг нөлөөллийн бүсийн 3, 4 аймаг нь хамтдаа эзэмшдэг байдлаар ингэж жоохон асуудлаа урагшлуулмаар байна аа. Ингэж байж энэ бүсчилсэн хөгжлийн чинь асуудал эдийн засгийн агуулгаар баяжих юмаа. Энэ дээр бас та нэг дэмжиж бас байр сууриа дэмжих үү, үгүй юу байр сууриа хэлээч?

2 дугаарт энэ шатахууны асуудал хүнд байгаа учраас уул уурхай, ХАА-н салбар дээр цахилгаан машин юу гэдэг юм энэ чиглэлийн техник тоног төхөөрөмжийг оруулж ирэх асуудлыг 5 жилийн удаа нэг чөлөөлөөд өгчхөөч. Та энэ

дээр ямар байр суурьтай байгаа вэ. Ингээд нэг бас нэг тал талын хувилбаруудыг бас оролдоод үзвэл яасан юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Тэгээд би бүрэн дэмжиж байна. Сумын зам төсөв санхүүжүүлэхгүй тэгээд төсвийн реформ яг эндээс эхлэх ёстой гээд би түрүүн хэлсэн. Тэр хуульд өөрчлөлт оруулах буюу тэр АМНАТ-ыг нөлөөллийн бүсэд нь хуваарилах энэ зарчмыг би дэмжиж байна. Одоо бол Засгийн газраас бас хуулийг нь өргөн барьчхаад байгаа гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд тэр хуультай нь танилцана. Тэгээд шаардлагатай бол дахиад өргөн мэдүүлнэ. Ер нь бол орон нутаг руу илүү их эрх мэдлийг шилжүүлэх тэр бодлогыг бол бас дэмжиж байна. Цахилгаан машины асуудал угаасаа энэ шинэ Засгийн газрын баримтлах бодлого бол ногоон хөгжлийн чөлөөлөлт. Тэр цахилгаан машин цэнэглэх станцууд цогцолборуудыг байгуулахыг бүрэн дэмжинэ. Ерөөсөө л энэ ногоон хөгжлийн чөлөөлөлт бол Засгийн газрын тэргүүлэх бодлого байна. Тэр Сайнзориг гишүүний саналуудыг дэмжиж байна аа. Ажил хэрэг болгоно.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Би нөгөө хэрэглээний талбайг бас дэмжиж байгаа явж байгааг ойлгож байгаа. Ер нь ХАА болоод яг уул уурхайн салбар дээр ч гэсэн энэ цахилгаан том том экскаватор янз бүрийн юм хэрэглэдэг болчихсон юм байна. Яах вэ зүгээр цаг уурын нөхцөл байдал бас хүнд. Энийг бид нар бас тодорхой хэмжээнд хөрөнгө оруулалтаа хийж байгаа ААН байгууллагуудыг ААН болон гааль, татвар, НӨАТ-ын орлогоос нэг тодорхой хугацаанд дэмжээд энийгээ дагасан эрчим хүчний станцууд ч гэсэн хэрэглэгчтэй болох байхгүй юу. Тэгэхээр энэ бодлогыг нэг хэдүүлээ бас нэгэнт одоо ийм тулаад ирсэн асуудал байгаа бол бас нэг ярилцаж үзээд бас шийдээч ээ гэж хүсэж байгаа юм. Тэгээд дараагийн хүндээ асуудал өвлүүлсэн биш, энэ боломжийг найдварыг, итгэлийг дамжуулж өгсөн Ерөнхий сайд байхыг танд хүсье. Амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мэндбаярын Мандхай.

**М.Мандхай:** Шинэ Ерөнхий сайд Учрал даргыг дэмжинэ. Тэгээд 1 асуудлыг өөрөөс нь бас боломж гарсан дээр нь ам авахыг хүсэж байна аа. Та 2022 онд нийгмийн даатгалын реформыг ярьж ирсэн. Ялангуяа энэ тэтгэврийн зөрүү байгаа. Энэ даатгалын төлөгчийн ачаалал энэ сангийн алдагдлын асуудлыг ингээд ер нь ингэж шинэчилж реформ хийх ёстой гэдэг ийм байр суурийг илэрхийлж ирсэн. Тийм учраас ч сая Улсын Их Хурлын дарга байхдаа даатгалын тогтолцооны энэ шинэтгэлийг хийх ажлын хэсгийг байгуулсан байгаа. Тэгэхлээр та Ерөнхий сайд болоод Засгийн газрыг ингээд тэргүүлж удирдаж явах хүний хувьд энэ даатгалын энэ шинэчлэлийг хэрэгжүүлэхэд Засгийн газар Улсын Их Хуралтай хэрхэн уялдаатай ажиллана гэж харж байгаа вэ гэдэг дээр бас хариулт хүсэж байна. Мөн энэ даатгалын тогтолцооны шинэчлэлд мэдээж улс төрийн амаргүй бас ийм эрсдэл дарамтууд сэрэх нь тодорхой. Энэ дээр бас Засгийн газар шийдвэр зоригтой гаргаад явж чадах уу гэдэг асуултыг асууя.

Хоёрдугаарт Татварын багц хуультай холбоотой нэг ноцтой энэ заалт байгаа ХХОАТ дээр хувиараа бизнес хийгээд амьжиргаагаа залгуулаад явж байсан иргэд орлогоосоо татвараа нэг хувиар тайлагнаж төлж ирсэн. Одоо энэ шинэ төслөөр

эдгээр бизнес эрхлэгчдийг 400 сая төгрөгийн орлого олонгуут 10 хувийн татвар авах гээд өөрчлөлт орж ирж байгаа. Энэ 400 сая төгрөгийн энэ орлогыг та одоо энэ татвар бүтэн төлөх боломжтой хангалттай орлого бүрдүүлсэн гэж бодож байна уу? Өнөөдөр 8 нэрийн барааны бараа ажиллуулдаг бизнес эрхлэгч өдрийн орлого нь цөөхөн хэдхэн бараа борлуулахад 2 сая төгрөгийн борлуулалт хийж чадаж байгаа. Яагаад гэхлээр юмны үнэ өсчихсөн инфляц нэмэгдсэн байгаа учраас. Тэгэхлээр энэ 400 сая төгрөгийг үлхэн төлчихнө. Тэгэхээр энэ 8 нэрийн бараа ажиллуулж байгаа орлогоо залгуулж явж байгаа бизнес эрхлэгч бол одоо ингээд 10 хувийн татвар төлж эхэлнэ ээ.

Хоёрдугаарт НӨАТ-тай холбоотой асуудал байгаа. Ялангуяа стратегийн хүнс буюу манай гол идэж байгаа сүү хүнс гэсэн энэ мах махан бүтээгдэхүүнийг худалдан авч үйлдвэрлээд борлуулахад чөлөөлдөг байсан энэ НӨАТ-ын хуулийн шинэчлэлээр бол төлдөг болж ирэх нь ээ. Тэгэхлээр энэ нөгөө иргэний сүү мах худалдан авч байгаа энэ үнийн дарамт яг энэ хэмээр хувиар өсөх нь. Тэгэхээр одоо махны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд шүүмжилж ирж байна. Тэгэхээр нөөцийн маханд бид өглөөний 7, 8 цагаас очерлоод өдөртөө авч чадахгүй ийм хомсдол үүсчихсэн. Үнэ...

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Тэгээд тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулж тухайн үед ажиллаж хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг өргөн мэдүүлж байсан. Сая Засгийн газраас энэ хувийн тэтгэврийн сангийн хуулийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тэгээд энэ хуулийг Их Хурал ажлын хэсэг гаргаад ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгээд Мандхай гишүүнээр энэ даатгалын эрх зүйн шинэчлэлийг хийх ажлын хэсгийг ахлуулсан. Тэгэхээр та одоо энэ хувийн нэмэлт тэтгэврийн хууль дээр ажиллаж энэ тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн үр дүнг гаргаж ажиллаасай гэж би хүсэж байгаа. Ингэж байж санхүүгийн сектор 2 баганатай ийм 2 тулгууртай бол болно. Энэ хувийн тэтгэврийн сангийн хуулийг баталснаар бас хөрөнгийн захыг дэмжих санхүүгийн салбарыг идэвхжүүлэхэд их том тус дөхөм үзүүлнэ ээ гэж бас ойлгож байгаа.

Тийм учраас энэ хуулийг Засгийн газар татаж авахгүй энэ хуулиа хэлэлцүүлээд явах ийм байр суурьтай байгаа. Татварын хуулийг би түрүүн хэлсэн. Татварын хуулийг төсвийн реформтой хамт хийх ёстой учраас энэ удаагийн өргөн баригдсан татварын хуулийг бол татаж авах нь зүйтэй юмаа гэж би үзэж байгаа учраас таны саяын хэлсэн саналуудыг нэгтгээд дахиад оруулж ирэх нь зүйтэй. 5 сарын 1-ээс өмнө төсвийн хүрээ барина.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Тодруулчихъя тиймээ. Баярлалаа. Бас даатгалын энэ шинэтгэлийг хийх цаг болсон. Олон тулгуурт энэ тогтолцоог бий болгох цаг хугацаа ирсэн гэж харж байгаа. Тэгээд бас Засгийн газрын тэргүүний хувьд бас дэмжиж ажиллана гэдгийг сонсоход таатай байна. Тэгэхээр татварын энэ багц хуулийг эргэж төсөвтэй уялдуулж татаж авч байгаа нь бас маш сайшаалтай байна аа. Энэ татварын багц хуульд хэд хэдэн бас ноцтой энэ заалтууд байгаа. Түрүүний миний хэлсэнчлэн ХХОАТ буюу амьжиргаагаа залгуулаад явж байгаа хувиараа бизнес эрхлээд бичил болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд таатай бус ийм заалтууд орж ирсэн байгаа шүү 1-д.

Хоёрдугаарт НӨАТ-тай холбоотой энэ стратегийн хүнс буюу мах сүүн дээр одоо үйлдвэрлэснийх нь төлөө үнээс чөлөөлдөг байсан эргүүлээд НӨАТ тооцдог болж ирж байгаа нь эцсийн хэрэглэгч буюу Монгол Улсын иргэнд энэ нь өөрөө үнийн дарамт болж орж ирэх учраас энэ дээр бас та анхааралтай...

**Ж.Бат-Эрдэнэ:** Баатаржавын Мөнхсоёл.

**Б.Мөнхсоёл:** Оройн мэнд хүргэе. Тэгээд 3 дахь удаагаа энэ Ерөнхий сайдын асуудал орж ирж байна. 2 товч асуултыг асууя гэж бодож байна. Улсын Их Хурлын дарга байхдаа чөлөөлье гэдэг аяныхаа хүрээнд эдийн засгийн эрх чөлөөний асуудлыг хөндсөн. Өөрөөр хэлэх юм бол хууль гаргах гэж ажиллаж байгаа нийт одоо Монгол Улсын хэмжээнд 933 хууль эрх зүйн акт үйлчилж байгаагийн 358 орчимд нь энэ бизнесийн эрх чөлөөг, эдийн засгийн эрх чөлөөг хөндсөн ийм заалтууд байна. Тэрийг одоо хиймэл оюун ухаан ашиглаж байгаад давхардлыг эсвэл орхигдсон зүйлүүдийг цэгцэлнэ гэж байгаа. Энийг би хувь гишүүний хувьд дэмжээд зорилтот бүлгүүдэд бас эдийн засгийн эрх чөлөө гэж юу юм, юуг шийдэхийг зорьж байгаа юм гэдгийг ажлын хэсэгт орсон гишүүний хувьд бас ажиллаж байгаа юмаа.

Тэгэхээр энэ тал дээр гол үргэлжлүүлээд хийх ажил богино хугацаанд юу байх бол оо. Яг уулзалт, хэлэлцүүлэгт орж байгаа бизнесийнхэн бол тодорхой яг өөрчлөлт авчраасай гэсэн ийм хүсэлт байгаа. Хамгийн наад зах нь сая Мандхай гишүүний хөндсөн Татварын багц хууль болон бусад нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сан гэдэг асуудлууд яригдаж байгаа.

Хоёрдугаарт нь эрх чөлөө гэдгийн нөгөө тал нь бас үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал байна аа. Ингээд бид нар бүгдээрээ харж байгаа. Энэ намын дотоод асуудал ч байна уу, улс төрийн энэ асуудлуудаас болоод иргэд маш их талцаж байна, хуваагдаж байна. Тэгэхээр үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдэлсэн гишүүдийг зоригтойгоор шударгаар, ёс суртахуунтайгаар үзэл бодлоо илэрхийлснийх нь дараагаас эхлээд ямар нэгэн байдлаар ялангуяа социал медиа дээр бүүлийдэх гэж ярьдаг шүү дээ. Ийм гүтгэх, доромжлох янз бүрээр одоо юу гэх юм сөрөг байдалд оруулах ийм үзэгдэл газар авчихлаа. Энэ тал дээр өөрөө ямар дорвитой ажил хийх вэ?

Хамгийн сүүлд нь базаад асуухад ер нь богино хугацаанд ямар үр дүнд хэрхэн яаж хүрнэ гэж бодож байгаа талаараа товч хэлээч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн.

**Н.Учрал:** Би Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан хийх Монгол хүнд заяасан энэ үндсэн эрх эрх чөлөөг хангуулахын төлөө байдаг ийм үзэл санаатай хүн. Тэгээд манай гишүүд ч хэлээд байх шиг байна. Энэ ардчилсан нийгэмд төрж өссөн сурч боловсорсон хүн гэж тийм. Тэгэхээр бидний үеийнхэн бол үзэл санааны хувьд ийм эрх чөлөөний төлөө үзэл санаатай. Тэгэхээр тэр нийгэмд хэн нэгнийг эрүүлээр шүүмжлэх тэр үгээ хэлэхийг би үргэлж хүндэтгэдэг. Гэхдээ өмнө нь бол бас энэ цахим орчинд хүүхдэд ийм сөрөг мэдээ мэдээлэл тараах асуудал дээр бол бид бас анхаарах ёстой гэдэг дээр би байр

сууриа илэрхийлж байсан. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах хуулийг хүртэл тухайн үед бас боловсруулж батлуулж явсныг та мэднэ.

Тэгэхээр ер нь бол нийгэм тэр чигтээ зөвхөн хуулиар зохицуулахаас илүүтэйгээр соён гэгээрлийн ажлуудыг их сайн хийх, ёс зүй, сахилга хариуцлагын үндэсний хэмжээний зөв мэдээ мэдээллийг түгээх ажлуудыг бол хийх цаг ирсэн байна аа л гэж би дүгнэдэг. Тэрнээс хууль гаргаснаараа юмыг аливаа зүйлийг хориглосноороо, хааснаараа асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй. Тийм ч учраас Засгийн газрын зүгээс нийгэм олон нийтэд соён гэгээрүүлэх, зөв мэдээ, мэдээллийг түгээх, нэг өглөө сэрж янз бүрийн сюрприз барих элдэв янзын шүгэл үлээхээс аль болох зайлсхийх. Илүү шинжлэх ухаанч тооцоололтой, үнэнийг ярьдаг Ерөнхий сайд байхыг л хичээж ажиллана л гэдгийг хэлье ээ.

Тэгээд Эдийн засгийн эрх чөлөөний хууль дээр та бас дэмжиж ажиллаж байсан. Тэгээд цаашдаа энэ бол нэг аль нэгэн улс төрийн нам эвслийн асуудал биш. Энэ бол бидний хамт энэ хуулийг дагалдуулан гаргах олон хуулиудыг хийж чадвал Үндсэн хуульд бидэнд олдсон тэр бизнес эрхлэх, хувийн өмчтэй байх, тэр баялаг бүтээх тэр эрх, эрх чөлөөг хангуулахад саад тотгор учруулаад байгаа тэр зүйлээс нь чөлөөлж чадвал тэр Үндсэн хууль чинь өөрөө бидэнд аз жаргалаа бүтээх эрх чөлөөг олгосон хууль байхгүй юу. Тэр гол нь тэр аз жаргалаа бүтээх эрх чөлөөнд хэн нэгэн бүдүүлгээр халдаад байвал түүнд иргэд бухимдалтай байдаг.

Тийм учраас бол энэ эрх чөлөөг хангуулахын төлөө байж л чадвал цаашдаа хэн бүр амар амгалан амьдралаа цогцлоон бүтээх боломж бидэнд байгаа. Тийм учраас Засгийн газар бол сюрпризээс хол тэгээд аль болох хувийн хэвшилтэй бизнестэй иргэддээ гай биш зай болсон ийм л бодол үзэл байдал дээрээ илүү үнэнч байх нь зөв болов уу л гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Манай хамгийн сүүлд үг хэлдэг Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Ингээд нөгөө итгэл найдвар хамгийн сүүлд бөхдөг билүү? Та ч одоо ингээд сүүлчийн л найдвар болчихоод байна л даа. Тэгээд МАН-ыг би ард түмэнтэйгээ хамт байгаасай л гэж бодож байгаа юм. Тэгээд сонголт бол дандаа байдаг. Үг хэлэх бол нэг өөр, сайхан сайхан ярьж болно оо. Тэгээд юмыг тэгээд үйлдлээр нь харна л даа. Тэгээд маргааш та нөгөөдөр ямар Засгийн газрын бүрэлдэхүүн оруулж ирэх юм. Тэрнээс чинь ингээд хүмүүс хараад л уншаад л явчихна л даа. Тэгээд барьцаалагдсан Засгийн газар байж болохгүй ээ. Та өмнөх Засгийн газрууд энэ чинь юу вэ 3 дахь Засаг нь уу, хэд дэх засаг нь юм. Яагаад огцров. Энэ дээр одоо та ямар сургамж авч байна вэ? Оюун-Эрдэнийн Засгийн газар огцорлоо. Тэр бол яагаад ч огцрохооргүй Засгийн газрыг төлөвлөж бодож хийсэн байсан огцорсон. Дараа нь Занданшатарын Засгийн газар огцорлоо. Бодвол авлига хулгайтайгаа зоригтой тэмцэл хийж чадахгүй байж байгаад л огцрох шиг боллоо. Одоо манай нам энэ одоо намууд таныг үнэхээр гарцаагүй тийм барьцаалагдсан байдалд оруулах ийм сонголт руу түлхээд байна уу ямар байна? Энийг та юу гэж бодож байна?

Одоо бид нар 2 хөрштэй. Тэгээд гаднын хөрөнгө оруулагчдынхаа өмнө байнга худлаа ярьдаг. Одоо итгэхээ байчихсан. Тэгээд ингэж байна л даа. 4 сарын 1-ээс манайд онцгойлон гэрээ хийж байгаа энэ тэр гэж. Одоо маш хүнд байдал угтаж магадгүй, юу ч болж мэднэ. Тэр дайнтай улс оронд яаж тэр амлалтад нь итгэх юм

бэ? Тийм юманд итгэж байвал инээдтэй шүү дээ, тэнэг л байна гэсэн үг. Энэ Харбины гэрээ гээд нэг юм байгаа. Энэ сонсгол нь явах уу, явахгүй юу? Ард түмэн мэдэх эрхтэй юм уу, үгүй юм уу? Энэ одоо 100, 200 сая долларыг машинаар ачаад тараасан гэж байна. Хамгийн мэдээлэлтэй байсан Ерөнхий сайд энийг зурагтаар ярьсан. Гадна дотно байгаа банкны эзэд тэгсэн ингэсэн гээд хэлж байна лээ. Энийг та юу гэж бодож байна вэ? Энэ ийм юм байгаа юм уу, үгүй юм уу? Энийг та хариулаач ээ. Ийм их мөнгийг ингэж авч байгаа нь харамсалтай байна аа.

Төмөр зам аягүй чухал аа. Энэ төмөр замыг хурдан тавиасай гэж хүсэж байна. Энэ хил холболтоо хийгээсэй. Тэгээд УБТЗ-аа 50 хувийг нь буцаагаад ав аа гэж байсан. Санал болгож байсан.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын тогтвортой үйл ажиллагааг хангах гээд үе үеийн Засгийн газар л хичээдэг. Гэхдээ мэдээж одоо бидний хамгийн том асуудал бол ирж байгаа том сорилтууд. Тийм ч учраас өнгөрсөн хугацаанд би Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга, Цахим хөгжлийн сайд, кабинетын зарчмаар л ажиллаж ирсэн. Занданшатар даргын үед Эдийн засаг хөгжлийн сайдаар ажиллалаа. Тэгэхээр энэ бол Монгол төрийн ажил бол залгамж чанараа хадгалах ёстой. Тэгээд тухайн үеийн Засгийн газрын алдаа нь ч миний багш амжилт нь ч миний багш. Тэгэхээр цаашдаа бол би бас тухайн засгийн газруудад кабинетад байсны хувьд ер нь эргээд харахад юун дээр алдав, юун дээр онов гэдгийг бол бас дүгнэж цаашдаа бол бас үйл ажиллагаандаа амжилт ололтыг нь ахиулж, алдаа оноог нь бол эргэж харж засаж залруулж ажиллах ийм л үүрэгтэй л гэж үзэж байгаа юм.

Тэгээд парламентын засаглалтай оронд намын дарга нь эрх барьж байгаа намын дарга нь гүйцэтгэх засаглалаа тэргүүлээд явах нь захиргааны эрх мэдэл, улс төрийн эрх мэдэл хамтдаа байж байж үр дүнд хүрдэг ээ гэдэг ийм л шаардлагаар манай намын гишүүд ч тийм санал хэлдэг л байсан. Сая бол мэдээж сөрөг хүчний зүгээс бас ийм шаардлагыг бол тавьсан учраас дотоод улс төрийн шийдвэр гаргаад л үйл ажиллагаа нь Засгийн газрын тэргүүн өөрийнхөө хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөөд тэгээд ийм ачаа үүрэх л хариуцлага над дээр оногдсон. Тэгэхээр би бол энэ хариуцлагаас намын даргын хувьд бол энийг даагаад, ачааг үүрээд ард түмнийхээ төлөө, иргэдийнхээ энэ дунд үүсэж байгаа асуудал бэрхшээлүүдийг шийдэхийн төлөө ажиллах ийм үүрэгтэй гэдгээ бол ухамсарлаж байгаа юм. Тэгэхээр манай Засгийн газар бол илүү хурдтай ажиллах шаардлага үүсэж байна.

Дээрээс нь биднээс хамаарахгүйгээр зөвхөн энэ чинь дотоод асуудал биш олон улсын байдал, дэлхийн дайн, энэ үүсэж байгаа энэ газрын тосны бүтээгдэхүүний үнэ гээд энэ олон асуудлууд сорилтуудтай тулгарч байна. Тэгэхээр дотоодын асуудал жишээлбэл энэ олон улсын асуудал болсон гэдгийг бас ойлгох ёстой байх гэж бодож байгаа. Тэгээд цаашдаа бол бас та бүхэнтэйгээ эргэх холбоотой, энгийн даруу хариуцлагатай ажиллая л гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дашдондогийн Ганбат гишүүн лавлая.

**Д.Ганбат:** Ерөнхий сайд маань жоохон тодорхой хариулаасай гэж хүсэж байна аа. Энэ байдал бол нэлээн хүнд ээ. Та ингээд дараа дараагийн сонголтоо хийгээд явна аа. Харамсалтай нь энэ бүх салбарууд маш хүнд байдалд байна аа.

Бид нар энд одоо болж байгаа юм шиг ингээд ярьдаг боловч яг одоо 21 дүгээр зууны өнөөгийн энэ байдлаас ингээд харахад, бусад орнуудтай харьцуулахад үнэхээр бид нар бас хэцүү болчихоод байна аа. Тэгэхээр бид нар мэдэх эрхийнхээ хүрээнд энэ нүүрстэй холбоотой энэ түр хороо байгуулах бид бүхний санаачилгыг та нар дэмжиж байна уу, дэмжихгүй байна уу? Энийг мэдэх эрхтэй юу, үгүй юу? Энд та бас хариулж өгөөч ээ.

Танай нам завсарлага аваад л тэрнээс хойш хэчнээн ч удчихав. Тийм тэр хууль ч хамаагүй л болчих шиг боллоо. За тэгээд энэ жижиг намуудыг нэг нэг яам хариуцуулаадахъя. Танай сайдууд ч одоо маш удаан хугацаагаар...

**Ж.Бат-Эрдэнэ:** Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Манай улс парламентын засаглалтай орон. Тэгээд Их Хурлын гишүүд хуулийнхаа дагуу гарын үсгээ цуглуулаад Түр хороо байгуулах санаачилгаа гаргаад Их Хуралд өргөн мэдүүлээд явдаг ийм л улс. Гэхдээ мэдээж энэ чинь олон улсын харилцааны асуудал учраас бас үүн дээр нэлээд мэдээлэлтэй байх ёстой гэдэг бол ийм л тайлбарыг бид нар тавьж байгаа. Жишээ нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ бол манай улс хүлээх ёстой. Тэр утгаараа 2 Засгийн газар хоорондын гэрээ Их Хурлаар батлагдсан учраас энэ нөгөө гуравласан асуудал буюу зөвхөн тэр нүүрсний үнийн үнэ жишээ нь нүүрсний үнийг өндрөөр тооцох тэр үнэ дээрээ юу гэж тооцох вэ гэдгээ ярьж болох боловчиг тэр хил холболтын асуудал дээр бол бид тэгж хамаагүй бас үүн дээр ингээд сонсгол хийгээд мэдээлэл дутуугаар явбал энэ 2 улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээн дээр буруу зөрүү ойлголт үүсчих вий гэдэг болгоомжлол хаа хаанаа байдаг аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүнд нэг минут.

**Н.Учрал:** Тийм учраас нэгэнт бүтээн байгуулалтын ажил өрнөж байгаа учраас үүн дээр бол бид нар тал талаас нь энэ гуравласан асуудал аа. Зөвхөн одоо тэр үнэ дээр нь ярих асуудал юмаа. Тэрнээс биш тэр хил холболтын асуудал огт энд хамаагүй гэж зааглаж ярихгүй бол мэдээлэл дутуугаас бид нар Их Хурал дээр орж сонсгол хийгээд үүний ард бол бас 2 улсын хоорондын Засгийн газар хоорондын байгуулсан гэрээнд янз бүрийн үл ойлголцол үүсэх вий гэдгээс болгоомжилдог. Энэ бол бас олон улсын харилцааны асуудал аа гэдгийг бид бас тал талаас нь зөв, бүрэн дүүрэн ойлгож, ухаалаг хандаасай гэж гишүүддээ бол хүсэж байгаа. Мэдээж Их Хурлын гишүүдийн мэдэх эрхийг хангуулах нийгэм олон нийт мэдэх эрхийг хангуулах асуудлыг хүндэтгэж байна. Тэгэхээр үүн дээр би бас дахин мэдээллүүдийг өгье өө.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж хариулт авч зарим гишүүд үг хэлж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Шижир гишүүнээр, Бейсен гишүүн татлаа, Шижир гишүүнээр тасаллаа. Цаг 22 цаг болж байна уу? Туваан гишүүнээр тасаллаа. Хэдэн гишүүн байна. 14 гишүүн үү? Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Бүгдээрээ нэрээ татчих аа гэдэг санал гаргаж байна аа. Өнөөдөртөө багтааж Засгийн газраа байгуулцгаая. Ажлуудаа хурдан явуулцгаая. Сая баахан асуулт асуусан. Тэгээд баахан үг хэлэх болж байх шиг байна. Тэгээд тийм санал гаргаж байна. Зүгээр миний хувьд тийм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

**С.Эрдэнэболд:** Та хэд энэ улсын гүйцэтгэх засаглалын тэргүүн сонгох гэж байхад 1, 2 цагийн наана цаана ямар хамаа байна аа. Тийм хувийн компани дээрээ ийм зан гаргаж болно шүү дээ. Энэ төрийн үйл хэрэг явж байна. Учрал нэр дэвшигчдэд хандаад хэлэхэд та бол Их засаг дээрээс нь Монголын нууц товчоогоо сайн судалсан хүн. Чингис хааны нэртэй сургууль төгссөн хүн. Монголын нууц товчоонд гардаг их төр сэтгэгдэх гэсэн агуулга байдаг. Их төр сэтгэгдэх гэдэг агуулга бол иргэдийнхээ сэтгэлийг муутгах буюу иргэддээ ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх гэсэн монгол ухаан. Тийм учраас одоо энэ Засгийн газрын гол ажил бол иргэд рүүгээ чиглэсэн өрхийн амьжиргааг дэмжсэн энэ бодлогыг тууштай явуулах ёстой.

2 дугаарт Монголчуудын энэ уламжлалт төрийг ойлгох ухаанд сүр хүч хийгээд өршөөл журам гэсэн 2 ойлголт байдаг. Сүр хүч гэдэг бол хуулийн засаг, өршөөл журам гэдэг бол ард түмнийхээ талд уг утгаараа бол ял алдар 2-ыг ус тосоор нь ялгах ийм ухаан байдаг аа. Тийм учраас улс төрийн ойлголцол гэдэг халхавчин доор гэмтнүүдийг ингээд зүгээр явуулж байдаг. Дээрээс нь одоо жирийн иргэддээ бол хууль нь хатуу буулга болж байдаг энэ зарчим бол ингээд таслан зогсоогдох ёстой.

Өнгөрсөн 20 сарын хугацаанд бид нар ингээд 3 дахь Ерөнхий сайдаа сольж байна. Үндсэндээ МАН-ын тэргүүлсэн энэ 2 удаагийн кабинет 3 дахь кабинет нь бүрдэх гэж байна. Давхардаагүй тоогоороо 60 гаруй хүмүүс сайд хийж байгаа гэсэн үг. 126-тай харьцуулахад бараг тал нь сайд хийж байгаа гэсэн үг. Дэд сайд нараа нэмэх юм бол дал гаруй хүн болж байгаа гэсэн үг. Энэ хэмжээгээрээ бүтээмж, засаглалын ур чадвар, үр ашиг унаж байгаа. Сүүлийн Учрал даргын хэлээд байгаа үгэн дээр бол энэ эрх чөлөөний 4 зам чөлөөлөх 4 зам гэж яриад байгаа. 2016 оноос хойш 2026 он хүртэл бүхэл бүтэн 10 жил 3600 хоног нэг нам эрх барьсан.

Тэгэхээр Учрал Ерөнхий сайдад нэр дэвшигч ээ, таны энэ чөлөөлөх гээд байгаа эрх чөлөөг тунхаглаж зарлаад байгаа гол үйл хэрэг чинь та өөрийнхөө намынхантай яс үзэж, хариуцлага тооцож хууль ёсыг сахиулахаас эхэлнэ ээ. Өөр нам эрх бариагүй учраас энэ 10 жилийн завхралыг та цэгцлэх гэж байгаа бол өөрийнхөө намын нэр дээр сайд дарга болсон, эрхтэн мэдэлтэн, ямба ямбатан тушаалтнуудтай үзэлцэнэ гэсэн үг шүү. Харин тэд нарын хууль бус үйлдэл, эс үйлдэл, Монголд учруулсан алдагдсан боломжийг та чөлөөлж болохгүй. Хариуцлага тооцоорой гэдгийг онцгойлон сануулъя.

Дээрээс нь ер нь бид нар ингээд энэ нэг ийм зүй тогтлыг их харж байна л даа. Хүн төрөлхтний түүхэн дээр байдаг. Хүчтэй ганган явахын цагт хүн байтугай нохой хүртэл инээдэг. Ноорч ядуурахын цагт нохой байтугай хүн хүртэл ураг гэнэ гэж 90 жилийн өмнө төрсөн Ренчингийн Чойном гуай шүлэглэж байсан байдаг. Эрх мэдэл байгаа газар долдойчид, бялдуучид, тойрон хүрээлэгч нар байдаг аа. Үе үеийн Монголын удирдлагуудын оюун санааг самууруулж төрийн бодлогын оронд хов жив хар PR яваад Засгийн газрууд онхолдож унаж байсан түүхүүд олон байгаа. Эхэн дээр нь хэлчихье. 2026 оны 3 сарын 30-ны өдөр. Тийм учраас өөрийн бодол өөртөө зөв тодорхой зарчимтай Монголынхоо төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр яваарай. Энд таныг тангараг өргөөд гарахад чинь тойрон хүрээлэгч нар чинь олон төрлийн амбицтай нөхдүүд чинь бүчиж авна аа. Хамгийн эхэнд санал хэлж байгаа хүмүүсийг та нүдийг нь тогтоож аваарай. Хамгийн түрүүнд урвах хүмүүс байгаа шүү. Түүх угаасаа тэгж явдаг. Тэгээд амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Өлзийхүүгийн Шижир гишүүн.

**Ө.Шижир:** Ерөнхий сайд түр гарчихсан уу тиймээ. Орж ирэхээр нь хэлчих үү. Хүлээж байя тиймээ. Бат-Эрдэнэ дарга аа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин. Хэлэхгүй байсан юм уу сая тэгээд. Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Тэнд хүн үгээ хэлээгүй байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Яасан бэ тэгээд, хүлээж байгаа юм биш үү. Үгүй тэгээд хүлээж байна шүү дээ. Хүлээж байна шүү дээ би юу ч дуугараагүй дуугүй л сууж байна шүү дээ. Би юу ч дуугараагүй дуугүй л сууж байна шүү дээ. Тэгээд би харин өөрийг чинь л хүлээгээд сууж байна шүү дээ. Яасан ч хэрүүлч юм бэ дээ. Өлзийхүүгийн Шижир гишүүн.

**Ө.Шижир:** Оройн мэнд. Ерөнхий сайдад хандаж нэг хэдэн үг хэлэх гэсэн юмаа. 1 дүгээрт та бизнес эрхлэгчдэдээ хайртай Ерөнхий сайд байгаарай. Яагаад гэвэл та өөрөө бас бизнесийн салбарт ААН эрхэлж байсан тодорхой тооны хүмүүсийг бас ажил олгогчоор хангаж байсан ийм хүн. Тийм учраас өнөөдөр бүх төрлийн татвар, шимтгэл, торгууль гээд алданги гээд энэ бизнест эрхэлж байгаа хүмүүс бүгд ийм юм төлж үйлээ үзэж байгаа. Жоохон илүү гарсан мөнгөнөөс нь урамшуулал нийгмийн даатгалд авна гэж дахиад тамладаг ийм юм байгаа. Бусдаар гүйцэлдүүлсэн арга хэмжээнээс нь НДШ авна гэж татвар авдаг гэж бас ингэж бизнес эрхлэгчдээ бас үйлийг нь үздэг нэг ийм тогтолцоо байгаа. Багахан зөрчил илрэхээр нь тэрэн дээр нь очоод торгууль алданги тавьдаг бас ийм тогтолцоо байгаад байгаа. Олсон орлогын алданги эсвэл зөрчил гээд хуу хамдаг ийм бас процесс байгаад байна.

Тийм учраас Ерөнхий сайд та бизнес эрхлэгчээ дэмждэг, ААН-үүдээ хайрладаг тийм Ерөнхий сайд байгаасай гэж хэлэх гэсэн юм. 2016 онд МАН засгийн эрх барихдаа нэг ч төрлийн татвар нэмэхгүй гэж амлаж байсан. 2020 онд бас энэ амлалтаа хэрэгжүүлээгүй. Түүнээс хойш нийтдээ давхардсан тоогоор 19 төрлийн татварыг МАН эрх барьж байгаа 10 жилийн хугацаанд нэмлээ. Нийслэлийн татварыг 2 дахин нэмлээ, нийслэл дэх нийтийн тээврийн хэрэгслийн татварыг 5 дахин нэмлээ. Авто зам ашиглалтын татварыг 3 дахин нэмлээ. Иргэдийн банканд хадгалуулдаг байсан хүүнээс нь хүү тооцдог боллоо. Газрын төлбөр нэмлээ, суудлын автомашины онцгой албан татвар нэмлээ, нийгмийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулаад ажил олгогчоос 26 шимтгэл авдаг боллоо.

Ер нь бол сүүлийн 10 жил эрх барьж байгаа МАН эдийн засгийн талаар, татварын талаар ААН-үүдийн талаар ярьсан өр яриа амлалтууд чинь бүгдээрээ өнөөдрийн байдлаар тэг байгаа шүү. Хоосон боомилсон, нэмсэн хаасан, боосон үйл ажиллагаа явуулахыг нь үл дэмжсэн үл хайхарсан ийм эдийн засгийн бодлого өнгөрсөн 10 жилийн хугацаанд явлаа. Тэгэхээр анх Засаг авсан буюу 2010 онд авсан Засаг авахдаа амлаж 2012 онд Засаг авахдаа амлаж байсан эдийн засгийн чиглэлийн бүх амлалтуудаа хэрэгжүүлээрэй. Дахиад уриа лоозон битгий болгоорой. 10 жил лоозон шинжтэй яваад өнөөдрийн байгаа эдийн засгийнхаа үр бүтцийг та нар ингээд харчих. Энэ бодитоор байгаа. Иргэдийн бодит амьдралд орлого нэмэгдсэн үү нэмэгдээгүй, худалдан авах чадвар сайжирсан уу сайжраагүй, өрхийн амьжиргааны түвшин нь дээшилсэн үү дээшлээгүй. Тэгээд өнөөдөр бид энд ингээд сууж байна. Зөвхөн цагаан сарыг угтаад гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнүүд чинь

хамгийн багадаа 16 хувь, хамгийн ихдээ 280 хувь өслөө. Үхрийн мах өнөөдөр 31 мянгыг даваад явчихлаа. Бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн нь дахиад бас 10-15 хувь нэмэгдэж байна аа. За одоо ингээд 4 сарын 1-ээс цахилгааны үнэ өнгөрсөн жил цахилгааны үнэ нэмэгдсэн. Энэ жил шатахууны үнэ одоо нэмэгдэх юм бол дахиад энэ гол нэрийн хүнсний бараа бүтээгдэхүүнүүд чинь 10-15 хамгийн багадаа нэмэгдэнэ ээ. Үүнийг дагасан эдийн засгийн бодлогуудаа хийгээрэй.

Дахиад хэлье. Бизнес эрхлэгчдэдээ, ААН-үүддээ, хөдөлмөр эрхлэгчдэдээ монголчууддаа хайртай Ерөнхий сайд байгаарай. Таны ажлын үр дүн бол юугаар хэмжигдэх вэ гэхээр уриа лоозонгийн хэрэгжилтээр биш иргэдийн бодит амьдралд халаасан дахь орлого нь хэдэн төгрөгөөр нэмэгдсэн бэ. Худалдан авах чадвар нь яаж сайжирсан бэ, ААН-үүдийн ажлын байр хэдээр нэмэгдсэн. Бизнес эрхэлж байгаа аж ахуйдын тоо хэдээр нэмэгдсэн, татвар төлсөн аж ахуй нэгжийн тоо хэдээр нэмэгдсэн бэ гэдэг энэ үр дүнгээр үнэлэгдэнэ. Тэрнээс биш бие биеэ магтсан сайхан үг, бие биедээ урмын үг хайрласан энэ юугаар хэмжигдэхгүй шүү гэдгийг танд хэлэх гэсэн юм. Тэгээд танд ажлын амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин.

**Х.Тэмүүжин:** Өнөөдөр маш олон гишүүдийн амнаас авлига хулгай, эдийн засгийн таагүй байгаа байдлын тухай үгнүүд сонсогдож байна. Монгол Улсын авлига тогтолцооны авлига болсон хүн бүгд энийг ер нь мэдэрч байгаа байх. Тогтолцооны авлигыг таньж мэдэх ганцхан л арга байгаа. Систем өөрөө буруу барьсан гажиг байгаа үед сүүдэр томорч доор нь хулгай гардаг. Хаалттай, хүнээс хамааралтай, сэтгэл хөдлөлөөрөө хөтлөгдөж байгаа бүх шийдвэрийн ард систем өөрөө хямарч байдаг. Тийм учраас миний ярьж байгаа энэ зарчмын байр суурь хүнд ерөөсөө хаяглагдаагүй шүү. Манай системийн авлигын нэг зүгээр нэг энгийн жишээ Улсын Их Хурлын тархин дээр Ерөнхий сайд гарч суудгийг болих ёстой. Би Оюун-Эрдэнийг Ерөнхий сайд байхад энэ хуулийг өргөн барьсан. Та бүхэн Ерөнхий сайдаа намын даргаа хамгаалаад одоо хүртэл хэлэлцээгүй. Занданшатарын үед хэлэлцүүлэх үү гэж би асуусан. Манай Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн биш учраас суудлыг нь тэндээс буулгачихаар энэ танхимаас гарчих гээд байна аа гэж хэлсэн. Энэ Учрал гэдэг хүнд хаягласан үг биш шүү. Парламентын тархин дээр Ерөнхий сайд гарч ирж сууж ерөөсөө болохгүй. Яг энэ мэтгэлцэж байгаа энэ 2 индэр байна. Энэ 2 индэр дээр Ерөнхий сайд сөрөг хүчний лидер 2 бодлогын мэтгэлцээн өрнүүлэх ёстой. Бусад улс орнуудад мэтгэлцэж байгаа индэрийнхээ харалдаа суудаг юм байна лээ. Нөгөө сөрөг хүчний дарга нь ч энд, Ерөнхий сайд нь ч тэнд. Ерөнхий сайдынхаа харалдаа ард нь сайдууд нь суудаг юм байна лээ. Тэр сууж байгаа сандал дээрээс Улсын Их Хурлын гишүүнийхээ биш сайдынхаа хариуцлагаар үг хэлдэг юм байна лээ. Тэгж байж систем зөв байршдаг юм байна лээ. Суудлаа олохгүй бол гүйдлээ олохгүй гэж үг байдаг. Бид 3 даргын улс байх ёсгүй. Тэр дундаа парламентын засаглал бүхий улс орны парламентын танхимд индэр дээр нь 3 дарга гарч ирж суучхаад загнаж эс үгүй бол даргалж дээрээс харсан өнгө аясаар үг хэлж болохгүй.

Та сая их гоё үг хэлсэн. Ямар ч албан тушаалтан иргэний дээрээс аашилж харж болохгүй ээ. Дээрээс харж байгаа ганцхан тохиолдол унасан хүнийг босгохын тулд дээрээс нь харж болно оо гэж. Яг тэрэнтэй адилхан гүйцэтгэх эрх мэдлийг толгойлж байгаа хүн парламентын дээрээс харж болохгүй ээ. Ядаж мэтгэлцдэг талбарынхаа дунд ирж зогсоод энэ парламентын мэтгэлцээнийг гүйцэтгэх эрх мэдэл хүлээн зөвшөөрч хүндэтгэж байгаа байр суурин дээрээс ярих ёстой.

Дахиад би дахиж үг хэлнэ. Улсын Их Хурлын дарга болж байгаа хүнд бас зориулж үг хэлнэ. Хэн нэг нь болох байх. Түрүүн Гантөмөр гишүүн хэлнэ лээ. Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайд протоколтой уулзах ёстой. Ерөнхийлөгч Улсын Их Хурлын дарга протоколтой уулзах ёстой гэж. Протоколтой уулзалтыг гуйдаггүй юмаа. Энэ парламентын байршиж байгаа байшингаас Засгийн газар гарах ёстой. Би энийг 2024 оны сонгуулиар бүрдсэн Улсын Их Хурал анх хуралдахад хэлж байсан. Засгийн газар энэ парламентын байшингаас гарах ёстой. Цаана чинь парламентын сайдууд нь Ерөнхий сайд нь парламентад орж ирэхдээ шат өгсөж орж ирдэг юм байна лээ. Яагаад гэвэл энэ өөрөө сонгогчдын төлөөлөл болсон парламент учраас гүйцэтгэх эрх мэдэл энэ байгууллага, энэ институтэд хүндэтгэлтэй хандах ёстой гэж. Бид дотроо холилдож суугаад нэг бай...

**Ж.Бат-Эрдэнэ:** Пүрэвжавын Сайнзориг алга байна. Жаргалсайханы Золжаргал.

**Ж.Золжаргал:** Учрал гишүүнд захиас байна. Хэрвээ Ерөнхий сайдаар сонгогдоод баталгаажвал Монголын их наядуудыг их наяд төгрөгүүдийг хайрлаарай гэж захимаар байгаа. Түлш эрчим хүч энэ салбар маш эмзэг маш чухал болж байна. Бид нар галаа өөрсдөө түлдэг. Хоолныхоо махыг малыг өөрсдөө малладаг. Цахилгаан өөрсдөө хийдэг байх хэрэгтэй байгаа. Би хоёрхон зүйл хэлье.

1 дүгээрт нь өнгөрсөн жил монголчууд галаа түлэхдээ Хятадаас нүүрс авч түлсэн. Тэгээд тэр их мөнгөөр өөрсдөө дотоодоосоо аваач ээ гэсэн. Манай нийслэлийнхэн баахан гомдсон. 200 хэд дараа нь 300 тэрбум нийт төгрөг. Нэг тонн нь сая 30 мянган төгрөг гэсэн шүү дээ өөрсдийнх нь хэлснээр. Нэг шуудай нүүрс 3700 биш бодит үнэ 50 мянган төгрөг нэг шуудайг бид нар авч түлжээ. Яагаад би энийг онцолж хэлж байна вэ гэхээр Монголд тэр Хятадаас орж ирсэн түүхий эд чинь байгаа. Хагас кокс гэж Монголд юм байна уу гээд Ерөнхий сайд өнгөрсөн намар салбарын сайдаас асууж байсан. Тийм юм байхгүй байна гэж хариу өгсөн юм шиг байна лээ. Тэгсэн Хятадаас ирсэн нүүрсэн дотор витринит гэж юм байдаг юм. Дотор нь юу байгааг гэрлээр ойлгож үздэг. Тэр нь бол антрацит буюу байгалийн утаагүй нүүрс. Монгол Улсад антрацид байгалийн утаагүй нүүрс байгаа. Тэрийг бид нар Хятад руу экспортоор гаргадаг. Тэрийгээ нугалсан үнээр буцаагаад шахмал түлш байдлаар нэг жил авлаа. Одоо дотоодод бэлэн байгаа түүхий эдийг тэр байгаа компаниудыг нь цуглуулаад чиглэл өгөөд шийдээч ээ. Энэ салбарын яамнаас болон Ашигт малтмалын газраас авсан бичиг надад энэ бичиг дээр үзүүлэлтүүд нь байгаа. За нэг асуулт ийм байна. Тэгэхээр энэ мөнгө Монголдоо үлдэг. Өмнө нь ямар нэгэн юм тохирчихсон барьчихсан мөнгө төгрөг нааш нь явуулчихсан юм үүгээр дуусаг ээ. Монголын мөнгө Монголдоо үлдэг. Монголын эрх ашиг номер нэг энэ цаг үед ч бас хэцүү болж байна.

Хоёр дахь нэг зүйл байна. Газрын тосны бүтээгдэхүүнүүд хүн нь олон улсад тэнгэрт хадаж байна. Энэ дайн бол ер нь нэлээн явах янзтай юм байна. Тэгэхээр бид нарт нөөц хэрэгтэй. За нөөц гэхээр зэрэг дахиад их наядууд яриад байна. Их наядуудаар баахан зээл өгч сав барих тохой бид нар ярьсан. Их наядуудаа хэмнээд газрын тос боловсруулах үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний савыг нь түрүүлээд дуусгачих аа. Ингэж бол болно техникийн хувьд. Тэнд чинь маш том сав байгаа. Тэртээ тэргүй зээл авчихсан, үнээ шийдчихсэн. Тэндээ бензин дизелийн түлшийг нь түрүүлж дуусгаад стратегийн нөөцөө хадгалмаар байна. Одоо Монголд стратегийн нөөц хэрэгтэй. Сөрөн тэсвэрлэх чадвар гэж ярьдаг болоод байгаа бид нар тэсэж

үлдэх хэрэгтэй. Үнэ өртгөө ч тэндээ хангалттай том байгаа. Тэртээ тэргүй мөнгө нь зарагдана. Тэгэхээр энийг эхэлж хийе.

Ингээд олон их наядаа хэмнэе. Энэ бол ингээд 2 жишээ би үүнээс цааш бол ярихгүй. Зөндөө олон жишээ байгаа. Түлш эрчим хүчин дээр Монголын их мөнгийг олон их наяд төгрөгийг Монголдоо үлдээж өөрөө өөрсдийнхөө асуудлыг шийдэх энийгээ бол нээлттэй шийдэх ийм зүйлийг та анхаараасай гэж хүсье. Тэгээд ажлын амжилт хүсье ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Шинэбаярын Бямбасүрэн гишүүн.

**Ш.Бямбасүрэн:** Оройн мэнд хүргэе. Оны дараа тойрогтоо очиж ажилласан. Тэгээд тойргоор явж байхад бол тэр төрийн албан хаагчдын цомхотголтой холбоотой асуудлыг бол маш их бухимдалтайгаар тавьж байсан. Та бас Их Хурлын дарга байхдаа бас орон нутагт ажиллаад томилолтоор явж байхдаа энэ асуудлыг ойлгосон гэж ярьж байсан. Тэгэхээр энэ асуудлыг яаралтай эргэж хараарай. Улсын Их Хурлын төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах тогтоол бол үндсэндээ бол давхардал, хийдэл байгаа газрууд дээр нь шинжилгээ хийгээд тэрэн дээр нь цомхотгол хийе гэсэн тогтоол болохоос биш нийтээр нь тэгж хоморголон цомхотгож цомхотгоорой гэсэн тогтоол байгаагүй ээ. Тийм учраас энийг бол та нэн түрүүнд эргэж харж харахгүй бол анхан шатан дээр ажиллаж байгаа тэр төрийн албан хаагчид үнэхээр хүндрэлтэй тэр соёлын төвийнхөн бол үнэхээр бухимдлаа барж дийлэхгүйгээр хэлж байсан. Энийг бас танд бас захиж хэлье ээ.

Инфляц үнийн өсөлт бол үнэхээр хэрээс хэтэрсэн. Иргэдийн нуруун дээрх хамгийн том ачаа байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд манай Засгийн газар төсвийн бодлогоо мөнгөний бодлоготойгоо хольчихсон. Монгол банк нь бие даасан хараат бус байдлаар ажиллах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ирээгүй. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр лүү ингээд давхар чиг үүрэгтэйгээр ороод явчихсан. Энэнээсээ болоод бид нар үндсэндээ мөнгөний бодлого мөнгөний нийлүүлэлтээ алдчихсан шүү. Тийм учраас дараа дараагийн төсвөө оруулж ирэхдээ битгий энэ мөнгөний бодлого руу ороорой. Энийг нь бие даасан байдлаар нь ажиллуулах тал дээр нь анхаараарай гэж хэлэх гэж байгаа юм.

Тэгээд Монгол Улсад үнэхээр хуулийн хэрэгжилт бол хангалтгүй байгаа. Тэгэхээр Засгийн газар бол өөрсдөө маш их хууль зөрчиж ирсэн шүү өнгөрсөн хугацаанд. Тэгэхээр хуулиа дээдэлж ажиллахыг танаас хичээнгүйлүүлсэн хүсье. Тэгээд эцэст нь хэлэхэд түрүүн гишүүдийн асуудалд нь асуултууд дээр та асуудалтайгаа нүүр тулна гэж хэлж байна. Тэгээд яг энэнтэй хэлсэнтэйгээ адилхан үнэн байгаарай. Аливаа асуудлыг Засгийн газрын маань нэр хүнд уначих вий, намын маань нэр хүнд уначих вий энэ асуудлыг бол ингээд үнэн бодитойгоор нь хэлчихээр намын маань нэр хүнд уначих вий гэж санаа зоволтгүйгээр парламент дотор ядаж үнэнийг хэлдэг байгаарай. Тэгж байж бид нар бол энэ олон жил үүсээд байгаа гацаанаасаа бол гарна шүү. Тэгээд таны цаашдын ажилд амжилт хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мөнхчулууны Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Учрал даргадаа амжилт хүсье. Залуу хүний эрч хүчээр богино хугацаанд хурдтай ажиллаж чадна аа, амжилт гаргаж чадна аа гэдэгт бол итгэж байна аа. Тэгээд Ерөнхий сайддаа нэлээн хэдэн захиасыг хэлье гэж ингэж бодож байна аа.

Нэгдүгээрт бид нар сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг эрчимжүүлэх тогтоолыг 12 сард батлахад нарны панельтай айл 78 ширхэг байсан. Тэгэхээр энэ тогтоолын хэрэгжилтийг хэмжих нэг хэмжүүр бол нарны панельтай айлын тоог нэмэгдүүлэх. Тэгэхээр энэ оны эцэс гэхэд ядаж одоо нэг 4 мянга, 5 мянган айл нарны панельтай болсон ийм амжилтыг гаргаарай гэж 1 дүгээрт хүсмээр байна аа.

Хоёрдугаарт болохоор та бүхэн мэдэж байгаа. Өнгөрсөн онд бид нар ДЦС 3-ын 50 мвт-ын станц эх үүсвэр байхгүй болсон дэлбэрсэн. Тэгэхээр энэ 50 мвт-ын эх үүсвэрийн сэргээн засах ажлыг эрчимжүүлэх ажлыг яаралтай хийгээрэй. Ирэх өвөл бид нар хүндэрнэ ээ. Ирэх өвлийн өвлөөс өмнө энийг ашиглалтад оруулах талаар онцгойлон анхаарал хандуулж ажиллаарай.

Гуравдугаарт нь ДЦС 4-ийг 500 тонн цагаар өргөтгөх ажлыг богино хугацаанд хийх боломжтой. Тийм учраас энэ төслийг яаралтай эхлүүлээрэй, хийж хэрэгжүүлээрэй. Хүсэх юм бол нэг жилийн дотор хийх бүрэн боломжтой. Энийг хэрэгжүүлснээр 300 мвт-ын дулааны эх үүсвэр бий болно оо, дулааны эх үүсвэр бий болно.

Дөрөвдүгээрт нь төсөв төлөвлөхдөө эрчим хүчний салбарт онцгойлон анхаарал хандуулаарай. Өнгөрсөн жилүүдэд эрчим хүчний салбар бол соёлын салбараасаа, замын салбараасаа ч доор төсөвтэй байсан. Тэгэхээр ингэж төсөв хөрөнгөө зарцуулахгүй бол энэ салбарын олон асуудлыг шийдэж чадахгүй ээ.

Дараагийн асуудал болохоор мэргэшсэн хүмүүсийнхээ үгийг анхааралтай сонсоорой. Мэргэшсэн хүмүүс таныг дагаад гүйх тийм хандлагатай биш ээ, даруухан хүмүүс ээ тийм хүмүүс. Тийм учраас та мэргэшсэн хүмүүсээ дуудаж ирж байгаад сонсоорой. Тэр хүмүүс танд тусалж чадна аа, үнэн бодит мэдээллийг тэр хүмүүс л өгч чадна шүү. Тэгэхээр мэргэшсэн хүмүүсийн үгэндээ итгээрэй. Яагаад гэвэл тэр хүмүүс даруухан хүмүүс. Таныг даргаа даргаа гээд тойрон хүрээлж дагаж гүйж чадахгүй. Тийм учраас тэдний хүмүүсийн цаана байгаа тэр мэргэшсэн хүмүүсээрээ дуудаж авчраад анхааралтай сайн сонсдог ийм Ерөнхий сайд байгаасай байгаарай гэж хүсмээр байна аа. Ингээд баярлалаа танд ажлын амжилт хүсье. 2 гараа өргөн тасралтгүй бүх боломжоо дайчлан дэмжин ажиллах болно оо.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн.

**Д.Жаргалсайхан:** Оройн мэнд хүргэе та бүхэнд. Сая хэд хоногт бас ирц хүрэхгүй өвчтэй, чөлөөтэй, гадаад томилолттой гээд манай эрх барьж байгаа нам маань хамтрагч нартайгаа нийлээд ирцээ бүрдүүлж чадахгүй байж байгаад л гэв гэнэт л Ерөнхий сайд огцорлоо гэсэн чинь л бүгдээрээ гүйгээд ороод ирсэн. Манай Батжаргал дарга бол ирцдээ ордоггүй энэ одоо Улсын Их Хурлын чуулгандаа оролцдоггүй хүмүүст хариуцлага тооцно оо л гээд байсан. Гэтэл бүгдээрээ ингээд гүйгээд ороод ирж байгаа. Тэгээд энэний цаана юу харагдаж байна вэ гэхээр бол ард иргэд бид бүхэн бол нэг зүйлийг л харж байна л даа. Занданшатарын Засгийн газар бол энэ хулгайчтай, энэ дээрэмчидтэй Монголын төрийг өнөөдрийг хүртэл ингэж доройтуулж явж байгаа хэдхэн энэ бүлэглэлүүдтэй тэмцсэн. Гэтэл өнөөдөр яаж одоо энэ Монголын төрийг хүчгүй болгож шантаажилж энэ засгийг огцруулж яаж эрхэндээ оруулдгийг л харлаа шүү дээ.

Тэгээд өнөөдөр нөгөө хүмүүс маань ингээд сайд болно гэхчигсэн нэг баахан албан тушаал барьчихсан л явж байгаа. Тэгээд энэнтэйгээ эвлэрээд явна гэдэгт үнэхээр энэ Засгийн газар урт наслахгүй ээ Учрал сайд аа. Тийм учраас энэ Монгол бол үнэхээр баян орон. Ганцхан энэ Монголынхоо энэ хэдэн олигарх энэ хулгайч нартайгаа л үндсэндээ тэжээж чадахгүй байгаа шүү дээ бид нарыг. Энэнийхээ шуналыг гүйцэлдүүлж чадахгүй байна шүү дээ. Тэгээд ингээд л Монголын төрөөр тоглоод л ирцэд нь ордоггүй ингэж шантаажилж байгаад л унагаангуут Засгийн газрыг бид нар асуудал яриагүй шүү дээ. Улсын Их Хурлын даргатай холбоотой асуудал ярьсан шүү дээ. Гэтэл ингээд ороод ирж байгаа юм.

Тэгэхээр үнэхээр Монголын төр эд нарын өмнө бол үнэхээр сөхөрдөг юм байна гэдгийг харж байна. Монголын ард түмэн бүгдээрээ харж байна энийг чинь. Тэгээд энэнтэй хийх тэмцлээ би таныг бол ухраад ингээд зогсоод больчихно гэдэгт би үнэхээр эргэлзэхгүй байгаа юм. Тийм учраас энэ шинэ Засгийн газарт бол яг энэ шантааж хийсэн, энэ ирцдээ ордоггүй Батжаргал дарга аа, ийм хүмүүсийг оруулж ирвэл энийг нотолж байна гэж ойлгоно шүү яг үнэндээ тийм. Бид нар бол энэ хэдхэн хоногийн хугацаанд их олон зүйлийг сонслоо шүү дээ. Долларыг машинаар нь аччихсан ингээд тараагаад л явж байдаг тиймээ. Энэ одоо юу вэ тиймээ. Ийм юм гэж байх уу. Ийм хэмжээнд Монголын төр хүрчихсэн байна шүү дээ. Монгол Улсын Ерөнхий сайд хийж байсан хүн энийг ярьж байна шүү дээ. Бид нар ингэж доройтсон байна шүү дээ. Энэ нам ингэж ялзарсан байна шүү дээ.

Тэгэхээр энэнтэй их тэмцлээ би таныг бол ингээд зогсоно, ингээд бууна ялагдана гэж үнэхээр бодохгүй байна. Үнэхээр тэр хүмүүстээ намаасаа хөөж байсан тиймээ, хариуцлага тооцно гээд бүлгийн дарга Батжаргал дарга ярьж байсан тиймээ. Тэгээд энэ хүмүүстээ үнэхээр хууль дүрэм журам гэж байдаг бол хариуцлага тооцох ёстой. Ингэж байж авлигал хулгай зогсоно шүү. Ойрх Дорнодод үүсэж байгаа нөхцөл байдалтай холбоотой энэ дайнтай холбоотой дэлхий хямарч байна. Тэр тусмаа Азийн орнууд маш их хямарч байна. Энэ Азийн орнуудад томоохон бас шинэчлэлт өөрчлөлтүүдийг хийж байна, хязгаарлалтуудыг хийж байна, хэмнэлтийн горимд шилжиж байна. Ингэхэд Монгол Улс энд бас ямар бэлтгэл хангах вэ. Шатахууны үнэ бол доод тал нь 2 дахин нэмэгдэх нь тодорхой болчихлоо. Бүх юмны үнэ өснө, ард иргэдийн амьдрал тэр чигээрээ доройтно, амьжиргаа дордоно. Тэгээд энэн дээр бол одоо маш их энэ зохион байгуулалттай сайн ажиллаж ямар ч байсан шатахуунтай болох асуудал нэг номерын асуудал байна аа. Энэ дээр ажиллаач ээ.

Мөн дээрээс нь бид нарын хувьд энэ төсөв мөнгө хэмнэх дээр өөрсдөөсөө эхлэх ёстой. Энэ дэд сайд нарын асуудлыг бол маш ойрын хугацаанд бол шийдэх ёстой. Энэ зардал мөнгө хэмнэх энэ төсөв мөнгийг бүрдүүлэх дээр бол нэлээн хүндрэлүүд гарах байх гэж харж байна. Энэ шатахуун мөнгө ингээд нэмэгдэхээр энэ улсын төсвийг бүрдүүлж байгаа энэ ААН-үүдийн орлого ашиг эрс муудна. Экспортод гарч байгаа бараа бүтээгдэхүүн тэр чигээрээ уул уурхайн бүтээгдэхүүнүүд байж байгаа. Энэ бүгд муудна. Тэгэхээр энэ...

**Ж.Бат-Эрдэнэ:** Лувсаннямын Гантөмөр гишүүн алга байна. Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** За юу байгаа юмаа. Ингээд манай Ерөнхий сайд тэгээд урдах урдах Засгийн газруудаасаа ингээд сургамж аваасай. Ерөнхий сайдуудаасаа гэж бодож байгаа юмаа. Тэгээд бид нар чинь энэ авлига хулгай, энэ нүүрсний хулгай

энэ тэр юмандаа бол одоо бид нар үнэхээр идэгдээд дууслаа шүү дээ. Аягүй өрөвдөлтэй хэдэн улс төрчид аягүй өрөвдөлтэй ард түмнээ хараад сууж байна л даа. Үнэхээр гэхдээ би ч тийм ч бас гутранги хүн биш ээ, өөдрөг харж байна. Арай дээр болоосой. Гэхдээ өөдрөг юм бол манайх чинь юу билээ 90 хувь нь фэйсбүүкээс мэдээлэл авдаг гэж байгаа. Тэр 30 хувь нь тэн дээр байгаа бүх юманд итгэдэг гэж байгаа. Гэхдээ бас манай залуучууд байна аа. Энэ 2000 оноос хойших залуучууд. Эд нар үнэхээр итгэл найдвар төрүүлж байна. Тэгээд авлига хулгайтай авлига хулгай хийж байгаа энэ улсуудаас гадна энийг зүгээр харсан ч хараагүй юм шиг хажуугаар нь дуугүй байж байгаа бид нар аягүй буруутай байхгүй юу, буруугийн буруутай. Тэгээд манай 2 хөрш маань энэ 2 хөрштэй муудалцуулахыг байнга хүсдэг энэ ард түмэнтэй. Тэд нарын өмнөөс одоо янз бүрийн юм тараадаг. Энэ 2 том улс энэ гуравхан сая 500 мянган хүн ингээд сайн сайхан амьдарчхаасай, болчихоосой, бүтчихээсэй, энэ юм нь тогтвортой байгаасай гэсэн ийм л бодолтой байдаг гэж би бодож байгаа. Гэтэл энийг бусниулаад, гацаагаад, энэ улс орны хөгжлийг тэр дундаас нь маш их хулгай хийж мөнгө завшдаг ийм улсууд байна аа. Тэр их мөнгөө, тэрний өчүүхэн хэсгийг энэ толгой угаах энэ улс орныг ийм ядуу байх энэ бүх юманд ингээд ашиглаж байна аа. Энийг бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ.

Энэ олон сайдууд их удаан хугацаагаар ажиллах юмаа. Энэ өөдөө гарч байгаа салбар ганц ч алга аа. Тэгээд 1 зураг байдаг л даа. Хараад би үнэхээр харамсдаг юм. Тэгээд нэг цус нь гоожсон тийм алх хадуур бариад л өрөө өрөө хаагаад л яваад байдаг. Тэгээд манай ард түмэн маань өдрөөс өдөрт энэ Непалынхан шиг, Бангладеш шиг л болоод байна л даа. Тийм ч болгож байна. Тэгээд энэ явдал чинь ингээд удаан үргэлжлээд явах юм бол тийм хэллэг гарчихсан байна шүү дээ. Энэ ард түмэн чинь одоо непалдана хүлээгээд. Энэ залуучууд чинь энэ амьдралыг ингээд тэвчээд тэсээд хүлээгээд байж чадахгүй ээ. Энэ муухай юмыг чинь хараад үнэхээр байж ядаж байна шүү дээ. Ийм баян, ийм сайхан байршилтай, ийм IQ өндөртэй ийм улс орныг яагаад ийм байлгадаг юм бэ. Эцсийн найдвар одоо МАН-аас та болчихоод байх шиг байна. Та ямар ч байсан бага ч байсан одоо өөрчлөлт хийгээсэй гэж бодож байна, найдаж байна.

Тэгээд Засгийн газраа яаж байгуулахаас энэ бүх юм чинь шалтгаална аа. Энэ гацсан төмөр зам. Уул нь энэ төмөр замыг зөв тавиад холбоод явуулаад ингэчихсэн бол бид нарыг коксжих нүүрс Энэтхэгт ч хүрч болох байсан...

**Ж.Бат-Эрдэнэ:** 2 гишүүн үг хэлсний ар дээр санал хураалт явуулна. Гишүүдийг танхимд урьж байна. Жуковын Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Учрал даргыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ байгуулагдаж байгаа Засгийн газар 2028 он хүртэл бүрэн эрхийн хугацаандаа бүтэн дуусгах ёстой гэж үзэж байгаа гэж бодож байгаа. Ардын намаас бас ард түмэндээ амласан амлалт олон амлалт байгаа. Тэрийг хэрэгжүүлж дуусгах ёстой гэж үзэж байгаа. Нийт ард түмний 50 хувь нь амьдарч байгаа Нийслэл хотын асуудалд бас шинэ Ерөнхий сайдыг онцгой анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Засгийн газар байгуулагдсаны дараа ажлын хэсгээ гаргаад нийслэлийн төслүүдийг хянан үзээд сайн төслүүдийг нь бас дэмжиж явуулаасай гэж Учрал даргаас хүсэж байна. За эрх баригч МАН-ынхаа гишүүдэд хэлэхэд эв нэгдэлтэй байж сөрөг хүчний улс төрд хөтлөгдмөөргүй байна аа. Саяхан улаан ногоон лаазаар удирдагдаж байсан сөрөг хүч маань өнөөдөр өөр болсон байна аа. Өчигдөр сөрөг хүчнийхэн маань Занданшатарын Засгийн газрыг огцруулахаас аргагүй байдалд оруулсан. Өнөөдөр Нямбаатарыг огцруулах асуудлыг ярьж байна. Маргааш магадгүй намар Учралын

Засгийн газрыг огцруулах асуудлыг хөндөнө өө. Тийм учраас энэ сөрөг хүчний улс төр. Тийм учраас Ардын намынхаа гишүүдэд хэлэхэд эв нэгдэлтэй байж сөрөг хүчний улс төрд хөтлөгдмөөргүй байна гэдгийг бас зориуд сануулан хэлэх гэсэн юмаа. Засгийн газрын үйл ажиллагаа, шинэ Засгийн газрын үйл ажиллагааг 100 хувь дэмжиж ажиллах болно оо. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэвэгдоржийн Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Оройн мэнд. Энэ нөхцөл байдал хүнд байгаа. Бид нар бас тэсэж үлдэх гэдэг асуудлыг асуудал дээр тулчихсан ийм цаг үе гэж харж байгаа. Тэгээд үнэхээр хүнд байна, хүнд болно. Тэгээд ямар ч байсан бид хэд Мягмар гарагаас монголчуудын цээрлэдэг Мягмар гарагаас өмнө бас Ерөнхий сайдаа баталчихмаар байна аа. Тэгээд энэ бол Монголчуудын эрх ашгийн асуудал учраас бүгдээрээ энэ дээр бас нэг тийм нэгдсэн бодолтой баймаар байна. Бензиний асуудал бид нар нөгөө эрчим хүчний асуудал бензин шатахууны асуудал бид нарт хамгийн их тулгамдсан асуудал. Ер нь бол нэг их юм хэрэггүй шүү дээ. Хоолтой ундтай баймаар байгаа. Дээрээс нь бензин эрчим хүчтэйгээ байхад бас их асуудал шийдэгдэнэ дээ. Тэгэхээр энэ дээр Ерөнхий сайд бас нэлээн бодлого барьж ажиллаасай гэж ингэж бодож байгаа юм.

Монгол Улс ОХУ хоорондын Засгийн газрын хэлэлцээр гэж байгаа. Тэр хэлэлцээр дээр бид нар улс төржиж байгаад энэ асуудлаа унагаасан. Өнөөдөр тэрнийхээ үзүүрийг, тэрнийхээ хохирлыг бид нар амсаж байна. Юу вэ гэхлээр газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх хэлэлцээр онгоцны түлшний хэлэлцээр 2. Тэгэхээр энэ асуудлыг бид нар янз янзын юм ярьж байгаад л тэгээд л унагаасан. Тэгээд өнөөдөр бас хор холбогдлыг бид нар амсахаар байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бас анхаараарай. Бид нар бас 2 хөрштэйгөө хийсэн асуудал дээрээ бас үгэндээ суудаг баймаар байна. Хэлсэндээ хүрдэг баймаар байна. Тэгэхгүй бол ингээд нэг мөн биш болоод л ингээд улс төржиж байгаад энэ асуудлыгаа унагаачихдаг эргээд энэ чинь ингээд тодорхой асуудал дээр ингээд хүрээд ирдэг юм шүү. Энэ асуудлыг бас бодолцоорой гэж ингэж бодож байна.

За нэг хэд гуравхан асуудал байгаа юм. Бид хэд бас Монгол Улсын Ерөнхий сайдаар нэр дэвшиж байгаа Учрал дарга бид хэд нэг кабинетад байсан. Энэ асуудал дээр тэр Цөмийн энергийн агентлагийн асуудлыг анхаарч үзээрэй. Хүмүүс бүгдээрээ л хасна, танана, цөөлнө л гээд байгаа. Бид нарын үед болохоор ярьж байсан асуудал бол энэ Цөмийн энергийн агентлагтай байх асуудлыг ярьж байсан. Нөгөө ураны асуудал гээд л бид нар ярьж байгаа тиймээ. Тэгэхээр энэ асуудлыг бас анхаарч үзээсэй. Бүгдийг таны үгэнд гарч байна лээ. Бүгдийг танах хасах биш зайлшгүй шаардлагатай асуудлуудыг бас нэмнэ гэдэг асуудлыг ярьж байсан. Тэгэхээр энийг энэ асуудлаа бодоорой.

Дээрээс нь энэ бүсчилсэн хөгжлийн асуудал өнөөдөр 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, биелэлт, аудитын тайлан ярьж байгаа. Энэ дээр бүсчилсэн хөгжлийн асуудал чинь нэлээн хойгуур явж байна лээ шүү. Тэгэхээр энэ асуудлыг бас бодоорой. Дээрээс нь энэ хийн хоолойн асуудлыг та бас ярина аа л гэж ярьж байна лээ. Тэгэхээр энэ 2 хөрштэйгөө ярих энэ нэлээн чухал асуудал шүү. Тэгэхээр энэ асуудал дээр бас бид бүхний ялангуяа АН-ын дэмжлэг туслалцаа байвал бид бүхэн энэ асуудал дээр ярина аа. Энэ Монгол Улсын эрх ашгийн асуудал. Өнөөдөр дэлхий нийтээрээ дайн байлдаан ярьж байна. Дэлхий нийтээрээ

тэсэж үлдэх асуудал ярьж байна шүү. Тэгэхээр энэ асуудлыг та бас нэлээн чухалчилж үзээрэй. Алт 3 гээд хөтөлбөр байсан. Энэ асуудлыг бас.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд үг хэлж дууслаа. Одоо Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох асуудлаар ил санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Ням-Осорын Учралыг болж байна уу?

Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 107 гишүүн оролцсоноос 88 гишүүн дэмжиж, 82.2 хувиар санал дэмжигдлээ.

Бямбацогт гишүүн, Батнайрамдал гишүүд, Галбадрах гишүүдийг оролцуулъя.

Ням-Осорын Учралыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналын санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Монгол Улсын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 6 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар Ням-Осорын Учралыг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал таныг суудалдаа суухыг урьж байна аа.

Одоо Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал үг хэлнэ. Таныг индэрт урьж байна.

**Н.Учрал:** Эрхэм хүндэт ард иргэд ээ, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын өндөр хариуцлагатай албан үүрэгт ажилд тохоон томилсон Та бүхэнд талархал илэрхийлье.

Засгийн газрын тэргүүний өндөр хариуцлагатай албан тушаалд нэрийг минь дэвшүүлсэн МАН журмын нөхдөдөө намын шийдвэрийг дэмжиж намайг Ерөнхий сайдаар томилуулах саналыг Улсын Их Хуралд өргөн барьж танилцуулсан Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Танд талархал илэрхийлье ээ.

Төсвийн хэмнэлт хийж, экспорт, гадаад валютын нөөцийг нэмж, эдийн засгийг тогтворжуулж ажилласан Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар болон түүний Засгийн газрын гишүүдэд хүндэтгэл илэрхийлж буйг минь хүлээн авна уу.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Би Монгол Улсын Ерөнхий сайдын ажил алба бол эрх мэдэл гэхээсээ илүү өндөр хариуцлага, ачааны хүндийг үүрч, асуудлыг шийдэл болгох үүрэг гэдгийг ухамсарлаж байна аа. Гадаад, дотоод 2 талаасаа олон улс эдийн засаг, улс төрийн эрсдэл, хямрал давхар нүүрлэсэн энэ цаг үед Монгол Улсын Ерөнхий сайдын өндөр хариуцлагатай ажил үүргийг хүлээн авч байна аа.

Ойрх Дорнодод дэгдсэн дайны улмаас эрчим хүч, газрын тосны үнийн өсөлт, хомсдол, тээвэр логистикийн хямрал, гадаад худалдааны гацаа саад дэлхийн эдийн засгийн судсыг царцаан агшаалаа. Дэлхийн олон улсын орнууд онц байдал зарлаад байна аа. Түлш шатахууны импортоос 100 хувь хамааралтай манай оронд үнийн өсөлт нөөц хангамж онцгой өндөр эрсдэлийг дагуулж байна. Түлш шатахууны үнэ бол бүх юмны үнэ юмаа. Түлшний үнэ бол талх, гурил, мах, сүүний үнэ бүх үйлдвэрлэлийн орц юмаа. Цалин орлогыг хумслагч инфляцыг улам бүүр өдөөж, төгрөгийн ханшийг султгаж, доллар валют гадагшаа илүү их урсах үүд хаалгыг нээдэг ээ. Тээвэр үйл ажиллагааны зардал багадаа 20 хувь өсөж, компани иргэдийн ашгийг идэж байна аа. Үүн дээр нэрмээс болж үнэ тарифын зохисгүй бодлого, өр авлагын сүлжээнд торлогдсон эрчим хүчний салбар ирэх өвөл ахин гал алдах аюул хэвээр байна.

Хаврын тариалалт бүтээн байгуулалтын улирал эхэлж байгаа энэ цаг үед гол орцууд болсон түлш, тэсэлгээний материал, бордоо зэрэг голлох түүхий эдийн нийлүүлэлт тасрах үнэ өсөх хүндрэл тулж ирээд байна аа. Улс орныг нөмрөн авч байгаа ийм бодит гадаад хүйтрэл дотоод хямралаас үүдэн тулгарсан эдгээр асуудлуудыг бид хэрхэн шийдэх вэ. Шинэ Засгийн газар ид шид амлахгүй ээ. Эдийн засгийн гайхамшиг бүтээнэ гэж хэлэхгүй ээ. Үнэнийг үнэнээр нь хэлнэ.

Өнөөдөр бид гадаад ертөнцийг өөрчлөхгүй боловч дотооддоо өөрсдөөсөө хамаарах бүхнийг хийх үүргийг хүлээж байна аа. Бид дэлхийг өөрчлөхгүй боловч өөрчлөгдөж байгаа дэлхийд Монголоо хохирол багатай авч үлдэж, хожим хойно хийгээгүй үйлдлийнхээ төлөө харамсахгүйн төлөө ачаагаа үүрэх ёстой. Газрын тосны дэлхийн зах зээлийн үнийг Монголд тогтоохгүй боловч онцгой нөхцөлд өөрсдийн бололцооны хэрээр тохируулгын арга хэмжээг авах болно оо. Түлш шатахууны үнийн 5 хувь болдог татварыг цуцаллаа ч 2 дугаар сард баррель нь 67 доллар байснаа өдгөө 2 дахин өсөж, цаашид улам нэмэгдэх төлөвтэй үнийн шуургыг сөрж өөрчилж чадахгүй ээ. Дэлхийн хөгжингүй том гүрнүүд онц байдал зарлаж, хэмнэлтийн горимд ороод байхад үнэ тогтоон барих ямар ч боломжгүйг шууд хэлэх ёстой. Үнийг тогтоон барих зорилгоор захиргааны хэв шинжтэй оролдлого хийх нь тухайн цагтаа хэрэгжээд өнгөрөх хэдий ч үр дагавар нь хатуу ирдэг гэдгийг бид олон

салбарт хангалттай харлаа. Түлш шатахуунаас тооцож авдаг татвар хураамжаа багасгах цуцлах нь үнийн хувьд нөлөө багатай хязгаарлагдмал арга хэрэгсэл юмаа.

Олон улсын зах зээл дээр давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр үнэ хэрхэн яаж өсөхийг, маргааш юу болохыг хэн ч таамаглан мэдэх аргагүй ээ. Гагцхүү түлш шатахуун тасалдаж, хомсдол нүүрлэхээс урьдчилан сэргийлж хичээн ажиллах шаардлагатай. ОХУ-тай бүх талын байнгын идэвхтэй яриа хэлцэл, холбоо харилцаатай байж, нөөц хангамж, тасалдал хомсдохгүй байхын төлөө ажиллах болно оо. Засгийн газар энэ бүх эрсдэлийг сөрж Улсын Их Хурлын даргаар ажиллаж байхдаа дэвшүүлсэн чөлөөлье санаачилга эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлтийн бодлогоо ажил хэрэг болгон хэрэгжүүлэх болно оо. Эрх чөлөө бол итгэлцэл юмаа. Эрх чөлөө бол хүч юмаа. Эрх чөлөө бол ардчилсан нийгмийн амьсгалах агаар нь юм. Эрх чөлөө бол эмх замбараагүй байдал биш ээ. Эрх чөлөө бол шударга ёс, эв нэгдлийн гагнаас юмаа. Эрх чөлөөний 4 зам 4 чөлөөлөлтөө иж бүрэн зураглан тодорхойлоход дэг журам нь хувиран өөрчлөгдөж хүчний нэг туйлаас олон туйлд шилжин байгаа дэлхийн цаг төрийн байдлыг харгалзан авч үзэх ёстой.

Дэлхийн 2 дугаар дайны дараа тогтсон дэг журам ганхаж, өнөөдөр хамгийн тодорхойгүй байдал хамгийн тодорхой байдалтай байна аа. Их гүрнүүдийн зөрчил хямрал гүнзгийрч, улс төр, эдийн засаг, геополитик, гео стратегийн өрсөлдөөн, мэдээллийн технологи, хиймэл оюун, хагас дамжуулагч, эрчим хүч, илч энерги, түүхий эдийн нөөц соёлын ширүүн тэмцэл болон өргөжлөө. Монгол Улс цээжинд нь оршдог Ази тивд дэлхийн эдийн засгийн хүндийн төвд шилжлээ. Дэлхийн ДНБ-д эзлэх Ази тивийн хувь 26 жилийн дотор 35 хувиас 47 хувь болон өсөн нэмэгдлээ. Ази тивийн эдийн засгийн дундаж өсөлт дэлхийн дунджаас 2 дахин өндөр буюу 4.5 хувьд хүрлээ. Нэг талаас даяаршлын хил хязгааргүй боломж нөгөө талаас үндэсний ондоошил дэлхийд Монголоороо үлдэх торгон заагаа хамгаалах шинэ сорилттой тулгарч байна аа.

Дэлхийг нөмөрсөн цар тахал дахин татагдсан төмөр хөшиг, дайн байлдаан, зөрчилдөөн мөргөлдөөн ар араасаа залгаж халуун цэгүүд бөмбөрцгийн бөөр бүхэнд асаж байна. Бид дэлхийг өөрчлөхгүй боловч өөрчлөх ёсгүй үндэсний ондоошлоо хадгалах сөрөн тэсвэрлэх нь бидний давах ёстой зорилт болоод байна аа. Эх орны эрдэс баялгаа илүү үнэ цэн өртөг ашиг нэмж, үйлдвэрлэн боловсруулж түүхий эдээ түүхийгээр нь гаргадаг түүхийг өөрчлөх нь бидний гэрийн даалгавар боллоо. Евро Азийн 5 улсын 2.4 их наяд долларын зах зээлийн үүдийг нээсэн түр хэлэлцээрийн боломжийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атрын 4 дүгээр аяны бодлоготой уялдуулж бүрэн дүүрэн ашиглаж, уул уурхайгаас хамааралтай эдийн засгаа төрөлжүүлэхийн төлөө хийх ажил их байна аа.

Мах, сүү, арьс шир, ноос ноолуураа үнэд хүргэн монгол малчид үндэсний компаниудын олох ашиг орлогыг өсгөхийн тулд шийдэх асуудал их байна аа. Эдийн засаг гоё тооноос илүү бодит чанар болж байж хүртээмжийн тухай ярина аа. Холын гоё тоонууд сонсоход таатай хэдий ч өрхийн үүдээр орлоо, амьдралыг минь өөрчилсөн гэж итгэл төгс хэлэх хүн алга байна аа. Хувийн хэвшлээ төрийн зуршлаас, хүнээ хүнд суртлаас чөлөөлөх нь шинэ Засгийн газрын шийдэх асуудлын гол зангилаа байна аа. Итгэл унавал эдийн засаг унадаг аа. Иргэндээ, хувийн хэвшилдээ гадаадын хөрөнгө оруулагчид, баялаг бүтээгчид нарынхаа хийе бүтээе гэсэн хүсэл эрмэлзэхэд нь итгэх нь Засгийн газрын жанжин шугам байх болно оо.

Нэг дэх зам эдийн засгийн чөлөөлөлт. Банкны зээлийн жигнэсэн дундаж хүү 17-20 хувь, ББСБ-ынх 30-42 хувь байгаа цагт зээлээс зээл, өрөөс өрийн хоорондох өнөөдрийн амьдралыг бид өөрчилж чадахгүй ээ. Монгол орон мөнгө хүүлэлтийн диваажин байгаа цагт урд хормойгоо хойд хормойгоороо нөхсөөр байгаа нөхцөлд өрийн дарамтаас сугарах үйлдвэрүүд үүдээ нээхэд хэцүү. Харин хаалгаа барих амархан. Өөрсдөө наад захын идэх уух, эдлэх хэрэглэхээ үйлдвэрлэж бүтээх олуулаа хийх ажилд авах цалинтай байх өдөр наашлахгүй ээ. Европ Азийн банкнуудыг Монголд урих, нэгэнт эхэлсэн яриа хэлцлүүд бол хямд өртөгтэй зээлийн эх үүсвэр чөлөөт өрсөлдөөний үр дүнд өндөр хүүгийн дарамтаас чөлөөлөгдөх замын эхлэл байх болно оо.

Монгол бол дэлхийн газрын зураг дээр гадаадын банк, хүү, гарын 5 хуруунд багтах цөөн улсын нэг ээ. Зах зээл дэх цөөн тоглогчийн хүсэл тохирол ашиг сонирхол, хууль журмаар тавьсан хиймэл зохиомол саадыг арилгаж, чөлөөт өрсөлдөөний үр дүнд хөрөнгө оруулалт, санхүүгийн хүртээмж нэмэгдэж, эх үүсвэрийн өртөг буух болно оо. Санхүүгийн секторыг 2 тулгууртай болгож, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг тэлснээр урт хугацааны хямд эх үүсвэр орж ирэх, эдийн засгийн өсөлт хүртээмжтэй байх эко системийг төрөөс төсвөөр биш зах зээлийн зарчмаар бий болгоно оо. Аюул гамшиг, аливаа эрсдэлийг хандив тусламж сайхан сэтгэлээр биш даатгалаар шийднэ ээ. Тэтгэврийн тогтолцоо зөвхөн төрийнх байж ирснийг өөрчилж хувийн тэтгэврийн санг дэмжиж ажиллах болно оо.

2.Төсөв болон ТӨК-иудын нийт зардлын эдийн засаг дахь харьцаа 2019 онд 51 хувь байсан бол 2024 онд 61 хувь болж өссөн байна аа. Чөлөөт зах зээлийн эдийн засагтай орон гэх атлаа 100 төгрөгийн 60 төгрөгийг дарга нарын гарын үсгээр зарцуулж байна. Ийм нөхцөлд хувийн хэвшил өсөж өндийх хөгжлийн хөдөлгүүр байх ямар ч боломж алга аа. ТӨК-иудыг олон нийтийн болгож, нэгтгэн нийлүүлж, татан буулгаж, төсвийн хэт тэлэлтийг хязгаарлаж, хувийн хэвшилдээ өсөн дэвжих орон зайг нээж өгнө өө. ААН-үүд жижиг нь томордог, том нь дэлхийд өрсөлддөг өртөө замыг нээн чөлөөлнө өө.

3.Бизнес эрхлэх эрх чөлөө, хувийн өмч хөрөнгө оруулалтыг хуульчлан хамгаалж, хуулиас давсан дүрэм журам гаргахыг таслан зогсооно оо. Төрийн бүх шатад бизнесийн орчинд сөргөөр нөлөөлж байгаа шийдвэрүүдийг цуцалж, No Surprises зарчим буюу төр гэнэтийн бэлэг барьж бизнесийн орчинд садаа тогтор үүсгэхийг хориглоно оо.

4.Төлдөг нь хохирдог, төлдөггүй нь хождог татварын тогтолцоог шударга болгох багц өөрчлөлтийн төсөлд татвар хураагчдын бус татвар төлөгчдийн санал бодлыг илүү өргөнөөр тусган 2027 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх болно оо.

5.Төсвийн зарлагыг эрэлт хэрэгцээ үр ашгаар нь эрэмбэлж, хэрэгцээ шаардлагыг шаардлагагүй зардлуудыг танаж, хэмнэлтийн горимд шилжинэ ээ. Төрийн давхардсан чиг үүргийг цэгцэлж нэг ажлыг олон талт давхардан хийдгийг болиулна аа. Улсын Их Хурлаас баталсан 208 хуулийн 1024 заалтаар Монгол Улсын төсвийн урсгал зардлыг хуульчилсныг нэгтгэн дүгнэж, төсвийн урсгал зардлын хэт тэлэлтийг хязгаарлах энэхүү шинэчлэлийг 2027 оны төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ ээ.

6.Төр хувийн хэвшлийн түншлэлээр бүх аймгууд бие даан төсөл хэрэгжүүлэх эрх чөлөөг нээх болно оо. Сайд, агентлагийн дарга нарын олгодог илүүц шаардлагагүй зөвшөөрлүүдийг цуцална аа. АМНАТ-ийг орон нутгийн хөгжлийн санд төвлөрдөг 10 хувийг 20 хувь болгож 2 дахин нэмэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ ээ. Баялгаа ашиглуулж байгаа аймаг орон нутаг өгөөжийг нь илүү хүртэж, зарим зардлаа өөрсдөө санхүүжүүлдэг байх чиг үүргийг нь шилжүүлэн өгнө өө. Үндэсний баялгийн сангаа өсгөн арвижуулж, стратегийн орд эзэмшигчтэй харилцан ашигтайгаар хэлэлцээрийг үргэлжлүүлж, баялагтаа Эзэн Монгол санаачилгын хүрээнд байгалийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үед тэгш шударга хүртээх Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх болно оо.

Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын жишигт нийцүүлнэ ээ. Оюу толгойгоос хүртэх Монголын талын өгөөжийг 53 хувьд хүргэх Гомбожавын Занданшатарын Засгийн газрын бодлогыг хатуу баримтлан хэлэлцээрийг үргэлжлүүлнэ ээ. Өмнөх Засгийн газруудын үед эхлүүлсэн импортыг орлож экспортыг нэмэх гэрэл асааж, үнэ цэн, өртөг ашиг бүтээх эдийн засгийн тусгаар тогтнолыг гагнаж босгох Газрын тос боловсруулах үйлдвэр, Гангийн үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС, зэс хайлуулах цогцолборын төслүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ ээ. Аль ч нийгэмд ажиллаж хөдөлмөрлөж, бүтээж амьдардаг мөн ажил хийгээд амьдрахад хэцүү, ажил хийхгүй ч амьдарч болоод байдаг сэтгэлгээг өөрчлөх болно оо. Ажилсаг хөдөлмөрч нь ажиллах дургүйгээ нуруундаа үүрч нугардаг байж болохгүй ээ. Халамж хавтгайрч эхлэхээрээ хайр биш хал болж байна аа. Хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг нь хөшүүрэгдэж, шинэ ажлын байрыг нээж, ур чадвар олгох, давтан сургах хөтөлбөрүүдийг хүндээ ойртуулан хэрэгжүүлэх болно оо. Хөдөлж байгаа, хөдөлмөрлөж байгаа хүн бүрийг дэмжих зарчмыг баримтлан ажиллана.

2 дахь зам Эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт. Хүслийг хяссан хүнд суртлаас хөдөлмөрч бүтээлч хүн ардаа, баялаг бүтээгч хувийн хэвшлээ төрийн зуршлаас чөлөөлөхийн тулд жин биш зам нээнэ ээ. Зөвшөөрөл нэртэй хориглолтын системийг нурааж, эдийн засгийн эрх чөлөөний замыг элдэв саадаас чөлөөлөх болно оо. Цахим засаглалын индексийг 28 байр урагшлуулсан амжилтаа ахиулж, хиймэл оюунд суурилсан шийдвэр гаргадаг И-кабинетыг бүрдүүлж, төрөөс олгож байгаа зөвшөөрөл лицензүүдийг зөвхөн цахимаар олгох шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, И-Бизнес 2.0 платформыг нэвтрүүлнэ.

2.Эрсдэл багатай, зардал ихтэй төрийн үйлчилгээг аутсорсинг хэлбэрээр хувийн хэвшилд шилжүүлж төр иргэндээ очиж үйлчилдэг соёлыг бүрэн нэвтрүүлж зөвшөөрөл, тендер материал, тайлан төлөвлөгөө, дүгнэлт таамаглал боловсруулах, тоон шинжилгээнд хиймэл оюун ухааныг ашиглаж эхэлнэ ээ. Иргэнээс нэг мэдээллийг нэг л удаа нэхдэг болох цааснаас чөлөөлөх болно оо. Төрийн албан хаагчид ажил хийж шийдвэр гаргахаас айж эмээдэг болжээ. Ажил хийж асуудал шийддэг нь буруудаж эс үйлдсэн нь завшдаг урвуу тогтолцоог эргүүлж шат шатад шийдвэр гаргах эрхийг нь буцаан олгоно оо. Хөл толгой нь олдохоо байсан төрийн албаны тогтолцоо, чиг үүргийн давхардалд шинжилгээ хийж оновчилно оо. Төрийн албан хаагчаа сар, улирал, хагас жил тутам 14-18 төрлийн тайлан мэдээ бичихээс нь чөлөөлж, once only зарчим буюу ижил агуулга бүхий тайланг зөвхөн нэг удаа гаргадаг болно оо. Төрийн ажлын үр дүнг олон улсын индекс бодлогын үр нөлөөгөөр хэмжиж, бодитоор үнэлж эхэлнэ ээ.

4. Дэлхий ертөнц технологийн хурдаар хувьсан өөрчлөгдөж, улс орнуудын өрсөлдөх чадвар зөвхөн газрын доорх баялгаар бус хүний тархинд буй мэдлэг, ур чадвараар хэмжигддэг шинэ эринд бид амьдарч байна. 2022 онд хийсэн олон улсын писа үнэлгээгээр сумын хүүхдүүд хотын хүүхдээс 3 хүртэлх жилээр, аймгийн хүүхдүүдээс нэг жилээр хоцорч байгааг тогтоосон байна аа. Бидний зорилго бол Улаанбаатарт байгаа хүүхэд алслагдсан сумын сургуульд сурч байгаа хүүхэд 2-ын хооронд мэдлэгийн ялгаа хоцрогдол үүсэхгүй байх явдал юмаа. Хүүхэд бүрийг мэдлэгийн хоцрогдлоос чөлөөлж, хаана амьдарч байгаагаас үл хамааран дэлхийн хэмжээний боловсролыг технологиор дамжуулан авах нөхцөлийг бүрдүүлнэ ээ. Сайн сургууль гэж сайн хөтөлбөртэй, сайн багштай, хуурамч дүнгүй хүүхэд бүр төсөвтэй, хамтын удирдлагатай, цахимжсан халуун хоолтой, үе тэнгийн дээрэлхэлгүй сургуулийг хэлдэг гэж би ойлгодог оо. Боловсролтой иргэн бэлтгэхийн зэрэгцээ айдасгүй хамгаалагдсан хүүхэдтэй байх нь чухал юмаа.

Хүүхэд хамгаалал бол зөвхөн хууль биш энэ бол үндэсний дархлаа юмаа. Бид хүүхдийн эсрэг хүчирхийлэлд тэг хүлцэл үзүүлэх бодлогыг хатуу баримтална аа. Бид оюуны дайжилтыг зогсоож дэлхийн түвшинд хүрсэн Монгол залуусаа эх орондоо авчрах, эх орондоо дэлхийн боловсрол эзэмших боломжийг нээх ёстой. Бид гадагшаа урсаж байгаа эрдэм оюуныг эх орондоо цугларах оюуны нөөц болгон хувиргах болно оо.

5. ЭМД мөн чанартаа даатгал биш хараа хяналт муутай халамж болсныг засаж, хамтын санхүүжилтийн тогтолцоонд шилжүүлнэ ээ. Зөвхөн улсын бус хувийн ЭМД-ын тогтолцоог бий болгож, хамтын санхүүжилтийг нэвтрүүлнэ. ӨЭМТ-үүдийг бэхжүүлж өвдсөн хойно нь эмчлэхээс илүү урьдчилан сэргийлэх эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх болно оо. Монголд эмчийн чадвар бус эмийн чанар дутагдаж байна аа. Эмийн бүртгэл, импорт, хяналт, түгээлтийн мэдээллийг нэгдсэн цахим системд нэгтгэх ажлыг эрчимжүүлнэ ээ. Ингэснээр хуурамч, чанаргүй эм орж ирэхийг хориглоно оо. Эмийн үнийн өсөлтөд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор импортын эм эмнэлгийн хэрэгслийн зах зээлд борлуулагдсан бөөний болон жижиглэнгийн үнэ, тоо хэмжээний мэдээлэл солилцох эмийн үнийн шатлал бүрд нэмэгдлийн хэмжээг системийг хөгжүүлнэ.

3 дахь зам Ногоон хөгжлийн чөлөөлөлт. Монгол бол эх дэлхийгээ хайрлан хайрлах энх мөнх оршихуй үзэл санааны өв уламжлалтай оюуны соёлын эх ундаргатай орон. Монгол бол нар салхины сэргээгдэх эрчим хүч энергийн дундаршгүй их өгөгдөлтэй орон. Монгол бол дэлхийн цаг уурын өөрчлөлтөд эмзэг өртөмхий өргөн уудам газар нутгийнх нь 76 хувь нь цөлжилт бэлчээрийн доройтолд нэрвэгдсэн орон. Байгаль орчноо ч хамгаалж, баялаг нөөцөө ч хариуцлагатай ашиглан ирээдүй хойчдоо эрсдэлгүй эх орноо өвлүүлэх нь энх оршихуйн ногоон хөгжлийн үзэл санаа байх болно оо. Энэ хүрээнд эх дэлхийдээ ээлтэй эдийн засаг, эко үйлдвэрлэл тогтвортой хөгждөг ХАА-г дэмжих сэргээгдэх эрчим хүч ашиглаж нүүрстөрөгчийн ялгаварлыг бууруулах ногоон чөлөөлөлтийн замын хөтөлбөр байх болно оо. Жилийн 240-өөс багагүй өдөр нь алтан нартай цэнгэг салхины орон мөртөө жилд 200 сая орчим доллароор бусдаас гэрэл цахилгаан, 2.2 тэрбум доллароор түлш шатахуун импортолж хараат хамааралтай байсаар байна аа.

Эрчим хүчний хэрэглээ жилд 6-10 хувиар өсөж байхад цахилгаан станцуудаа цаасан дээр зурж гацаасаар өвлийн ид хүйтэнд бид гал алдлаа. 4 дүгээр цахилгаан станц барьснаас хойш 43 жил цахилгаан станц барьж босгосонгүй ээ. 100 мянган нарны гэр санаачилгаар 2035 он гэхэд Улаанбаатар хотод гэр хорооллын айлуудад

туршсан амжилттай болсон хөтөлбөр шиг 100 мянган айл нарны хавтан халаагуур хураагуур хосолсон систем суурилуулан, буулгах яндан нэмэрлэх цахилгаан олох орлого бүхэн нийлж ногоон чөлөөлөлтийн өргөн замыг нээх болно оо. 100 мвт тархмал эх үүсвэр санаачилгаар аймаг орон нутагт бие даан ажилладаг нарны панелаас өөрийгөө бүрэн цэнэглээд хураадаг системийг суурилуулж чөлөөлөх болно оо. Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг бүрдүүлэх хувийн хэвшлийн санаачилгыг нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж, Засгийн газар бүрэн дэмжиж ажиллана.

3-ыг үржих нь 100 хөтөлбөрийн нэг салаа зам шугам нь өргөн уудам нутагтаа өмнөөс умард, баруунаас зүүн гол замууд дагуу 100 мянган цахилгаан тээврийн хэрэгсэл түргэн цэнэглэх дэд бүтцийн өртөө байгуулах санаачилга байх болно оо.

Манай улс өргөн уудам нутагтай нар салхины арвин их нөөцтэй орон. Нүүдлийн соёл уламжлалаа хадгалж суугаа малчдадаа нэмэлт орлоготой болгох нарлаг монголын малчин хөтөлбөр бэлчээрийн доройтлыг бууруулж, бэлчээрийн доор агуулагдаж байгаа нүүрс төрөгчийн шингээлтийг үнэгүйдүүлж хэмжүүлээд Швейцар, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй газар нутаг багатай орнуудтай байгуулсан гэрээний дагуу малчин өрх хөдөөгийн иргэн хүссэн хэн бүхэн доллар валютаар ашиг олох шинэ чөлөөлөлтийн замыг нээх болно оо.

4.Авлигын эсрэг чөлөөлөлт. Олон улсын Трансперенси Интернэшнл байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт сайжрах биш муудаж, урагшлах бус ухарч байгаа нь бидэнд ирж байгаа ноцтой анхааруулга юмаа. 2025 онд Монгол Улс 31 оноо авч 10 байраар ухарлаа. Бид олон улсын байгууллагын дэлхийд танилцуулдаг тайлантай, өөрсдийнхөө толин дахь тусгалтайгаа заргалдаад нэмэргүй ээ. Харин засаж залруулахын төлөө хамтдаа хичээн ажиллах ёстой. Шилэн ажиллагаагаар олон нийтэд нээлттэй болгосон 820 мянга гаруй мөр өгөгдлийг эх өгөгдөл болгон хүнээс хамааралгүй шийдвэр гаргадаг тогтолцоог бүрдүүлэх болно оо. Авлигын эсрэг энэхүү дэвшилтэт ололт амжилтуудыг хэрэгжүүлэхэд Шүгэл үлээгчийг хамгаалах хууль, Олборлох салбарын ил тод байдлын хуулиудыг бодитойгоор хэрэгжүүлж ажиллах болно оо.

Манай Засгийн газар хурд, гүйцэтгэл, дижитал шинэчлэл давамгайлсан крайс менежмент төлөвлөгөөтэй, цахим засаглалын түргэвчилсэн горимын дагуу өгөгдөлд суурилсан шийдвэр гаргадаг иргэндээ ээлтэй нээлттэй эрх чөлөөний төлөө Засгийн газар байх болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголчууд эвлэлдэж нэгдэх бүрдээ мандан бадарч, эвдэрч бутарсан цагтаа уруудан доройтож явсан түүхтэй. Эрчим хүч, энергийн үнийн өсөлт, хомсдол, тээвэр, логистик, худалдааны хямралыг өдөөсөн дэлхийн цаг төрийн үймээн самууныг үзэл бодол, намын харьяалал, ажил мэргэжил үл харгалзан Монгол хэмээх нэгэн туган дор нэгдэн асуудлыг шийдэл болгон хамтдаа зүтгэцгээе ээ.

Бие биедээ Монгол нь Монголдоо, иргэн нь иргэндээ, баялаг бүтээгч хөрөнгө оруулагчдаа бүрэн итгэж бүтэн зүтгэж хүслийг хяссан хүнд суртлаас хийе бүтээе гэсэн хүн бүрийг чөлөөлж, ард түмэндээ амар амгалан амьдрах орчныг бүтээх зорилго дор нэгдэн нягтарч, цагийн шуургыг сөрж давцгаая аа. Суудал шийдэл ярьдаг бус асуудал шийдэл ярьдаг, сандал ширээ булаалддаг бус санал шийдлээ

уралдуулдаг бүтээлч Монголыг бүтээцгээе ээ. Эргэх холбоотой иргэндээ ойрхон, энгийн даруу ажиллах болно оо. Эрх чөлөөний наран Монгол хүн бүрийг ивээж эрх чөлөөт тусгаар Монгол Улс мандан бадрах болтугай.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал Танд талархал илэрхийлье.

Үүгээр 2026 оны 3 сарын 30-ны өдрийн Улсын Их Хурлын чуулган өндөрлөж байна аа.

23.18 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*